



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУВИЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ XIII БОТЪ

(2022 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2023 он

ДАА 340

ННА 67

С-701

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛСЫН ХАРАА

*Олон улсын жишигт нийцсэн эрдэм, шинжилгээ, сургалт мэдээллийн
үндэсний хүрээлэн болон хөгжинө.*

© Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Зохиогч болон нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр тус номын агуулгыг хэсэгчлэн болон бүтнээр хэвлэх, электрон аливаа хэлбэрээр хувилах, бичлэг хийх, хайлтын системд оруулах, хэвлэн олшруулахыг хориглоно. Хууль зүйн үндэсний хүрээлэн.

Хянан тохиолдуулсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Эмхэтгэсэн: Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х.Буянбат (LL.M)

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч, дизайнер
Б.Заяа

Цаасны хэмжээ:

Хэвлэлийн хуудас: 13х.х

“ ” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN: 978-9919-9964-6-8

ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт уншигч та бүхний түмэн амгаланг айлтган мэндчилье.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд заасан эрх зүйн салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх зорилтын хүрээнд бид 2022 онд хийсэн судалгааны тайлангуудаа “Хувийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XIII боть)”, “Эрүүгийн эрх зүйд холбогдох

судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XIV боть)”, “Нийтийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XV боть)” хэмээх гурван ботиор уншигч олноо толиулж байна.

Хувийн эрх зүйд холбогдох судалгааны тайланг эмхэтгэсэн энэхүү XV боть нь хувийн эрх зүйн голлох салбаруудыг хамаарах харьцуулсан судалгаа голчилсон, онолын шинэ хандлагаар практик дахь тулгамдаж буй олон асуудалд шийдэл дэвшүүлснээрээ онцлог. Тухайлбал, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцоо: харьцуулсан судалгаанд гэм хор учруулснаас үүсэх үүргийн ойлголт, онолын үзэл санаа эх газрын болон англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудад өдийг хүртэл хэрхэн хөгжиж ирсэн тухай авч үзэхийн хамт Монгол Улсын Иргэний хуульд заасан гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий болон тусгай зохицуулалтад дүн шинжилгээ хийж, эрх зүйн тогтолцоо, соёлын хувьд ойролцоо зарим улсыг сонгон гэм хорын эрх зүйн тогтолцоог нь судалснаар Монгол Улсын гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцоонд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, даван туулах арга замыг эрэлхийлсэн шинэлэг судалгаа болсон юм.

Манай улсад хуулийн этгээдийг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж ангилдаг хэдий ч бусад байгууллага, тэр дундаа хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг төрөлжүүлсэн зохицуулалт байдаггүйгээс ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хуулийн этгээдийн ашгийн бус тодорхой төрлүүдээс ялгаж ойлгох шаардлага үүсдэг. “Ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллага” харьцуулсан судалгаанд хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг ангилж буй шалгуурыг тодруулж, ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллагын ялгаатай шинжийг эрх зүйн бүлээр нь ялган тодорхойлсон.


Хувь хүн хуулийн этгээдийн нэгэн адил төлбөрийн чадваргүй байдалд орох тохиолдолд манай улсад жилээс жилд нэмэгдсээр байгаа ч тухайлсан зохицуулалтгүй байна. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил, олон улсын чиг хандлагыг тандан, зарим улсын туршлагыг судалж, онцлогийг тодруулах замаар Монгол Улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор Хувь хүний дампуурлын ба эрх зүйн зохицуулалт (олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага) судалгааг гүйцэтгэв.

Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Гэр бүлийн тухай хууль хэрэгжиж эхлээд хэдийн 23 жил өнгөрч нэгэнтээ эдийн засаг, нийгэм, соёлын өөрчлөлтийг дагасан гэр бүлийн харилцааны өөрчлөлтийг бүрэн зохицуулж чадахгүйд хүрчээ. Иймд Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулсан төслийг боловсруулах ажилд дэмжлэг

үзүүлэх зорилгоор Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох тандан судалгаа болон Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн практикт дүн шинжилгээ хийх замаар тулгамдаж буй зарим асуудлыг тодруулсан судалгааг гүйцэтгэлээ.

Уг ботид эмхэтгэгдсэн бидний судалгаа нь Монгол Улсын хувийн эрх зүйн салбарт тулгамдаж буй олон асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэгдэхэд зохих ёсны хувь нэмрийг оруулж хувийн эрх зүйн шинэтгэлд дэмжлэг болно гэдэгт итгэж байна.

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

ГАРЧИГ

Өмнөх үг.....	lii
Гарчиг.....	V
Товчилсон үгийн жагсаалт.....	vi
Хүснэгтийн жагсаалт	vii
Графикийн жагсаалт	viii
Нэг. Ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллага	9
Хоёр. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт: олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага.....	27
Гурав. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцоо (харьцуулсан судалгаа).....	59
Дөрөв. Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	125

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
ГБтХ	Гэр бүлийн тухай хууль
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДНХ	Дизоксирибо нуклеин хүчил
ДтХ	Дампуурлын тухай хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ЗГ	Засгийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
GDPR	General Data Protection Regulation/ Европын Холбооны Ерөнхий мэдээллийг хамгаалах журам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Ашгийн төлөө болон ашгийн бус байгууллагын ялгаа	19
Хүснэгт 1.2. Ашгийн төлөө бус болон ашгийн төлөө бус байгууллагын ялгаа	20
Хүснэгт 3.1. Гэм хорын эрх зүйн монгол, англи нэр томъёог харьцуулсан нь	69
Хүснэгт 3.2. Монгол Улсын Иргэний хуулийн зарим зүйл, заалтад хийсэн дүн шинжилгээ	75
Хүснэгт 3.3. Монгол Улсын Иргэний хуулийн 498 дугаар зүйл	81
Хүснэгт 3.4. Шүүхийн шийдвэр №1	83
Хүснэгт 3.5. Шүүхийн шийдвэр №2	84
Хүснэгт 3.6. Шүүхийн шийдвэр №3	84
Хүснэгт 3.7. Монгол Улсын Иргэний хуулийн 499 дүгээр зүйл	85
Хүснэгт 3.8. Шүүхийн шийдвэр №4	88
Хүснэгт 3.9. Шүүхийн шийдвэр №5	89
Хүснэгт 3.10. Монгол Улсын Иргэний хуулийн 500 дугаар зүйл	91
Хүснэгт 3.11. Шүүхийн шийдвэр №6	91
Хүснэгт 3.12. Шүүхийн шийдвэр №7	92
Хүснэгт 3.13. Монгол Улсын Иргэний хуулийн 501 дүгээр зүйл	94
Хүснэгт 3.14. Шүүхийн шийдвэр №8	95
Хүснэгт 3.15. Шүүхийн шийдвэр №9	96
Хүснэгт 3.16. Монгол Улсын Иргэний хуулийн 502 дугаар зүйл	98
Хүснэгт 3.17. Шүүхийн шийдвэр №10	99
Хүснэгт 3.18. Шүүхийн шийдвэр №11	99
Хүснэгт 3.19. Шүүхийн шийдвэр №12	101
Хүснэгт 3.20. Монгол Улсын Иргэний хуулийн 503 дугаар зүйл	102
Хүснэгт 3.21. Шүүхийн шийдвэр №13	103
Хүснэгт 3.22. Шүүхийн шийдвэр №14	104
Хүснэгт 3.23. Монгол Улсын Иргэний хуулийн 504 дүгээр зүйл	105
Хүснэгт 3.24. Шүүхийн шийдвэр №15	106
Хүснэгт 3.25. Монгол Улсын Иргэний хуулийн 512 дугаар зүйл	107
Хүснэгт 3.26. ХБНГУ-ын гэм хорын ерөнхий зохицуулалт	111
Хүснэгт 3.27. ХБНГУ-ын Иргэний хуулийн зарим зүйл, заалт	112
Хүснэгт 3.28. БНФУ-ын Иргэний хуулийн 1240-1244 дүгээр зүйл	115
Хүснэгт 4.1. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн төрөл (2020-2021 он)	133

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 4.1. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо (2017-2021)	130
График 4.2. Шийдвэрлэсэн хэрэг.....	131
График 4.3. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийг төрлөөр ангилсан нь (2016-2021).....	132
График 4.4. Гэрлэлт цуцлах хэргийн тоо (2016-2021).....	134
График 4.5. Гэрлэлт цуцлах болсон шалтгаан (2017).....	135
График 4.6. Гэрлэлт цуцлах болсон шалтгаан (2022).....	135
График 4.7. Эцэг тогтоох хэргийн тоо (2016-2021).....	136
График 4.8. Эцэг эх байх эрх хассан хэргийн тоо (2017-2021).....	137
График 4.9. Эцэг эх байх эрх хассан хэргийн тоо (2018-2021).....	138
График 4.10. Хүүхийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо (2017-2021).....	139

НЭГ. АШГИЙН ТӨЛӨӨ БОЛОН
АШГИЙН ТӨЛӨӨ БУС БАЙГУУЛЛАГА

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur)
----------------	--

Судалгааны багийн бусад гишүүд:

С.Сүхбаатар	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (LL.D)
Э.Анударь	Эрдэм шинжилгээний ажилтан
А.Намуунаа	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2022.06.30.

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	11
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛ	12
1.1. Хуулийн этгээдийг ангилах шалгуур.....	13
1.2. Жишиг орон (Швейцар улсын жишээн дээр)	15
ХОЁРДУГААР БҮЛЭГ. АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛ	15
2.1. Америкийн Нэгдсэн Улс.....	15
2.1.1. Корпорацын ангилал	15
2.1.2. Ашгийн төлөө, ашгийн бус, ашгийн төлөө бус байгууллагуудын ялгаа.....	15
2.2. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс	16
ДҮГНЭЛТ.....	22
НОМ ЗҮЙ.....	23

УДИРТГАЛ

Монгол Улсын Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна. Эрх зүйн онолын үүднээс эрх зүйн харилцааны субъектийг хувь хүн, иргэн; төр, байгууллага; албан тушаалтан, ажилтан гэж хувааж болно. Байгууллага олон янз төрөлтэй боловч нийтлэг дүр төрх, нэгдмэл шинжүүдтэй байна. Тухайлбал, байгууллага бүхэн хууль зүйн тодорхой шалгуурыг хангасан үед эрх зүйн харилцааны субъект болно. Уг шалгуур нь хуулийн этгээд байх чадвар юм.¹

Манай улсад хуулийн этгээдийг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж ангилдаг хэдий ч бусад байгууллага (хуулийн этгээдийн эрхгүй байгууллага)-ыг төрөлжүүлсэн зохицуулалт байхгүй юм. Иймд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хуулийн этгээдийн ашгийн бус тодорхой төрлүүдээс ялгаж ойлгох шаардлагатай юм. Уг харьцуулсан лавлагааны хүрээнд байгууллагыг (хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллага) ямар шалгуураар ангилж буйг тодруулсны үндсэн дээр ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллагын ялгаатай шинжийг эрх зүйн бүлээр нь ялган тодорхойлохыг зорилоо.

1 Д.Баярсайхан, Эрх зүйн онол, (УБ, 1996), 150 дахь тал.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛ

Өнөөдөр манай улсад үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтын хүрээнд байгууллагыг (хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллага) зорилгоос нь хамаарч ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байгууллага, чиг үүргээс нь хамаарч төрийн болон бусад байгууллага, өмчийн хэлбэрээр нь нийтийн, хувийн, холимог, эрх зүйн байдлаас нь хамаарч үндэсний, олон улсын болон гадаад улсын байгууллага, зохион байгуулалтын хэлбэрээр нь энгийн болон нийлмэл (хуулийн этгээдүүдийн нэгдэл), үйл ажиллагаа явуулах газар нутгийн харьяаллаар нь төв болон орон нутгийн гэж нийтлэг байдлаар ангилахаас гадна үйл ажиллагааны чиглэлээс нь хамаарч боловсролын, эрүүл мэндийн, хүмүүнлэгийн, улс төрийн, хэвлэл мэдээллийн, шашны гэх зэргээр тусгайлан нэрлэн ангилж болохоор байна.²

Хуулийн этгээд гэдэгт хүмүүс болон хөрөнгийн нэгдлийг тодорхой зохион байгуулалтад оруулж, хамтын зорилгод үйлчлүүлснээр тухайн эрх зүйн тогтолцооноос эрх зүйн субъект болохыг нь хүлээн зөвшөөрсөн нэгдлийг ойлгоно.³ Зохион байгуулалтын хэлбэр, өмчийн хэлбэр, үйл ажиллагааны төрлөөсөө хамааран олон төрөлд хуваагдана.

Хуулийн этгээдийг ямар шалгуураар төрөлжүүлэн ангилах нь эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудад нийтлэг хэдий ч зарим талаараа онцлог ялгаатай байдаг. Монгол Улсад хамгийн анх 1994 оны Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн этгээд нь ашиг олох үндсэн зорилготой ба ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан өөр зорилготой ба ашгийн төлөө бус байж болно.” гэж зааснаар хуулийн этгээдийг ашиг олох зорилгоор нь ангилах үндэс болсон.

2002 оны Иргэний хуульд хуулийн этгээдийг ашиг олох зорилгоор нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хэмээн төрөлжүүлсэн байдаг ч “хувийн эрх зүйн хуулийн этгээд” болон “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэх ерөнхий 2 төрөлд хуваагаагүй байна.⁴ Харин өмчийнх нь хэлбэрээр л нийтийн, хувийн, холимог өмчийн хуулийн этгээд гэж хуваахаар заажээ.⁵

“Ашгийн төлөө” гэдэг бол хувийн аливаа бусад үйл ажиллагаанаас бизнесийг ялгаж буй гол шалгуур юм. Албан хаагч, төсөвт байгууллагын бүх үйлчилгээний ажилтан гэх мэт нь ажил хэргийн хүн мөн боловч ашгийн төлөө биш, цалинтай боловч ашиг олох зорилгогүй хөдөлмөр эрхлэгч гэж болно.⁶ Ашгийн төлөө хуулийн этгээд нь компани, нөхөрлөл, хоршоо байна.

Харин Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт тусгасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн ангиллыг тодорхойлоход ихээхэн бэрхшээл гардаг. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үндсэн хэлбэр нь хамтран ажиллах

2 Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Ашгийн бус байгууллагын талаархи Монгол Улсын эрх зүйн зохицуулалт (эрх зүйн дүн шинжилгээ), (УБ, 2018), 2 дахь тал.

3 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, Ерөнхий анги, гурав дахь хэвлэл, (УБ, 2018), 48 дахь тал.

4 Хувийн эрх зүйн, нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж хуваах шаардлага бий болсныг Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, нэр томъёоны хэрэглээ, 2021 оны судалгааны тайлангаас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

5 Монгол Улсын Иргэний хууль, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг.

6 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл, хоёрдугаар дэвтэр, (УБ, 2004), 93 дахь тал.

гэрээт талууд (Иргэний хуулийн 476 дугаар зүйл) байх ёстой боловч энэ тухай тодорхой зохицуулалт байхгүй, хамтран ажиллаж буй хүмүүсийн нэгдлийн эрх зүйн чадварыг хүлээн зөвшөөрөөгүй байгаа билээ. Холбоо, сан, хоршооны хувьд хүмүүсийн нэгдэл эсвэл бусад идеал зорилго чухал байдаг гэсэн үзэл баримтлалын үүднээс ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж үздэг ч эдгээр нь бодит байдал дээр тодорхой ашиг олох үйл ажиллагаа явуулдаг.⁷

Үүнээс харвал, дан ганц хуулийн этгээд бус хуулийн этгээдийн эрхгүй байгууллага ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байх боломжтой юм. Иймд эхлээд хуулийн этгээдийг ангилах шалгуурыг авч үзсэний үндсэн дээр ашгийн төлөө болон ашгийн бус байгууллагыг хэрхэн ангилж буйг Швейцар улсын жишээн дээр авч үзье.

1. Хуулийн этгээдийг ангилах шалгуур

Эх газрын эрх зүйн бүлийн улс орнууд хуулийн этгээдийг дараах нийтлэг шалгуураар ангилж байна. Үүнд⁸:

- А. Өмчийн хэлбэр;
- Б. Үйл ажиллагааны зорилго;
- В. Үүсгэн байгуулагчид;
- Г. Гишүүдийн эрх;
- Д. Байгууллагын эд хөрөнгийн эрхийн хүрээ;
- Е. Хүмүүсийн эсхүл хөрөнгийн оролцооны хувь хэмжээ;
- Ё. Үүсгэн байгуулах дараалал;
- Ж. Үүсгэн байгуулах баримт бичиг;
- З. Гишүүнчлэл.

А. Өмчийн хэлбэр

Хуулийн этгээдийг өмчийн хэлбэрээс нь хамааран төрийн болон хувийн өмчит гэж хуваадаг. Ийнхүү ангилснаар төрийн өмчит хуулийн этгээд (ашиг олох зорилготой байсан ч) төрийн ашиг сонирхлыг хамгаалж, тусгайлсан эрх зүйн зохицуулалттай байх боломж бүрддэг байна. Тус ангиллыг нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэдэгтэй шууд холбоо хамааралтайгаар авч үзэх боломжтой.

Б. Үйл ажиллагааны зорилго

Хуулийн этгээдийг үйл ажиллагааны зорилгоор нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж ангилна. Энэ нь тухайн хуулийн этгээд үйл ажиллагаа явуулсныхаа үндсэн дээр гишүүддээ ашиг хуваарилах, эсхүл аж ахуйн шинжтэй бусад зорилготой байхыг ойлгоно. Ерөнхий дүрмээр бол ашгийн төлөө бус хуулийн этгээд нь гагцхүү дүрэмдээ заасан зорилгоо хэрэгжүүлэх үүднээс л аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжтой. Энэ тохиолдолд тэдгээр нь гишүүддээ ашиг орлогоо хуваарилахгүй юм.

7 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, Ерөнхий анги, гурав дахь хэвлэл, (УБ, 2018), 48 дахь тал.

8 Сергеева А.П., Толстого Ю.К., Гражданское право, Том 1. изд.6, перераб., доп, М, 2004, стр.166-169.

В. Үүсгэн байгуулагчид

Хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчдаар нь: 1/ үүсгэн байгуулагч нь гагцхүү хуулийн этгээд байх (холбоо, сан); 2/үүсгэн байгуулагч нь гагцхүү төр байх (төрийн байгууллага, төрийн өмчит компани зэрэг); 3/бусад эрх зүйн субъект үүсгэн байгуулагч байх гэж ангилдаг байна.

Г. Гишүүдийн эрх

Хуулийн этгээдийн хөрөнгөтэй холбоотойгоор гишүүдийн эдлэх эрхийн шинж байдлаар дараах байдлаар хувааж болно: Үүнд

- Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээдийн хөрөнгийн хувьд өмчлөх эсхүл эд хөрөнгийн бусад эрх эдэлдэг байгууллага- төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн байгууллага;
- Гишүүд нь үүргийн эрх эдэлдэг байгууллага- аж ахуйн нөхөрлөл⁹ эсхүл холбоо, хоршоо, ашгийн төлөө бус нөхөрлөл¹⁰, төрийн корпорацууд¹¹, ОХУ-ын хойд бүс, Сибирь, алс зүүн хязгаарт байрлах угсаатны цөөнхийн нийгэмлэг;
- Гишүүд нь хуулийн этгээдийн хөрөнгийн хувьд өмчийн эрх эдэлдэггүй байгууллага- холбоо, шашны байгууллага, сан, хуулийн этгээдийн болон хараат бус ашгийн бус байгууллагын нэгдэл.

Д. Хүмүүсийн эсхүл хөрөнгийн оролцооны хувь хэмжээ

Хуулийн этгээдийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг урьтал болгож байгаа, эсхүл хөрөнгөө нийлүүлэх зорилгыг урьтал болгож байгаа эсэхээр нь ялгаж болно. Аж ахуйн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийн хэмжээгээр бүрэн хариуцлагатай нөхөрлөл, итгэлцлийн нөхөрлөл, нэмэлт хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани гэсэн дарааллаар авч үзэх боломжтой.

Е. Үүсгэн байгуулах дараалал

Хуулийн этгээд нь зөвшөөрлийн үндсэн дээр эсхүл урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр байгуулагддаг нөхцөлд энэ ангилал ач холбогдолтой юм.

Ё. Үүсгэн байгуулах баримт бичиг

Үүсгэн байгуулах баримт бичгийн төрлөөр нь гэрээгээр- аж ахуйн нөхөрлөл; гэрээ болон дүрмээр- хязгаарлагдмал болон нэмэлт хариуцлагатай компани, эвлэл, холбоо; дүрмээр гэж ангилж болно. Гэвч төрийн аливаа нэгдлийг энэ ангиллын дагуу авч үзэх боломжгүй байдаг. Учир нь тэдгээр нь үүсгэн байгуулах баримт бичгээр бус хуульд зааснаар байгуулагдана.

9 Орос хэлээр “хозяйственные товарищества” гэснийг орчуулав.

10 Орос хэлээр “некоммерческое партнерство” гэснийг орчуулав.

11 Орос хэлээр “государственные корпорации” гэснийг орчуулав.

Ж. Гишүүнчлэл

Германд 16-19 дүгээр зууны үед үйлчилж байсан хувийн эрх зүйд (ХБНГУ, Швейцар) нэгдэл¹² (эвлэл) болон албан газрыг¹³ ялгадаг байжээ. Нэгдэл нь гишүүд нь солигдохоос үл хамааран зайлшгүй гишүүнчлэлтэй, тэдгээрийн нийтлэг зорилготой байдгаараа онцлог байна. Харин албан газар нь ихэвчлэн нэг үүсгэн байгуулагчтай бөгөөд хуулийн этгээдийн зорилго, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эрхийн хэлбэрийг ганцаараа тогтооно.¹⁴

Ийнхүү хуулийн этгээдийг ганцхан шалгуураар ангилахад төвөгтэй байна. Мөн зарим улсад эрх зүйн харилцааны оролцогч болохын тулд аливаа байгууллага улсын бүртгэлд бүртгүүлсэн байх шаардлагатай байдаг бол ХБНГУ, ОХУ зэрэг орнуудад хуулийн этгээдийн эрхгүй холбоог хуулиараа хүлээн зөвшөөрсөн юм.

2. Жишиг орон (Швейцар улсын жишээн дээр)

Швейцар улсад хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүйгээр зарим байгууллага эрх зүйн харилцаанд оролцох боломжтой. Гэвч ингэхдээ хуулийн этгээд нь зайлшгүй хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар удирдах байгууллага бий болсон буюу эрх зүйн чадамжтай болсон үеэс үйл ажиллагаа явуулах боломжтой.¹⁵ Харин хуулийн этгээдийн төрлүүдийг Иргэний хуульд тусгайлан заагаагүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийг л ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж хуваахаас илүү байгууллагыг бүхэлд нь ашгийн төлөө болон ашгийн бус үйл ажиллагаа явуулж буйгаар ангилан авч үзэх боломжтой байна. Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй байгууллагыг хуулийн этгээд (нийтийн компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани) болон нөхөрлөл (хязгаарлагдмал нөхөрлөл, энгийн нөхөрлөл, хувиараа аж ахуй эрхлэгч) гэж хуваах боломжтой. Эдгээрийг дэлгэрүүлбэл:

- a. **Хувиараа аж ахуй эрхлэгч (Einfache Gesellschaft)**- жилд 100,000 CHF (швед франк)-ийн орлого олдог бол хувиараа аж ахуйн эрхлэгч нь арилжааны бүртгэлд бүртгүүлсэн байх шаардлагатай. Энэ нь хуулийн этгээд биш бөгөөд татвар төлөх үүрэгтэй байна. Жижиг аж ахуй эрхлэгчид энэ хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь элбэг юм.
- b. **Энгийн нөхөрлөл (Kollektivgesellschaft KG)**- ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах энгийн нөхөрлөлийг байгуулахын тулд 2 ба түүнээс дээш иргэн (хувь хүн) нэгдлийн гэрээ байгуулна. Энгийн нөхөрлөл нь худалдааны нэртэй бөгөөд арилжааны бүртгэлд бүртгүүлсэн байна. Хэдийгээр хууль зүйн хувьд эрх эдэлж, үүрэг хүлээж, шүүхэд хариуцагч байх боломжтой хэдий ч энэхүү нөхөрлөл нь хуулийн этгээд биш юм.
- c. **Хязгаарлагдмал нөхөрлөл (Kommanditgesellschaft)**- энэхүү нөхөрлөл нь хоёр төрлийн партнертай байна. Нэг нь ямар нэг хязгаарлалтгүйгээр хариуцлага хүлээх бол нөгөөх нь өөрийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээх юм. Эхний төрлийн партнер нь гагцхүү хувь хүн байх бол хоёр дахь нь хуулийн этгээд болон бусад корпораци байх боломжтой

12 Корпорация.

13 Учреждения.

14 Мөн тэнд.

15 Швейцар улсын Иргэний хууль, 54 дугаар зүйл.

юм. Хязгаарлагдмал нөхөрлөл нь энгийн нөхөрлөлтэй ижил эрх, үүрэгтэй байна.

- d. **Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Gesellschaft mit beschränkter Haftung, GmbH)**- хуулийн этгээд бөгөөд хөрөнгийн хамгийн бага хэмжээ 20,000 CHF байна. Партнер (хувь хүн эсхүл компани) нь дор хаяж 100 CHF оруулсан байх шаардлагатай бөгөөд арилжааны бүртгэлд нэр, хаягаа бүртгүүлнэ. Компанийг удирдах, төлөөлөх этгээд нь заавал партнерууд байхыг шаардахгүй ч аль нэг нь Швейцар улсын оршин суугч байхыг шаарддаг байна.
- e. **Нийтийн компани (Aktiengesellschaft, AG)**- Швейцар улсад хамгийн түгээмэл байдал компанийн хэлбэр байна. Хөрөнгийн хамгийн бага хэмжээ 100,000 CHF байна. Хамгийн уян хатан зохион байгуулалтын хэлбэр гэж тооцогддог тул гадаадын хөрөнгө оруулагчид илүү сонирхдог. Нийтийн компанийг байгуулахын тулд нэг хувь хүн эсхүл компани үүсгэн байгуулагч байх шаардлагатай. Хувь эзэмшигчдээс бусад этгээд компанийг төлөөлөх боломжтой бөгөөд удирдлага дахь бүрэлдэхүүн дор хаяж нэг Швейцар улсын оршин суугч байх шаардлагатай.¹⁶

Швейцар улсын хууль тогтоомжид “ашгийн бус” гэдгийг нарийвчлан тодорхойлоогүй боловч бизнесийн үйл ажиллагаа нь ашгийн төлөө бус зорилгод нийцэхгүй гэдгийг тэмдэглэдэг байна. Ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдэд холбоо, сан хамаардаг байна.

Зарим хувь эзэмшдэг компани, хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой. Ингэхийн тулд тэдгээр нь үүсгэн байгуулах баримт бичигтээ гишүүддээ ашиг хуваарилахгүй талаараа тусгасан байх шаардлагатай байдаг. Харин ашгийн бус хуулийн этгээд татварын хөнгөлөлт эдлэхийн тулд тухайн хуулийн этгээд нийтийн ашиг сонирхлын төлөө “золиос” гаргасан байх хэрэгтэй бөгөөд удирдах байгууллагын гишүүд зөвхөн зардлаа нөхөх эрхтэй боловч ажил үүргээ гүйцэтгэснийхээ дагуу цалин хөлс авахыг хориглодог байна.

Герман, Нордикийн хуулийг хэрэгжүүлдэг олон оронд (жишээлбэл, Герман, Швед, Финланд) ашгийн төлөө бус байгууллагууд ихэвчлэн сайн дурын холбоо байдаг боловч зарим нь корпорацийн бүтэцтэй байдаг (жишээлбэл, орон сууцны корпорациуд). Сайн дурын холбоо нь ихэвчлэн нэг хүн нэг саналын зарчмаар байгуулагддаг. Том хэмжээний, үндэсний хэмжээний байгууллагыг ихэвчлэн эвлэл (league) хэлбэрээр зохион байгуулдаг: орон нутгийн төв нь хотын эсвэл мужийн түвшний, хувь хүний гишүүнчлэлтэй холбоо байдаг бөгөөд эдгээр холбоо нь үндэсний холбооны гишүүд юм. Энэ нь орон нутгийн түвшний бие даасан байдлыг хангахын тулд ерөнхий корпорацийг аливаа нэг холбооны хууль ёсны болон санхүүгийн алдаанаас хамгаалсаар байгаа юм. Ийм эвлэлүүдийн (league) зохион байгуулалт (жишээлбэл, үйлдвэрчний эвлэл эсвэл нам) нарийн төвөгтэй байж болно. Ердийн, “идеалист” холбоод (спортын клубээс эхлээд үйлдвэрчний эвлэл хүртэл), улс төрийн намууд, шашны урсгалуудыг зохицуулдаг тусдаа хууль байдаг бөгөөд байгууллагын төрөл тус бүрийг сонгосон салбараар нь хязгаарладаг.

16 Nicola Gianoli: Setting up a company in Switzerland different types of companies, Холбоо: https://www.legalmondo.com/2016/09/setting-company-switzerland-different-types-companies/?fbclid=I-wAR22uH1WQE92S3u3xQVI6EgL-hbgjdggZGp_mJKntfLgzkrErcD4ZYONvY

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АНГЛИ-АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛ

2.1. Америкийн Нэгдсэн Улс

2.1.1. Корпорацын ангилал

Англи-америкийн эрх зүйн бүлийн улс орнуудад хуулийн этгээдийг эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудтай харьцуулахад өөрөөр ангилсан байдаг. Хуулийн этгээд (legal entity)-ийн оронд корпорац (corporation) эсвэл байгууллага (organization) гэсэн нэр томьёог өргөн ашигладаг байна.

АНУ-д корпорацыг дотор нь:

- 1/ нийтийн (public);
- 2/ холимог (quasi-public);
- 3/ ашгийн төлөө (business);
- 4/ ашгийн бус (non-profit) гэж дөрөв хуваадаг.¹⁷

Д.Речман, М.Мексон, К.Боуви, Д.Тилл нэртэй АНУ-ын эрдэмтэд хуулийн этгээд (корпорац)-ийн өөр ангиллыг боловсруулжээ. Эдгээрт: *1/төрийн корпорац* (холбооны болон муж улсын засгийн газраас тодорхой зорилгоор байгуулсан компаниуд) *2/төрийн холимог корпорац* (бүх нийтийн үйлчилгээ үзүүлж буй монополь эрхтэй ашгийн төлөө аж ахуйн нэгжүүд) *3/ашгийн төлөө болон ашгийн бус гэж хуваагдах хувийн корпорац* орох юм.¹⁸

АНУ-ын корпорацын төрлүүдийг доор дэлгэрүүлэн авч үзье.¹⁹

a. Нийтийн (public)

Нийтийн корпорац төрийн болон орон нутгийн нэгж (хот, тойрог, тосгон) хамаардаг байна. Эдгээр нь төрийн нэгдсэн аппаратын нэг хэсэг болдог бөгөөд төрийн эрх мэдлийн тодорхой эрхийг тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлдэг. Эх газрын эрх зүйн бүлийн орнуудад энэ төрлийн байгууллагыг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллагад хамааруулах бөгөөд корпорацд хамааруулдаггүй байна.

b. Холимог (quasi-public)

Холимог корпорац гэж хүн амын нийтлэг хэрэгцээг хангахад үйлчилдэг байгууллагыг ойлгодог байна. Тухайлбал, хий, ус, цахилгаан хангах, зам тээвэр, төмөр зам зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж буй корпорацыг ойлгож болно. Энэ нөхцөлд корпорац гэдэг нэр томьёогоор татвар төлөгчдийн мөнгөөр үйл ажиллагаа явуулах хүн амын нийтлэг хэрэгцээг хангах чиг үүрэгтэй байгууллагыг илэрхийлэх юм. Эдгээрээс гадна холимог корпорацд төрийн өмчит эсхүл хувьцааг нь төр эзэмших аж ахуйн нэгж хамаардаг.

Үүнээс бусад бүх хуулийн этгээд хувийн корпорац гэдэгт хамаарна. Хувийн корпорацыг харин дотор нь аж ахуйн болон аж ахуйн бус гэж хуваах боломжтой юм.

17 Сабирова Л.Л., "Теоретические и правовые основы юридических лиц в российском и зарубежном праве", Вестник экономики, права и социологии, №2 (2014), стр.143.

18 Речман Д., Мексон М., Боуви К., Тилл Д., Современный бизнес, Т.1, М, 1995, стр.82.

19 Кашашина Т.В., Корпоративное право. Право хозяйственных товариществ и обществ. М, 1999, стр.131-132.

с. Аж ахуйн (ашгийн төлөө)

Аж ахуйн корпорацыг ашиг олох зорилгоор байгуулдаг байна. Энэ төрлийн хуулийн этгээд нь эдийн засгийн хөгжилд хамгийн том байр суурийг эзэлдэг бөгөөд улс төрийн нөлөөлөл ч өндөр байдаг. Харин хууль, эрх зүйн хувьд аж ахуйн корпорацын зохицуулалт ээдрээтэй байна. Аж ахуйн корпорацууд үйлдвэрлэл, зам тээвэр, худалдаа болон аж ахуйн бусад салбарт үйл ажиллагаагаа явуулдаг. Мөн тусгайлсан эрх зүйн зохицуулалттай банк, даатгалын компаниуд зэрэг ордог байна.

Эдгээр корпорацуудыг өмчийнх нь хэлбэрээр хуваах тохиолдолд эх газрын эрх зүйн бүлийн орнуудын хувьцаат компаниудтай төстэй юм. Харин нөхөрлөл Их британи болон АНУ-д хуулийн этгээдийн эрхгүй байдаг. Уламжлалт ёсоор нөхөрлөл нь хувь хүмүүсийн нэгдэл бөгөөд тэдгээрээс тусдаа хуулийн этгээд болдоггүй байна. Харин орчин үед нөхөрлөлүүд нь де-факто хуулийн этгээд байгаа ч бүрэн хуулийн этгээдийн эрх зүйн чадавхтай гэж үзэхэд бэрхшээлтэй юм. Энэ нь эрх зүйн бүл хооронд конвергенц явагдаж байгааг илэрхийлж байна. Ийнхүү аж ахуйн корпорацуудыг хувьцаат компанитай жишиж ойлгох боломжтой хэдий ч хэт явцуу ойлгогдох бөгөөд эх газрын эрх зүйн бүлд эдгээр байгууллагыг өөрөөр зохицуулдаг ажээ.

d. Аж ахуйн бус

Аж ахуйн бус корпорацад шашны байгууллага, боловсролын байгууллага (сургууль, их сургууль г.м.), сайн үйлсийн сангууд хамаарна. Эдгээр нь ашиг олох зорилгогүй бөгөөд ашиг олсон тохиолдолд гагцхүү үүсгэн байгуулагдах үндэс болсон зорилгоо хэрэгжүүлэхэд л ашигладаг байна.

Үүнээс харахад, корпорацыг ангилал шалгуур нь үндсэн 4 байх бөгөөд хууль зүйн бус буюу *албан бус ангилал* олон байдаг байна. Тэдгээрийг дараагийн хэсэгт дэлгэрүүлэн авч үзье.

2.1.2. Ашгийн төлөө, ашгийн бус, ашгийн төлөө бус байгууллагуудын ялгаа

а) Ашгийн төлөө (for profit) ба ашгийн бус (nonprofit) байгууллагын ялгаа

Ашгийн бус байгууллагуудын (nonprofit) үндсэн зорилго нь үйл ажиллагаанаасаа орлого олох бус нийгэмд тусламж үзүүлэх, хөгжүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулахад чиглэгдсэн бөгөөд татвар төлөх шаардлагагүй байдаг бол ашгийн төлөө байгууллагууд нь эдийн засаг, мөнгөний үр өгөөжийг шууд хүртэх үндсэн зорилготой байгуулагдсан байгууллагууд юм.²⁰

Ашгийн бус байгууллагуудын (nonprofit) хувьд нэгдүгээрт нийгэм, дараа нь хувийн сэдэл байдаг. Ашгийн төлөөх байгууллагууд бол эсрэгээрээ тул уг хоёр байгууллага ашиг олох зорилгоос гадна хамрах хүрээний хувьд өөр өөр байна.²¹

20 Ashih Kumar Srivastav: Nonprofit vs For Profit Organizations, <https://www.wallstreetmojo.com/for-profit-vs-nonprofit-organizations/>, Last visited: 2022.01.24.

21 Мөн тэнд.

Сүүлийн хэдэн арван жилд дэлхийн бараг бүх улс оронд ашгийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, нөлөөлөл асар хурдацтай өссөн. Ашгийн бус байгууллагуудын идэвхжил нэмэгдэж байгаа нь нэг талаараа ардчиллын үр дүнд аяндаа гарч буй үзэгдэл буюу нийгмийн үйл ажиллагаа, идэвхжил, иргэний оролцооны өсөлт билээ. Ийнхүү ашгийн бус салбарын бодлого боловсруулах, эдийн засгийн амьдралд гүйцэтгэх үүрэг нь нэмэгдэж байгаа ч улс орон бүрийн салбар хоорондын түүхэн үндсэн ялгаа их байдаг тул уг өсөлт нь тухайн салбарын өнгөрсөн үеийн хувьслын нөлөөнөөс хамааран улс орон бүрд харилцан адилгүй байна. Иймд тухайн улсын хувьд ашгийн бус салбарын тоонд аль байгууллагыг оруулахыг шийдэх нь өөрөө таавар юм.²²

Ашгийн бус байгууллагуудын орлогын эх үүсвэр нь гишүүнчлэлийн татвар, хандив гэх зэрэг байдаг. Ашгийн төлөөх байгууллагуудын орлогын эх үүсвэр нь бараа, үйлчилгээ борлуулах явдал юм. Ашгийн бус байгууллагуудын үндсэн хөрөнгө засгийн газрын буцалтгүй тусламж, өндөр орлоготой хүмүүсийн хандив гэх мэтээс бүрддэг бол ашгийн төлөө байгууллагуудын үндсэн хөрөнгийг ихэвчлэн түншүүд эсвэл бизнесийн эзэд хангадаг.²³

Татварын хувьд ашгийн төлөө байгууллагууд өөрийн тусын тулд өөртөө ашиг олдог тул төрд татвар төлөх ёстой. Харин ашгийн бус байгууллагууд бүхэлдээ нийгэмд туслан ашиг олдог учраас аливаа татвараас чөлөөлөгддөг давуу талтай.

Энэ хоёр төрлийн байгууллагын соёл ч бас ондоо байдаг. Ашиг орлого олж буй байгууллагуудын хувьд соёл нь эцсийн хугацаа, үйлчлүүлэгчдэд зориулж ажлаа аль болох хурдан гүйцэтгэх, тухайн нөхцөлд тохирсон өөр өөр арга барилыг дагаж мөрдөх явдал юм. Ашгийн бус байгууллагуудын хувьд байгууллагын соёл нь гишүүдийн оруулсан хувь нэмрийг үнэлдэг бөгөөд гишүүн бүр өдөр тутмын ажлын хуваариас гадна хэр их хувь нэмэр оруулж чадахыг үнэлдэг.

Ашгийн төлөө байгууллагуудын хувьд хамгийн боломжит худалдан авагчдад чиглэдэг бол ашгийн бус байгууллагууд илүү өргөн ойлголттой буюу ихэнх тохиолдолд хүмүүс сайн дураараа нэгдэх, хувь нэмэр оруулах, гишүүн болох боломжтой.²⁴

Хүснэгт 1.1. Ашгийн төлөө болон ашгийн бус байгууллагын ялгаа

Суурь харьцуулалт	Ашгийн төлөө байгууллага	Ашгийн бус байгууллага
Зорилго	Хувийн хэрэгцээг хангахын тулд ашиг олох.	Нийгэмд үйлчлэхийн тулд ашиг олох.
Байгууллагын төрөл	Байгууллага нь компани, нөхөрлөлийн байгууллага эсвэл хувиараа бизнес эрхэлдэг фирм байж болно.	Ашгийн бус байгууллагууд нь клуб, итгэлцэл, нийгэмлэг гэх мэт.
Удирдлага	Бизнес эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчид эсвэл түншүүд.	Итгэмжлэгдсэн төлөөлөгч, удирдах байгууллага эсвэл хорооны гишүүд.

22 John Casey, "Comparing Nonprofit Sectors Around the World: What Do We Know and How Do We Know It?" Journal of Nonprofit Education and Leadership, Vol. 6, No. 3 (2016), p.187-223.

23 Ashih Kumar Srivastav: Nonprofit vs For Profit Organizations, <https://www.wallstreetmojo.com/for-profit-vs-nonprofit-organizations/> (Last visited: 2022.01.24).

24 Мөн тэнд.

Орлогын эх үүсвэр	Энэ төрлийн байгууллагын орлогын эх үүсвэр нь бараа, үйлчилгээг борлуулах явдал юм.	Энэ төрлийн байгууллагын орлогын эх үүсвэр нь хандив, тусламж гэх мэт.
Үндсэн хөрөнгийн зохион байгуулалт	Энэ төрлийн байгууллагын хувьд үндсэн хөрөнгийг бизнес эрхлэгчид эсвэл компанийн үүсгэн байгуулагчид зохион байгуулдаг.	Ашгийн бус байгууллагын хувьд үндсэн хөрөнгийг засгийн газрын буцалтгүй тусламж авах, хандив гуйх гэх мэт хэлбэрээр зохион байгуулдаг.
Санхүүгийн тайлан/ данс	Ашгийн төлөө байгууллага, хөрөнгө орлогын мэдүүлэг, мөнгөн гүйлгээний тайлан, тайлан тэнцэл гаргана.	Ашгийн бус байгууллагын хувьд орлого, төлбөрийн данс, орлого, зарлагын данс, балансыг бэлтгэдэг.
Орлогын данс	Капитал данс.	Хөрөнгийн сангийн данс.

б) Ашгийн бус (non-profit) болон ашгийн төлөө бус (not-for-profit) байгууллагын ялгаа

Ашгийн бус (nonprofit) байгууллагын нэгэн адил ашгийн төлөө бус байгууллага (not-for-profit) нь өөрт ашиг орлого олдоггүй байгууллага юм. Бизнесийн үйл ажиллагаа явуулах эсвэл хандив тусламжаар олсон бүх мөнгө тухайн байгууллагын үйл ажиллагааг явуулахад шууд зарцуулагддаг.

Гэсэн хэдий ч ашгийн төлөө бус (not-for-profit) байгууллагууд нийтийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах шаардлагагүй. Ашгийн төлөө бус байгууллага нь гишүүдийнхээ зорилгыг биелүүлэхэд л чиглэдэг. Үүний нэг жишээ бол спортын клуб юм; Клубийн зорилго нь гишүүдийнхээ хүсэлд нийцүүлэн оршин тогтнох явдал юм. Эдгээр байгууллагууд Дотоод орлогын алба (IRS)-аас татвараас чөлөөлөгдөх статус, түүний дотор борлуулалтын татвар, үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөгдөх хүсэлт гаргах ёстой. Энэ нь мөн хувь хүний ашгийн төлөө бус байгууллагад хандивласан мөнгийг тухайн хүний татварын тайлангаас хасч болохгүй гэсэн үг юм.²⁵

Ашгийн төлөө бус (not-for-profit) болон ашгийн бус (nonprofit) байгууллагууд нь ижил төстэй боловч тодорхой шалгуур үзүүлэлтийн хувьд ялгаатай байдаг.²⁶

Хүснэгт 1.2. Ашгийн төлөө бус болон ашгийн төлөө бус байгууллагын ялгаа

	Ашгийн төлөө бус (not-for-profit)	Ашгийн бус (nonprofit)
Байгууллагын зорилго	Аливаа үйл ажиллагаа эсвэл олон нийтийг дэмждэг	Буяны, боловсролын эсвэл шашны зорилгыг дэмждэг
Ашиг, орлогын хэрэглээ	Тэдний зорилготой холбоотой үйл ажиллагаа, хобби, зугаа цэнгэлийг санхүүжүүлдэг	Ашиг нь байгууллагын зорилгод зориулагдах боловч ажилчдын цалин, захиргааны хэрэгцээг хангахад ашиглаж болно.
Ажилчид	Сайн дурын ажилтнууд, цалинтай ажилтнууд эсвэл холимог	Цалинтай ажилчид болон цалинтай сайн дурын ажилтнуудтай байж болно
Татвараас чөлөөлөгдөх боломжтой	Тийм (улсын болон холбооны түвшинд байх ёстой)	

25 Emily Heaslip: Nonprofit vs. Not-for-Profit vs. For-Profit: What's the Difference, Холбоос: <https://www.uschamber.com/co/start/strategy/nonprofit-vs-not-for-profit-vs-for-profit>, Last visited: 2022.01.24.

26 Michele Bossart: What Is a Not-for-profit Organization, Холбоос: <https://www.patriotsoftware.com/blog/accounting/what-is-a-not-for-profit-organization/>, Last visited: 2022.01.24.

Мөн ашгийн бус байгууллага нь хуулийн этгээд байж болох бол ашгийн төлөө бус байгууллага нь хуулийн этгээд байж чадахгүй. Ашгийн бус байгууллагууд бизнес шиг ажиллаж, ашиг олохыг хичээдэг ч энэ нь гишүүдээ дэмжихийн төлөө бус байна. Харин ашгийн төлөө бус байгууллагууд нь орлого олох зэрэг бизнесийн зорилготой ажилладаггүй “амралт зугаалгын байгууллага” гэж үздэг.

АНУ-д ашгийн бус байгууллагуудад Дотоод орлогын албанаас 501(с)(3) статус олгодог. Ашгийн төлөө бус байгууллага (not-for-profit) нь мөн Дотоод орлогын албаны татварын хуулийн 501(с) хэсгээр зохицуулагддаг боловч зорилгоосоо хамааран тэдгээр нь 501(с)(7) дахь хэсэг гэх мэт өөр хэсэгт багтаж болно.

Татвараас чөлөөлөгдөх байдал

Ихэнх улс оронд ашгийн бус байгууллагууд татвараас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж болох бөгөөд ингэснээр санхүүгийн хандивлагчид хандивын орлогын албан татвараа буцааж нэхэмжлэх замаар байгууллага өөрөө орлогын албан татвараас чөлөөлөгдөх боломжтой юм. АНУ-д, улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээд байгуулагдсаны дараа ашгийн төлөө бус корпорацын хувьд орлогын албан татвартай холбоотой татвараас чөлөөлөгдөх статусыг эрэлхийлэх явдал болжээ. Үүнийг дотоод орлогын албанд өргөдөл гаргах замаар хийдэг. Дотоод орлогын алба (IRS) нь тухайн татвараас чөлөөлөгдсөн байгууллагын зорилго нь (буяны үйл ажиллагаа гэх мэт) хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлд нийцэж буй эсэхийг шалган өргөдлийг хянан үзсэний дараа ашгийн бус байгууллагад орлогын албан татварын зорилгоор татвараас чөлөөлөгдсөн статус олгох зөвшөөрлийн бичгийг гаргана. Энэхүү чөлөөлөлт нь Холбооны бусад татваруудад хамаарахгүй.

с) Байгууллагын хэлбэрээ өөрчлөх

Зарим бизнесүүд нэг байгууллагын төрлөөр байгуулагдаж, дараа нь өөр хэлбэрт шилжихээр шийддэг. АНУ-ын хуулийн хүрээнд энэ нь боломжтой боловч холбогдох байгууллагуудын төрлөөс хамааран бага зэрэг төвөгтэй байдаг.

Ашгийн бус байгууллагаас ашгийн төлөө бус руу шилжих

Практикт ашгийн бус байгууллагаас ашгийн төлөө ажиллахыг хүсэж, шилжүүлж болох юм. Үүний тулд хувьцаа эзэмшигчид санал нэг байгаа бол Дотоод орлогын алба (IRS)-д хуульд заасан баримт бичиг, мэдэгдлийг бүрдүүлэн мэдэгдэх шаардлагатай байдаг байна.

Ашгийн төлөөхөөс ашгийн бус руу шилжих

Дотоодын орлогын алба нь татвар төлөхөөс зайлсхийхийн тулд бизнес эрхлэгчдийг ийм алхам хийхээс сэргийлэн ашгийн төлөөх байгууллагыг ашгийн бус байгууллага болгон хувиргах нь арай илүү хэцүү байдаг. Гэхдээ үүнийг ашгийн бус байгууллагыг эхнээс нь эхлүүлэхээс огт өөр үйл явцаар дамжуулан хийж болдог.

Энэхүү шилжилт нь мэдэгдэл бичих, хуулийн дагуу төрийн нарийн бичгийн даргадаа үүсгэн байгуулах тухай бичиг зэрэг баримт бүрдүүлэх гэх мэтчилэн зүйлс орно. Байгууллагын дүрмийн дагуу ашгийн төлөөх байгууллагатайгаа ижил нэртэйгээр Төрийн нарийн бичгийн даргад мэдэгддэг.

d) Ашгийн бус байгууллагыг татан буулгахтай холбоотой асуудал²⁷

Байгууллагын дүрэмд татан буулгах тухай заалт байх бөгөөд үүнийг зохион байгуулах үед тогтоож Дотоод орлогын албаны 501(с)(3) статустай болгохыг шаарддаг. Урьдчилан тогтоосон журмын дагуу удирдах зөвлөл болон ажилтнууд татан буулгах тухай мэдэгдэл гаргаж, алхмууд болон цаг хугацааны хуваарийг тодорхойлсон татан буулгах төлөвлөгөө гаргадаг.

Хууль эрх зүйн арга хэмжээ

Хэрэв сайн дураараа татан буугдаж байгаа бол ТУЗ-ийн санал хураалтаар, эсвэл гишүүнчлэлд суурилсан ашгийн бус байгууллага бол ТУЗ-ийн саналаар, гишүүдийн саналаар татан буугдаж болно.

Ашгийн бус корпорац нь татан буугдсан тухайгаа төрийн нарийн бичгийн даргадаа хүргүүлдэг. Улс орнууд ихэвчлэн эдгээр тохиолдлуудад зааварчилгаа өгдөг. Албадан хаагдсан тохиолдолд ашгийн бус байгууллагыг үүсгэн байгуулсан муж улсын төрийн нарийн бичгийн дарга эсвэл ерөнхий прокурор татан буулгах ажлыг эхлүүлнэ.

Ашгийн бус байгууллагын удирдах зөвлөл нь шийдвэрээ гацаанд оруулсан эсвэл тухайн байгууллага хэсэг хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй бол албадан хаах шийдвэр гаргахыг шүүхэд гаргаж болно.

Санхүүгийн үйл ажиллагаа

Татан буулгах шийдвэр гарсны дараа ашгийн бус байгууллага үйл ажиллагаагаа зогсоохоос бусад тохиолдолд бизнес эрхлэхээ зогсоох ёстой.

Үлдсэн хөрөнгийг өр төлбөрийг төлөхөд ашиглах ёстой. Хэрэв өрийг төлсний дараа хөрөнгө хэвээр байвал ашгийн бус байгууллага (хэрэв энэ нь 501(с)(3) бол) тэдгээрийг өөр 501(с)(3) байгууллага эсвэл засгийн газарт хуваарилах ёстой.

Буяны ашгийн бус байгууллагын хөрөнгийг зөвхөн чөлөөлөгдөх зорилгоор ашиглаж болно. Энэ нь хөрөнгө нь ажилтнууд эсвэл ТУЗ-ийн гишүүдэд очихгүй гэсэн үг юм. Хөрөнгө хуваарилахдаа тухайн байгууллага бусад буяны байгууллага эсвэл хөрөнгийг хүлээн авах чөлөөлөгдсөн байгууллагуудад хуваарилахыг шаарддаг. Эдгээр бүх мэдээллийг Дотоод орлогын алба (IRS)-д тайлагнах бөгөөд үүнд хөрөнгийн жагсаалт, тэдгээрийн үнэ цэнэ, тэдгээрийг шилжүүлэх эрх чөлөөлөгдсөн аж ахуйн нэгжийн нэрс багтсан болно.

Татан буугдсан ашгийн бус байгууллага хуулийн дагуу үлдсэн бүх хөрөнгөө татвараас чөлөөлөгдсөн нийтийн буяны зориулалт бүхий өөр байгууллагад “501(с)(3)” эсвэл холбооны/муж/овгийн/орон нутгийн засаг захиргаанд шилжүүлэх үүрэгтэй. Энэ нь татан буулгах явцад таны ашгийн бус байгууллага хувь хүмүүст, тэр дундаа ТУЗ-ийн гишүүд, бусад сайн дурын ажилтнууд, ажилчид болон үйлчлүүлсэн хүмүүст өмч хөрөнгөө өгөх боломжгүй гэсэн үг юм. Харин ашгийн бус байгууллага нь тухайн хөрөнгийг худалдан авч буй хувь хүн эсвэл аж ахуйн нэгж боломжийн хэмжээний, “зах зээлийн үнийг” төлж байгаа тохиолдолд хөрөнгөө зарж болно.²⁸

27 Joanne Fritz: How to Close Your Nonprofit Organization, <https://www.thebalancesmb.com/how-do-you-shut-down-a-nonprofit-2501889>, Last visited: 2022.01.24.

28 Dissolving a Nonprofit Corporation, Холбооц: <https://www.councilofnonprofits.org/tools-resources/dissolving-nonprofit-corporation>, Last visited: 2022.01.24.

2.2. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс²⁹

Англи улсад байгууллагуудыг өмчлөлийн төрлөөр нь дараах байдлаар ангилсан байх ба эдгээр өмчлөлийн хэлбэрийн ангиллууд нь эдийн засгийн салбарыг бүрдүүлдэг байна.

а. Хувийн салбар

Энэ нь ашгийн төлөө ажилладаг хувийн хэвшлийн байгууллагууд бөгөөд хувь хүний өмч юм. Хувийн хэвшлийн байгууллагуудаас олох ашиг нь эзэмшигчид, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад хуваарилагддаг ба хувьцаа эзэмшигчдийн хувийн мөнгө, банкны зээлээр санхүүждэг.

Хувийн хэвшлийн хамгийн түгээмэл хэлбэр нь:

- хувиараа худалдаачин (sole trader)
- түншлэл (partnership)
- хувийн хязгаарлагдмал компани (private limited company) байна.

б. Нийтийн салбар

Нийтийн салбар нь төрийн өмчийнх бөгөөд засгийн газар удирддаг ба олон нийтийн ашиг тусын тулд бараа, үйлчилгээ үзүүлдэг. Энэ төрлийн байгууллагууд нь татвараас цуглуулсан мөнгөөр үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр байгууллагад төлөх мөнгийг төрөл бүрийн татвараар цуглуулдаг. Жишээ нь:

- Орлогын татвар
- Үндэсний даатгал
- НӨАТ
- Агаарын зорчигчийн үүрэг
- Түлшний татвар

с) Гуравдагч салбар

Гуравдагч салбарын байгууллагуудыг итгэмжлэгдсэн төлөөлөгч сайн дураараа эзэмшиж, удирддаг. Эдгээр байгууллагыг ашиг олох зорилгоор биш, харин олон нийтэд туслах хэрэгцээ шаардлагаар удирддаг ба нийгэмд өөрчлөлт оруулах зорилготой. Мөн хандив, бэлэглэлийн мөнгөөр үйл ажиллагаагаа явуулдаг ба аливаа орлого ашиг зөвхөн тухайн байгууллагын хөрөнгө оруулалт болдог. Гуравдагч салбарын байгууллагууд нь нийгмийн аж ахуйн нэгж (social enterprise) байх ба 1/буяны болон олон нийтийн бүлгүүд, 2/нийгмийн аж ахуйн нэгжүүд хэмээн ангилдаг.

29 Types of business organisations, Холбооц: <https://www.bbc.co.uk/bitesize/guides/zpx7gdm/revision/1>, Last visited: 2022.01.24.

ДҮГНЭЛТ

Хуулийн этгээдийг ангилан төрөлжүүлэх нь эрх зүйн бүлээс хамааран өөр өөр байхаас гадна тухайн улс орны онцлог, нийгэм, эдийн засаг, эрх зүйн уламжлал, түүхэн хөгжлөөс хамааран харилцан адилгүй ангилдаг ба судлах явцад нэр томьёоны хувьд ч ихэд ялгаатай тул олон улсын хувьд нэгдсэн дүгнэлтэд хүрэхэд хүндрэлтэй байв.

Энэхүү ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй холбоотой лавлагааг гүйцэтгэхэд тавьсан зорилтын дагуу эх газрын болоод Англи-Америкийн эрх зүйн бүл дэх онцлог, ялгааг ерөнхий байдлаар судлан хүргэлээ. Нэр томьёоны асуудлыг үл харгалзан улс орон бүрт хийгээд судлаачид хуулийн этгээд, байгууллагуудыг (өргөн хүрээнд) ашгийн төлөө болон ашгийн бус байгууллагыг олон янзаар хувааж байна.

Эх газрын эрх зүйн бүлийн орнуудад хуулийн этгээдийг зорилгоор нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж хувааж байх бөгөөд хуулийн этгээдийн эрхгүй бусад байгууллагыг ч энэ шалгуураар ангилах боломжтой юм. Эх газрын эрх зүйн бүлийн орнуудад хуулийн этгээдийг ангилах хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий шалгуур нь нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд байна. Харин хуулийн этгээд бус байгууллагын хэмжээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа болон аж ахуйн шинжгүй гэж хуваах боломжтой юм.

Англи-Америкийн эрх зүйн бүлийн орнууд хуулийн этгээдийн оронд корпорац гэсэн нэр томьёог өргөн хэрэглэдэг бөгөөд үүнийг нийтийн, холимог, ашгийн, ашгийн бус (ашгийн төлөө бус, ашгийн бус) хэмээн ангилдаг байна.

НОМ ЗҮЙ

МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль.
2. Иргэний хууль.
3. (1994) Монгол Улсын Иргэний хууль.

Ном, сурах бичиг

1. Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, УБ, 1996.
2. Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн удиртгал, Ерөнхий анги*, гурав дахь хэвлэл, УБ, 2018.
3. Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл, хоёрдугаар дэвтэр*, УБ, 2004.
4. Сергеева А.П., Толстого Ю.К., *Гражданское право*, Том 1. изд.6, перераб., доп, М, 2004.
5. Кашашина Т.В., *Корпоративное право. Право хозяйственных товариществ и обществ*, М, 1999.
6. Речман Д., Мескон М., Боуви К., Тилл Д., *Современный бизнес*, Т.1, М, 1995.

Судалгааны өгүүлэл, эмхэтгэл

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, нэр томъёоны хэрэглээ*, УБ, 2021.
2. Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, *Ашгийн бус байгууллагын талаархи Монгол Улсын эрх зүйн зохицуулалт* (эрх зүйн дүн шинжилгээ), УБ, 2018.

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ

Судалгааны өгүүлэл, эмхэтгэл

1. Сабирова Л.Л., “Теоретические и правовые основы юридических лиц в российском и зарубежном праве”, *Вестник экономики, права и социологии*, №2 (2014).
2. John Casey, “Comparing Nonprofit Sectors Around the World: What Do We Know and How Do We Know It?” *Journal of Nonprofit Education and Leadership*, Vol. 6, No. 3 (2016).

Цахим мэдээлэл

1. *Nicola Gianoli: Setting up a company in Switzerland different types of companies*, https://www.legalmondo.com/2016/09/setting-company-switzerland-different-types-companies/?fbclid=IwAR22uH1WQE92S3u3xQVI6EgL-hbgjdggZGp_mJKntfLgzrkrErcD4ZYONvY
2. *Ashih Kumar Srivastav: Nonprofit vs For Profit Organizations*, <https://www.wallstreetmojo.com/for-profit-vs-nonprofit-organizations/> (Last visited: 2022.01.24)
3. *Emily Heaslip: Nonprofit vs. Not-for-Profit vs. For-Profit: What's the Difference?* <https://www.uschamber.com/co/start/strategy/nonprofit-vs-not-for-profit-vs-for-profit> (Last visited: 2022.01.24)
4. *Joanne Fritz: How to Close Your Nonprofit Organization*, <https://www.thebalancesmb.com/how-do-you-shut-down-a-nonprofit-2501889> (Last visited: 2022.01.24)
5. *Michele Bossart: What Is a Not-for-profit Organization?* <https://www.patriotsoftware.com/blog/accounting/what-is-a-not-for-profit-organization/> (Last visited: 2022.01.24)
6. *Dissolving a Nonprofit Corporation*, <https://www.councilofnonprofits.org/tools-resources/dissolving-nonprofit-corporation> (Last visited: 2022.01.24)
7. *Types of business organisations*, <https://www.bbc.co.uk/bitesize/guides/zpx7gdm/revision/1> (Last visited: 2022.01.24)

ХОЁР. ХУВЬ ХҮНИЙ ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:
ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА

Судалгааг удирдсан:

С.Сүхбаатар

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D)

Судалгааны багийн гишүүн:

Б.Энх-Амгалан

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2022.12.30.

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	29
НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ.....	32
1.1 Хувь хүний дамбуурлын эрх зүйн судлагдсан байдал	32
1.2. Хувь хүний дамбуурлын эрх зүйн хөгжлийн хандлага.....	37
ХОЁР. ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ	43
2.1 Америкийн Нэгдсэн Улс.....	43
2.2 Бүгд Найрамдах Австри Улс	45
2.3 Унгар Улс.....	46
ДҮГНЭЛТ.....	51
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	55
НОМ ЗҮЙ.....	56

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд Монголын ард түмэн ... хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, ... хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон. Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтын түгээмэл хэлбэрт олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, улс орнуудын эрх зүйн зохицуулалтын сайн туршлага зүй ёсоор багтана.

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, олон улсын эрх зүйн хөгжлийн нөлөөгөөр Монгол Улсад хүний эрхийн хамгааллын тогтолцоо сайжирч ирсэн. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

Үндсэн хуульд төрөөс эдийн засгийг зохицуулах эрх зүйн үндэс тодорхойлогдсон байдаг. Иймээс төлбөрийн чадваргүйдэл, дампуурлыг тооцохтой холбоотой харилцаанд төрийн оролцоо байх ёстой. Энэхүү оролцоо нь зөвхөн хуулийн этгээдийн хүрээнд бус хувь хүний төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг мөн орхигдуулах учиргүй.

Дампуурлын хууль нь эдийн засгийн харилцаанд зайлшгүй шаардлагатай хуулийн нэг. Тухайн хуулийн зохицуулалтын зорилго нь эдийн засгийг цэвэршүүлэх, хөгжүүлэхтэй зэрэгцэн нийгэмд үүсэх үр дагавруудыг тооцсоны үндсэн дээр сөрөг байдлыг арилгах, шаардлагатай харилцааг нөхөн сэргээх арга хэмжээ авахад оршдог.

Монгол Улсад дампуурлын харилцааг 1991 оноос эхлэн хууль тогтоомжоор зохицуулсан бөгөөд 1997 оны хууль өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх явцад практикт зарим хүндрэл гарч байгаа бөгөөд хуулийг төлбөрийн чадваргүйдлийн харилцааны олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн сайжруулах шаардлагатай талаар дотоод, гадаадын судалгааны байгууллагуудын дүгнэлт, олон улсын байгууллагын санал, зөвлөмжүүд бий.

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” 2019 оны судалгааны 10 гол үзүүлэлтээс Монгол Улс “Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх” үзүүлэлтээр хамгийн бага оноо авсан; Дэлхийн бусад улстай харьцуулахад Монгол Улсад зээл, өр төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээ хамгийн бага (16.9 хувь) байдаг ба асуудлыг шийдвэрлэхэд хамгийн их хугацаа (4 жил) зарцуулдаг; Одоогийн байдлаар төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль эрх зүйн орчны хөгжлийн түвшин нь нийт 16 онооноос 6.5 оноо авсан.¹ Энэ нь Монгол Улсад төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчны шинэчлэл хэрэгтэйг харуулж байв.²

1 Жинчанг Лай, Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчны шинэчлэл ба хөрөнгө оруулалтын орчин, 2019, Холбоос: https://www.mongolbank.mn/documents/press_conference/20191022_05.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.12.10.

2 Дэлхийн банк улс орнуудын бизнесийн орчны талаарх “Doing Business” /“Бизнес эрхлэхүй”/ тайланг гаргахаа зогсоож, цаашид бизнес, хөрөнгө оруулалтын орчныг үнэлэх шинэ арга барилыг нэвтрүүлж ажиллах болсноо мэдэгдсэн.

Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, судалгаа шинжилгээний дүгнэлтүүдийг үзэхэд, уг хууль тухайн цаг үеийн үүргээ гүйцэтгэж, хуулийн этгээдийн дампуурлын үндсэн харилцааг зохицуулж ирсэн боловч зохицуулалтыг улам боловсронгуй болгох, өргөжин тэлж буй эдийн засаг, санхүүгийн харилцааны онцлогт тохирсон өргөн хүрээтэй цогц хэм хэмжээ бүхий хууль тогтоомж болгон шинэчлэн найруулах хэрэгцээ шаардлага бий болсон; олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай гэсэн агуулгыг илэрхийлдэг.

Дээр дурдсан нөхцөл байдлуудыг харгалзан, холбогдох судалгаа хийсний үндсэн дээр Дампуурлын тухай хуулийн төслийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өнөөгийн аргачлал, стандарт, зарчмын дагуу шинэчлэн боловсруулсан. Уг хуулийн төсөлд хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг хангах, хэрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, түүнийг томилох, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалт, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан.

Түүнчлэн уг хуулийн төсөл нь төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгахаас гадна түүнийг дахин зохион байгуулж, үйл ажиллагааг нь сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулахад чиглэсэн тул хуулийн нэрийг олон улсын жишгийн дагуу “Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль” гэж өөрчилжээ. Хуулийн төсөл батлагдсанаар зах зээлийн эдийн засгийн нэг үзэгдэл болох төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг зохицуулсан олон улсын жишигт нийцсэн үр дүнтэй эрх зүйн орчин бүрдэж, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлага сайжрах, эдийн засгийг цэвэршүүлэхэд чухал ач холбогдолтой хэмээн хуулийн төслийн танилцуулгад дурдсан байна.

Үүнээс үзэхэд, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд хувь хүний дампууралтай холбогдолтой зохицуулалтыг тусгаагүй байна. Гэтэл олон улсад 1980-аад оноос эхлэн эрх зүйн хүрээнд, тухайлбал дампуурлын хуулийн үйлчлэх хүрээнд хувь хүний дампуурал гэсэн томоохон институтийг зохицуулдаг харилцаа хөгжсөөр өдий хүрчээ.

Монгол Улс 1991 онд батлан хэрэгжүүлж байсан “Ажахуйн нэгжийн дампуурлын хууль”-д тус хуулийн хариуцагчийн хүрээнд хувиараа эрхлэх аж ахуйг хамруулж, энэ нь иргэн хүн хоршоо, компани байгуулалгүйгээр үйлдвэр, үйлчилгээ эрхлэн, үйл ажиллагаанаас үүсэх үүргийг өөрийн эд хөрөнгөөр хариуцах аж ахуйн нэгж хэмээн тодорхойлсон байдаг. Харин 1997 онд Дампуурлын тухай хуулийг батлахдаа хувь хүнийн дампууралтай холбогдолтой зохицуулалтыг хассан түүхтэй.

Гэвч өнөө үед, Монгол Улсад хувь хүн хуулийн этгээдийн нэгэн адил төлбөрийн чадваргүй байдалд орж, үүнээс хамааралтай хүндрэл бэрхшээл улам их тохиолдох болсон. Үүнийг харгалзан хувь хүний дампуурлын асуудлыг улс орнууд эрх зүйгээр хэрхэн зохицуулж байгааг судлах нь зүйтэй юм. Энэхүү хэрэгцээ, шаардлагыг харгалзан Хууль зүйн үндэсний хүрээлэн “Хувь хүний дампуурлын эрх зүйн

зохицуулалт (Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага)”³ сэдвийн хүрээнд судалгаа хийхээр зорьсон.

Судалгааны зорилго. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил, олон улсын чиг хандлагыг тандан, зарим улсын туршлагыг судалж, онцлогийг тодруулах замаар Монгол Улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах ажилд дэмжлэг үзүүлэх дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилт. ХЗДХЯ-аас өгсөн чиглэлийн дагуу, тус судалгаанд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Хувь хүний дампуурлын эрх зүйн түүхэн хөгжлийг судалж, олон улсын чиг хандлагыг тандах;
2. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын онцлогийг тодруулах хүрээнд Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Австри Улс, Унгар Улсын туршлагыг тухайлан судлах;
3. Судалгааны үр дүнд, Монгол Улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах ажилд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны арга зүй. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийг тоймлож, олон улсын чиг хандлагыг тандан судлахад баримт бичгийн судалгааны арга, түүхчлэн судлах арга, харьцуулалтын арга, хууль зүйн техник, хууль тайлбарлах зэрэг судалгааны арга; хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын онцлогийг тодруулах хүрээнд баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, хууль зүйн техник, хууль тайлбарлах арга, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх аргыг ашиглаж; тодорхой дүгнэлтэд хүрч, дотоодын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж дэвшүүлэхийн тулд индукц, дедукцийн нэгдэл зэрэг логик арга зүйг энэхүү судалгаанд ашиглав.

Судалгааны хамрах хүрээ. Монгол Улсын хувьд хувь хүний дампуурлыг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодруулахад судалгаагаар дэмжлэг үзүүлэх үүднээс хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил, олон улсын чиг хандлага болон гадаад орнуудын эрх зүйн эх сурвалжийн хүрээнд уг судалгааг хийв. Ингэхдээ тус сэдвийн судлагдсан байдлыг судалсны үндсэн дээр хувь хүний дампуурлыг эрх зүйгээр зохицуулахад зайлшгүй авч үзэх шаардлагатай асуудлуудыг тодруулсан. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын онцлогийг илрүүлэх зорилтын дагуу, дэлхийн улс орнуудын зохицуулалтын үндсэн загвар болон судалгааны захиалагчийн саналыг үндэслэн Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Австри Улс болон Унгар Улсыг сонгон судалсан. Харин Монгол Улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг зохицуулах дотоодын эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн цогц хувилбар бүхий бодлогын асуудлыг энэхүү судалгаанд хамруулаагүй болно.

³ Хэдийгээр хуулийн төслийг “Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль” гэж нэрлэсэн ч өнөө хүчин төгөлдөр үйлчилж буй Дампуурлын тухай хуулийг харгалзан, түүнчлэн ХЗДХЯ-аас ирүүлсэн судалгааны ажлын захиалгад тусгасны дагуу энэхүү судалгааны сэдэвт “хувь хүний дампуурал” гэсэн нэр томъёог ашиглав.

Тулгарсан бэрхшээл. Судалгааны бусад ажлын ачааллын улмаас энэхүү судалгааг хэт богино хугацаанд гүйцэтгэсэн учир хангалттай хэмжээнд дүн шинжилгээ хийж, эцэслэн боловсруулах бололцоо хомс байсныг дурдах нь зүйтэй.

Судалгааны ажлын хүрсэн үр дүн. Хувь хүний дампуурлын эрх зүйн хөгжил, олон улсын чиг хандлагыг тандан, зарим орны туршлагад үндэслэн зохицуулалтын онцлогийг тодруулж, Монгол Улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг эрх зүйгээр зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлоход харгалзан үзэх дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулав.

НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

1.1 Хувь хүний дампуурлын эрх зүйн судлагдсан байдал

Хувь хүний дампуурлын эрх зүйн судлагдсан байдал⁴ нь түүний зохицуулалтын түүхэн хөгжлийг дараах байдлаар илтгэж байна.

Зохицуулалтын хувьд харьцуулан судалсан байдлыг авч үзвэл Efrat (2002, х. 82–87) өрийг өршөөх боломж⁵, нөхцөлүүдийг тодорхой тусгасан эсэх, шуурхай байдал буюу богино хугацаанд дампуурлын хэрэг үүсгэх боломж зэргийг үндэслэн улс орнуудыг дараах байдлаар бүлэглэжээ. Үүнд, консерватив зохицуулалттай буюу өрийг өршөөх нөхцөл заагаагүй, “шинээр эхлэх” боломжгүй; дунд зэргийн зохицуулалттай буюу өрийг хөнгөлөх нөхцөл заасан, “шинээр эхлэх” боломжтой; либерал зохицуулалттай буюу дампуурал зарласнаар, эсвэл эргэн төлөлтийн тохиролцоонд хүрмэгц “шинээр эхлэх” боломж шууд үүсдэг орнууд гэж тус тус ангилсан байна.

Ramsay (2007, 2012) хэрэглэгчийн дампуурал⁶-ыг харьцуулсан байдлаар авч үзсэн бөгөөд Европын орнуудын хууль тогтоомжид “шинээр эхлэх” гэсэн ойлголт бий болгоход АНУ-ын зохицуулалтын үзүүлсэн нөлөө зэргийг хамруулж, тус тивийн орнуудын зохицуулалтын гол шинж чанаруудыг тодорхойлсон байна. Мөн эрх зүйн институци, соёлын ялгаа, эрх зүйн гарал үүсэл болон улс төрийн ашиг сонирхол, нийгэм дэх янз бүрийн бүлгүүдийн нөлөөлөл зэргээс шалтгаалан зохицуулалтын хувьд ялгаатай байдал үүсч байгааг тайлбарлажээ.

Neuer (2014) хэрэглэгчдийн дампуурлын талаарх тогтсон тогтолцоог эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй 15 орны хүрээнд авч үзэж ангилсан. Ингэхдээ дампуурлын “нийтлэг үндэс”-ийг тодорхойлж, шинээр эхлэх боломж ба хязгаарлалт дээр тулгуурлан тухайн орны тогтолцоог тодорхойлох дөрвөн хүчин зүйл(зах зээл, хязгаарлалт, хариуцлага, өршөөлийн загвар)-ийг тодорхойлсон нь онцлог юм.

Харин Graziano нарын судалгаанд (Graziano et al. 2019) Европын 30 орны хууль тогтоомжийг хамруулж, улс бүрээс мэргэжилтнүүдийг оролцуулан, судлагдсан орнуудын ижил төстэй шинж чанар, хоорондоо ялгаатай хэмжигдэхүүн буюу хүчин зүйлс (хүртээмж, өрийн чөлөөлөлт, процесс, эрх бүхий шүүх, зээлдэгч болон зээлдүүлэгчийн статус, зардал)-д үндэслэн харьцуулт хийсэн.

4 Walter, György, and Jens Valdemar Krenchel, “The Leniency of Personal Bankruptcy Regulations in the EU Countries”, 2021, Холбоос: <https://doi.org/10.3390/risks9090162>, Сүүлд үзсэн огноо: 2022.12.10.

5 Өмнө дурдсан “хөнгөлөлтийн нөхцөл” гэсэн ойлголт, орчуулга: leniency

6 Consumer bankruptcy

Kilborn (2020) Орос болон Европ, Хойд Америкийн зарим улсын хувь хүний дампуурлын тогтолцооны харьцуулсан судалгааг гүйцэтгэсэн байна. Тус судалгаанд улс орнуудын тогтолцоо хоорондын ялгагдах хүчин зүйлс, тэдгээртэй холбогдох зардал зэргийг харьцуулан, ОХУ болон бусад судлагдсан улс орны тогтолцооны ижил төсөөтэй байдлыг тодруулжээ.

Түүнчлэн эдгээрээс гадна зөвхөн эрх зүйн талаас нь хязгаарлагдахгүйгээр авч үзсэн буюу өрийн хөнгөлөлт нь бизнес эрхлэлтэд нөлөөлж буй байдал, зээлийн зах зээлд нөлөөлөх хүчин зүйлс, хөдөлмөрийн нийлүүлэлт зэрэг асуудал мөн судлагдсан байв. Тухайлбал, Fan, White нар(2003) улсын түвшний томоохон өр чөлөөлөлтийг нийт бизнес эрхлэлтийн өсөлттэй холбон дүгнэсэн бол Lee нар (2008) бизнес эрхлэгчдэд ээлтэй дампуурлын зохицуулалт нь бизнес эрхлэлтийн хөгжлийг хэрхэн дэмжиж байгааг харуулсан судалгаа хийсэн.

Мөн Cumming, Li нар (2013) 1995-2010 оны хоорондын бизнесүүдийн эхлэл ба дампуурлыг АНУ-ын төрийн бодлогын хэд хэдэн асуудалтай холбон судалжээ. Харин Pavan (2008) өр чөлөөлөлтийн түвшин, баялгийн хуримтлал, зээлийн хатуу хязгаарлалт зэрэг асуудалд дүн шинжилгээ хийж, даатгал, зээлийн хязгаарлалтыг өөрчлөхөд үзүүлэх нөлөө нь маш бага бөгөөд илүү зөөлөн бодлого нь цэвэр баялгийг бууруулж байна хэмээн дүгнэсэн байна.

Сүүлийн үеийн судалгаанаас дурдахад, Chen нар (2020) хувь хүний дампуурлын тогтолцооны өөрчлөлтийн хөдөлмөрийн нийлүүлэлтэд үзүүлэх нөлөөг ажил олгогчийн өнцгөөс судалсан байна. Ингэхдээ, хувь хүний дампуурлын талаарх зохицуулалтад гарсан өөрчлөлт, хувь хүмүүс дампуурлын хамгаалалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлэх зэрэг нь хөдөлмөрийн зардал, компанийн бодлогод хэрхэн нөлөөлж байгаа талаар дүн шинжилгээ хийжээ.

Ду Зиен “Шэньжэний эдийн засгийн онцгой бүсийн хувь хүний дампуурлын харилцааны журам”-ыг баталснаар Хятад улсад хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоог хэрэгжүүлэх суурь тавигдсаныг онцолж, дампуурлын эрх зүйн үндсэн зарчмуудад суурилан аж ахуйн нэгжийн дампуурал ба хувь хүний дампуурлын ижил төстэй ба ялгаатай байдлыг тодорхойлон, тэдгээрийн холбоо хамаарлыг харгалзсан тогтолцоог бүрдүүлж, зөрчилдөөн үүсэхээс сэргийлэх; хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоон дахь олон талын эрх бүхий этгээдүүдийн ашиг сонирхол болон үүнтэй холбоотой харилцааг шинжлэн дүгнэсний үндсэн дээр хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх; өр барагдуулах, төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх бусад тогтолцоотой харьцуулж эдийн засгийн үнэ цэнийг нь тодорхойлох замаар хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай талаар тайлбарласан⁷ нь Хятад улсад хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоог хэрхэн чухалчилж байгаагийн нэг илрэл юм.

Харин Монгол Улсад хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтыг тухайлан судалсан эх сурвалж хомс юм. Гэхдээ дампуурлын эрх зүйн хүрээнд хийгдсэн судалгаа шинжилгээ, зөвлөлдөх ажиллагааны үр дүн нэлээд байна. Энэ чиглэлийн зарим эх сурвалжийг цуглуулж, бодлого боловсруулах ажлын хэрэгцээнд зориулж мөн лавлагаа бэлтгэв. Үүнд, магистрын зэрэг хамгаалсан ажил – 4; Ном, гарын

7 杜籽燕, “个人破产法律制度的比较研究”, 西南科技大学法学院, 区域治理, 2022, 第37期, 148-151.
<http://gfiiiz82246a9f15464d5fsoff5oxfqkfx96o6k.fcya.libproxy.ruc.edu.cn/>, Сүүлд үзсэн огноо: 2022.12.12.

авлага, судалгааны тайлан, эмхэтгэл – 10; Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл - 4 багтана.⁸ Эдгээр бүтээл Монгол Улсад дампуурлын эрх зүйг хөгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэснээрээ хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт шаардлагатай эсэхийг тандан судлах ажилд ихээхэн ач холбогдолтой.

Г.Амаржаргалан (2002), М.Алтанцэцэг (2005), Б.Мөнхчимэг (2012), Л.Энхбат (2018) зэрэг судлаач дампуурлын эрх зүйн зохицуулалт сэдвийн хүрээнд судалгаа хийж магистрын зэрэг хамгаалжээ.⁹ Тухайлбал, судлаач Г.Амаржаргалан Монгол Улсын дампуурлын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн орчинг шинжлэн судалж, цаашид боловсронгуй болгох шаардлагатай зарим асуудлыг дэвшүүлсэн. Дампуурлын эрх зүй сэдвээр, тухайлбал доктор Т.Мөнхжаргал “Аж ахуйн нэгжийн дампуурал”, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2014, 2017 онуудад “Дампуурлын эрх зүй: Гарын авлага”, Санхүү, эдийн засгийн дээд сургуулиас “Дампуурлын хэрэг гүйцэтгэгчдийн гарын авлага” сэдэвт гарын авлагыг тус тус хэвлүүлснээр дампуурлын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, шүүхийн практикийг хөндсөн эх сурвалж болжээ. Түүнчлэн бизнесийн эрх зүйн сэдэвт номын нэг бүлэг болгож, бизнесийн байгууллага, аж ахуйн нэгжийн дампуурал сэдвийг тухайлан судалсан бүтээлүүд мөн хэвлэгдсэн байна.¹⁰

Судлаач Р.Батхүү “Аж ахуйн нэгжийн реорганизаци”¹¹ өгүүлэлдээ Дампуурлын эрх зүйн нэгэн институци болох реорганизацийн үүсэл, агуулга, хэрэгжилтийг онол, практикийн үүднээс, олон улсын чиг хандлага, зарим улсын жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарлахдаа цаашид дампуурлын эрх зүйг боловсронгуй болгоход харгалзан үзэх шаардлагатай асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх боломжуудын талаар нэлээд нухацтай авч үзжээ.

Судлаач Д.Энхзул “Дампуурлын эрх зүйн зарим асуудал”¹² сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлдээ дампуурлын эрх зүйн онол, практикийг тусгаж, зарим тулгамдсан асуудлыг онцлох замаар цаашид эрх зүйн орчинг боловсронгуй болгохтой холбоотой санал дэвшүүлсэн; судлаач Н.Баярмаа “Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, онцлог: Гадаадын зарим орны туршлагаас”¹³ сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлдээ дампуурлын эрх зүйн процессыг онолын хувьд тайлбарлахаас гадна зарим орны туршлагыг харьцуулан дүгнэсэн нь мөн ихээхэн ач холбогдолтой юм.

8 Зохиогчийн нэр, бүтээлийн нэр, огноо, хэвлэгдсэн газар, цахим холбоос зэрэг мэдээлэл бүхий лавлагааг судалгааны Ном зүй хэсгээс үзнэ үү.

9 Г.Амаржаргалан, “Дампуурал, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал”, магистрын зэрэг горилсон бүтээл, Монгол Улсын Их Сургууль, 2002; Б.Мөнхчимэг, “Дампуурал, түүний эрх зүйн зохицуулалт”, магистрын зэрэг горилсон бүтээл, Орхон их сургууль, 2012; М.Алтанцэцэг, “Дампуурал, түүний эрх зүйн зохицуулалт”, магистрын зэрэг горилсон бүтээл, Их засаг их сургууль, 2005; Л.Энхбат, “Дампуурлын хэрэг үүсгэх, шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”, магистрын зэрэг горилсон бүтээл, Монгол Улсын Их Сургууль, 2018.

10 “Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай ойлголт”, Бизнесийн эрх зүй, (УБ, 2000); “Бизнесийн байгууллагын дампуурал”, Бизнесийн эрх зүй: Бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага, (УБ, 2003); “Бизнесийн байгууллагын дампуурал”, Бизнесийн эрх зүй: Хуульчдад зориулсан гарын авлага, (УБ, 2003).

11 Р.Батхүү, Аж ахуйн нэгжийн реорганизаци, Холбоос: <http://asuult.net/erkhzui/niitel/reorganization.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.12.14.

12 Д.Энхзул, “Дампуурлын эрх зүйн зарим асуудал”, Эрх зүй сэтгүүл 1(2011).

13 Н.Баярмаа, “Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, онцлог: Гадаадын зарим орны туршлагаас”, Эрх зүй ба эдийн засаг(илтгэл, шийдвэрийн эмхэтгэл, (УБ, 2018).

Түүнчлэн дотоодын эх сурвалжид Дампуурлын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэрэгцээнд зориулсан судалгааны тайлангууд томоохон байр суурь эзэлнэ. Тухайлбал:

1. ХЗДХЯ-ны захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2011 онд хийсэн “Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбоотой судалгааны ажлын тайлан”;
2. ХЗДХЯ-ны захиалгаар “Эм Ди Эс энд Хаанлекс” Өмгөөллийн нөхөрлөлийн 2016 онд хийсэн “Дампуурлын хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний тайлан”;
3. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс 2014 онд гаргасан “Дампуурлын хуулийн төсөлд тусгагдвал зохих асуудал-олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн туршлага” судалгааны тайлан;
4. Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн “Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”;
5. ХЗДХЯ-ны захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэн 2017 онд хийсэн “Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа” сэдэвт судалгаа зэрэг нь Монгол Улсын өнөөгийн эрх зүйн орчин, түүний практик болон цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг илэрхийлэх мэдээлэл лавлагаа, санал, зөвлөмж бүхий эх сурвалжид зүй ёсоор багтана.

Түүнчлэн Дампуурлын хуулийн хэрэгжилтийн үр дагаврын талаар нарийвчилсан, тодорхой мэдээлэл авах зорилгоор тодорхой салбар, чиглэлийн мэдлэг туршлага бүхий мэргэжилтнүүд, хууль хэрэгжүүлж байгаа болон хэрэглэж байгаа, мөн хуулийн хэрэгжилтэд хамаарах субъектүүд оролцсон хэлэлцүүлэг, зөвлөлдөх ажиллагаа нэлээд зохион байгуулагдсан. Тухайлбал, “Төлбөрийн чадваргүйд тооцох буюу дампуурлын эрх зүйн орчинг сайжруулах нь” сэдвийн дор зохион байгуулагдсан зөвлөгөөнд Олон улсын Санхүүгийн Корпорац, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр зэрэг байгууллагаас гадна БНСУ-ын Дээд шүүх, БНХАУ-ын Төлбөрийн чадваргүйд тооцох эрх зүйн орчныг судлах холбоо зэрэг байгууллагыг төлөөлсөн гадаад дотоодын 100 гаруй зочид төлөөлөгч оролцжээ. Тус зөвлөгөөнд 1/. “Монгол Улсад төлбөрийн чадваргүйд тооцох/ Дампуурлын эрх зүйн орчинг сайжруулах шинэчлэлийг хийх хэрэгцээ, шаардлага болон олон улсын чиг хандлага”; 2/. “Орчин үеийн төлбөрийн чадваргүйд тооцох хэлбэр/ Дампуурлын эрх зүйн орчинг хэрхэн бий болгох вэ?”; 3/. “Шүүхийн бус журмаар дампуурлын хэргийг шийдвэрлэх болон аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх нь” гэсэн 3 үндсэн сэдвийн хүрээнд гадаад, дотоодын 8 илтгэл хэлэлцүүлжээ.¹⁴

14 “Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”-ний тайлан, Холбоос: <https://forum.parliament.mn/files/148389> -аас илтгэлүүдийн талаарх мэдээллийг дэлгэрүүлж үзнэ үү, Сүүлд үзсэн огноо:2022.12.08.

“Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа сэдэвт судалгаа”¹⁵-нд Дампуурлын тухай хууль, нэн ялангуяа аж ахуйн нэгжийн дахин хөрөнгөжүүлэх асуудлыг судлан, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын зэрэгцээ БНСУ, болон ХБНГУ-ын дахин хөрөнгөжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг харьцуулан судлах замаар Монгол Улсын дахин хөрөнгөжүүлэх ажиллагаатай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмжийг боловсруулсан. Тодруулбал дахин хөрөнгөжүүлэх бодлого, зорилго, зарчим, зохицуулалтын хүрээ, үр дүнтэй тогтолцооны хувилбарыг тодорхойлж, хялбарчилсан шуурхай, зардал багатайгаар дампуурлын хэргийг хянан шийдвэрлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөл зэргийг судлах замаар Монгол Улсад нэвтрүүлэх боломж бололцоонд урьдчилсан дүн шинжилгээ хийж, тодорхой санал дэвшүүлсэн.

Гэхдээ дээр дурдсан судалгаанууд нь аж ахуйн нэгжийн дампууралтай холбоотой асуудлын хүрээнд хийгдсэн учир хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын талаар төдийлөн дурдаагүй байв.

Харин “Хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагын дампуурал”¹⁶ сэдэвт судалгаанд дампуурал, төлбөрийн чадваргүйдлийг тодорхойлж буй олон улсын болон Монгол Улсын эрх зүйн ойлголт, дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл буюу төлбөрийн чадваргүйд тооцох үзүүлэлт, дампуурлын давуу ба сул тал, дампуурлын эрх зүйн зохицуулалтын онцлог, олон улсын чиг хандлагын талаар өргөн хүрээнд судалсан бөгөөд хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын талаар цухас авч үзсэн. Тухайлбал, “... олон улсад хувь хүн төлбөрийн чадваргүй болоход улмаар үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлагыг хангахын тулд эд хөрөнгийг нь хуваарилах, нэхэмжлэлийн хэмжээг багасгах, зарим үүргээс чөлөөлөх зэрэг зохицуулалтыг хуульчилсан байдаг. Тухайлбал АНУ-д 100 000 доллараас доошгүй хэмжээний өр төлбөрөө барагдуулж чадахгүй байгаа хувь хүнийг дампуурсанд тооцуулахаар шүүхэд ханддаг. Ихэнх улс оронд хувь хүнийг төлбөрийн чадваргүй гэж үзэн дампуурсанд тооцохдоо зөвхөн “cash flow” буюу өр төлбөрөө цаг хугацаандаа төлж чадахгүй болсон ойлголтыг хэрэглэдэг”¹⁷ талаар тусгажээ. Хэдийгээр тус судалгаа нь хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагын дампууралтай холбоотой асуудлыг судалсан боловч дампуурлын эрх зүйн суурь асуудал, олон улсын чиг хандлагын талаар нэлээд тусгасан эх сурвалжид тооцогдоно.

Судлаач М.Номинцэцэг “Хувь хүний дампуурал” сэдэвт илтгэлдээ дампуурлын эрх зүйн зохицуулалт дахь хариуцагчдын хамрах хүрээ, үүнд хувь хүний дампуурлын эзлэх байр суурь, хувь хүний дампуурлыг эрх зүйгээр зохицуулах зайлшгүй шаардлага гэсэн хүрээг хамруулж, тухайн зохицуулалтын мөн чанар, зорилго, ач холбогдлыг нотлохыг зорьсон байна.¹⁸ Энэхүү өгүүлэлд:

15 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа сэдэвт судалгааны тайлан, Холбоос: <https://nli.gov.mn/pdf/aj-ahuin.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.12.11.

16 “Хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагын дампуурал” сэдэвт судалгааны тайлан, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхийг бэхжүүлэх” төсөл, 2016. Холбоос: https://cdeaproject.files.wordpress.com/2016/12/2-dam-puural.pdf?fbclid=IwAR1HQ0Hfws3innlHFhP1ovJggpL7_tB5Y5-r6wBwdYY-vVNo2BL84aE3Wg, Сүүлд үзсэн: 2022.12.10.

17 Мөн тэнд.

18 М.Номинцэцэг, “Хувь хүний дампуурал”, Бүгд Найрамдах Улс тунхагласны болон Анхдугаар Үндсэн хууль батлагдсан 80 жил, Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 13 жилийн ойд зориулж 2005 онд Ханнс-Зайделийн сангаас зохион байуулсан Хууль зүйн салбарын залуу багш, судлаач оюутны эрдэм шинжилгээний бага хурлуудын Илтгэлийн эмхтгэл (2004-2005), Ханнс Зайделийн сан, (УБ, 2005), 183-191 дэх тал.

- Хувь хүмүүс зах зээлийн харилцаанд аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа маш ихээр, бие даан эрхэлж оролцож байна. Хувь хүмүүсийн зах зээл дэх оролцоо цаашид улам өсөн нэмэгдэнэ;
- Хувиараа бизнес эрхлэгчдийн зээл авагчдын дунд эзлэх хувь нэмэгдэж байна;
- Хувь хүмүүсийн эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаа эрсдэлд өртөх нь их байна. Иймд хувь хүмүүс цаашид үйл ажиллагаа үргэлжлүүлэн эрхэлж явуулах төлбөрийн чадваргүй болох тохиолдол ихэснэ хэмээн үзэж, хувь хүмүүсийг дампуурсанд тооцож зарлах материаллаг болон процессын эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна хэмээн дүгнэсэн.

Шударга бус гэрээ, хэлцлийг илрүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах, зарим төлбөрөөс чөлөөлөх, төлбөрийн чадваргүй атлаа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй нэртэйгээр харилцагчдыг төөрүүлэх явдлаас хамгаалж эдийн засгийг цэвэршүүлж байдгаараа дампуурлын эрх зүйн зохицуулалтын ач холбогдол тодорхойлогдоно; Хувь хүний дампуурлыг зарлахын хувьд түүнийг бусад этгээдийг хохироохоос сэргийлж, түүний цаашид ашиг олох зорилгоор аж ахуй эрхлэх эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлан, бизнесийн харилцагч нарт сэрэмжлүүлэх зорилго агуулна; Хувь хүмүүс төлбөрийн чадваргүй болсон асуудлыг ийнхүү тухайлан авч үзэх нь хувь хүмүүс өрөө төлөх замаар бие даасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нээж өгөх, шүүхүүдийн ачааллыг хэт нэмэгдүүлэхгүйгээр хэрэглэгчдийн хэрэгцээг хангасан хянан шийдвэрлэх процесс бий болгох ач холбогдолтой¹⁹ хэмээн тус өгүүлэлд онцолжээ.

Дээр дурдсанаас өөр, Монгол Улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлагыг тухайлж тандан судалсан бүтээл нийтлэгдээгүй байв. Иймд хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын олон улсын чиг хандлага, гадаад орнуудын туршлагыг судалж, хувь хүний дампуурлыг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалж бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь зүйтэй юм.

1.2. Хувь хүний дампуурлын эрх зүйн хөгжлийн хандлага

Хувь хүний дампуурлын харилцааг 1980-аад оноос эхлэн эрх зүйгээр зохицуулж эхэлсэн гэж үзэх боловч уг асуудал цоо шинэ ойлголт биш юм. Түүхэн цаг хугацааны хувьд, ерөнхийдөө 20 дугаар зууны сүүлийн хагаст, хувь хүнд олгох зээлийн үйл ажиллагаа эрс нэмэгдэж, улмаар найдваргүй, эргэн төлөгдөх боломжгүй нөхцөл байдал их хэмжээгээр үүссэнтэй холбоотойгоор хувь хүний дампуурлын асуудлыг тусгайлан зохицуулах, орчин үеийн эдийн засаг, санхүүгийн системд тохирсон зохицуулалт бий болгох шаардлага үүссэн байна. Ийнхүү улс орнууд хувь хүнд олгосон эргэн төлөгдөөгүй зээлийг шийдвэрлэх зохицуулалтыг бий болгож эхэлсэн бөгөөд тухайлбал, сүүлийн 30 жилийн хугацаанд Европ тивийн дийлэнх улсад хувь хүний дампуурлыг зохицуулсан хууль тогтоомж баталж хэрэгжүүлжээ²⁰.

¹⁹ Мөн тэнд, М.Номинцэцэг, “Хувь хүний дампуурал”, Бүгд Найрамдах Улс тунхагласны болон Анхдугаар Үндсэн хууль батлагдсан 80 жил, Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 13 жилийн ойд зориулж 2005 онд Ханнс-Зайделийн сангаас зохион байгуулсан Хууль зүйн салбарын залуу багш, судлаач оюутны эрдэм шинжилгээний бага хурлуудын Илтгэлийн эмхтгэл (2004-2005), Ханнс Зайделийн сан, (УБ, 2005), 189 дэх тал.

²⁰ György Walter, “Personal Bankruptcy: Model structures and the fresh start”, Corvinus University of Budapest, 2020.

Тодруулж үзвэл, 1979 онд АНУ-д Дампуурлын тухай хууль батлагдсанаас хойш хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт дэлхий нийтийн анхаарлыг татсан гэж хэлж болно. Тухайлбал, 1986 онд Их Британи, 1989 онд Франц, 1994 онд Герман, 1995 онд Австри улсад хувь хүний дампуурлын талаарх эрх зүйн зохицуулалт бий болсон бол Чех 2008 онд, Польш 2009 онд, Итали 2012 онд, Испани 2013 онд, Унгар 2015 онд тус тус холбогдох зохицуулалтыг хуульчлан баталсан.

Судалгааны бүтээлүүдийг үзэхэд улс орнуудын хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтууд ерөнхийдөө шинээр эхлэх боломж²¹, нийгмийн даатгалын нөхцөл, хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөө, бизнес эрхлэх сэдэлд нөлөөлөх хувь хүний дампуурлын нөхцлүүд болон өр тэглэх нөхцөл, хувь хүний нэр хүнд, нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал, холбогдох зөрчлийг тодорхойлсон байдал, хөнгөлөлтийн нөхцөл зэрэг олон талын асуудлын хувьд хоорондоо нэлээд ялгаатай байна.

Эдгээрээс хөнгөлөлтийн нөхцөл²² нь АНУ болон Европын орнуудын зохицуулалтын хувьд үндсэн ялгарах нөхцөл болж байгаа бөгөөд энэ нь өрийг чөлөөлөх болон хөнгөлөх нөхцөл, шинээр эхлэх боломж зэргийг хамарсан асуудал юм. Үүнд, өрийн хөнгөлөлтийн нөхцөл нь төлөх хугацааг хойшлуулах, тухайн өртэй холбогдох аливаа үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх, хүүнээс чөлөөлөх, бууруулах зэрэг зохицуулалтын арга хэмжээг багтаадаг.

Харьцуулж авч үзвэл, АНУ-ын зохицуулалт нь түүхэн уламжлалын хувьд анх зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илүүтэй авч үзсэн бол, үүнээс хожим зохицуулалт хийсэн Европын орнуудын хувьд зээлдүүлэгчийн эрх ашгийг хангах тал дээр түлхүү анхаарсан байв. Харин сүүлийн үеийн чиг хандлагыг тандвал, АНУ-ын зохицуулалт илүү чангарсан буюу зээлдэгчид үзүүлэх хөнгөлөлтийн нөхцөлүүдийг багасгаж байгаа бол Европын орнууд эсрэгээрээ, зохицуулалтаа зөөллөх хандлагатай байгаа нь ажиглагдсан.

Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтад дараах асуудал²³-ыг анхаарах шаардлагатайг онцолдог байна. Үүнд:

Дампуурлын процессыг эхлүүлэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Процесст оролцох эрхтэй буюу өргөдөл гаргах эрхтэй этгээд (хувь хүн, хувиараа бизнес эрхлэгч), онцгой болон хязгаарлах нөхцөлүүд гэх мэт;
- Процессыг эхлүүлэх эрхтэй этгээд, үүнд багтах зээлдүүлэгч, хариуцагч гэх мэт этгээд;
- Урьдач нөхцөлүүд, үүнд хөрөнгө, орлого, барьцаанд үүсч буй эрсдэл, процессыг эхлүүлэх эрх зүйн байдал (статус) гэх мэт;
- Өрийн урьдчилсан нөхцөлүүд, үүнд өр үүссэн байдал, өрийн хэмжээ гэх мэт;
- Хэрэглэгчийн бус төрөлд хамаарах үүргийн хүчинтэй байдал, үүнд тэтгэмж, торгууль гэх мэт;

21 Fresh start

22 Leniency – өршөөх байдал

23 György Walter, "Personal Bankruptcy: Model structures and the fresh start", Corvinus University of Budapest, 2020.

- Өр төлбөрийн хугацаа хэтэрсэн тохиолдолд эхлэх, эсвэл төлбөрийн чадваргүй болмогц шууд эхлэхийн аль нь үйлчлэх тухай;
- Процесстой холбоотой зардал, үүнд багтах төлбөр болон бусад зардал, тэдгээрийг хэн хариуцах зэрэг асуудал багтана.

Процессын хүрээнд:

- Процессыг хэн хариуцаж явуулах тухай, үүнд дампуурлын асуудал хариуцсан алба, хороо, шүүх, хотын захиргаа гэх мэт;
- Бүх зээлдүүлэгчийг оролцуулах эсэх;
- Дампуурлын хэлэлцээрт хүрэх арга зам, үүнд зээлдүүлэгчдийн олонхийн шийдвэрийг харгалзах гэх мэт;
- Эргэн төлөлтөд хамрагдах үл хөдлөх хөрөнгө, үүнээс нийт үл хөдлөх хөрөнгө ба гэрээний хэрэгжилтэд хамаарах үл хөдлөх хөрөнгө, ирээдүйд бий болох үл хөдлөх хөрөнгө гэх мэт ангилал;
- Процессоос чөлөөлөгдөх буюу хамаарахгүй тохиолдол, нөхцөлүүд, үүнд зээлдүүлэгч эргэн төлөлт хүлээн авахад хамаарах урьдчилан сэргийлэлт, хариуцагчийн ирээдүйд олох орлого болон үл хөдлөх хөрөнгө гэх мэт;
- Процесс үргэлжлэх хугацаа, үүнд төлбөр түдгэлзүүлэлт буюу царцаалтын үргэлжлэх хугацаа, харилцан тохиролцсон эргэн төлөлтийн үүрэг гэх мэт;
- Эргэн төлөлтийн хуваарийг албадан биелүүлэх зорилго бүхий, хариуцагчийн эсрэг тогтоосон бусад төрлийн зохицуулалт бий эсэх, үүнд зээл авахыг хориглох, бүх төрлийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг хянах механизм зэрэг асуудал багтана.

Процессын үр дүн, төгсгөлийн шатны хүрээнд:

- Эргэн төлөх үүргийн үргэлжлэх хугацаа;
- Хаалт хийх шаардлагад нийцсэн эргэн төлөлтийн жишиг түвшин, түүнийг өрийн хувиар тооцсон байх;
- Идэвхтэй оролцооны улмаас өрөөс чөлөөлөгдөх түвшин, хэмжээ, үүнд зөвхөн түдгэлзүүлэх буюу царцаах, эсвэл тодорхой хувийг чөлөөлөх гэх мэт арга хэмжээ;
- Цаашид авагдах захиргааны нэмэлт арга хэмжээ, түүний алхмууд, үүнд зээл авах хязгаарлалт, зарлал, бүртгэл, жагсаалтад оруулах гэх мэт холбогдох харилцаа багтана.

Үүнээс гадна хувь хүний дампуурлын харилцааг зохицуулсан хууль тогтоомж, холбогдох ажиллагааны арга барилд нь үндэслэн улс орнуудыг ангилах болон түүний учир шалтгааныг тодорхойлох зааг ялгааг гаргах боломжтой. Ингэхдээ процессын явцад зээлдүүлэгч, хариуцагчийн алины нь ашиг сонирхол түрүүнд тавигдаж, хэнийг нь илүү хамгаалж байна вэ гэдгийг авч үздэг. Тухайлбал, хариуцагчид ээлтэй буюу хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын уламжлалт байдлыг илүүд үздэг Европ тивийн орнуудтай харьцуулахад, АНУ-ын эрх зүйн зохицуулалт нь хувь хүний дампуурлын харилцаанд зээлдүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг давуу байдлаар тусгасан байна.

Эдгээр ялгаатай арга барил нь хувь хүний дампуурлын харилцааг янз бүрийн өнцгөөс судлахад мөн хүргэдэг. Үүнд:

- Ёс суртахууны шинжтэй эрсдэл, өр барагдуулах, чөлөөлөх асуудал, “шинэ эхлэл”-ийн харилцаа болон түүнийг урвуулан ашиглах магадлал;
- Дампуурлыг нийгмийн даатгалын нэг төрөл гэж үзэх, нийгмийн халамжид хамааруулах байдал;
- Бизнес эрхлэх хөшүүрэг болон дампуурлын зохицуулалтын харилцан хамаарал, ажиллах хүчний нийлүүлэлтэд үзүүлэх нөлөө;
- Оролцогчдод тулгарах хүний эрхийн асуудал, гутаан доромжлох үйлдэл зэрэг асуудал багтана.

Дээрх асуудлууд нь хоорондоо нягт холбоотойгоос гадна зарим хандлага, үр дагавар нь улс орнуудын зохицуулалтын хэрэгжилтэд ихээхэн нөлөөлдөг.

Саяхан болтол дэлхий нийтээр “дампуурал” гэдгийг төлбөрийн чадваргүй болсон этгээдийн үйл ажиллагааг нь бүрмөсөн зогсоон, зах зээлээс шахан гаргах гэсэн явцуу ойлголтоор авч үздэг байсан бол дампуурлын эдийн засагт үзүүлэх нөлөө, ажлын байр болон бусад олон чухал нийгмийн асуудлыг харгалзан төлбөрийн чадваргүй этгээдийн үйл ажиллагааг нь зогсоон дуусгавар болгодог дампуурлын эрх зүйн үндсэн арга замын зэрэгцээ сэргээх, хөл дээр нь босгох, дахин хөрөнгөжүүлэх реорганизацийн аргыг дампуурлын зохицуулалт гэсэн ойлголтын хүрээнд авч үзэх болсон.²⁴ Үүний нэг бол “Шинэ эхлэл”-тэй холбоотой зохицуулалт юм.

“Шинэ эхлэл”

Хувь хүний дампуурлын зохицуулалтын нэг чиглэл бол шинээр эхлэх боломж олгох тухай ойлголт юм. “Шинэ эхлэл” гэх ойлголтыг хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын ашиг тусыг урвуулан ашиглах явдал, нийгмийн даатгалд хамаарах эсэх, гүтгэлэг доромжлол зэрэг хүний эрхийн зөрчил, тэдгээрийн шийдвэрлэлт, зайлшгүй байдал, бизнес эхлүүлэх сэдэл, хөдөлмөрийн зах зээлтэй холбогдох харилцаа зэрэг талаас нь нэлээд судалсан байдаг. Ерөнхийдөө шинээр эхлэх боломж нь хувь хүмүүс болон бизнес эрхлэгчдийн өр төлбөрийн асуудал дээр тухайн орны зохицуулалт хэр зэрэг өршөөнгүй ханддагтай шууд холбоотой үүсдэг.

“Шинэ эхлэл” бол хувь хүний дампуурлын зохицуулалтын хувьд тодорхой шинж чанарыг агуулсан байх тухай ойлголт юм. Боломж олгох буюу шууд дампуурлын талаарх ойлголт, холбогдох зохицуулалт бий эсэх (АНУ-ын хуулийн 7 дугаар зүйлд заасантай ойролцоо гэх мэт)-ийг авч үзнэ. Үүнд хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтад холбогдох дараах асуудал орно.

Багтах эсэхийг тогтоох шалгуур:

- Процесст оролцох эрхтэй буюу өргөдөл гаргах эрхтэй этгээд (хувь хүн, хувиараа бизнес эрхлэгч), онцгой болон үүссэн процесстэй холбогдох хязгаарлах нөхцөлүүд гэх мэт;

24 “Хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагын дампуурал” судалгааны тайлан, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох- чадавхийг бэхжүүлэх” төсөл, 9 дэх тал, 2016. Холбоос: https://cdeaproject.files.wordpress.com/2016/12/2-dam-puural.pdf?fbclid=IwAR1HQ0Hfwbs3innIHfHP1ovJggpL7_tB5Y5-r6wBwdYY-vVNo2BL84aE3Wg, Сүүлд үзсэн: 2022.12.16.

- Ажиллагааг эхлүүлэх эрхтэй этгээд, үүнд багтах зээлдүүлэгч, хариуцагч гэх мэт этгээд;
- Урьдач нөхцөлүүд, үүнд хөрөнгө, орлого, барьцаанд үүсэж буй эрсдэл, процессыг эхлүүлэх эрх зүйн байдал гэх мэт;
- Өрийн урьдчилсан нөхцөлүүд, үүнд өр үүссэн байдал, өрийн хэмжээ гэх мэт;
- Хэрэглэгчийн бус төрөлд хамаарах үүргийн хүчинтэй байдал, үүнд тэтгэмж, торгууль гэх мэт;
- Өр төлбөрийн хугацаа хэтэрсэн тохиолдолд эхлэх, эсвэл төлбөрийн чадваргүй болмогц шууд эхлэхийн аль нь үйлчлэх тухай;
- Хариуцагчийн өнцгөөс авч үзвэл ажиллагааны зардал хэр байгаа тухай (гүйлгээний зардал).

Процессын нарийн төвөгтэй байдал:

- Процессыг хэн хариуцаж явуулах тухай, үүнд дампуурлын асуудал хариуцсан алба, хороо, шүүх, хотын захиргаа гэх мэт;
- Бүх зээлдүүлэгчийг оролцуулах эсэх;
- Дампуурлын хэлэлцээрт хүрэх арга зам, үүнд зээлдүүлэгчдийн олонхын шийдвэрийг харгалзах, хянан шийдвэрлэх ажиллагаа гэх мэт;
- Процессын үргэлжлэх хугацаа, үүнд түдгэлзүүлэлт буюу царцаалтын үргэлжлэх хугацаа, харилцан тохиролцсон эргэн төлөлтийн үүргүүд гэх мэт.
- Хамрагдахгүй тохиолдлууд, үүнд босго, хөрөнгийн болон орлогын төрөл, ирээдүйн орлого, өмч зэрэгт нь үндэслэх гэх мэт.

Өрийн бүтцийг өөрчлөх үед чөлөөлөх нөхцөлүүд:

- Эргэн төлөх үүргийн үргэлжлэх хугацаа, харилцан тохиролцсон хугацаа;
- Тогтоосон шаардлагад нийцсэн эргэн төлөлтийн жишиг түвшин, түүнийг өрийн хувиар тооцсон байх;
- Идэвхтэй оролцооны улмаас өрөөс чөлөөлөх түвшин, хэмжээ, үүнд зөвхөн түдгэлзүүлэх буюу царцаах, эсвэл тодорхой хувийг бүрэн чөлөөлөх гэх мэт арга хэмжээ;
- Шууд чөлөөлөх, эсвэл шүүхийн шийдвэрээс шалтгаалах нөхцөлтэйгээр чөлөөлөх.

Өргөдөл гаргах үед болон өргөдөл гаргасны улмаас нэр хүндэд учрах хохирол (stigma):

- Эргэн төлөлтийн хуваарийг албадан биелүүлэх зориулалттай, хариуцагчийн эсрэг бусад төрлийн зохицуулалт бий эсэх, тухайлбал зээл авахыг хориглох, бүх төрлийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг хянах гэх мэт зохицуулалт;
- Хууль тогтоомжийн хүрээнд нэр хүндэд учрах хохирол (stigma), үүнд дампуурал, өр барагдуулалт гэх мэт;

- Захиргааны нэмэлт арга хэмжээ, алхмууд, үүнд зээл авах хязгаарлалт, бүртгэл, жагсаалт, зарлалд оруулах гэх мэт холбогдох харилцаа багтана.

Дээрх жагсаалт нь 2007 онд хийгдсэн, АНУ, Франц, Герман, Англи, Канад Улсыг харьцуулсан судалгаа²⁵-аар тодорхойлсон ангилалд үндэслэсэн. Тус судалгаанд улс орнуудыг дампуурлын асуудалд баримтлах бодлогын хувьд өр төлөх үүрэгтэй хариуцагчид даатгал олгох болон үүргээ биелүүлээгүй тохиолдолд шийтгэл хүлээлгэх хоёрын хоорондын уян хатан байдлыг үндэслэн харьцуулалт хийсэн. Ингэхдээ нийт 7 ангилал буюу шалгуурыг ашигласан бөгөөд үүнд, өр төлбөрөөс чөлөөлсөн хэмжээ, хамрагдахгүй эд хөрөнгийн төрөл, хамрагдахгүй орлогын төрөл, хамрагдахгүй орлогоос илүү гарсан тохиолдолд хариуцагч өр төлөхөд зарцуулах ёстой хувь хэмжээ, эргэн төлөлтийн үүргийн үргэлжлэх хугацаа, дампуурлын нийт зардал, дампуурлын шийтгэл гэсэн асуудал багтсан. Эдгээр асуудлын хүрээнд ангилан авч үзэхэд улс орнууд, түүний дотор Европ тивийн орнууд ч хоорондоо ихээхэн ялгаатай байжээ.

2002 онд хийгдсэн судалгаа²⁶-нд өрийг өршөөх боломж, түүний тодорхой бөгөөд шуурхай шийдвэрлэх байдалд нь үндэслэн улс орнуудыг ангилжээ. Ингэхдээ эхний бүлэг буюу “консерватив зохицуулалттай” орнуудад өрөөс чөлөөлөх ямар ч боломжгүй, шинээр эхлэх боломж байхгүй бөгөөд арилжааны гэсэн ангилалд хамаарахгүй дампууралд өртсөн хувь этгээд дампуурал зарлах өргөдөл гаргах зохицуулалт байхгүй, ийм зохицуулалт байсан ч өрөөс чөлөөлөх ямар ч боломж олгодоггүй байна. Хоёр дахь бүлэг буюу “дунд зэрэг зохицуулалттай” ангилалд хамаарах орнуудын хувьд өрөөс чөлөөлөх, шинээр эхлэх боломж байдаг ч тухайн нөхцөлүүдийг эдлэх эсэх нь тодорхойгүй буюу хамрагдах шалгуур маш хатуу, ажиллагаа явуулах процесс олон нийтэд танигдаагүй, зардал өндөр болон боломжийг урвуулан ашиглахтай холбоотой хардалт өндөр байна. Харин гурав дахь бүлэгт багтах буюу “либерал зохицуулалттай” улсуудын хувьд шууд дампуурал зарлах болон эргэн төлөлтийн тохиролцоонд хүрсэнээр автоматаар, богино хугацаанд шинээр эхлэх боломж үүсдэг.

“Шинэ эхлэл” гэсэн ойлголтын талаар түүнийг шүүмлэх болон дэмжих олон төрлийн аргумент гарсан байдаг бөгөөд үүний нэг нь шинэ эхлэл нь хариуцагчид “нийгмийн баталгаа” олгодог учраас бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх тал дээр хувь хүнд учруулах эрсдэлийг бууруулдаг гэсэн аргумент юм. Гэхдээ энэ нь бизнесийн үйл ажиллагааг дэмждэг ч ёс суртахууныг алдагдуулах эрсдэлтэйд мөн тооцогдож байна. Өөрөөр хэлбэл эрсдэл зээлдүүлэгчид рүү шилжих буюу зээл олгогчид зээлийн өндөр хүү тогтоох зэрэг арга хэмжээ авахад хүргэж болзошгүй гэсэн сөрөг үр дагавар үүсэх магадлалтай юм.

25 White (2007)

26 Efrat (2002)

ХОЁР. ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

Дампуурлын тогтолцоо нь хөгжиж буй эдийн засагтай аливаа оронд эдийн засгийн эмх замбараагүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, дэг журмыг төлөвшүүлэн үйлчлэх ёстой. Түүнчлэн дампуурлын механизм нь аливаа хариуцагчийг дампуурсан тохиолдолд нэг талаас нэхэмжлэгч өөрийн хохирлыг багасгах, эд хөрөнгөө тодорхой хэмжээгээр эргүүлэн авах, нөгөө талаас хариуцагчийг дахин найдваргүй бизнесийн үйл ажиллагаа явуулахаас сэргийлэх нөхцөлийг бий болгодог билээ. Энэхүү асуудал нь өөрөө цаад угтаа нийгмийн олон төрлийг харилцааг агуулсан, тэдгээртэй шууд уялдан, эсвэл тодорхой төрлийн харилцаануудаас үүсэн гарсан байдаг.²⁷

Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын онцлогийг илрүүлэх зорилтын дордараах 3 улсыг сонгож судлав. Үүнд, хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцооны хувьд хамгийн эртний загварын нэг бөгөөд хамгийн зөөлөн зохицуулалттайд тооцогддог Америкийн Нэгдсэн Улс; Европын орнуудын зохицуулалтын үндсэн загвар байсан боловч процессын хатуу зохицуулалтаа зөөлрүүлсэнд тооцогдож буй Бүгд Найрамдах Австри Улс; нөхцөл, шалгуур, процессын хувьд нэлээн төвөгшилтэйд тооцогддог боловч нарийвчилсан зохицуулалт бүхий Унгар Улсыг хамруулсан.

2.1 Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын загвар нь хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцооны хамгийн эртний загварын нэг бөгөөд уламжлалт байдлаар хамгийн зөөлөн тогтолцооны нэгд тооцогдож ирсэн.

Тус улсын Дампуурлын тухай хууль²⁸-д зээлдэгч хувь хүн дампуурлын талаар өргөдөл гаргах боломжтой хоёр төрлийн процесс (хоёр бүлэг) бий. Нэг нь тус хуулийн 7 дугаар бүлгийн хүрээнд хамаардаг бол нөгөө нь 13 дугаар бүлгийн хүрээнд хамаарна. Тухайн хоёр процессоос сонгох нөхцөл 2005 онд Дампуурлыг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийг хамгаалах тухай хууль²⁹ батлагдсанаар ихээхэн өөрчлөгдөж, 7 дугаар бүлгийн хүрээнд хамрагдах нөхцөл илүү чангарчээ.

ДтХ-ийн 7 дугаар бүлгийн дагуу, төлбөрийн чадваргүй болсон хүн өргөдөл гаргахад өртэй этгээд, эсвэл томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүрэн төлж барагдуулахын тулд хөрөнгийн тодорхой багцаа татан буулгадаг. Татан буугдах хөрөнгийг тухайн мужийн хуулиас хамааран муж бүрт ялгаатай заасан. Ингэхдээ хөрвөх чадвартай хөрөнгийг татан буулгах тохиолдолд зээлдэгч баталгаагүй өрийн ихэнх хэсгээс чөлөөлөгддөг. Үүнд, баталгаагүй өр гэдэгт кредит картын төлбөр, хувь хүнээс авсан зээл, эмнэлгийн төлбөр, байрны хэрэглээний төлбөр зэрэг багтана. Мөн зээлдэгч 7 дугаар бүлгийн дагуу өргөдөл гаргаснаас хойш дахин 6 жилийн дотор тус зохицуулалтын хүрээнд өргөдөл гаргах

27 М.Номинцэцэг, “Хувь хүний дампуурал”, Бүгд Найрамдах Улс тунхагласны болон Анхдугаар Үндсэн хууль батлагдсан 80 жил, Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 13 жилийн ойд зориулж 2005 онд Ханнс-Зайделийн сангаас зохион байуулсан Хууль зүйн салбарын залуу багш, судлаач оюутны эрдэм шинжилгээний бага хурлуудын Илтгэлийн эмхтгэл (2004-2005), Ханнс Зайделийн сан, (УБ, 2005), 183 дахь тал.

28 Bankruptcy Code.

29 Bankruptcy Abuse Prevention and Consumer Protection Act.

эрхгүй болно (АНУ-ын шүүхийн шийдвэрээр). Энэхүү загвар нь ерөнхийдөө ихэнх улс оронд үйлчилдэг корпорацуудын арилжааны зээлийг татан буулгах загвартай адил бөгөөд “шууд дампуурал” гэсэн ангилалд багтдаг.

Харин ДтХ-ийн 13 дугаар бүлгийн зохицуулалтын хувьд зээлдэгчийн хөрөнгө түүнд хэвээр үлддэг буюу хөрөнгийг нь оролдохгүй боловч зээлдэгч ирээдүйд олох орлогоосоо эргэн төлөх төлөвлөгөөний дагуу зээлээ бүрэн болон хэсэгчлэн төлөх үүрэг хүлээдэг. Эргэн төлөлтийн хуваарийг 3-5 жилийн хугацаатай төлөвлөнө. Хуваарийн дагуу төлж дууссаны дараа бүх өр чөлөөлөгдөнө. Зээлдэгч 13 дугаар бүлгийн дагуу өргөдөл гаргаснаас хойш 180 хоногийн дотор дахин энэ зохицуулалтын хүрээнд өргөдөл гаргах эрхгүй.

Дампуурлыг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийг хамгаалах тухай 2005 оны хуулиас өмнө зээлдэгч нь дээр дурдсан хоёр зохицуулалтаас аль нэгийг сонгох эрхтэй байжээ. Харин шинэ хууль батлагдсанаар шинээр эхлэх боломжийг аль ч талаас нь авч үзэхэд бэрхшээлтэй болсон. Тус хууль нь ДтХ-ийн хоёр зохицуулалтыг сонгох нөхцөлүүдийг хязгаарласан бөгөөд өөрөөр хэлбэл зээлдэгчийн хувьд илүү хатуу болж, эргэн төлөлтийг уртасгасан байна. Ингэснээр өргөдөл гаргахад төлөх хураамж илүү өндөр болж зээлдэгчид тавих шаардлага мөн нэмэгдсэн. Гол зорилго нь хэрэглэгчийн хамгаалалтыг бууруулах, ДтХ-ийн дээр дурдсан хоёр бүлгийн зохицуулалтад хамрах зээлдэгчийн тоог багасгах, өрөө төлөх хангалттай хэмжээний орлоготой зээлдэгч 13 дугаар бүлгийн зохицуулалтын хүрээнд эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлтөө хийх баталгааг хангахад чиглэжээ. Харин 7 дугаар бүлгийн зохицуулалт нь зөвхөн хангалттай хэмжээний орлоготой зээлдэгчид л үйлчлэх болсон.

Өргөдөл гаргаснаар, дампуурлын зохицуулалтыг урвуулан ашиглаж байгаа эсэхийг шийдэх шалгуур буюу хяналт шалгалтаар орох шаардлагатай болсон. Үүний хүрээнд сүүлийн таван жилийн сар бүрийн нийлбэр орлогыг авч үздэг байна. Шүүх хэрэв хувь хүний өр нь бизнесийн өр биш хэрэглэгчийн өр төлбөр байвал “урвуулан ашигласан” гэсэн үндэслэлээр 7 дугаар бүлгийн зохицуулалтын хүрээнд гаргасан өргөдлийг хүлээн авахаас татгалздаг. Харин 13 дугаар бүлгийн дагуу өргөдөл гаргахад эргэн төлөлтийн нийт хугацааг улсын хэмжээний нийт эргэн төлөлтийн дундаж хугацаагаар тогтоох болжээ. Үүнд, зээлдэгчийн орлого улсын дундаж түвшингээс бага бол эргэн төлөлт 3 жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд харин орлого дундаж түвшингээс дээш бол ерөнхийдөө 5 жил үргэлжилнэ. 13 дугаар бүлэгт заасан зохицуулалтын дагуу тогтоосон хугацаанд эргэн төлөлтийг хуваарийн дагуу хийж дууссаны дараа бүх өр чөлөөлөгддөг тул хугацааг урт тогтоох нь зээлдүүлэгчид илүү ашигтай юм.

Шалгуур. ДтХ-ийн 7 дугаар бүлэгт тусгасан шалгуурын хувьд зээлдэгч нь хувь хүн, нөхөрлөл, компани болон бизнесийн бусад хэлбэртэй байж болох (АНУ-ын шүүхийн тайлбарын дагуу) бөгөөд хувь хүний хувьд зарим төрлийн хязгаарлалт тогтоосон. Ингэхдээ өргөдөл гаргасны дараа өрийн чөлөөлөлт/хөнгөлөлт нь нөхөрлөл, компанид бус хувь хүмүүст хамааралтай байхаар заажээ. Гэхдээ өрийн чөлөөлөлт/хөнгөлөлт олгогдох нь баталгаатай бус бөгөөд зарим төрлийн өрийг чөлөөлөхгүй байхаар заасныг анхаарах нь зүйтэй. Үүнээс гадна дампуурлын харилцаанд үл хөдлөх хөрөнгийн барьцаанаас чөлөөлөгдөхгүй.

Тус хуулийн 13 дугаар бүлэгт заасан шалгуурын хувьд ямар ч хувь хүн тус зохицуулалтад хамрагдахаар өргөдөл гаргаж болох бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгч, бүртгэлгүй бизнес эрхлэгч хувь хүн, цорын ганц өмчлөгч нар өрөөс чөлөөлөгдөх шалгуурт багтана. Гэхдээ баталгаагүй өрийн хэмжээ нь тогтоосон доод хэмжээнээс хэтрээгүй тохиолдолд өрийн хөнгөлөлт/чөлөөлөлтөд хамрагдана³⁰. Компани болон нөхөрлөл энэ зохицуулалтад хамаарахгүй.

Хуулийн хэрэгжилтийн судалгааны дүнд, зохицуулалт ба хэрэгжилт хоорондоо ихээхэн зөрүүтэй байгаа нь ажиглагддаг. Энэ нь муж бүрт тогтсон эрх зүйн соёл, хандлага болон төрийн албан хаагч, шийдвэр гаргагчдын дунд нэгэнт тогтсон ажлын арга барилаас үүдэлтэй³¹ бөгөөд хамгийн гол ялгаа нь бодитоор олгогдож байгаа өрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн түвшин юм. Гэхдээ муж бүрийн хувьд харилцан адилгүй нөхцөл байдалтай байна.

2.2 Бүгд Найрамдах Австри Улс

Австри Улсын 1995 онд үүссэн хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын загвар 2017 онд шинэчлэгдэх хүртлээ Европын орнуудын үндсэн загвар болж байв. Харин 2017 онд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль (*Insolvency law -Insolvenzrechtsänderungsgesetz 2017*) баталж, шинэчлэл хийснээр дампуурлын процессын хатуу бүтцээ зөөлрүүлсэн гэж үздэг.

Тус улсын дампуурлын эрх зүйн зохицуулалт нь зээлдэгч, зээлдүүлэгч, шүүх/захиргааны байгууллагын шийдвэрээс шалтгаалан процесс хаана, хэрхэн явагдах тухайд шаталсан хувилбарын сонголттой. Ингэхдээ, аль ч процессыг эхлүүлэхэд “шударга санаа” агуулсан байх ёстой бөгөөд энэ нь хувь хүний дампуурлын зохицуулалтын үндсэн зарчим болдог.

Австри Улсын зохицуулалтад “шууд дампуурал”-ын сонголт байхгүй. Ажиллагааны эхний шат нь шүүхээс гадуурх ажиллагаа байх бөгөөд энэ нь 1995 онд хууль батлагдахаас ч өмнө үйлчилж байсан. Энэ нь үндсэндээ зээлдүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан гэрээнд үндэслэн үүргийн бүтцэд өөрчлөлт оруулах замаар эвлэрлийн журмаар шийдвэрлэх ажиллагаа юм. Эргэн төлөлтийн төлөвлөгөөг зээлдүүлэгчдийн олонхын шийдвэрээр хамгийн ихдээ 7 жилийн хугацаанд амжилттай биелүүлсэн тохиолдолд төлбөр барагдуулсанд тооцно. Энэ тохиолдолд зээлдэгч өөрийн хөрөнгө, орлого, зардлаа зохицуулах бүрэн эрхээ өөртөө хадгалж, эргэн төлөлтийн төлөвлөгөөг биелүүлэх үүрэг хүлээх бөгөөд өр барагдуулах албан ёсны зөвлөхүүд процессын явцад дэмжлэг үзүүлдэг.³²

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон тохиолдолд шүүхийн процесст шилжихэд мөн ялгаатай сонголтууд бий. Шүүхийн ажиллагаа эхлүүлэхэд зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон, мөн эвлэрэх ажиллагаа амжилтгүй болсон гэдгийг нотлох шаардлагатай. Эхний сонголт бол “албадан өөрчлөлт” (“*Zwangsausgleich*”) юм. Зээлдэгч нь “дахин сэргэх” төлөвлөгөө гаргасны үндсэн дээр төлбөр төлөх үүргийн 20%-ийг 2 жилийн дотор, 5 жилийн дотор 30%-ийг төлөх саналыг зээлдэгчид тавьдаг. Зөвшөөрөх эсэхийг зээлдэгчдийн олонхын саналаар шийдэх бөгөөд зээлдэгч бүр өөр өөр босго тавьж болно. Энэ тохиолдолд эд хөрөнгийг албадан худалдахгүй.

30 Currently about TUSD 400 unsecured debt and MUSD 1,2 secured debt

31 Efrat, 2003

32 Györi, Hetes-Gavra et al., 2016

Хэрэв энэ ажиллагаа амжилтгүй болвол дараагийн алхам нь эргэн төлөлтийн төлөвлөгөө байна. Энэ ажиллагааны үед зээлдэгчийн хөрөнгө, эд хөрөнгийг бүртгэх бөгөөд үндсэн хэрэгцээг хангах хэмжээний хөрөнгөөс бусад хөрөнгийг худалдан борлуулах боломжтой. Эргэн төлөлтийн төлөвлөгөөнд дээд тал нь 7 жилийн хугацааг заах бөгөөд зээлдэгчдийн олонхын шийдвэрээр зөвшөөрөл өгнө. Гүйцэтгэлийн явцад зээлдэгч зээлдүүлэгчийн хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулах ба төлөвлөгөө амжилттай хэрэгжсэний үндсэн дээр өр төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөнө.

Хэрэв зээлдүүлэгчид төлөвлөгөөнөөс татгалзвал сүүлийн шатны процесс нь “оролцох процесс” (“Abschöpfungsverfahren”) байна. Үүнд, орлогын доод хэмжээг шүүх тогтооно. Тус босгыг давсан орлогын хувьд албан ёсоор томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч төлбөрийг хариуцаж зээлдэгчид рүү шууд шилжүүлнэ. Энэ процесс ерөнхийдөө итгэмжлэгдсэн төлөөлөгч, зээлдэгч нарын хяналт дор явагдах бөгөөд амьдралын баталгаажих доод түвшинтэй тэнцэх хэмжээний орлогоор зээлдэгч нь амьдрах болно. Мөн энэхүү процесс 3-7 жил үргэлжлэх бөгөөд үүргийн хэдэн хувийг төлсөн гэдгээс хамаарч гүйцэтгэл эцэслэгдсэн эсэхийг шийднэ. 3 жилийн хугацаагаар тогтоогдсон тохиолдолд төлбөрийн үүргийн 50%-ийг төлж дуусгасан байх ёстой. Харин 7 жилийн хугацаанд баталгаагүй үүргийн 10%-ийг төлж барагдуулаагүй бол төлбөрөөс шууд чөлөөлөгдөхгүй (2017 оны өөрчлөлтөөр энэ шаардлагыг хассан). Гэхдээ энэ нь зөвхөн шүүхийн шийдвэрт үндэслэх бөгөөд шүүхээс эргэн төлөлтийн хугацааг сунгаж болно. Энэ шатанд гол онцлог нь зээлдэгчдийн зөвшөөрлийг авах хэрэггүй бөгөөд тогтоосон журмын дагуу зохицуулагдаж, мөн уг арга хэмжээнд хамрагдах өргөдөл гаргахад хатуу шаардлага (өмнө нь өргөдөл гаргаж энэ процесст хамрагдаж байсан эсэх, хүчирхийлэл үйлдэж байгаагүй байх, шударга, хариуцлагатай хандсан байх г.м) тавигддаг.

Харин 2017 онд хийсэн шинэчлэл нь “шинэ эхлэл”-ийг дэмжих хэд хэдэн шинжийг агуулсан байна. Тухайлбал, орлого багатай өргөдөл гаргагч дээр дурдсан ажиллагаануудад хамрагдах боломж хязгаарлагдмал байсныг шинэчилж, орлого багатай өргөдөл гаргагч шууд сүүлийн шатны процесс болох “оролцох процесс”-т хамрагдах эрхтэй байхаар хуульчилсан. Үүний зэрэгцээ тухайн процессыг эхлүүлэх шалгуурыг зөөллөсөн байна. Өмнө дурдсанчлан, 7 жилийн хугацаанд баталгаагүй үүргийн 10%-ийг төлж барагдуулсан байх шаардлагыг хасч, тухайн хугацааг 5 жил болгон богиносгосон. Эдгээрээс гадна захиргааны зардлаас чөлөөлөгдөх боломжуудыг нэмж тусгажээ. Ингэснээр Австри Улсын зохицуулалт илүү зөөлөн шинжтэй загвар болсон учир дампуурлын процессын дагуу өргөдөл гаргах боломжтой этгээдийн тоо нэмэгдсэн байна³³.

2.3 Унгар Улс

Хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг зохицуулах эрх зүйн шийдэл Унгар Улсад дэлхийн II дайнаас өмнө байсан боловч социалист дэглэмийн үед арилсан байна. Харин энэ төрлийн эрх зүйн зохицуулалтыг дахин бий болгох санал 2009 оны санхүүгийн хямралын нөлөөгөөр чанаргүй жижиг зээлийн хэмжээ эрс нэмэгдсэн үеэс яригдах болжээ. Мөн хөрш орнуудад нь хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт бий болж, хэрэгжиж эхэлсэн явдал ч нөлөөлсөн. Ийнхүү Унгарт 2015 онд хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт- Act on the debt settlement

33 Kilborn, 2018.

of natural persons (personal insolvency act or Act) бий болсон бөгөөд үндсэн зарчим, зорилго нь Герман, Австри, Ирланд, Испанийн зохицуулалтад тулгуурласан байна. Тус улсын зохицуулалтын гол онцлог нь зээлдүүлэгчийн ашиг сонирхлыг илүүтэй авч үздэгт орших бөгөөд энэ нь Европын бусад орны чиг хандлагатай ижил юм.

Унгар Улсын хувьд хувь хүний дампуурлын эрх зүйн харилцааны үндсэн шалгуурт багтах гол зарчмууд нь харилцан тохиролцох хүсэл эрмэлзэл, эрх бүхий байгууллага, зээлдүүлэгчтэй хамтран ажиллах дур сонирхол, мөн хууль тогтоомжийг хүндэтгэн сахих зэрэг зарчим болно. Мөн өрийн төрөл, бүтэц, үүргийн хэмжээнээс хамааран шалгуур нь хатуу, нарийн ялгамжтай байдлаар зохицуулагдсан. Хүлээх үүрэг нь хувь зээл, хэрэглэгчийн зээл болон хувийн бизнес эрхлэлтээс үүдэлтэй байх нь харгалзан үзэх гол шалгуур юм. Заавал хангасан байх шалгууруудыг нарийвчлан хуульчилсан бөгөөд тухайлбал, хугацаа хэтэрсэн өрийн дээд болон доод хэмжээ (2-20 унгар форинт), зээлдэгчийн нийт хөрөнгөд эзлэх өр төлөх үүргийн хувь (200%-аас ихгүй), бүтэц (хугацаа хэтэрсэн үүрэг хамгийн багадаа 0.5 сая унгар форинт, ингэхдээ 5-аас илүүгүй хоёрдогч үүрэгтэй байх) зэрэг болно. Одоо үргэлжилж байгаа болон өмнө нь байсан хамрагдах боломжгүйд тооцогдох нөхцөлүүд мөн тавигддаг байна (хариуцагчтай холбоотой гэмт хэрэг болон зөрчлийн хувиар шалгагдаж байгаа бусад асуудал г.м).

Ерөнхийдөө тус улсын хуульд заасан хувь хүний дампууралтай холбогдолтой 3 төрлийн процесс буюу боломж байна. Австри Улсын загвартай ижил эхний процесс нь харилцан тохиролцоо (эвлэрүүлэн зуучлал) буюу шүүгч, шүүхийн оролцоогүйгээр зээлдэгч, зээлдүүлэгчийн хооронд зээлдэгчийн үүргийг шинэчилсэн тохиролцоонд авч үзэх боломж юм. Шүүхийн процессыг зөвхөн энэхүү харилцан тохиролцоо бүтэлгүйтэх буюу эвлэрлийн журмаар тохиролцсон үүргээ биелүүлээгүй, эсвэл гол томоохон зээлдэгч байхгүй нөхцөлд эхлүүлнэ. Ерөнхийдөө эвлэрүүлэн зуучлалаар харилцан тохиролцох зарчим Европт нийтлэг үйлчилдэг (Англи, Герман, Франц, Австри г.м). Гэхдээ энэ нь төрийн ямар нэгэн институцийн оролцоотой болон оролцоогүйгээр янз бүр хэрэгжиж байна.³⁴

Хувь хүний дампуурлын зохицуулалтын процесс нь зээлдэгч гол зээлдүүлэгчид мэдэгдсэнээр эхлэх ёстой. Тусгай эрх бүхий байгууллага зээлдэгчийн орлого, хөрөнгийн байдлыг тогтооно. Гол зээлдүүлэгч нь зээлдэгч болон бусад зээлдүүлэгч хоорондын гэрээний харилцаанд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Байгуулсан гэрээг тусгай байгууллагад бүртгүүлнэ. Ерөнхийдөө зээлдэгчид тавих хяналт нь харьцангуй чанга биш, зээлдэгчийн өдөр тутмын төлбөр, орлогын байдалд хяналт тавих итгэмжлэгдсэн төлөөлөгч томилдоггүй, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулахыг заавал шаарддаггүй боловч харилцан тохиролцсоны дагуу үүссэн эргэн төлөлтийн харилцаанд харин хатуу шаардлага тавьдаг. Зээлдэгч өөрийн бүх хөрөнгө, ирээдүйн орлогоо эргэн төлөлтөд оролцуулах үүрэг хүлээнэ. Зөвхөн тодорхой хэмжээний буюу хувийн үндсэн хэрэгцээг хангах хэмжээгээр орлогын зарим хэсгийг өдөр тутмын амьдралдаа зарцуулж болох бөгөөд шинээр нэмэлт үүрэг, хариуцлага хүлээхийг хориглодог. Захиргааны хураамжаас гадна татвар, даатгал, хэрэглээ (байрны)-ний зардлаа тогтмол төлөх ёстой бөгөөд сар бүр төлөхөөр заасан доод хэмжээгээр (үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн анхны үнэ х $(7,8\%/12=0,65\%)$) эргэн төлөлтийг заавал хийх ёстой.

³⁴ Báger, MNB, 2015.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон тохиолдолд дараагийн алхам нь шүүхийн ажиллагаа юм. Шүүхийн ажиллагааны эхний үе шат нь “өрийн тохиролцооны журам” (“adósságrendezési eljárás”) байх бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгч процессыг удирдаж, хүрсэн тохиролцоо нь процесст оролцсон бүх зээлдэгчийн хувьд хүчинтэй байна. Хэлэлцээрийг эцэст нь шүүхээс батлах боловч энэ нь зайлшгүй шаардлага бас биш юм. Энэхүү гэрээнд эргэн төлөлтөд хамаарах бүх нөхцөл, зохицуулалт, барьцаанд тавьсан хөрөнгийг худалдан борлуулах төлөвлөгөө, орлогын ашиглалт, хяналтын төлөвлөлт, аливаа тэтгэмжийн зарцуулалтын талаар тусгах ёстой.

Ерөнхийдөө гэрээг хэрэгжүүлэх явцад зээлдэгчийн ахуй амьдрал, орлого, зарлагын байдал нь эрх бүхий байгууллагаас тогтоосон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтад байх бөгөөд тэрээр банкны дансны бүх гүйлгээнд хяналт хийнэ. Үндсэн хэрэгцээ болон тухайн хэрэгцээг хангах зарцуулалтын босго хэмжээг нэг хүнд ногдох байдлаар тооцоолж гаргах бөгөөд түүнд үндэслэн банкны дансны болон бэлэн мөнгөний гүйлгээний хязгаарыг батална. Үл хөдлөх хөрөнгийг заавал худалдан борлуулах шаардлагагүй бөгөөд тухайн хөрөнгийг хэвээр эзэмших болон бага үнийн дүнтэй үл хөдлөх хөрөнгө болгож өөрчлөн эзэмшиж болно. Бүх төрлийн гэнэтийн орлого, шинэ үл хөдлөх хөрөнгийг тайлагнаж, эргэн төлөлт хийхэд зарцуулна. Гэрээнд оролцоогүй зээлдүүлэгчид зээлдэгчээс эргэн төлөлтөд хамаарах аливаа ажиллагааг явуулах эрх байхгүй. Мөн зээлдэгч болон түүний гэр бүлийн амьжиргааны үндсэн хэрэгцээг хангах хэмжээгээр чөлөөлөгдөх орлого, хөрөнгийн жагсаалт гаргана. Өрийн тохиролцооны журмыг шүүхээс зөвшөөрөх хүртэл эргэн төлөлтийн үүрэг нь өмнө дурдсан эвлэрлийн гэрээнд заасан доод хэмжээ (үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн анхны үнэ x ($7,8\%/12=0,65\%$))-тэй тэнцүү байна. Нэмэлт төлбөрийн үүрэг, даатгал, төлбөр, татварын үүрэг мөн хүлээнэ. Үүргээ биелүүлсний хариуд зээлдэгч нь аливаа өр цуглуулах арга хэмжээний эсрэг дампуурлын хамгаалалт эдэлдэг. Харин хариуцагч үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд журмыг хүчингүйд тооцож өмнө явагдаж байсан эргэн төлүүлэх ажиллагаа үргэлжилнэ.

Дээрх өрийн тохиролцооны журмыг хэрэгжүүлэх явцад тохиролцоонд хүрч чадаагүй бол “өр барагдуулах журам” (“adósságtörlesztési eljárás”)-ын харилцаа эхэлнэ. Өмнөх “өрийн тохиролцооны журам”-ын үед томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн саналд үндэслэн, зээлдэгч болон зээлдүүлэгч нарын хооронд хэлэлцээр хийгдсэний дараа эргэн төлөлтийн төлөвлөгөө гаргаж, шүүх батална. Эргэн төлөлтийн төлөвлөгөөнд орлого болон эд хөрөнгийг бүлэглэн ангилах, хуваах талаар нарийвчлан тусгаж чөлөөлөгдөх орлогын түвшин, худалдах үл хөдлөх эд хөрөнгө, орлогыг зээлдүүлэгчдийн дунд хэрхэн хуваах талаарх журам, эргэн төлөлтийн бүтцээс гадна бусад хамааралтай үүрэг, үйл ажиллагааны талаар мөн тусгадаг. Эргэн төлөлтийн хуваарийг ихэвчлэн 5 жилийн хугацаатай гаргах бөгөөд зээлдүүлэгчид зөвшөөрсөн тохиолдолд 2 жилийн хугацаагаар сунгаж болно. Ингэхдээ, зээлдүүлэгчид насанд хүрээгүй, зээлдэгчийн гэр бүлийн бүртгэлд хүүхдүүд эсвэл 70-аас дээш насны гэр бүлийн гишүүдтэй, эсвэл зээлдэгчийн хүлээсэн үүрэг нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн анхны үнэд хүрэхгүй байгаа зэрэг хуульд заасан шалтгаан байгаа тохиолдолд байр, үл хөдлөх хөрөнгийг нь худалдан борлуулахгүйгээр үлдээж болно. Мөн худалдсан тохиолдолд зээлдүүлэгчдийн зөвшөөрлөөр, амьдралын хэрэгцээг хангах хэмжээний жижиг орон сууц болгож өөрчлөн худалдан авч болдог.

Өр төлбөрийг дуусгах үндсэн нөхцөл нь өөр өөр шатлалаар ангилж бүлэглэсэн (ипотек, давуу эрхтэй зээлдэгч, бусад болон өөр зээлд хамаарах зээл гэхчлэн ангилдаг байна) зээлдүүлэгчдэд эргэн төлөлтийг заасан доод хэмжээгээр хийх шаардлага байна. Гол зээлдэгч нь ерөнхийдөө барьцаа хөрөнгө, бусад төрлийн барьцаагаар баталгаажсан зээл олгогч ипотекийн зээлдэгчид байна. Эргэн төлөлтийн хугацаанд үл хөдлөх хөрөнгө, бусад хөрөнгийн зах зээлийн анхны үнэ нь эргэн төлөлтийн хэмжээнд хүрсэн тохиолдолд төлөлт амжилттай хийгдсэнд тооцно. Ипотекд заасан үүрэг, татвар, төлбөр, өмнөх болон одоогийн ажиллагааны зардлыг төлөхөөс өмнө хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардлыг мөн төлөх шаардлагатай. Ангиллын хувьд авч үзвэл “Бусад зээл”-д хамаарах нь 38%, “Өөр төрлийн зээл”-д хамаарах нь 5%, харин “Давуу эрхтэй зээлдэгчийн зээл” нь “Бусад зээл” гэсэн ангиллын зээлийн 120%-д хүрэх хэмжээнд эргэн төлөлт хийгдэх ёстой. Энэхүү тооцоог гаргахдаа торгуулийн хэмжээ болон хугацаа хэтэрсэн хүүгийн хэмжээг оруулах ёсгүй.

Уг ажиллагааны шатанд, амьжиргааны наад захын хэрэгцээг хангах хэмжээнээс бусад төрлийн орлого ерөнхийдөө маш хатуу зохицуулагддаг. Ингэхдээ амьдралын өртгөөс гадна байрны хэрэглээний зардал, даатгалын зардал, засвар үйлчилгээтэй холбоотой баталгаажсан тогтмол зардлуудыг мөн эргэн төлөлтийн орлогоос чөлөөлж болно.

Мөн нөгөө талаас зээлдэгчийн орлогын байдалд өөрчлөлт гарсан тохиолдолд (10%-аас дээш), онцгой төрлийн орлого орсон, шинэ хөрөнгөтэй болсон тохиолдолд шууд мэдэгдэх үүрэгтэй. Томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь зээлдэгчийг тухай бүр шалгаж, хянах боломжтой. Ерөнхийдөө эргэн төлөлтийн хуваарийн биелэлт, зээлдэгчийн хөрөнгийн борлуулалт, эргэн төлөлтийн байдал, бусад холбогдох үйл явцын талаар хагас жил тутам Зээлдүүлэгчид тайлагнах ёстой.

Хуульд заасны дагуу эргэн төлөлтийн төлөвлөгөөг шүүхээс батлах ёстой учраас эцэст нь эргэн төлөлт бүрэн хийгдсэн эсэх, үүргээс бүрэн чөлөөлөгдөх эсэхийг мөн шүүх шийдвэрлэнэ. Төлөлт амжилттай дууссан гэсэн шийдвэр гарсан тохиолдолд эргэн төлөлтийн төлөвлөгөөнд багтаагүй бүх төрлийн үүргээс шууд чөлөөлөгдөнө. Тус ажиллагаанд оролцоогүй зээлдүүлэгчдийн хувьд тохиролцооны журмыг хүчингүйд тооцохгүй ч (өмнөх болон цаашид хийгдэх) энэ ажиллагааны үед ямар нэг байдлаар эргэн төлөлт хийлгэхийг хориглоно.

Шалгуур. Ерөнхий зарчмын шалгуур буюу төлбөрийн чадваргүйдэлд тооцогдох субъектив шалгуурын хувьд: шударга байдал, хамтын ажиллагаа, хууран мэхлэх үйлдэл гаргахгүй байх зэрэг шалгуур тавигдаж байна. Харин объектив шалгуурын хувьд илүү нарийвчилсан хатуу зохицуулалт үйлчилдэг. Өрийг чөлөөлөх эргэн төлөлт хийгдэх шаардлагатай нийт хугацаа нь 1-8 жил бөгөөд гол төлөв 5 жилийн хугацаанд хэрэгждэг байна.³⁵ Төлөлт хийгдсэнд тооцох доод хэмжээ нь ангиллын хувьд гол зээлдүүлэгч болох ипотекийн зээлдүүлэгчийн хувьд үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн анхны үнээр тооцогдож байна. Энэ нь бусад улс оронд ихэнхдээ үүргийн тодорхой хувиар тооцогддог. Эцэст нь дүгнэж үзэхэд Унгарын зохицуулалтын загвар нь процесс ажиллагаа, нөхцөл, шалгуурын хувьд нэлээн төвөгтэй зохицуулалтад тооцогдож байна.³⁶

35 Bäger, 2015

36 Walter, György, and Jens Valdemar Krenchel, “The Leniency of Personal Bankruptcy Regulations in the EU Countries”, 2021, Холбоос: <https://doi.org/10.3390/risks9090162>, Сүүлд үзсэн огноо: 2022.12.20.

Ерөнхийдөө Унгарын эрх зүйн зохицуулалт нь Австрийн эхэн үеийн зохицуулалттай төстэй бөгөөд Европын орнуудын загварт багтдаг хатуу зохицуулалтын шинжүүдийг агуулжээ. Эдгээр улс орнууд процессын хувьд ерөнхийдөө адил, тухайлбал процессыг эхлүүлэхээр өргөдөл гаргасны дараа юуны өмнө шүүхийн ажиллагаанаас гадуур шийдвэрлэх, хэрэв амжилтгүй болсон тохиолдолд шүүхээр шийдвэрлэх зарчим баримталж байгаагаараа мөн адил байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсад хувь хүний дампуурлыг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлага бий эсэхийг тодруулахад судалгаагаар дэмжлэг үзүүлэх үүднээс хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын үүсэл, хөгжил, олон улсын чиг хандлага болон зарим улсын зохицуулалтыг судаллаа. Үүний үр дүнд дараах дүгнэлтийг хийв. Үүнд:

Судлагдсан байдлын хувьд

Гадаад орнуудын зохицуулалт, олон улсын чиг хандлагыг түүхчлэн судалж, харьцуулан шинжилсэн судалгааны эх сурвалжуудаас үзэхэд хувь хүний дампуурлын эрх зүй судлал, түүний дотор харьцуулсан судалгааны төрөл нэлээд хөгжсөн нь анхаарал татаж байна. Тоймловол:

Өрийг өршөөх боломж, нөхцөлийн тодорхой байдал, шуурхай буюу богино хугацаанд дампуурлын хэрэг үүсгэн шийдвэрлэх бололцоо олгосон шинжээр нь улс орнуудыг хувь хүний дампуурлын эрх зүйн консерватив, дунд зэргийн, либерал зохицуулалттай хэмээн бүлэглэсэн ангилал бий болгосон (Efrat);

Эрх зүйн институци, соёлын ялгаа, эрх зүйн гарал үүсэл болон улс төрийн ашиг сонирхол, нийгэм дэх янз бүрийн бүлгүүдийн нөлөөлөл зэргээс шалтгаалсан зохицуулалтын ялгаатай байдал, улс орнуудын зохицуулалт хоорондын үр нөлөөг тодорхойлсон (Ramsay);

Дампуурлын “нийтлэг үндэс”-ийн тодорхойлолт, шинээр эхлэх боломж, хязгаарлалт дээр тулгуурлан тухайн орны тогтолцоог тодорхойлох дөрвөн хүчин зүйл буюу зах зээл, хязгаарлалт, хариуцлага, өршөөлийн загварыг тогтоосон (Heuer);

Улс орнуудын ижил төстэй шинж чанар, ялгагдах хүчин зүйлс буюу хэмжигдэхүүн (хүртээмж, өрийн чөлөөлөлт, процесс, эрх бүхий этгээд буюу шүүх, зээлдэгч болон зээлдүүлэгчийн статус, зардал)-ийг тодруулж, тогтолцооны болон зохицуулалтын харьцуулалт гаргасан (Graziano, Kilborn зэрэг);

Өрийн хөнгөлөлтийн эрх зүйн бусад асуудалд, тухайлбал бизнес эрхлэлт, зээлийн зах зээлд нөлөөлөх хүчин зүйлс, хөдөлмөрийн нийлүүлэлтэд үзүүлэх үр нөлөө, жишээлбэл улсын түвшний томоохон өр чөлөөлөлт ба бизнес эрхлэлтийн өсөлт (Fan, White нар), бизнес эрхлэгчдэд ээлтэй дампуурлын зохицуулалт ба бизнес эрхлэлтийн хөгжлийн дэмжлэг (Lee нар), бизнесүүдийн эхлэл ба дампууралд нөлөөлсөн төрийн бодлогын холбоо хамаарал (Cumming, Li нар), өр чөлөөлөлтийн түвшин, баялгийн хуримтлал, зээлийн хатуу хязгаарлалтын харилцан нөлөөлөл (Pavan), хувь хүний дампуурлын тогтолцооны өөрчлөлт ба хөдөлмөрийн нийлүүлэлт, хөдөлмөрийн зардал, компанийн бодлогод үзүүлэх үр нөлөө (Chen нар);

Хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоог бүрэлдүүлэхдээ аж ахуйн нэгжийн дампуурлын хамаарлыг уялдуулж, зөрчилдөөн үүсэхээс сэргийлэх, эдийн засгийн үнэ цэнийг нь тодорхойлох замаар хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоог бий болгох хэрэгцээ, шаардлага, боломж (Ду Зиен) зэрэг асуудлыг судалж эргэлтэд оруулжээ.

Монгол Улсын дампуурлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа шинжилгээний болон зөвлөлдөх ажиллагаа нэлээд хийгджээ. Харин хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтыг судалсан эх сурвалж хомс байгаа нь манай улсад энэ төрлийн харилцааг хуульчлаагүйтэй холбоотой байх магадлалтай.

Эрх зүйн зохицуулалтын чиг хандлагын хувьд

Ихэнх улсад хувь хүний дампуурлын эрх зүй хөгжиж, зохицуулалтын үндсэн асуудлаас хальж өрийг хэрхэн өршөөх, үйл ажиллагааг сэргээх, шинээр эхлэх боломж хэрхэн олгох вэ зэрэг дараагийн түвшний асуудалд анхаарлаа хандуулах болжээ. Үүний нэг болох “шинэ эхлэл”-ийн бодлого нь улс орнуудад эрх зүйн шийдлийн зохистой хувилбар шаарддаг шинэ сорилт юм. Монгол Улсын тухайд судалгаанд суурилж, дотоод гадаадын эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн оролцоотой өргөн хүрээний зөвлөмжийг тусгаж Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл боловсруулсан боловч хувь хүний дампууралтай холбогдолтой зохицуулалтыг уг төсөлд тусгаагүй байна. Иймд хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ, шаардлагыг тандан судлах ажил хийгдэх ёстой. Үүнд олон улсын чиг хандлага, улс орнуудын туршлагыг харгалзах нь дамжиггүй.

Хувь хүний дампуурлын зохицуулалтыг харьцуулан судалсны дүнд тухайн харилцааг эрх зүйгээр зохицуулах асуудлын хүрээг тодорхойлох хандлага бий болсон нь мөн энэ чиглэлийн судлал хөгжсөний илрэл бөгөөд холбогдох эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд удирдамж болгож харгалзан үзэх суурь юм.

Хувь хүний дампуурлын зохицуулалтыг харьцуулан судлахдаа дампуурлын процессыг эхлүүлэх шалгуур үзүүлэлт, процесс ажиллагаа, процесс ажиллагааны үр дүн гэсэн гурван хүрээнд багцалсан асуудлуудад анхаарлаа хандуулдаг байдал нь шинээр ийм төрлийн эрх зүйн зохицуулалт бий болгох улс орнуудын хувьд мөн баримтлах шаардлага гэж үзэж болно.

Үүнээс гадна хувь хүний дампуурлын харилцааг зохицуулсан хууль тогтоомж, холбогдох ажиллагааны арга барилд нь үндэслэсэн улс орнуудын ангилал болон үүний учир шалтгааныг тодорхойлдог ялгаатай байдлуудыг анзааралгүй орхих ёсгүй. Хувь хүний дампуурлын процессоор дамжуулж зээлдүүлэгч, хариуцагчийн алины нь ашиг сонирхлыг түрүүнд тавих, хэнийг нь илүү хамгаалж, эрхийг нь хангах вэ гэсэн сонголттой нүүр тулдаг. АНУ шиг зээлдүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг илүүтэй авч үзэх үү, Европ тивийн орнуудын адил хариуцагчид ээлтэй уламжлалт хандлагыг хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт хийхдээ баримтлах уу гэдэг бодлогоо улс бүр тодорхойлж таарна.

Түүнчлэн бусад салбарын өнцгөөс бас тооцоолох асуудлууд тулгардаг болохыг судалгааны үр дүн харууллаа. Тухайлбал хувь хүний дампуурлыг зохицуулах тогтолцооны ашигтай байдал, тааламжтай арга хэмжээ (өр барагдуулах, чөлөөлөх, “шинэ эхлэл” зэрэг)-г буруугаар ашиглах буюу ёс суртахуунаас үүдэлтэй эрсдэл, дампуурлын зохицуулалтыг нийгмийн даатгал, нийгмийн халамжийн бодлоготой холбох хандлага, бизнес эрхлэх хөшүүрэг ба ажиллах хүчний нийлүүлэлтэд дампуурлын зохицуулалтын үзүүлэх нөлөө, харилцан хамаарал, оролцогч этгээдүүдийн нэр хүндийг хамгаалах, гутаан доромжлохоос сэргийлэх зэрэг асуудлыг хамтад нь авч үздэг туршлага байна.

Өөрөөр хэлбэл хувь хүний дампуурлын харилцааг эрх зүйгээр зохицуулахад дээр дурдсан үндсэн болон бусад олон талын асуудлыг харгалзан үзэх шаардлагатай гэдгийг судлаачид онцолсон нь зохицуулалтын хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, улмаар хуулийн төсөл боловсруулахад ихээхэн ач холбогдолтой юм.

“Дампуурал” гэдгийг төлбөрийн чадваргүй болсон этгээдийн үйл ажиллагаа бүрмөсөн зогсох гэж зөвхөн ойлгодог хуучирсан, явцуу ойлголтоос ангижирч, дампуурлын эрх зүйн зохицуулалтын үндсэн арга замтай зэрэгцүүлэн реорганизацийн аргыг хэрэглэх хандлагыг эрх зүйн хүрээнд төдийгүй иргэдийн ухамсар, соёлын түвшинд суулгах шаардлага байгааг мөн анзаарах хэрэгтэй.

Хувь хүний дампуурлыг тухайн хувь хүнд нь үлдээж хариуцуулахгүйгээр яагаад нийгмийн асуудал болгож, хувь хүний өрийг нийтээрээ шийдвэрлэх ёстой вэ, тэр байтугай өртэй буюу “гэм буруутай” этгээдэд шинээр эхлэх боломжийг олгох албатай юу гэх мэт нийгмийн сэтгэл зүйд байдаг уламжлалт хандлагыг бодолцох, түүнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж, бололцоо бий эсэхийг бодлогын хувьд тодорхойлох ёстой юм.

Зарим улсын туршлагын хувьд

Энэхүү судалгааны хүрээнд судлагдсан орны хувьд хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт нь дараах онцлогтой байв. Үүнд:

Америкийн Нэгдсэн Улс: АНУ-ын хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоо нь хамгийн эртний загварын нэг бөгөөд хамгийн зөөлөн тогтолцооны нэгд тооцогдож ирсэн бол шинэчлэл хийснээр зарим нөхцөл, тухайлбал зээлдэгчид тавих шаардлагыг нэмэгдүүлж, зээлдүүлэгчийг хамгаалах чиглэл баримтлах болж өөрчлөгдсөн байна.

Тус улсын Дампуурлын тухай хуульд хувь хүний дампуурлыг зохицуулах хоёр төрлийн процессыг тусгасан нь өргөдөл гаргагчдыг өр төлөх хангалттай хэмжээний орлоготой болон орлогогүй байдлыг харгалзсан тусгай ангиллыг бий болгож, зохицуулалтыг уян хатан болгоход чиглэжээ. Түүнчлэн дампуурлын зохицуулалтыг урвуулан ашиглаж байгаа эсэхийг нягтлах шалгуурыг бий болгож, тодорхой шаардлага тогтоосон.

Бүгд Найрамдах Австри Улс: Тус улсын эрх зүйн зохицуулалт нь Европын орнуудын зохицуулалтын үндсэн загвар байсан бөгөөд 2017 онд шинэчлэл хийснээр хатуу зохицуулалтаа харьцангуй зөөлрүүлсэнд тооцогдож байна.

Хувь хүний дампуурлын процесс нь “шударга санаа”-ны зарчмыг эрх зүйн зохицуулалтын үндэс болгодог; “шууд дампуурал”-ын сонголт байхгүй; шаталсан хувилбар бүхий үе шатуудтай, эвлэрлийн журмаар эхэлж, эс бүтвэл дараалан чангарсан процесс (албадан өөрчлөлт, эргэн төлөлтийн төлөвлөгөө, оролцох процесс) -ын дагуу зээлдэгчийн эрх хумигдах байдлаар ажиллагаа явагддаг.

Гэхдээ хувь хүний дампуурлын процесст “шинэ эхлэл”-ийг бодлогоор дэмжих болсноор орлого багатай өргөдөл гаргагчдад олон төрлийн боломж олгож, хамрагдах шалгуурыг цөөрүүлж, захиргааны зардлаас чөлөөлөх зэрэг арга хэмжээг нэвтрүүлснээрээ зохицуулалтын зөөлөн загварт шилжиж байгаа хандлага ажиглагдаж байна.

Унгар Улс: Тус улсын зохицуулалтын гол онцлог нь зээлдүүлэгчийн ашиг сонирхлыг илүүтэй авч үздэг учир Европын бусад орны чиг хандлагатай ижил. Гэхдээ дампуурлын процесст заавал хангах шалгуурууд (хугацаа хэтэрсэн өрийн дээд болон доод хэмжээ, зээлдэгчийн нийт хөрөнгөд эзлэх өрийн үүргийн хувь, үүргийн бүтэц г.м)-ыг илүү нарийвчлан хуульчилсан. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, эс бүтвэл шүүхийн ажиллагаа (“өрийн тохиролцооны журам”, эс бүтвэл “өр барагдуулах журам”) гэсэн шаталсан хувилбар бүхий процесстой. Унгарын зохицуулалтын загвар нь нөхцөл, шалгуур, процесс ажиллагааны хувьд нэлээн төвөгшилтэйд тооцогдож байгаа ч тодорхой нарийвчлан тусгаснаараа сайн талтай юм.

Сэдвийн судлагдсан байдал, түүгээр тогтоогдсон үр дүнд тулгуурлан авч үзвэл хувь хүний дампуурлын асуудал өргөн хүрээтэй; улс орон бүр үндэсний онцлогтоо тохирсон зохицуулалтын тогтолцоог бүрдүүлсэн ч хувьсан шинэчлэгдэж байгаа өнгө аястай байна. Үүнийг харгалзан улс орнуудын хувь хүний дампуурлын эрх зүйн тогтолцоонд харилцан уламжлал, ижилсэл, хувирал өөрчлөлтийн чиг хандлага ажиглагдаж байна хэмээн дүгнэв.

Судлагдсан 3 улсын тухайд зөөлөн зохицуулалттай АНУ зохицуулалтаа чангатгаж байгаа бол, хатуу зохицуулалттай байсан Австри Улс зохицуулалтаа зөөлрүүлэх, Унгар Улс хатуу бөгөөд төвөгтэй процесстой боловч зохицуулалтаа нарийвчлах бодлого тус тус баримталж байгаа нь анхаарал татаж байв. Энэ нь хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт чухал боловч нухацтай хандах ёстой асуудал болохыг илэрхийлнэ.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

Санал: Цаашид хууль зүйн бодлогын хүрээнд 1/Монгол Улсад хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах; 2. Хэрэв зохицуулалт хийх хэрэгцээ, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөлд тусгах, холбогдох төслийн бүрдүүлбэрийг хангахтай холбоотой судалгаа, шинжилгээг хийх; олон улсын чиг хандлага болон гадаад орнуудын туршлагыг харгалзан үзсэний үндсэн дээр үндэсний онцлогт тохирсон хувилбарыг боловсруулах шаардлагатай гэсэн ерөнхий саналыг дэвшүүлж байна.

Зөвлөмж: Монгол Улсад хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж тодорхойлох ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Дампуурлын эрх зүйн зохицуулалтад холбогдох судалгааны эх сурвалж, түүний дотор хувь хүний дампуурлын эрх зүй, гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтын болон харьцуулсан судалгааны үр дүн, судлаачдын тайлбар, санал, зөвлөмжийг харгалзан үзэх, тухайлбал энэхүү судалгааны тайлангийн дүгнэлт (судлагдсан байдал, эрх зүйн зохицуулалтын чиг хандлага, зарим улсын зохицуулалтын онцлог)-д тусгагдсан чиглэл, холбогдох арга хэмжээг сайтар нягтлах;
- Хууль тогтоомжийн тухай хуульд заасныг үндэслэн Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлахдаа тал бүрийн оролцоог хангаж хэлэлцэх, зөвлөлдөх ажиллагааг хэрэгжүүлэх, шүүхийн практик судлах, ярилцлагын арга зэрэг хэлбэрээр судлаач, мэргэжилтнүүдийн саналыг тусгах зэрэг арга зүй багтана.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж

Ном, сурах бичиг

1. Т.Мөнхжаргал, Аж ахуйн нэгжийн дампуурал: Хууль зүйн асуулт, хариулт, УБ, 1993.
2. Дампуурлын эрх зүй: гарын авлага, Шүүхийн ерөнхий зөвлөл, УБ, 2014.
3. Дампуурлын эрх зүй: гарын авлага, Шүүхийн ерөнхий зөвлөл, УБ, 2017.
4. Дампуурлын хэрэг гүйцэтгэгчдийн гарын авлага, Санхүү, эдийн засгийн дээд сургууль, УБ, 2000.
5. Бизнесийн эрх зүй: Бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага, Хууль зүйн үндэсний төв, УБ, 2003.
6. Бизнесийн эрх зүй: Хуульчдад зориулсан гарын авлага, Хууль зүйн үндэсний төв, УБ, 2003.

Магистрын зэрэг горилсон бүтээл

1. Г.Амаржаргалан, “Дампуурал, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал”, магистрын зэрэг горилсон бүтээл, Монгол Улсын Их Сургууль, 2002.
2. М.Алтанцэцэг, “Дампуурал, түүний эрх зүйн зохицуулалт”, магистрын зэрэг горилсон бүтээл, Их засаг их сургууль, 2005.
3. Б.Мөнхчимэг, “Дампуурал, түүний эрх зүйн зохицуулалт”, магистрын зэрэг горилсон бүтээл, Орхон их сургууль, 2012.
4. Л.Энхбат, “Дампуурлын хэрэг үүсгэх, шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”, магистрын зэрэг горилсон бүтээл, Монгол Улсын Их Сургууль, 2018.

Судалгааны тайлан

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Аж ахуйн нэгжийн дампуурал ба дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа* (судалгааны тайлан), 2018.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

1. М.Номинцэцэг, “Хувь хүний дампуурал”, *Бүгд Найрамдах Улс тунхагласны болон Анхдугаар Үндсэн хууль батлагдсан 80 жил, Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 13 жилийн ойд зориулж 2005 онд Ханнс-Зайделийн сангаас зохион байгуулсан Хууль зүйн салбарын залуу багш, судлаач оюутны эрдэм шинжилгээний бага хурлуудын Илтгэлийн эмхэтгэл (2004-2005)*, Ханнс Зайделийн сан, УБ, 2005.
2. Н.Баярмаа, “Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, онцлог: Гадаадын зарим орны туршлагаас”, *Эрх зүй ба эдийн засаг (илтгэл, шийдвэрийн эмхэтгэл)*, УБ, 2018.

Цахим эх сурвалж

1. Жинчанг Лай, Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчны шинэчлэл ба хөрөнгө оруулалтын орчин, 2019, https://www.mongolbank.mn/documents/press_conference/20191022_05.pdf
2. Р.Батхүү, “Аж ахуйн нэгжийн реорганизаци”, <http://asuult.net/erkhzui/niitlel/reorganization.pdf>
3. “Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”-ний тайлан, <https://forum.parliament.mn/files/148389>
4. “Хуулийн этгээд, банк санхүүгийн байгууллагын дампуурал” сэдэвт судалгааны тайлан, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох-чадавхийг бэхжүүлэх” төсөл, 2016. https://cdeaproject.files.wordpress.com/2016/12/2-dampuural.pdf?fbclid=IwAR1HQ0Hfws3innlHFhP1ovJggpL7_tB5Y5-r6wBwdYY-vVNo2BL84aE3Wg

Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Chen, Yi-Wen W., Joseph T. Halford, Hung-Chia Scott Hsu, and Chu-Bin Lin, “Personal Bankruptcy Laws and Corporate Policies”, *Journal of Financial and Quantitative Analysis* 55(2020).
2. Cumming, Douglas, and Dan Li, “Public policy, entrepreneurship, and venture capital in the United States”, *Journal of Corporate Finance* 23(2013).
3. Efrat, Rafael, “Global trends in personal bankruptcy”, *American Bankruptcy Law Journal* 76 (2002).
4. Fan, Wei, and Michelle J. White, “Personal bankruptcy and the level of entrepreneurial activity”, *Journal of Law and Economics* 46(2003).
5. Heuer, Jan-Ocko, “Rules and Norms of Consumer Insolvency and Debt Relief: A Comparison and Classification of Personal Bankruptcy Systems in 15 Economically Advanced Countries”, Ph.D.thesis, University of Bremen, Germany
6. György Walter, “Personal Bankruptcy: Model structures and the fresh start”, *Corvinus University of Budapest*, 2020.
7. Graziano, Thomas Kadner, Juris Bojars, and Veronika Sajadova, eds, “A Guide to Consumer Insolvency Proceedings in Europe”, *Cheltenham and Northampton: Edward Elgar Publishing*, 2019.
8. Kilborn, Jason J, “Fatal Flaws in Financing Personal Bankruptcy: The Curious Case of Russia in Comparative Context”, *American Bankruptcy Law Journal* 94(2020).
9. Lee, Seung-Hyun, Yasuhiro Yamakawa, and Mike W. Peng, “Entrepreneurship and the Barrier to Exit: How Does an EntrepreneurFriendly Bankruptcy Law Affect Entrepreneurship Development at a Societal Level? The Office of Advocacy Small Business Working Papers”, Washington, DC: U.S. Small Business Administration, Office of Advocacy.
10. Pavan, Marina, “Consumer durables and risky borrowing: The effects of bankruptcy protection”, *Journal of Monetary Economics* 55(2008).

11. Ramsay, Iain, "Comparative consumer bankruptcy", *University of Illinois Law Review* (2007).
12. Ramsay, Iain, "Between neo-liberalism and the social market: Approaches to debt adjustment and consumer insolvency in the EU", *Journal of Consum Policy* 35 (2012).
13. 杜籽燕, "个人破产法律制度的比较研究", 西南科技大学法学院, 区域治理, 2022, 第37期.

ГУРАВ. ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ
ҮҮРГИЙН ТОГТОЛЦОО (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Судалгааг удирдсан:

С.Сүхбаатар	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (LL.D)
-------------	---

Судалгааны багийн гишүүн:

Б.Түмэндэмбэрэл	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Э.Анударь	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Энэхүү судалгааг ХЗҮХ-ийн 2022 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.6-д заасны дагуу хийсэн болно.

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2022.12.30.

АГУУЛГА

I. УДИРТГАЛ.....	62
II. ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ ҮҮРГИЙН ОЙЛГОЛТ, ЗАРЧИМ.....	63
2.1. Гэм хорын эрх зүйн онол	63
2.1.1. Залруулах шударга ёсны онол	63
2.1.2. Шийтгэлийн шударга ёсны онол	65
2.2. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн ойлголт	68
2.2.1. Нэр томьёоны тайлбар.....	68
2.2.2. Хууль зүйн ойлголт	70
2.2.3. Гэм хорын эрх зүйн үндсэн зарчим	71
2.2.3.1. Гэм буруутайгаар хариуцлага хүлээх зарчим.....	72
2.2.3.2. Гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарим	72
III. МОНГОЛ УЛСЫН ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ ҮҮРГИЙН ТОГТОЛЦОО	75
3.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго	75
3.1.1. Залруулах шударга ёсыг тогтоох зорилго	75
3.1.2. Шийтгэлийн шударга ёсыг тогтоох зорилго	78
3.2. Гэм хорын ерөнхий зохицуулалт.....	80
3.3. Гэм хорын тусгай зохицуулалт	80
3.3.1. Байгууллага, албан тушаалтан бусдад учруулсан гэм хор	81
3.3.2. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хор.....	85
3.3.3. Барилга, байгууламж барих, ашиглах явцад учирсан гэм хор	90
3.3.4. Амьтны учруулсан гэм хор	93
3.3.5. Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойронд аюултай бусад зүйлээс учирсан гэм хор.....	98
3.3.6. Насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй иргэний учруулсан гэм хор	102
3.3.7. Үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгохгүй буюу өөрийгөө зөв удирдах чадваргүй байхдаа учруулсан гэм хор	105
3.3.8. Бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хор.....	106
IV. ГАДНЫ ОРНЫ ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ ҮҮРГИЙН ТОГТОЛЦОО ..	110
4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс.....	110
4.1.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго	111
4.1.2. Гэм хорын ерөнхий зохицуулалт	111
4.1.3. Гэм хорын тусгай зохицуулалт	112
4.2. Бүгд Найрамдах Франц Улс	114

4.2.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго	114
4.2.2. Гэм хорын ерөнхий зохицуулалт	115
4.2.3. Гэм хорын тусгай зохицуулалт	115
4.3. Япон Улс.....	116
4.3.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго	117
4.3.2. Гэм хорын ерөнхий зохицуулалт	117
4.3.3. Гэм хор учруулсан тооцохгүй зохицуулалт	117
4.3.4. Гэм хорын тусгай зохицуулалт	118
V. ДҮГНЭЛТ.....	120
НОМ ЗҮЙ.....	121

I. УДИРТГАЛ

Монгол Улс гэм хорын ерөнхий болон тусгай зохицуулалтыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын (цашайд ХБНГУ гэх) үүргийн эрх зүйн тогтолцооны загвар дээр суурилж хуульчилсан бөгөөд 2002 оны Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалт хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн. Гэвч өөрт учирсан гэм хорыг иргэний журмаар арилгуулах иргэдийн эрх зүйн сэтгэлгээ, мэдлэг төдийлөн төлөвшөөгүй байна.

Аливаа улсын хувийн эрх зүйн тогтолцоонд гэм хор учруулснаас үүсэх үүрэг буюу иргэний эрх зүйн зөрчлийн улмаас үүссэн үүргийн зохицуулалт томоохон байр суурь эзэлдэг. Учир нь иргэд аливаа зөрчлөөс өөрийн хохирсон эрх ашгийг нөхөн сэргээх, хохирлоо барагдуулах боломжтой гол хөшүүрэг нь гэм хорын эрх зүй юм. Бусад салбар эрх зүйгээр, тухайлбал эрүүгийн эрх зүй нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага оногдуулж, торгуулийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлдэг бол гэм хорын эрх зүйгээр хуульд заасан эрхээ сэргээлгэх, өөрт учирсан хохирлыг иргэд бодитой нөхөн төлүүлэх боломжтой байдгаараа давуу талтай.

Тус судалгааны ажлын зорилго нь гэм хорын эрх зүйн үндсэн зарчим, онолын үндэслэлийг тайлбарлахаас гадна гаднын зарим улсын гэм хорын эрх зүйн тогтолцоог судалснаар Монгол Улсын гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцоонд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, даван туулах арга замыг эрэлхийлэхэд оршино.

Энэхүү судалгааны хүрээнд гэм хор учруулснаас үүсэх үүргийн ойлголт, онолын үндэслэлийг эх газрын болон англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудад хөгжиж ирсэн үзэл санаагаар тодорхойлох; Монгол Улсын Иргэний хуульд заасан гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий болон тусгай зохицуулалтад дүн шинжилгээ хийх; эрх зүйн тогтолцоо, соёл, сэтгэлгээ ойролцоо гаднын зарим улсын гэм хорын эрх зүйн ерөнхий болон тусгай зохицуулалтыг судлах болно.

Түүнчлэн тус судалгааг баримтын судалгааны арга болон харьцуулсан судалгааны аргаар гүйцэтгэх бөгөөд судалгаа нь удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт гэсэн гурван үндсэн бүрэлдэхүүнтэй.

II. ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ ҮҮРГИЙН ОЙЛГОЛТ, ЗАРЧИМ

2.1. Гэм хорын эрх зүйн онол

Гэм хор учруулснаас үүсэх үүргийг судалдаг гол салбар эрх зүй бол гэм хорын эрх зүй. Гэм хорын эрх зүй нь хохирол барагдуулах (providing compensation), эрсдэлийг хуваарилах (loss shifting and spreading), хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх (deterrence) зэрэг хэд хэдэн зорилгыг агуулж байдаг. Эдийн засгийн агуулгаар гэм хорын эрх зүй нь үр ашиггүй байдлыг багасгах (avoidance of inefficient behaviour) зорилготой байна.¹ Үүнээс гадна хохирогчтой эвлэрэх буюу сэтгэл хангалуун болгох, түүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тодорхой хэрэг маргаан дээр бодит нөхцөл байдлыг тогтоох зэрэг зорилгыг агуулж байдаг.²

Гэм хорын эрх зүйн эдгээр зорилгууд нь улс болгоны гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтад тусгалаа олсон байдаг. Иргэний журмаар хохирлоо барагдуулах зорилгын суурь болсон онол бол залруулах шударга ёсны онол юм. Харин англи-америкийн эрх зүйн тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг иргэний эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын үндэс болдог онол бол шийтгэлийн шударга ёсны онол юм. Эдгээр хоёр онолын ач холбогдлыг шууд харьцуулан жинлэх боломжгүй боловч Монгол Улс болон бусад улс орны гэм хорын эрх зүйн тогтолцоонд хэрхэн биежсэн болохыг тодруулахын тулд дэлгэрүүлэн авч үзье.

2.1.1. Залруулах шударга ёсны онол

Залруулах шударга ёсны онолыг (corrective justice) гэм хорын эрх зүй, гэрээний эрх зүй болон бусад салбар эрх зүйн зорилгыг тайлбарлахад хэрэглэдэг бөгөөд гэм хорын эрх зүйд ач холбогдолтой эдийн засгийн бус онол юм. Энэхүү онолоор гэм хорын эрх зүйг нэг болон хоёр дахь үүргийн тогтолцоо гэж үздэг. Нэг дэх үүрэг нь гэмтэл, хохирол учруулахгүй байх. Хоёр дахь үүрэг нь нэг дэх үүргийг зөрчсөн тохиолдолд түүнийгээ залруулах. Тэрхүү хохирол учруулсан үйлдэл нь зөрчлийн шинжтэй байна. Үүний тулд хохирол учруулсан этгээдийн ёс суртахууны байдлыг харгалзахгүй бөгөөд гагцхүү хохирогчийн эрхийг зөрчсөн байхыг л шаардана. Тиймээс ч гэм хор учруулсан байхын тулд нэг талд заавал хохирогч байдаг бөгөөд гэм хорын эрх зүйгээр хүний зүй бус үйлдлийг бус тодорхой зөрчлийг зохицуулдаг байна.³

Аристотелийн үзэл санаанаас үндэстэй тус онолын үүднээс А нь хууль зөрчиж Б-д хохирол учруулсан бол түүнийгээ залруулж, Б-ын хохирлыг барагдуулах учиртай. Ингэхдээ хохирол барагдуулах үүрэг гагцхүү А шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхийн шийдвэр гарснаар үүснэ. Гэвч хохирол барагдуулах гэдэг авснаа буцаахаас илүү төвөгтэй ойлголт юм. Бурууг засах олон хэлбэр (эргүүлэн өгөх, нөхөн төлөх, уучлалт гуйх) байдаг ч засрахаас илүү засрахгүй зүйл нь их. Тухайлбал, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, хүний нэр төрийг гутаан доромжлох зэргийг буцаан сэргээх боломжгүй тул энэ онолын үүднээс авч үзэхэд илүү төвөгтэй байдаг.

1 W.van Gerven, Tort Law, Casebooks for the Common Law of Europe, Hart publishing, 2000, p.18-21.

2 Loth, Marc, "Corrective and distributive justice in tort law: On the restoration of autonomy and a minimal level of protection of the victim", Maastricht Journal of European and Comparative law, 22(6), p.791-792.

3 R.Arthur, Theories of the Common Law of Torts, Холбоос: <https://plato.stanford.edu/entries/tort-theories/> CorJus, сүүлд үзсэн огноо: 2022.03.24.

Учир нь аливаа зөрчлийг “залруулсан” гэж үзэх хүн бүрийн хандлага ч ялгаатай байдаг. Иймд залруулах шударга ёсны онолын дагуу хохирол учруулсан этгээдийн үйлдлийг жинлэх бус хохирогчийг гомдолгүй болгоход анхаардаг байна. Энэ үүднээс гэм хорын эрх зүйн зорилгыг хариуцагчаас нэхэмжлэгчид мөнгөн төлбөр шилжүүлэх бус хохирогч, гэм хор учруулагчийг эвлэрүүлэх гэж харах нь зүйтэй юм.⁴

Залруулах шударга ёсны онол дээр үндэслэн гэм хорын эрх зүй дэх гэм буруутайгаар хариуцлага хүлээх зарчмыг тайлбарлах боломжтой болдог. Учир нь тус онолын үүднээс аливаа этгээдэд учирсан хохирол гэм хор учруулагчийн санаатай болон болгоомжгүй үйлдэлтэй шалтгаант холбоотой байна. Гэтэл нөгөө талаасаа гэм хорын эрх зүйгээр ослын улмаас учирсан хохирлыг аюултай үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцдаг. Энэ тохиолдолд осол хэн нэгний шууд буруутай эсхүл хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээс шалтгаалаагүй байдаг. Ийнхүү ослын улмаас гэм хор учирсан тохиолдолд тус онолын үүднээс хохирол барагдуулах үндэслэлийг тайлбарлахад бэрхшээлтэй байна.

Эдийн засгийн болон улс төрийн эрдэмтэн судлаачид залруулах шударга ёсны онолыг хэд хэдэн үндэслэлээр шүүмжилдэг байна. *Нэгдүгээрт*, гэм хорын эрх зүй нь үр ашгийг (efficiency) тэргүүнд тавьдаг. Тэр ч утгаараа гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмын дагуу “хамгийн бага зардлаар эрсдэлийг бууруулах боломжтой этгээд” (the least cost avoider) гэм буруутай эсэхээсээ үл хамааран бүх хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй байдаг. *Хоёрдугаарт*, хуульд нийтийн эрх ашиг сонирхол үргэлж шингэсэн байдаг гэх инструментализмын онолын үүднээс гэм хорын эрх зүйг хардагтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйн салбарт хувь этгээдүүдийн хоорондын харилцааны цаана нийтийн эрх ашиг байнга хөндөгдөж байдаг учраас гэм хорын эрх зүй нь бүхэлдээ нийгмийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэдэг байна.⁵

Ийнхүү залруулах шударга ёсны онолын дагуу гэм хорын эрх зүй нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эрх ашиг сонирхолд учруулсан гэм хорыг нэхэмжлэлийн үндсэн дээр гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, хохирогчийг сэтгэл хангалуун буюу хохиролгүй болгоход чиглэнэ. Өөрөөр хэлбэл, болоод өнгөрсөн үйл явдлыг шүүх хуралдаанаар шийдвэрлэж, хохирогчийн алдагдал буюу хохирлыг гэм хор учруулсан тал барагдуулснаар шударга ёс тогтсон гэж үзэх юм.

Харин ирээдүйд бий болох томоохон осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчим зэргийг тус онолын дагуу тайлбарлах боломжгүй байна. Үүнийг шударга ёсны онолоор бус эдийн засгийн онолын үүднээс авч үздэг бөгөөд энэхүү судалгаагаар эдийн засгийн онолуудыг дэлгэрүүлэхгүй болно. Харин нийтийн ашиг сонирхлыг гэм хорын эрх зүйгээр хамгаалах зорилгыг агуулдаг шийтгэлийн шударга ёсны онолыг авч үзье. Ингэснээр Монгол Улсад гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалт хэрэгжихэд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулах ач холбогдолтой гэж үзлээ.

4 Scott Hershovit, Corrective justice for civil recourse theorists, Хонбоос:

<https://web.law.columbia.edu/sites/default/files/microsites/law-theory-workshop/files/Corrective%20Justice%20for%20Civil%20Recourse%20Theorists.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.03.24.

5 Benjamin C. Zipursky, “Civil recourse, not corrective justice”, The Georgetown law journal, Vol.91:695, (2003), p.695-697.

2.1.2. Шийтгэлийн шударга ёсны онол

Шийтгэлийн шударга ёсны (distributive justice) үндсэн зорилго нь зөрчил үйлдсэн хүнийг буруутгахаас илүүтэй тийм үйлдэл гаргахаас айдас бий болгох замаар тогтоон барихад оршдог. Уг шударга ёсны зарчим гэм хорын эрх зүйд ялын журмаар гаргуулах хохирлын хэлбэрээр (punitive damages) тусгалаа олсон байна.

Залруулах шударга ёсны онолын дагуу А нь Б-д бодитой учруулсан хохирлыг барагдуулах ёстой байсан бол шийтгэлийн шударга ёсны онолын дагуу А нь Б-д учруулсан хохирлоо барагдуулахаас гадна шүүгч бусад этгээдэд А-д учирсан шиг гэм хор ахин учрахаас урьдчилан сэргийлж, Б-ээс нэмэлтээр нөхөн төлбөр гаргуулан А-д өгөхийг хэлнэ. Үүнийг гэм хорын эрх зүйд ялын журмаар гаргуулах хохирол⁶ гэдэг байна.

Ялын журмаар гаргуулах хохирол гэж иргэний эрх зүйн зөрчлөөс бий болсон бодит хохирол (compensatory damages)-ыг барагдуулахаас гадна гэм хор учруулсан этгээдэд нэмэлтээр төлөхийг шаардсан “торгууль”-ийн шинжтэй мөнгөн дүнг хэлнэ. Үүнийг Black’s Law Dictionary толь бичигт “Хариуцагчийн хайхрамжгүй, өс хонзонтой, эсхүл хуурч мэхэлсэн үйлдлийн төлөө түүний бусдад учруулсан бодит хохирол дээр нэмэгдэж төлөхөөр тогтоосон мөнгөн дүнг хэлнэ.”⁷ гэжээ.

Ялын журмаар гаргуулах хохирлын хэлбэр хамгийн анх МЭӨ 2000 оны Хаммурабийн хуульд тусгалаа олсон гэж үздэг. Харин Ромын эрх зүйд шийтгэлийн шударга ёсыг хүлээн зөвшөөрдөг байсан эсэх дээр түүхч судлаачид маргаантай байр суурьтай байдаг байна.⁸ Ялын журмаар гаргуулах хохирлыг АНУ-д “punitive damages”, Их Британид “exemplary damages”, Франц улсад “amende civile” гэсэн нэр томъёогоор илэрхийлж байна.

Англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудад шүүхээс гэм хор учруулсны улмаас олсон ашгаас нөхөн төлбөр гаргуулах эсхүл гэм хор учруулагчийн эд хөрөнгийг хумих зорилгоор нэхэмжлэгчид учруулсан хохирлоос өндөр үнийн дүнгээр нөхөн төлбөр гаргуулах замаар шийтгэл хүлээлгэдэг байна.⁹ Харин эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудад ялын журмаар гаргуулах хохирлын асуудал маргаантай сэдэв хэвээр байна.

АНУ-ын Хоёр дахь тойргийн давж заалдах шатны шүүгч, Йелийн хуулийн сургуулийн эмирит профессор Guido Calabresi шийтгэлийн шударга ёс нь гэм хорын эрх зүйд таван чиг үүрэгтэй талаар тайлбарлажээ. Үүнд:

6 Энэхүү судалгааны ажилд “punitive damages” гэсэн нэр томъёог монгол хэлэнд С.Нарангэрэл, Хууль зүй судлалын англи-монгол тайлбар тольд ялын журмаар гаргуулах хохирол гэснээр буулган хэрэглэв.

7 Bryan A. Garner, editor in chief. Black’s Law Dictionary, 9th ed., Thomson Reuters, 2009, p.448. [punitive damages. Damages awarded in addition to actual damages when the defendant acted with recklessness, malice, or deceit; specif., damages assessed by way of penalizing the wrongdoer or making an example to others. Punitive damages, which are intended to punish and thereby deter blameworthy conduct, are generally not recoverable for breach of contract.]

8 Marco Cappelletti, Comparative reflections on Punishment in Tort law, in Jean-Sébastien Borghetti and Simon Whittaker (eds), French Civil Liability in Comparative Perspective, Hart Publishing, 2019, p.329.

9 Maud Laroche, “Reconnaitre de très larges pouvoirs au juge : le juge peut-il considérer les comportements du responsable et de la victime”, Revue de Jurisprudence Commerciale, Juillet/Août Numéro 4 (2013), p.1-2.

1. **Нийгмийн хэв журмыг (societal norms) хамгаалах чиг үүрэг**- гэмт хэргийн шинж агуулсан ч эрүүгийн журмаар шийдвэрлэхэд бэрхшээлтэй үйлдлийг иргэний журмаар шийдвэрлэж болох бөгөөд шүүхээс тогтоосон нөхөн төлбөр нь нөгөө талаараа “шийтгэл” болдог байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн журмаар шийдвэрлэхэд бэрхшээлтэй хэргийг иргэний журмаар өмгөөлөгчийн тусламжтайгаар мөрдөж, өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүн өөрөө хамгаалах боломжтой юм. Үүнийг хэрэгжүүлэхэд хариуцагч хохирлыг нөхөн төлөх санхүүгийн чадамжтай байх чухал. Гэвч нөхөн төлбөрийн хэмжээг хэт өндөр тогтоосон нөхцөлд double jeopardy буюу нэг гэм буруутай этгээдэд нэг удаа хариуцлага хүлээлгэх зарчим хөндөгддөг байна.
2. **Үржүүлэх чиг үүрэг**- өмнө нь амьдрал дээр хохирч байсан ч хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй хохирогч нарын хохирлын хэмжээгээр үржүүлж, нөхөн төлбөрийн хэмжээг өндөр тогтоохыг хэлнэ. Түүнчлэн нэхэмжлэгч хэргийн харьяаллаас хамааран аль нэг шүүхэд амжилт олохгүй байх эрсдэлийг тооцоолж, бүх аргаар хохирлоо нөхөн төлүүлэх агуулгаар мөн ойлгоно.
3. **“Эмгэнэлтэй сонголт”-ын чиг үүрэг**- энэ нь бусдын санаатай болон болгоомжгүй үйлдэл өндөр гарз, хохирол учруулж болзошгүй нөхцөл бүрдүүлсэн тохиолдолд тухайн этгээдийг анхаарал болгоомжгүй байсных нь төлөө торгуулийн шинжтэй мөнгөн дүн гаргуулахыг ойлгоно. Жишээ нь, *Grimshaw v. Ford Motor Company (the Pinto case)* маргаан дээр Форд компани хийн түлштэй тээврийн хэрэгслийг газ дэлбэрэх эрсдэлтэй газар байрлуулсан учраас өндөр хэмжээний төлбөр төлөх болсон юм. Олон хүний амь насанд эрсдэл учруулахуйц тэрхүү үйлдэл нь бодит хохирол хэн нэгэнд учруулаагүй ч шүүх тус хэрэгт шийтгэлийн шударга ёсыг тогтоосон байна.
4. **Арилгах боломжгүй хохирлыг барагдуулах чиг үүрэг**- бодитой учирсан хохирлыг (compensatory damages) арилгах боломжгүй, тухайлбал сэтгэл санааны хохирлыг бүрэн нөхөн төлөх боломжгүй нөхцөлд ач холбогдолтой байдаг.
5. **Хувь хүнийг хохиролгүй болгох чиг үүрэг**- энэ үзэл санаагаар зүгээр нэг хохирол барагдуулаад дуусах нь хангалтгүй гэж үздэг бөгөөд хүний эрхийг ноцтой зөрчсөн үйлдэлд нь хариу авах, Үндсэн хуульд заасан бүхий л арга хэмжээг авч хүний эрхийг хамгаалахыг шаарддаг байна.¹⁰

Ийнхүү шийтгэлийн шударга ёсны онол англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудын гэм хорын эрх зүйн тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг. Энэ нь залруулах шударга ёсны үүднээс залруулах боломжгүй хохиролд “шийтгэл”-ийн шинжтэй нөхөн төлбөрийг хариуцагчаас гаргуулахыг ойлгоно. Ингэснээр тодорхой этгээд, эсхүл тодорхой гэм хорын улмаас нийтийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлдэг байна.

Гэвч нөгөө талаараа хэн нэгнийг иргэний журмаар “шийтгэх” бодлогыг нийгэм дэх зөрчлийн хэв шинжээс шалтгаалж янз бүрээр тогтоох хэрэгтэй. Эс тэгвэл гэм хорын эрх зүй нь хувийн эрх зүйн хүрээнээс хальж, эрүүгийн эрх зүйтэй давхардах

10 Guido Calabresi, *The complexity of torts- the case of punitive damages*, Exploring tort law, ed. by M. Stuart Madden, Cambridge University Press, 2005, p.333-346.

эрсдэл үүсэхээс гадна гэмт хэргийн улмаас учруулсан гэм хорыг нөхөн төлөхөд гэм буруугийн зарчим хөндөгдөж эхэлнэ. Иймд эрүүгийн болон гэм хорын эрх зүйн нийтлэг болон ялгаатай шинжийг нарийн авч үзэх хэрэгтэй.

Эрүүгийн эрх зүй бол хүмүүсийн нийтлэг эрх ашгийг хамгаалахад зориулагдсан эрх зүйн салбар юм. Хэдийгээр нэг талаас нийгмийн буюу хүмүүсийн нийтлэг эрх ашгийг илэрхийлж, хамгаалах төр- нөгөө талаас тэрхүү нийтлэг эрх ашигт халдаж гэм хор учруулсан “гэмт хэрэгтэн” хоёрын хооронд үүсэж буй гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлыг эрүүгийн эрх зүйгээр зохицуулж буй мэт боловч энэхүү зохицуулалтын зорилго нь Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон үнэт зүйлс, нийтлэг эрх ашгийг хамгаалах явдал байдаг.¹¹

Ийнхүү эрүүгийн эрх зүйд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго байдаг бол гэм хорын эрх зүй нь мөн адил иргэний эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгыг агуулж байдаг юм.

Нийгэмд хохирол учруулсан зөрчил нь эрүүгийн хариуцлагын зүйл байдаг бол хувь этгээдэд хохирол учруулсан зөрчил нь хувийн эрх зүйн хариуцлагын (тэр дундаа ялын журмаар гаргуулах хохирол) зүйл болно. Тус хоёр хариуцлага нь өөр өөрийн ялгагдах шинжтэй: эрүүгийн хариуцлагын цаана уг үйлдлийг гаргахаас сэргийлэх төрийн ашиг сонирхол байдаг бол ялын журмаар гаргуулах хохирлын цаана өшөө авах хувь хүний ашиг сонирхол байдаг.¹²

Нэг талаас, иргэний маргаанд нэхэмжлэлийн шаардлагад баригдаж шүүх хэргийг шийдвэрлэдэг байхад нийгмийн “шаардлага”-аар хүнийг шийтгэх хүрээнд өндөр хэмжээний нөхөн төлбөр төлөх шийдвэр гаргах боломжгүй юм. Нөгөө талаас, ялын журмаар хохирол гаргуулах хохирол (punitive damages) нь хувь хүн, түүний өмгөөлөгчид өөрсдөө мөрдөн байцаалт хийж, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд хүчтэй хөшүүрэг бий болгож, эрүүгийн хуулийн зарим хийдлийг нөхдөг байна. Ингэснээр торгуулиа төлөөд хууль тогтоомжийг дураараа зөрчиж, өөрийнхөө хууль бус үйлдлийг хохирол барагдуулах байдлаар зөвтгөдөг этгээд нийгмийн өмнө хариуцлага хүлээх боломжтой болдог. Энэ нь ихэвчлэн эдийн засгийн том тоглогч, нөлөө бүхий этгээдүүдийн харилцаанд ач холбогдолтой байна. Иймээс ч эдийн засгийн үр ашгийг эрэлхийлсэн онолд шийтгэлийн шударга ёсыг эрхэмлэсэн байр суурь давамгайлдаг. Эдгээр онолын зорилго нь гэм буруутай этгээдийг шударга ёсны өмнө бөхийлгөхөөс илүүтэй айдас бий болгох замаар тодорхой үйлдэл хийхийг зохистой хэмжээнд хязгаарласан хэм хэмжээг тогтооход оршдог.¹³

Ийнхүү уг асуудал хоёр талтай бөгөөд эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудад маргаантай сэдэв хэвээр байна. Тухайлбал, Франц улсад шийтгэлийн шударга ёсыг няцаасаар ирсэн бөгөөд гэм хорын эрх зүй нь гагцхүү хохирлыг нөхөн төлөхөд чиглэх хэрэгтэй ба шийтгэлийг эрүүгийн эрх зүйн зохицуулах асуудлаар нь үлдээх хэрэгтэй гэж үздэг байв. Учир нь гэм хорын эрх зүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй нэгэн адилаар шийтгэл оногдуулснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхүүдийг хамгаалахгүйгээр хариуцагчийг

11 Эрүүгийн эрх зүйн гарын авлага, (ҮБ, 20070, 45 дахь тал.

12 Guido Calabresi, The complexity of torts- the case of punitive damages, Exploring tort law, ed. by M.Stuart Madden, Cambridge University Press, 2005, p.335.

13 Marco Cappelletti, Comparative Reflections on Punishment in Tort Law in Jean-Sébastien Borghetti and Simon Whittaker (eds), French Civil Liability in Comparative Perspective, Hart Publishing, 2019, p.332-333.

шийтгэх нөхцөл бүрдэнэ хэмээн тайлбарладаг байжээ.¹⁴

Харин 19-р зууны хагасаас томоохон хэмжээний осол олноор гарах болсноор даатгалын тогтолцоо хөгжих үндэс болж, Францын гэм хорын эрх зүй нь хувь хүний хариуцлагаас илүү нийгмийн хариуцлагын тогтолцоо руу шилжиж эхэлсэн. Үүнээс үүдэн нэхэмжлэгч хариуцагчийн хооронд үүсэх сонгодог харилцаанаас илүүтэй нийтийн ашиг сонирхолд тулгуурласан гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцаа хүчтэй байр суурь эзлэх болсон байна. Үүнд үндэслэн БНФУ-ын Хууль зүйн яамнаас “Projet de réforme” буюу иргэний эрх зүй дэх өөрчлөлтийг боловсруулан батлуулсан юм.

Үүнээс харвал, шийтгэлийн шударга ёсны онол гэм хорын эрх зүйн үүргийг тайлбарлахад ач холбогдолтой гол онолын нэг байна. Улс орнууд гэм хорын эрх зүйн тогтолцоонд шийтгэлийн шударга ёсны онолын үүднээс ялын журмаар гаргуулах хохирлыг хүлээн зөвшөөрөх эсэхийг эрүүгийн болон ялын бодлогыг тодорхойлохтой ижил зарчмаар шийдвэрлэх нь зүйтэй юм. Эрүүгийн бодлогын тусламжтайгаар нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, ямар төрөл, хэмжээний ял, бусад төрлийн эрүүгийн хариуцлага хүлээлгэх, үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохтой холбоотой бусад институтийг хэрхэн бүрдүүлэх үзэл баримтлалыг тодорхойлдог.

Иймд ялын бодлогын тусламжтайгаар нийгмийн хөгжил, гэмт явдлын байдал, хандлагад нийцүүлэн гэмт хэрэгт ял ногдуулахад баримтлах үзэл баримтлал төлөвшдөгтэй ижил гэм хорын эрх зүйд шийтгэлийн шударга ёсны онолыг баримтлах эсэхийг хууль тогтоогч оновчтой тодорхойлох шаардлагатай байна. Монгол Улсын гэм хорын эрх зүйд тус онол хэрхэн нөлөөлж буйг судалгааны ажлын III бүлэгт дэлгэрүүлэн авч үзэх болно.

2.2. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн ойлголт

2.2.1 Нэр томьёоны тайлбар

Гэм хор учруулснаас үүсэх үүрэгт гэрээний бус үүргийг ойлгодог бөгөөд германаар “deliktsrecht”, францаар “responsabilité civile délictuelle”, англиар “tort”, “non-contractual liability”, оросоор “деликтные обязательства” гэж нэрлэдэг байна. Гэрээний бус үүрэг гэж буйн шалтгаан нь гэм хорын эрх зүй болон гэрээний эрх зүй хохирол нөхөн төлөх арга хэрэгсэл, зорилгоороо ялгаатайд оршино. Гэрээний эрх зүй нь гэрээний талуудын баялгийг төлбөр, бараа бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр нэмэгдүүлэхэд чиглэдэг бол гэм хорын эрх зүйгээр хувь хүнийг хамгаалах, түүний баялгийн бүрэн бүтэн байдлыг хадгалан хамгаалахад чиглэдэг. Хувийн эрх зүйн энэхүү хоёр салбар хоорондоо нягт уялдаатай бөгөөд өөр өөрийн гэсэн онцлогтойгоор бие даан оршдог байна.

Гэм хор учруулснаас үүсэх үүргийн ойлголтыг зөв ойлгож, судлахын тулд юуны түрүүнд нэр томьёоны хэрэглээнд ач холбогдол өгөх шаардлагатай. Гэм хорын эрх зүйн харилцаанд гол хэрэглэгддэг хэд хэдэн нэр томьёо бий. Эдгээрт “tort”, “harm”, “damages”, “wrongs”, “liability” зэрэг орно. Академич С.Нарангэрэлийн “Хууль зүй судлалын англи-монгол тайлбар толь”-д эдгээр нэр томьёог монгол хэлэнд дараах байдлаар буулгажээ. Үүнд:

14 C Jauffret-Spinosi, Les dommages-intérêts punitifs dans les systems de droit étrangers.

- Tort- иргэний эрх зүйн зөрчил;
- Harm- гэм хор;
- Damages- хохирол;
- Punitive damages- ялын журмаар гаргуулах хохирол;
- Wrongs- гэм хор, эрх зүйн зөрчил;
- Liability- хариуцлага;
- Strict liability- хатуу хариуцлага.

Дээрх нэр томьёог “Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг” болон үндэсний бусад эх сурвалж, АНУ-ын хууль зүйн толь бичиг болох “Black’s Law Dictionary”-д буй тодорхойлолттой харьцуулж үзэх замаар монгол хэлэнд оновчтой буулгахыг оролдъё.

Хүснэгт 3.1. Гэм хорын эрх зүйн монгол, англи нэр томьёог харьцуулсан нь

Үндэсний толь бичиг	Black’s Law Dictionary
Гэм хор (англ. harm)- иргэний эрх зүйд хохирогчийн эд хөрөнгийн буюу материаллаг бус баялгийг (амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэг) багасгах, устгах, хөндөх замаар илэрхийлэгдэх материаллаг хохирол. Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус хохирлын аль алиныг багтаана. Хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт “хохирол” гэсэн нэр томьёог нэлээдгүй хэрэглэдэг. “Гэм хор” ба “хохирол” гэсэн нэр томьёо нь өөр хоорондоо яг нийцдэггүй. ¹⁵	Tort- хохирлын хэлбэрээр нөхөн төлөгдөх боломжтой, гэрээний үүргийг зөрчихөөс бусад иргэний эрх зүйн зөрчлийг ойлгоно. Түүнчлэн тэдгээр зөрчлийг зохицуулж буй салбар эрх зүйг илэрхийлж болно; аливаа этгээдүүд хоорондын харилцаанд хуульд заасан үүргээ зөрчснийг хэлнэ. Мөн эдгээр зөрчлийг зохицуулж буй салбар эрх зүйг ойлгодог. ¹⁶ Harm- гэмтэл, гарз, материаллаг буюу биет хохирол. ¹⁷
Хохирол (англ. damages)- иргэний эрх зүйд нэг этгээдийн хууль зөрчсөн үйлдлээр нөгөөд учруулсан мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдсэн алдагдал, хөнөөл, сүйтгэл. Хохирол нь: 1/ хэн нэгэн этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнийг сэргээн тогтоолгоход гаргах ёстой зардал, тэрчлэн түүний эд хөрөнгийг алга болгосон ба гэмтээсэн бодит хохирол; 2/ хэрэв үүрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор биелүүлсэн бол олж авах ёстой байсан орлого, алдагдсан ашиг юм. ¹⁸	Damages- гарз хохирол учруулсны нөхөн төлбөрт аливаа этгээдээс нэхэмжилсэн эсхүл төлөхөөр тогтоосон мөнгөн дүнг хэлнэ. ¹⁹

15 С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, (УБ, 2021), 88 дахь тал.

16 Bryan A, Garner, editor in chief, Black’s Law Dictionary, 9th ed., Thomson Reuters, 2009, p.1626.

[tort. 1.A civil wrong, other than breach of contract, for which a remedy may be obtained, usually in the form of damages; a breach of a duty that the law imposes on persons who stand in a particular relation to one another. 2.The branch of law dealing with such wrongs.]

17 Id. at 784.[harm. Injury, loss, damage; material or tangible detriment.]

18 Мөн тэнд, 496 дахь тал.

19 Id. at 447.[damages. Money claimed by, or ordered to be paid to, a person as compensation for loss or injury.]

Зөрчил (англ. wrongs)- эрх зүйн тогтолцоонд хэн ч халдаж үл болох эрхүүдийг хамгаалах зорилгоор хуулиар хориглосон үйлдэл гэж байх ба энэ хоригийг давсан үйлдлийг эрх зүйн зөрчил гэдэг. Иргэний хуульд ийм зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох тогтолцоог тусгасан байх ба зөрчлөөс үүдэн хохирол бий болох явдлыг гэм хор учруулах хэмээн нэрлэсэн. Зөрчил нь холбогдох этгээдийн гэм буруутай үйлдлээр нөхцөлдсөн байхаас гадна гэм буруугаас үл хамааран бусдыг аюулд оруулсан нөхцөлд ч яригдах тул гэм хорын эрх зүй нь бусдад аюул учруулснаас үүсэх үүргийг мөн адил хамарч байдаг.²⁰ Иргэний эрх зүйн зөрчил (lat. delicta)- хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй болон зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд иргэний эрх зүйн зөрчилд тооцох бөгөөд уг зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд эд материалын хариуцлага хүлээлгэнэ.²¹	Civil wrong- гэм хор учруулах, гэрээний үүргийг зөрчих, итгэлцэл эвдэх зэргээр нийтийн эрх зүйн хэм хэмжээ болон эрүүгийн хуулиас бусад хуулийг зөрчсөнийг ойлгоно. Түүнчлэн иргэний процессоор шийдвэрлэгдэх хууль зөрчсөн үйлдлийг хэлнэ.²²
Деликтын хариуцлага (delictual responsibility)-иргэний эрх зүйд деликтын үр дүнд гэм хор учруулсны улмаас хүлээлгэх гэрээний бус хариуцлага.²³	Liability- хуулиар заавал үүрэг эсхүл хариуцлага хүлээх байдал, эсхүл хариуцлагын хэмжээг ойлгоно.²⁴
	Strict liability- бодит хохирол эсхүл хохирол учруулагчийн гэм буруугийн санааг үл харгалзан аливаа зүйлийг аюулгүй байлгах зайлшгүй үүргээ зөрчснөөр үүсэх хариуцлагыг хэлнэ.²⁵

Дээрхээс харвал, “harm” гэсэн нэр томьёо монгол хэлний гэм хор гэдэгтэй яг нийцэхгүй бөгөөд түүнээс явцуу утгатай буюу материаллаг хохирол, гарзыг илэрхийлсэн ойлголт байна. Түүнчлэн “tort” гэж гэрээний бус үүргийг зөрчсөн иргэний эрх зүйн зөрчлөөс гадна тухайн харилцааг зохицуулж буй салбар эрх зүйг илэрхийлж болох өргөн ухагдахуун байна. Зарим гадаад нэр томьёог монгол хэлэнд гэм хор, хохирол гэсэн хоёрхон үгээр буулгаж, өөр өөр утга санааг нарийн гаргаж чадахгүй байгаа нь гэм хорын эрх зүйн салбар дахь ойлголтыг гүнзгийрүүлэн судалж бичихэд хүндрэл учруулж байна.

Иймд энэхүү судалгааны ажлын хүрээнд зарим нэр томьёог, тухайлбал “tort”- гэм хор, гэм хор учруулснаас үүсэх үүрэг, гэм хорын эрх зүй; “wrong”- зөрчил; “harm”- материаллаг хохирол, эд хөрөнгийн алдагдал, гэмтэл; “damages”- хохирол; “punitive damages”- ялын журмаар гаргуулах хохирол; “strict liability”- гэм буруугүйгээр хүлээлгэх хариуцлага, хатуу хариуцлага гэж буулган хэрэглэх замаар гэм хор учруулснаас үүсэх үүргийн ойлголтыг судалж бичих болно.

2.2.2 Хууль зүйн ойлголт

Гэм хор (tort) гэх үгийг англи хуульчид франц хэлнээс авчээ. Энэ нь зөрчил гэсэн утгатай бөгөөд гэм хор учруулна гэдэгт хэн нэгэнд зөрчил үйлдэхийг ойлгоно.

20 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, гурав дахь хэвлэл, (УБ, 2018), 120-121 дэх тал.

21 Б.Улаанбаатар, Иргэний эрх зүйн тайлбар толь, (УБ, 2005), 65 дахь тал.

22 Id. at 1751.[civil wrong. A violation of noncriminal law, such as a tort, a breach of contract or trust, a breach of statutory duty, of a defect in performing a public duty; the breach of a legal duty treated as the subject matter of a civil proceeding.]

23 С.Нарангэрэл, Хууль зүй судлалын англи-монгол тайлбар толь, (УБ, 2005), 298 дахь тал.

24 Id. at 997.[liability. The quality or state of being legally obligated or accountable; legal responsibility to another or to society, enforceable by civil remedy or criminal punishment.]

25 Id. at 998.[strict liability. Liability that does not depend on actual negligence or intent to harm, but that is based on the breach of an absolute duty to make something safe.]

Харин гэм хор болгон зөрчил болох ч зөрчил болгон гэм хор болдоггүй байна. Өөрөөр хэлбэл, гэм хор гэж хуулиар зөрчилд тооцсон ёс суртахууны хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг хэлнэ. Тиймээс ч гэм хор нь эрх зүйн зөрчил дотор онцгой байр суурь эзэлдэг байна.

Нэгдүгээрт, гэм хор бол хүн хоорондын харилцаанаас бий болох зөрчил юм. Учир нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөөгүй, жигшмээр үйлдлийг бус хэн нэгэнд эсхүл бүлэг хүмүүст чиглэсэн зөрчлийг л гэм хор гэж үзнэ. **Хоёрдугаарт**, гэм хор бол бусдад хохирол учруулсан зөрчил. Эрүүгийн болон бусад салбар эрх зүйгээр хохирогчгүй зөрчлийг хамт зохицуулдаг бол гэм хорын эрх зүйн харилцаанд хохирогч заавал байдаг. **Гуравдугаарт**, гэм хор бол иргэний эрх зүйн зөрчил. Учир нь хохирогч тухайн хууль бус үйлдлийг иргэний журмаар шийдвэрлүүлэх боломжтой. Зарим үйлдэл гэм хор болон гэмт хэргийн бүрэлдэхүүнийг аль алийг нь хангаж болох ч иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарснаар эрүүгийн хэрэг үүсэх үндэслэл болохгүй юм.²⁶

Монгол Улсын хувьд 2002 оны Иргэний хуульд хохирол болон гэм хорын ялгааг нэлээд тод гаргаж өгсөн бөгөөд уг хуулийн 227 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно” гэснээс харахад хохирол бол гэрээний болон гэрээний бус үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан материаллаг зардал, олох байсан орлого юм.²⁷

Дээрхээс үзвэл, гэм хор гэж бусдад материаллаг болон материаллаг бус хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй, нийгмийн зан суртахууны нийтлэг хэм хэмжээнд харшилсан, гэрээнээс үүдэлтэйгээс бусад иргэний эрх зүйн зөрчлийг ойлгож болохоор байна. Үүнийг судлаач Т.Мөнхжаргал өөрийн бүтээлдээ: “Гэм хороос үүсэх үүрэг буюу зөрчлийн улмаас үүсэх үүрэг гэдэг нь хохирогчийн салшгүй эрх болох эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрхүүдийг зөрчсөний улмаас үүссэн гэм хорыг гэм хор учруулагч этгээдээс болон гэм хор арилгах үүргийг хуулиар олгосон этгээдүүдээс аль болох бүрэн хэмжээгээр сэргээлгэх явдлыг хангахад чиглэсэн гэрээний бус үүргийг хэлнэ”²⁸ гэжээ.

Ийнхүү гэм хор учруулсан этгээд гэм хорыг арилгаж, хохирлыг барагдуулах үүрэгтэй байна. Ингэхдээ нэг талаас учруулсан бодит хохирлыг байгаагаар нь барагдуулж, зөрчигдсөн эрхийг сэргээх, байсан зүйлийг хуучин хивэнд нь оруулах, нөгөө талаас бодит хохирол дээр нэмэгдээд төлөх хохирлын асуудал гэм хорын эрх зүйд яригддаг. Өөрөөр хэлбэл, хохирол барагдуулах хоёр үзэл санаа байдаг бөгөөд нэг нь нөхөн төлүүлэх хохирол (compensatory damages), нөгөө нь ялын журмаар гаргуулах хохирол (punitive damages) юм. Уг хохирол барагдуулах үзэл санаа нь судалгааны өмнөх хэсэгт дурдсан залруулах болон шийтгэлийн шударга ёсны онолын үзэл санаатай нягт уялдаатай байна.

26 John C. P. Goldberg, Benjamin C. Zipursky, The Oxford Introductions to U.S. Law, Torts, NY, 2010, p.1-4.

27 Ж.Оюунтунгалаг, “Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал”, магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС-ХЗС, 9-10 дахь тал.

28 Т.Мөнхжаргал, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, (УБ, 2005), 6 дахь тал.

2.2.3. Гэм хорын эрх зүйн үндсэн зарчим

Гэм хор учруулснаас хүлээх хариуцлага, түүний бүрэлдэхүүнийг шалгахад гэм хор учруулсан этгээдийн гэм бурууг харгалзах эсэхээс хамаарч гэм буруутайгаар хариуцлага хүлээх (fault liability), гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчим (strict liability) яригддаг. Иймд тус хоёр үндсэн зарчмыг дэлгэрүүлэн авч үзье.

2.2.3.1 Гэм буруутайгаар хариуцлага хүлээх зарчим

Гэм буруугийн зарчим 19-р зууны сүүл үеэс АНУ-ын гэм хорын эрх зүйн тогтолцоонд чухал байр суурь эзлэх болсон. Гэм буруугийн зарчмын сонгодог үзэл санаа Холмесийн “Нийтлэг эрх зүй” бүтээлд тусгалаа олжээ. Иргэний эрх зүйн зөрчил үйлдэхийг хариуцагч ухамсраараа сонгосон, мөн тэрхүү үйлдэл нь урьдчилан харах боломжтой аюулыг нэхэмжлэгчид бий болгосон тохиолдолд хариуцагчийг гэм буруутай гэж үзэх юм. Иймээс ч ослын улмаас учирсан хохирлыг гэм хорын эрх зүйгээр бус даатгалын журмаар барагдуулах учиртай гэж Холмес үзжээ.²⁹

Хууль зүйн талаасаа гэм бурууг англи-америкийн эрх зүйн бүлийн улсад хайхрамжгүй байдал (negligence)-тай холбон тайлбарладаг байна. Хайхрамжгүй үйлдэл гэдэгт 1/ урьдчилан харах боломжтой гарз, гэмтлээс урьдчилан сэргийлэх хэмнэлттэй арга хэмжээ авч чадаагүй, 2/ үйл ажиллагааг явуулахад баримтлах мэргэжлийн стандартыг мөрдөөгүй, 3/ нийтийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн дүрэм журмыг зөрчсөнийг ойлгоно. Хайхрамжгүй байдлыг ийнхүү хэмжих нь объектив бөгөөд зарим талаараа ухамсрын хувьд гэм буруутай үйлдлийг тодорхойлж чаддаггүй байна.³⁰

Эх газрын эрх зүйн бүлийн улсуудад тус зарчим гэм хорын эрх зүй дэх үндсэн зарчим болж, ерөнхий зохицуулалтад тусгалаа олсон байдаг. Тухайлбал, БНФУ-ын Иргэний хуульд гэм буруутайгаар гэдэгт “санаатай” эсхүл “болгоомжгүй” хэлбэрийг тусгасан бөгөөд “санаатай” гэдэг нь хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд халдах сэдэл байсныг илэрхийлдэг бол “болгоомжгүй” нь тухайн нийгэмд зайлшгүй гэж тооцогддог анхаарал болгоомжийн төвшнийг баримтлаагүйг ойлгохоор заажээ.³¹

Улс орнуудад гэм буруутайгаар хариуцлага хүлээх зарчим нийтлэг байдаг ч гэм буруугийн болон хохирлын бүрэлдэхүүнийг шалгахад бага зэрэг ялгаатай шалгуур тавьдаг байна. Ийнхүү гэм хорын эрх зүйн хүрээнд харьцуулсан судалгаа хийхэд ялгамжтай хэд хэдэн нэр томъёог олон янзаар буулгасан байдаг нь улс болгоны гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтын бүрэлдэхүүн ялгамжтай байдгаас үүдэлтэй юм.

2.2.3.2 Гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчим

Англи-америкийн эрх зүйн бүлийн улс орнуудад гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчмыг гэм хор учруулсан этгээд гэм буруутай эсэхийг үл харгалзан хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээх агуулгаар тайлбарладаг. Гэм буруугаас үл хамааран хариуцлага хүлээх зарчмын онолын үндэс нь тухайн үйлдэл, үйл ажиллагаа нь зүйд огт нийцэхгүй буюу хориглохгүй бол болохгүй

29 Catharine Pierce Wells, “Tort law as corrective justice: a pragmatic justification for jury adjudication”, Michigan Law Review, Vol.88 (1990), p.2355.

30 Id. p.2358.

31 Ж.Оюунтунгалаа, Харьцуулсан иргэний эрх зүй, (УБ, 2013), 98 дахь тал.

үйлдэл, үйл ажиллагаа биш бөгөөд харин ч эсрэгээрээ нийгэмд үр өгөөжтэй, зайлшгүй шаардлагатайд тооцогддог үйл ажиллагаа байна. Гэвч энэ хэмжээгээрээ нийгэмд өндөр аюулыг бий болгоно. Ийнхүү эрх зүйгээр нийгэм дэх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үзэл баримтлалын үүднээс тодорхой үйлдэл, үйл ажиллагаа явуулсан этгээдэд тухайн үйлдэл, үйл ажиллагаанаас бусдад учирсан эрсдэлийг заавал хариуцуулах ёстой гэж үзжээ.³²

Гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх зарчмын үндэс суурь нь зэрлэг амьтан тэжээгчийн хариуцлагаас үүсэлтэй юм. Зэрлэг амьтан хүний хараа хяналтгүйгээр сул байх тохиолдолд бусад хүнийг гэмтээх нь байгалийн жам. Иймээс тус амьтан бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд амьтныг тэжээж, өөрөө хараа хяналтад байлгаж буй этгээд хохирлыг маргаангүйгээр барагдуулах үүрэг хүлээдэг болжээ.

Орчин үед үйлдвэрлэл хөгжихийн хирээр орчиндоо аюул учруулж болзошгүй үйлдвэрлэл, үйл ажиллагаанд тус зарчим хэрэглэгдэх болсон. Энэ нь өөрийн хүслээр бусдад аюултай үйл ажиллагаа явуулж буй, эсхүл аюултай зүйл эзэмшиж буй этгээд анхаарал болгоомжтой байсан ч хохирол учрах эрсдэл байгаа үед тухайн хүн бүх эрсдэлийг өөр дээрээ үүрэх юм.

Эдийн засгийн хувьд олон хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг өндөр эрсдэлээс хамгаалахын тулд тухайн үйл ажиллагаанаас бий болох хохирлыг нөхөн төлөх этгээдийг шууд тодорхойлохын оронд хамгийн бага зардлаар осол гарахаас урьдчилан сэргийлэх боломжтой этгээдийг (the least cost avoider) тодорхойлох нь илүү ач холбогдолтой гэж үздэг. Аюултай үйл ажиллагаа явуулж буй этгээд осол гарсны дараа хохирлыг нөхөн төлөх үү, гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах уу гэдэг тухайн этгээдийн сонголт байх бараг боломжгүй. Учир нь урьдчилан сэргийлэх зардал осол гарсны дараах зардлаас үргэлж бага байна.

Иймд аюултай үйл ажиллагаа эрхэлснээс бий болох эрсдэлийг бүхэлд нь үйл ажиллагаа эрхлэгчид үүрүүлснээр аль ч тохиолдолд бизнес эрхлэгч анхаарал болгоомжтой байх үүргээ ухамсартайгаар биелүүлэх юм. Үүнийг хууль зүйн шинжлэх ухаанд гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчим (strict liability) гэдэг байна.³³

Уг зарчмыг хэрэгжүүлэхийн тулд гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх онцгой аюултай үйл ажиллагаа гэдэгт юуг хамааруулахыг тодорхойлох шаардлагатай болно. Жишээ нь, АНУ-д онцгой аюултай үйл ажиллагааг тодорхойлоход дараах 6 хүчин зүйлийг шалгадаг байна. Үүнд:

1. Хүн, газар болон бусдын эд хөрөнгөд гарз хохирол учрах өндөр эрсдэлтэй;
2. Үйл ажиллагаанаас бий болох эд хөрөнгийн хохирлын хэмжээ нүсэр их байх төлөвтэй;
3. Анхаарал болгоомжтой (reasonable care) байсан ч эрсдэл алга болохгүй;
4. Үйл ажиллагаа нь онцгой буюу нийтлэг бус;

32 Л.Амгаланбаатар, “Тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас учирсан гэм хорын эрх зүйн онолын асуудал, хууль хэрэглээ, магистрын зэрэг горилсон бүтээл”, МУИС-ХЗС, 2018.

33 Ward Farnsworth, The legal analyst: a toolkit for thinking about the law, The University of Chicago, 2007, p.47.

5. Үйл ажиллагааг тохиромжгүй орчин, байршилд явуулж байгаа;
6. Нийгэмд үзүүлж буй эерэг үр нөлөө үйл ажиллагаанаас бий болох аюулаас өндөр зэрэг юм.³⁴

Англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудад гэм хорын цөөн хэдэн төрөлд хатуу хариуцлагын зарчмыг хэрэглэдэг. Эх газрын эрх зүйн бүлийн орнуудын хууль тогтоомж дахь тусгай гэм хорын зохицуулалтад уг зарчим мөн л тусгалаа олсон байна. Ийнхүү аль ч эрх зүйн тогтолцоонд уг зарчмын үндэс суурь нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, гэм хор учирсан тохиолдолд хамгийн бага зардлаар хариуцлага хүлээх этгээдийг тодорхойлоход оршино.

34 Joseph W. Glannon, The law of torts, 4th ed., p.326.

III. МОНГОЛ УЛСЫН ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ ҮҮРГИЙН ТОГТОЛЦОО

3.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго

Монгол Улсын Иргэний хуулийн зөрчлийн улмаас үүсэх үүргийн зохицуулалт нь гэм хор учруулснаас үүсэх үүрэг юм. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтыг эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудад буй ерөнхий ба тусгай гэсэн хоёр хэсэгт хувааж болно.

Гэм хор үүссэн нөхцөл, шалтгаан, шалтаг, түүний үндсэн шинж төлөв, гэм хор учруулагчид хүлээлгэх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болон бусад гэм хорын тусгай үүргүүдэд ерөнхий чиглэмж болох заалтыг **ерөнхий** хэмээн хэлж болно. Харин тодорхой төрлийн гэм хор үүссэн өвөрмөц онцлог, гэм хор учруулагчийн эрх, үүрэг, эрх зүйн байдалтай шууд холбогдож, зөвхөн тухайн нэрлэн заасан зохицуулалтыг **тусгай** гэнэ.³⁵

2002 оны Иргэний хуулийн “Гэрээний бус үүрэг” гэх IV хэсгийн “Зөрчлийн улмаас үүсэх үүрэг” нэртэй II дэд хэсэгт гэм хорын ерөнхий, тусгай зохицуулалтаас гадна гэм хорын улмаас учруулсан хохирлыг хэрхэн нөхөн төлөхийг 505-511, 513, 514 дүгээр зүйлд заасан. Ингэхдээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан тохиолдолд учирсан хохирлыг хэрхэн арилгах процессыг заажээ.

Гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтын системчлэлийг ерөнхий болон тусгай зохицуулалтаас харах боломжтой боловч уг тогтолцоо ямар зорилгыг агуулж буйг хохирол нөхөн төлүүлэх зохицуулалтаас харах боломжтой гэж үзлээ. Ингэхдээ судалгааны эхний хэсэгт авч үзсэн залруулах болон шийтгэх шударга ёсны онолын үүднээс задлан шинжилье.

3.1.1. Залруулах шударга ёсыг тогтоох зорилго

Монгол Улсын Иргэний хуулийн 505, 507, 508, 510, 511 дүгээр зүйлд бусдын эд хөрөнгө, эрүүл мэнд, амь нас, нэр төр, алдар хүнд болон ажил хэргийн нэр хүндэд учруулсан материаллаг болон материаллаг бус хохирол, түүнийг барагдуулах журмыг зохицуулжээ. Эдгээр зохицуулалтад гэм хорын эрх зүйн онолын үүднээс дүн шинжилгээ хийж үзье.

Хүснэгт 3.2. Монгол Улсын Иргэний хуулийн зарим зүйл, заалтад хийсэн дүн шинжилгээ

Хуулийн зүйл, хэсэг, заалт	Дүн шинжилгээ
510.1. Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийн засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө.	Эд хөрөнгөд учирсан материаллаг хохирлыг залруулах шударга ёсны үүднээс өмнө нь байсан байдалд нь сэргээж, сэргээх боломжгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлөхөөр зохицуулсан байна.

35 Т.Мөнхжаргал, Монгол Улсын иргэний эрх зүй, Үүргийн тусгай төрөл, (УБ, 2015), 214 дэх тал.

505.1.Бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсан этгээд нь хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ийнхүү эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар сувилуулах зэрэг зайлшгүй бүх зардлыг хохирогчид төлөх үүрэгтэй.	Хүний эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгахдаа хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан орлого, эмчилгээний болон холбогдох бусад зардлыг нөхөн төлөхөөр зохицуулжээ. Үүнд болоод өнгөрсөн үйл хэрэг дээр үндэслэн гаргуулах нөхөн төлбөрийг ойлгоно.
507.1.Эрүүл мэндэд нь гэм хор учирснаас болж, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан иргэний хөдөлмөрийн чадвар нь цаашид дордох буюу авч байгаа тэтгэврийн хэмжээ багасвал гэм хор учруулсны төлбөрийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийг хариуцагчаас шаардах эрхтэй. 507.2.Хохирогчийн хөдөлмөрийн чадвар сайжирсантай холбоотойгоор авч байгаа цалин, хөлс, орлого болон тэтгэврийн хэмжээ нэмэгдвэл хариуцагч нь гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг багасгахыг шаардах эрхтэй.	Гэм хор учруулснаас ирээдүйд үүсэх нөхцөл байдлыг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг өөрчлөх агуулгатай байна. Гэм хор учруулсны төлбөрийг хохирогчийн эрүүл мэндийн нөхөн сэргэсэн, эсхүл дордсон төвшинд нийцүүлэн өөрчилж байгаа нь залруулах шударга ёсны онолыг баримталж буй зохицуулалт болохыг илэрхийлж байна. Ингэхдээ хүний сэргээгдэшгүй эрүүл мэндийг түүний авч буй цалин, хөлс, орлого болон тэтгэврээр хэмжиж байна. Үүн дээр сэтгэл санааны хохирлыг тооцох зохицуулалт байхгүй юм.
508.1.Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй. 508.2.Гэм хор учруулсны төлбөрийг нас барсан хохирогчийн асрамжид байсан буюу нас барах үед түүнээс тэтгэвэр авах эрхтэй байсан хөдөлмөрийн чадваргүй этгээд, хохирогчийг нас барсны дараа төрсөн хүүхэд тус тус, түүнчлэн нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байнгын цалин хөлс орлогогүй эцэг, эх, нөхөр / эхнэр/-ийн аль нэг нь авах эрхтэй. 508.3.Төлбөр гаргуулах хэмжээг тогтоохдоо нас барагчид өөрт нь болон түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсгийг хасаад нас барагчийн сарын цалин хөлс, орлогын дунджаар тогтооно. Түүнчлэн төлбөр авагч тус бүрт тогтоосон төлбөрийн хэмжээнээс тэжээгчээ алдсаны тэтгэврийг хасна.	Хүний амь насыг хэзээ ч, ямар ч хэлбэрээр нөхөн сэргээх боломжгүй байдаг. Гэсэн ч хохирогч нас барсан нөхцөлд гэм хор учруулсны төлбөрийг нас барагчийн сарын цалин хөлс, орлогын дунджаар тогтоож оршуулгын зардалтай хамт төлөхөөр байна. Хэрэв нас барагч хөдөлмөр эрхлэх насанд хүрээгүй, эсхүл хөдөлмөр эрхэлдэггүй иргэн байсан тохиолдолд уг зохицуулалтаар хүний амь насанд гэм хор учруулсны төлбөрийг нөхөн төлөх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, уг эрх ашиг залруулагдахааргүй, хохирогчийн гэр бүлийн гишүүдэд сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх боломжгүй байгаа нь энэ тохиолдолд залруулах шударга ёс ч, шийтгэх шударга ёс ч хэрэгжихэд хүндрэлтэй байгааг илэрхийлж байна.

511.1.Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ. 511.2.Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно. 511.3.Энэ зүйлд энэ хуулийн 21.4³⁶, 21.5³⁷, 21.6³⁸-д заасан журам нэгэн адил үйлчилнэ.	Тус зүйлд зааснаар эдийн бус гэм хор гэдэгт хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасныг л ойлгохоор байна. Үүнийг нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд эдийн бус гэм хорыг арилгах бусад хэлбэрт тараасан мэдээлэлд няцаалт хийхийг ойлгохоор байна. Харин хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээс гадна сэтгэл санааны бусад хохирлыг арилгах зохицуулалт байхгүй байгаа нь энэ төрлийн гэм хорыг арилгах боломж хязгаарлагдмал байгааг илэрхийлж байна.
--	--

Дээрхээс харвал, Монгол Улсын Иргэний хуулийн гэм хорыг арилгах зохицуулалтад залруулах шударга ёсны онол тусгалаа олсон байна. Өөрөөр хэлбэл, гэм хор учруулагч учруулсан хохирлынхоо хэмжээгээр л хохирол барагдуулах юм. Үүнээс гадна эдийн бус гэм хорыг гагцхүү нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учруулсан хохирлоор хязгаарлажээ. Энэ нь ХБНГУ-ын гэм хорын эрх зүйн тогтолцоотой төсөөтэй байна.

Тодруулбал, ХБНГУ-д эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тохиолдол тун ховор юм. Иргэний хэргийн шүүх нэхэмжлэгчийн эрх ноцтой зөрчигдөж, нөхөн төлбөр гаргуулахаас өөр аргагүй нөхцөлд л эдийн бус хохирлыг барагдуулах шийдвэр гаргадаг. Хэдийгээр ХБНГУ дахь гэм хорын эрх зүйн онолын дагуу гэм хор учруулагчийг шийтгэх үзэл санааг хүлээн зөвшөөрдөггүй ч эдийн бус гэм хорын тухайд Европын Холбооны Ерөнхий мэдээллийг хамгаалах журам (GDPR)-ын 82 дугаар зүйлд заасан “бүрэн болон үр дүнтэй нөхөн төлбөр”³⁹ гэдгийг өргөн хүрээнд тайлбарлан эдийн бус хохирлыг барагдуулах шинэ чиг хандлагыг хэд хэдэн хөдөлмөрийн шүүх дээр төлөвшүүлээд байна.⁴⁰

Ийнхүү дан ганц залруулах шударга ёсны онол дээр үндэслэн гэм хорыг барагдуулдаг байх нь эдийн бус гэм хорыг бүрэн барагдуулах боломжийг хязгаарлаж байна. Энэ нь гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг мөн барагдуулахад хамааралтай юм.

36 Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг: “Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй”.

37 Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг: “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй”.

38 Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэг: “Иргэний нийгэмд эзлэх байр суурьтай холбогдуулан түүнийг сурталчлах зорилгоор болон сургалт, эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн, эсхүл тухайн этгээд өөрийгөө дүрслүүлсний төлөө хөлс, шан харамж авсан бол түүний зөвшөөрөл шаардагдахгүй”.

39 “full and effective compensation”.

40 Dr. Detlev Gabel, Markus Langen et al: Compensating non-material damages based on Article 82 GDPR- is there de minimis threshold? Холбооц: <https://www.whitecase.com/insight-alert/compensating-non-material-damages-based-article-82-gdpr-there-de-minimis-threshold>.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт “Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч” байхаар заасан. Гэмт хэргийн улмаас учруулсан гэм хорыг уг хуульд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол гэж заасан бөгөөд эрүүгийн шүүх иргэний нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэгтэй хамтад нь шийдвэрлэх юм.

Ийнхүү шийдвэрлэхдээ Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий болон тусгай зохицуулалтыг хэрэглэх, эсхүл Иргэний хуулийн 228-230 дугаар зүйлд заасан гэм хор арилгах зохицуулалтыг хэрэглэх эсэх нь тодорхойгүй байна. Монгол Улсын Дээд шүүхийн 2009 оны 15 дугаар тогтоолд зааснаар эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт заасан гэм хорыг ойлгохоор зохицуулжээ.⁴¹

Үүнээс харвал, гэмт хэргийн улмаас учирсан гэм хорыг ерөнхий зохицуулалтын хүрээнд шийдвэрлэхээр байна. Харин ерөнхий зохицуулалтын хүрээнд хохирол барагдуулах журам дээр эдийн бус гэм хор гэдэгт хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан үйлдлийг л ойлгох тул Иргэний хуулийн 505, 507, 508, 510, 511 дүгээр зүйлд тусгалаа олсон залруулах шударга ёсны үүднээс сэтгэл санааны хохирлыг барагдуулах боломжгүй байна.

3.1.2. Шийтгэлийн шударга ёсыг тогтоох зорилго

Монгол Улсад англи-америкийн эрх зүйн бүлийн улс оронтой нэгэн адил иргэний хэргийн шүүхээс ялын журмаар хохирол гаргуулах боломжгүй юм. 2002 оны Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтад гагцхүү залруулах шударга ёсыг бэхжүүлэхийг зорьсон болохыг судалгааны өмнөх дэд хэсэгт дүгнэсэн. Шийтгэлийн шударга ёсны зарчим эрүүгийн эрх зүйд л хамааралтай гэж эх газрын эрх зүйн бүлийн орнуудын номлолд үздэгтэй ижил байдлаар Монгол Улсад төлөвшсөн эсэхийг тодруулж үзье.

Залруулах болон шийтгэлийн шударга ёсны онолын үзэл санааг ямар харьцаатайгаар гэм хорын эрх зүйн тогтолцоонд шингээхийг тухайн төрийн бодлого, иргэдийн сэтгэлгээтэй холбон тайлбарлах боломжтой гэж үзэж байна. Монгол Улсын хувьд иргэд өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх зүйн соёлд төлөвшиж амжаагүйгээс болж гэм хорын эрх зүй нь залруулах шударга ёсыг бэхжүүлэх чиг үүргийг гүйцэтгэж чадахгүй байж болох юм. Гэм хорын эрх зүйн хөгжил бусад салбар эрх зүйгээс сул явагдсан ч иргэдийн хуульд заасан эрх, эрх чөлөөг хамгаалах шаардлагын үүднээс зөрчлийн улмаас үүсэх үүргийн зохицуулалтын зорилгыг өөр хуулиар зохицуулах нөхцөл бүрдсэн нэг жишээ бол Зөрчлийн тухай хууль юм.

Зөрчлийн тухай хуулийн зорилт нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршдог. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хууль нь захиргааны эрх зүйн зөрчлийг нэгтгэсэн хууль гэхээсээ илүү шийтгэх шударга ёсыг хэрэгжүүлэх

41 Монгол Улсын Дээд шүүх, Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай, №15, 2009, 1.1 дэх хэсэг.

зорилгоор бүхий л зөрчлийн шинжтэй үйлдэлд оногдуулах хариуцлагыг нэгтгэн боловсруулсан хууль гэж үзэх боломжтой байна.

Жишээ нь, Зөрчлийн тухай хуулийн 5.19 дүгээр зүйлд заасан “орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах” зөрчил нь Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “амьтны учруулсан гэм хорыг хариуцах” гэм хорын төрөлтэй зорилго, агуулга нэг байна. Өөрөөр хэлбэл, аюултай амьтныг хараа хяналтгүй байлгах үүргээ биелүүлээгүйн улмаас бусдын эрүүл мэндэд хохирол учирсан бол Зөрчлийн тухай хууль болон Иргэний хуулийн аль алианаар нь хохирол, нөхөн төлбөрийг гаргуулах хууль зүйн үр дагавартай байна.

Үүнээс харвал, иргэний эрх зүйн зарим зөрчил (delicts) Зөрчлийн тухай хуульд байгаа нь нэг талаасаа Өмнөд Африк⁴² болон Шри Ланкагаас бусад улсад байхгүй жишиг хэдий ч манай улсын эрх зүйн түүхэн хөгжил, нийгмийн нөхцөл байдлын тусгал болсон хууль байх боломжтой юм. Өөрөөр хэлбэл, гэм хорын эрх зүйн сул хөгжил Зөрчлийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг бий болгосон байхыг үгүйсгэхгүй.

Зөрчлийн тухай хуулийг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд хамааруулах⁴³, “жигжиг гэмт хэрэг”-ийг тусгасан хэм хэмжээ гэж зарим эрдэмтэн, судлаачид үзэх тохиолдол байдаг ч эдгээр зөрчил гэмт хэргийн шинжийг хангадаггүй нь дээр эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим зөрчил шалган шийдвэрлэхэд хэрэгждэггүй билээ. Харин аливаа зөрчил нь гэмт хэрэг болон гэм хорын бүрэлдэхүүнийг давхар хангах боломжтой.

Ийнхүү иргэний эрх зүйн зөрчил буюу гэм хорын зарим төрлүүд Зөрчлийн тухай хуульд давхардан зохицуулагдсан байна. Энэ нь 4.3 дугаар зүйлд заасан хохирол, нөхөн төлбөр гаргуулах албадлагын арга хэмжээ уг хуульд заасан 324 зөрчилд хэрэгжихээр заасан байдлаас мөн харагдаж байна. Иргэний журмаар учирсан гэм хороо арилгуулахыг хүссэн хүн Зөрчлийн тухай хуулиар нэрлэн заасан зөрчилд мөн л хохирлоо барагдуулах боломжтой нөхцөл бүрджээ.

Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны үндсэн зорилго нь хохирлыг нөхөн төлөхөд оршдог бол Зөрчлийн тухай хуульд хохирол, нөхөн төлбөр гаргуулах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь гэм хорын эрх зүй болон зөрчлийн эрх зүйн зорилгын хувьд зарим давхардлыг бий болгожээ. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуульд гэм хорын эрх зүйн шийтгэлийн болон залруулах шударга ёсыг бэхжүүлэх зорилго тусгалаа олсон байна. Иймдээ ч уг хуулиар Иргэний хуульд заагаагүй олон зөрчлийг, тэр дундаа гэм хорын тусгай төрөл байж болохуйц иргэний эрх зүйн зөрчлийг нэмж хуульчлах эрсдэлтэй юм.

Манай улсын хувьд гэм хорын эрх зүйн тогтолцооны хажуугаар зөрчлийн эрх зүйн тогтолцоо бүрэлдэн тогтсон нь бусад улс оронд нийтлэг байхгүй жишиг байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хууль шийтгэлийн шударга ёсыг бэхжүүлэхийг зорьж байхад Иргэний хуулиар залруулах шударга ёсыг тогтоох зорилготой байна.

42 Өмнөд Африкт 1965 оны Хохирол хуваарилах тухай хууль (The Apportionment of Damages Act)-иар хайхрамжгүй үйлдлээр бусдад учруулсан хохирлыг барагдуулах зохицуулалтыг хуульчилсан юм. Өөрөөр хэлбэл, тус улсад гэм хорын эрх зүйн чиг үүргийг зөрчлийн эрх зүй (the law of delicts) гүйцэтгэдэг байна.

43 Үз: Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц, (УБ, 2016), 16 дахь тал.

Англи-америкийн эрх зүйн бүлийн улс оронд ялын журмаар гаргуулах хохирлыг зайлшгүй тохиолдолд эдийн засаг, улс төрд нөлөө бүхий этгээдийн хийсэн үйлдэлд ихэвчлэн урьдчилан сэргийлэх зорилгоор оногдуулдаг. Гэвч манай улсын хувьд энэ агуулгаар шийтгэлийн шударга ёсны зарчмыг шингээсэн гэж үзэхгүй байна. Учир нь тэдгээр улсад ялын журмаар гаргуулах хохирол нь эрүүгийн хуулийн зарим хийдлийг нөхөж байдаг. Манай улсын хувьд эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхээргүй буюу гэмт хэргийн бүрэлдэхүүн агуулаагүй зөрчилд Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулах юм. Иймд Зөрчлийн тухай хуулиар Эрүүгийн хуулийн хийдлийг нөхөх гэсэн гэм хорын эрх зүйн зорилго шингээгүй байна.

Харин шинэ төрлийн иргэний эрх зүйн зөрчлийг бий болгох боломж бүрдүүлсэн нь Иргэний хуульд заасан гэм хорын тусгай төрлүүдээс өөр зөрчлүүдийг Зөрчлийн тухай хуульд зааж, англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудын нэгэн адил 40-50 тусгай гэм хорын төрөлтэй болох эрсдэлтэй гэж судлаачийн хувьд харж байна. Энэ тохиолдолд Иргэний хууль дахь гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалт хэрэгжихгүй улам “үхмэл” хэлбэрт шилжихийг үгүйсгэхгүй. Нэгэнт Зөрчлийн тухай хуулиар хүн, хуулийн этгээд өөрийн зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалуулж, хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой болбол иргэний журмаар нэхэмжлэл гаргах нь тухайн хүний өөрийн сонголтын асуудал болон үлдэх юм.

Өмнөд Африкийн жишгээр зөрчлийн эрх зүйгээр гэм хорын эрх зүйн тогтолцоог орлуулж болох боловч энэ нь хууль тогтоогч нарын бодлогын төвшинд шийдвэрлэх асуудал юм. Харин иргэд өөрийн эрх, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг иргэний журмаар буруутай этгээдээр нөхөн төлүүлж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх сэтгэлгээг төлөвшүүлэхийн тулд Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцоо болон зөрчлийн эрх зүйн тогтолцооны харилцаа, хамаарлыг зохистой төвшинд зохицуулах шаардлагатай гэж үзлээ.

3.2. Гэм хорын ерөнхий зохицуулалт

Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт ерөнхий зохицуулалтыг заасан бол үүнээс гадна нийт 8 тусгай зохицуулалтыг хуульчилжээ. Гэм хорын ерөнхий зохицуулалт нь тусгай зохицуулалтын урьдчилсан нөхцөл биш бөгөөд англи-америкийн эрх зүйн бүлийн улсуудад буй хэдэн арван гэм хорын төрлийг нэгтгэсэн ерөнхий гэм хор юм.

Монгол Улсын Иргэний хуульд гэм хорын ерөнхий зохицуулалтыг 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.” гэж заасан. Харин ерөнхий зохицуулалт нь дараах урьдчилсан нөхцөлтэй байна. Үүнд⁴⁴:

1. Объектив бүрэлдэхүүн;
 - в. Гэм хор учруулсан үйлдэл;
 - с. Хамгаалагдсан эрхийн зөрчил;
 - д. Хариуцлагыг үндэслэгч шалтгаант холбоо;
2. Хууль бус үйлдэл;

44 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, (УБ, 2018), 122-124 дэх тал.

3. Субъектив бүрэлдэхүүн;
 - а. Гэм буруутайн улмаас хариуцлага хүлээх;
4. Хохирол

Үүнээс харвал, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт заасан гэм хор нь объектив бүрэлдэхүүн, хууль бус үйлдэл, субъектив бүрэлдэхүүн, хохирол гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Үүнд гэм буруу нь зайлшгүй шалгах нөхцөл байна. Эх газрын эрх зүйн бүлийн бусад орнуудад ерөнхий зохицуулалт нийтлэг байдаг ч түүний бүрэлдэхүүн, агуулгыг нь тайлбарлах арга зам ялгаатай байдаг. Манай улсын хувьд ерөнхий зохицуулалтын бүрэлдэхүүнийг тайлбарласан судалгааны бүтээл дутмаг байх бөгөөд уг асуудлыг дэлгэрүүлэн харьцуулан судлах хэрэгцээ байсаар байна. Энэхүү судалгааны ажлаар гэм хорын эрх зүйн тогтолцоо, түүний зорилго, гэм хорын ерөнхий болон тусгай зохицуулалтыг ерөнхийлөн судлах тул тус асуудлыг хөндөөгүй болно.

3.3. Гэм хорын тусгай зохицуулалт

Бүх гэм хорыг ерөнхий зохицуулалтын хүрээнд шийдвэрлэхэд хүндрэлтэй юм. Ийнхүү зарим иргэний эрх зүйн зөрчлийг шийдвэрлэхэд хэрэглэх нарийвчилсан журмыг тусгай зохицуулалтаар бий болгосон байдаг. Энэ нь манай улсын хувьд дараах иргэний эрх зүйн зөрчлүүд юм. Үүнд:

- Байгууллага, албан тушаалтан бусдад учруулсан гэм хор;
- Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хор;
- Барилга, байгууламж барих, ашиглах явцад учирсан гэм хор;
- Амьтны учруулсан гэм хор;
- Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлээс учирсан гэм хор;
- 7-14 насны, насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй иргэний учруулсан гэм хор;
- Үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгохгүй буюу өөрийгөө зөв удирдах чадваргүй байхдаа учруулсан гэм хор;
- Бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хор зэрэг юм.

Нэгэнт гэм хорын ерөнхий зохицуулалтын үндсэн бүрэлдэхүүнд гэм буруу хамаарч байгаа тул ихэвчлэн гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх нөхцөлтэй гэм хорыг тусгайлан бие даан зохицуулжээ. Тэдгээрийг нэг бүрчлэн задлан шинжлэхээс илүүтэй гэм хорын эрх зүйн зарчмын үүднээс дүн шинжилгээ хийж үзье. Ингэснээр иргэний эрх зүйн зөрчлийн тусгай төрөл бусад эрх зүйн зөрчлөөс хэрхэн ялгагдаж, ямар уялдаа холбоотой хэрэгжиж буйг тодорхойлох боломжтой болно.

3.3.1 Байгууллага, албан тушаалтан бусдад гэм хор учруулсан гэм хор

Иргэний хуулийн 498 дугаар зүйлд байгууллага, албан тушаалтан бусдад учруулсан гэм хорыг ажил олгогч хариуцахаар заасан. Энэ нь эдийн засгийн утгаараа аливаа үйлдвэрлэл, үйл ажиллагааны улмаас бусдад учирсан гэм хорыг арилгах үүргийг ажил олгогчид хүлээлгэснээр тэрээр ажилчдадаа хяналт тавьж, тодорхой эрсдэлээс хамгийн бага зардлаар урьдчилан сэргийлж чадах этгээд болохоос үүдэлтэй байна.

Хүснэгт 3.3. Монгол Улсын Иргэний хуулийн 498 дугаар зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1	498 дугаар зүйлийн 498.1 дэх хэсэг	498.1.Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.
2	498 дугаар зүйлийн 498.2 дахь хэсэг	498.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорын түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.
3	498 дугаар зүйлийн 498.3 дахь хэсэг	498.3.Хохирогч өөрөө санаатай буюу илтэд болгоомжгүй хандсан, эсхүл хууль тогтоомжид нийцсэн арга хэрэгслээр үүсч болох хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс өөрт нь гэм хор учирсан бол энэ хуулийн 498.1, 498.2-т заасан байгууллагыг хариуцлагаас чөлөөлж болно.
4	498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэг	498.4.Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана.
5	498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэг	498.5.Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийг тайлбарлахдаа үгийн шууд утгаар бус хуулийг системчлэн тайлбарлах аргын хүрээнд авч үзвэл 498 дугаар зүйл нь ажил үүргээ гүйцэтгэх явцад ажилтны учруулсан гэм хорыг арилгах эрх зүйн үндэслэлийг тодорхойлж, 498.1, 498.2, 498.4 гэсэн хэсгүүдээр тусгайлан зохицуулжээ.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.1 дэх хэсгийн зохицуулалт нь ажил олгогч өөрийн ажилтны бусдад учруулсан хохирлыг арилгах зохицуулалт юм. Ажил олгогч хэдийгээр ажилтны гэм хорыг хариуцахаар заасан ч үүнд ажилтны гэм буруу, хохирогчийн тухайн хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийсэн эсэхийг харгалзаж үзэх тул уг зохицуулалтад гэм буруутайгаар хариуцлага хүлээх зарчим үйлчилнэ. Үүнийг дагаад ажил олгогч өөрийн гэм буруугүйг нотлох уу, хохирогч өөрийн анхаарал болгоомжтой байснаа нотлох уу гэдэг нь хэргийн нөхцөл байдлаас шалтгаалахаар байна.

Харин Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2 дахь хэсгийг хэрэглэхэд нэг талаас “төр”, “төрийн байгууллага”-ыг “ажил олгогч”-той адилтган үзсэн мэт, нөгөө талаас төрийн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан хоёрдмол утгатай байна. Гадаад улс орнуудад тогтсон иргэний эрх зүйн онолын дээрх чиг хандлагын үүднээс авч үзвэл төрийг ердийн ажил олгогчтой адилтган үзсэн агуулгаар энэ заалтыг тайлбарлах боломжгүй юм.⁴⁵

Төрийн албан хаагчийн учруулах гэм хорыг арилгах Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2 дахь хэсэг нь онцлог зохицуулалт юм. Гэм хор нь иргэний эрх зүйн зөрчил байдгаас гадна төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгээгүй гэм буруутай үйлдэлд төр хариуцлага хүлээх нь гэм хорын эрх зүйн улсын төсвөөс

45 Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүйн онолын асуудал, (УБ, 2018), 129-130 дахь тал.

иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлөх тогтолцоо болохыг хүлээн зөвшөөрч буй хэрэг болно. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцаа хувь этгээдүүдийн хооронд үүсдэг бөгөөд ийнхүү нэг талд “төр” гэсэн субъект байх нь учир дутагдалтай байна.

2002 оны хуучин Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7 дахь заалтад “хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах” гэж заасан байжээ. Харин 2017 оны Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад энэ заалт байхгүй бөгөөд төрийн албан хаагчийн учруулсан гэм хорыг төр барагдуулах ч эргээд буруутай этгээдээр нөхөн төлүүлэх юм.

Ингэснээр Иргэний хуулийн 498.5 дахь хэсэгт заасны дагуу төр бүх хохирлыг барагдуулах бус төр эргээд буруутай төрийн албан хаагчаас нэхэмжлэх харилцаа төлөвших үндэс болжээ. Үүнийг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасан.

Энэ зарчим энгийн ажилтан, ажил олгогчийн хооронд мөн үйлчлэх боловч 498.5 дахь хэсэгт заасан “шууд санаатай” болон “илтэд болгоомжгүй” гэж Иргэний хуулийн 497.1 дэх хэсэгт заасан “санаатай” болон “болгоомжгүй” гэснээс хэрхэн ялгагдах нь ойлгомжгүй байна.

Хүснэгт 3.4. Шүүхийн шийдвэр №1

1.	Шийдвэрлэсэн шүүх	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх
2.	Огноо, дугаар	2022.02.11 129/ШШ2022/00089
3.	Талууд	Нэхэмжлэгч: Архангай аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба Хариуцагч: Архангай аймгийн Засаг дарга М
4.	Маргааны агуулга	Архангай аймгийн Засаг дарга М буруу шийдвэр гаргаж, Засаг даргын тамгын газрын дарга Ч-г үндэслэлгүйгээр ажлаас халсны улмаас 26,053,035 төгрөг нөхөн төлөх тухай шүүхийн шийдвэрийн биелэлтийг М нь Засаг даргын тамгын газрын төсвөөс олгосон байна.
5.	Шийдвэрлэсэн байдал	Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.5-д зааснаар нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, иргэн М-с 10,657,818 төгрөг гаргуулж Архангай аймгийн Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын төсөвт оруулахаар шийдвэрлэсэн.

Дээрх шүүхийн шийдвэрээс харахад, Засаг даргын захиргааны акт бус дотоод шийдвэр буюу ажилтныг ажлаас үндэслэлгүй халсан гэх иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр гаргуулсан мөнгөн дүнг Санхүүгийн хяналт аудитын алба нэхэмжилсэн. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэг нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны байгууллагын хууль бус шийдвэрийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулахаас өргөн агуулгатай байна. Төрийн албан хаагчийн дотогш чиглэсэн шийдвэрийн улмаас иргэнд олгох нөхөн олговрыг хүртэл төр тухайн шийдвэрийг гаргасан албан хаагчаас нэхэмжилж байгаа нь төр хариуцлагаас бүрэн чөлөөлөгдөж буй хэлбэр юм.

Дээрх тохиолдолд Засаг дарга М нь тухайн шийдвэрийг шууд санаагүйгээр гаргах боломжгүй. Иймд ямар ч тохиолдолд төрийн албан хаагчийн бүх шийдвэрийн өмнөөс төр бус тухайн албан хаагч хариуцлага хүлээх нөхцөл бүрджээ. Ингэснээр тухайн төрийн албан хаагч ямар нэг алдаа гаргахгүй байж, өөрийн гаргаж буй шийдвэрийн өмнөөс хариуцлага хүлээх юм. Ийм тохиолдол амьдрал дээр бараг байх боломжгүй бөгөөд төр болон ажил олгогч ажилтан, албан хаагчид хяналт тавих байдлаар хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх хуулийн зохицуулалтын суурь зорилготой нийцэхгүй. Гэвч нөгөө талаасаа бүхий л тохиолдолд төр хариуцлага хүлээдэг байх нь эргээд учир дутагдалтай тул төрийн албан хаагчийн учруулсан гэм хорыг арилгах зохицуулалтын бүрэлдэхүүн болох “шууд санаатай” болон “илтэд болгоомжгүй” гэдэгт юуг ойлгохыг практикт илүү тодорхой болгох шаардлагатай байна.

Хүснэгт 3.5. Шүүхийн шийдвэр №2

1.	Шийдвэрлэсэн шүүх	Улсын Дээд шүүх
2.	Огноо, дугаар	2017.09.19 001/ХТ2017/00971
3.	Талууд	Нэхэмжлэгч: С Хариуцагч: 3 дугаар эмнэлэг
4.	Маргааны агуулга	2015.09.21-ний өдөр 6 настай охин С эмэг эх О-ийн хамт шүдний эмчээс зөвлөгөө авахаар 3 дугаар эмнэлэгт шүдний эмч У-д үзүүлэхэд дээд, доод араанд ломботой адил төстэй эм тавьж, эмчилгээ хийсэн. Гэтэл охины нүүрний зүүн хэсгээр хавдан улайж, хоол, унд идэхгүй, халуурч, хүчтэй зовиурлах болсон тул эмч У-тай дахин уулзахад шарлага эмчилгээ хийсэн. Гэвч охины биеийн байдал улам дордож, зовиурлах нь ихэссэн тул 2015.09.27-ны шөнө 23 цагийн орчим Эх нялхсын эмнэлэгт очиж, 2015.09.28-ны өдөр яаралтай мэс засал хийлгэсэн. Хүүхэд халуурч байхад шарлага хийж идээт буглааг улам идэвхжүүлж буруу эмчилгээ хийсэн буруутай тул 3 дугаар эмнэлгээс гэм хорын хохиролд 2.107.500 төгрөг гаргуулахаар шаардсан байна.
5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.1, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт заасныг баримтлан хариуцагч 3 дугаар эмнэлэгт холбогдуулан гэм хорын хохиролд 2.107.500 төгрөг гаргуулах тухай С-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх: Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.1 дэх хэсэгт зааснаар хариуцагч 3 дугаар эмнэлгээс 557.500 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч С-д олгож, үлдэх 1.550.000 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Хяналтын шатны шүүх: Давж заалдах шатны шүүх хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас нэхэмжлэгчид гэм хор учирсан эсэх, гэм хорын хэмжээ, зайлшгүй зардал, хохирлыг хэрэгт цугларсан баримтын хүрээнд дүгнэж, нэхэмжлэлээс эмийн зардал 17.500 төгрөг, өвчний улмаас хичээл завсардаж багш хөлслөхөд төлсөн 300.000 төгрөг, өмгөөллийн хөлс 200.000 төгрөг, 3 дугаар эмнэлэгт төлсөн төлбөр 40.000 төгрөг нийт 557.500 төгрөгийн шаардлагыг хангасан нь эрх зүйн харилцааг зохицуулсан Иргэний хуулийн дээрх заалтад нийцсэн гэж үзэж шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Хүснэгт 3.6. Шүүхийн шийдвэр №3

1.	Шийдвэрлэсэн шүүх	Улсын Дээд шүүх
2.	Огноо, дугаар	2019.03.07 001/ХТ2019/00310
3.	Талууд	Нэхэмжлэгч: Г ХХК Хариуцагч: Б
4.	Маргааны агуулга	Хариуцагч Б нь нэхэмжлэгч компанид борлуулагч, жолоочоор ажилладаг. Ийнхүү ажиллах явцдаа 2014.05.10-ны өдөр Барс-2 худалдааны төвд газ хүргэж өгөхдөө өөрийн төрсөн дүү Ч-г оруулж холболт хийлгэсний улмаас гал алдсан. Ийнхүү гал алдсанаар 5 цайны газар шатаж нийт 9 918 903 төгрөгийн хохирол учирсан. Энэхүү хохирлыг нэхэмжлэгч компани хариуцагчийн өмнөөс хохирол учирсан цайны газрын эздэд төлж барагдуулсан. Хариуцагч Б нь ажиллах явцдаа бусдад учруулсан хохирлоо нэхэмжлэгч компанид буцаан барагдуулах үүрэгтэй байсан боловч барагдуулалгүй ажлаас гарсан. Мөн Б-ын үйлдлийн улмаас С ХХК, Ө ХХК-ийн худалдаалж байсан эд хөрөнгөнд хохирол учирч тухайн хохирлыг Мандал даатгал ХХК барагдуулсан байдаг. Гэвч Мандал даатгал ХХК нь даатгуулагчид учирсан гэм хорын хохирлыг нэхэмжлэгч байгууллагаас нэхэмжилсэн. Иймээс Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэгт заасны дагуу Б-аас нийт 16 805 073 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.
5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.1, 510 дугаар зүйлийн 510.1, 514 дүгээр зүйлийн 514.1-д тус тус заасныг баримтлан хариуцагч Ч.Б-аас 4 590 766 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч “Г” ХХК-д олгож, үлдэх 12 214 307 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх: Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.1 гэснийг Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 гэж өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн. Хяналтын шатны шүүх: Ч.Б нь “Г” ХХК-д 2012.02.17-ны өдрөөс борлуулагч, жолоочоор ажиллаж, автомашинаар хийн түлш тээвэрлэн, угсрах ажил үүргийг гүйцэтгэж байсан үйл баримтыг зохигчид маргаагүй боловч хөдөлмөрийн гэрээний харилцаа үүссэн гэх хангалттай баримт байхгүй тул бусдад гэм хор учруулсан гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээг буруутгах үндэслэлгүй байна. Иймд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт зааснаар “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.” тул “Г” ХХК нь хариуцагч Ч.Баас өөрт учирсан хохирлыг шаардах эрхтэй гэж үзэн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Дээрхээс харвал, эмнэлгийн ажилтны мэргэжлийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан гэм хортой холбоотой эрх зүйн маргааныг Иргэний хуулийн 498 дугаар зүйлд заасны хүрээнд шийдвэрлэж байна. Мөн гэм хор учруулагчийн гэм бурууг шалгахад гэм хорын тусгай зохицуулалтаас гадна ерөнхий зохицуулалтыг давхар зүйлчлэн хэрэглэж байгаа нь учир дутагдалтай байна. Учир нь тусгай зохицуулалт нь тусгай журмаар шийдвэрлэгдэх, өөр зарчмыг үндэслэл болгодог бөгөөд ерөнхий зохицуулалтын хүрээнд шийдвэрлэгдэх боломжгүй тусгайлсан зохицуулалт юм.

3.3.2. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хор

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлд тээврийн хэрэгслийн ашиглалтаас буюу ослоос үүдэлтэй гэм хорыг тусгайлан зохицуулсан. Тээврийн хэрэгсэл гэдгийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад заасны дагуу хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг **замаар** тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг ойлгох юм. Харин агаарын болон усан тээврийн хэрэгслийг тээврийн хэрэгсэлд хамааруулаагүй боловч 499 дүгээр зүйлийн 499.2 дахь хэсгийг харвал мөн зүйлийн 499.1 дэх хэсэгт заасан тээврийн хэрэгсэл гэдэгт агаарын болон усан онгоц хамаарахаар ойлгогдож байна.

Хүснэгт 3.7. Монгол Улсын Иргэний хуулийн 499 дүгээр зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1	499 дугаар зүйлийн 499.1 дэх хэсэг	499.1.Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй.
2	499 дугаар зүйлийн 499.2 дахь хэсэг	499.2.Агаарынхаас бусад тээврийн хэрэгслийг ашиглах явцад гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэнээс гэм хор учирсан бол энэ хуулийн 499.1-д заасан үүрэг үүсэхгүй.
3	499 дугаар зүйлийн 499.3 дахь хэсэг	499.3.Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
4	499 дугаар зүйлийн 499.4 дэх хэсэг	499.4.Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад зам тээврийн осол гэдэгт зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч, гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно. Энэ тохиолдолд гэм хор учруулсан этгээдийн гэм буруутай эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг нөхөн төлүүлэх тул Иргэний хуулийн 499 дугаар зүйлд хатуу хариуцлагын зарчим тусгалаа олжээ.

Хатуу хариуцлагын зарчим үйлчлэхгүй ганцхан тохиолдол нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал юм. Гэвч ингэхдээ агаарын тээврийн хэрэгслийг бүхий л нөхцөлд хатуу хариуцлага хүлээхээр Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.2 дахь хэсэгт зохицуулжээ. Үүний шалтгаан нь агаарын тээврийн хэрэгслийн олон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах өндөр эрсдэлтэй байдлаас үүдэлтэй юм.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал гэдэгт агаарынхаас бусад тээврийн хэрэгслийг ашиглах явцад хүний хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй саад тотгор тохиолдохыг ойлгохоор байна. Эдгээрт:

- Зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн, бослого, гадаадын түрэмгийлэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, хувьсгал;
- Байгалийн бүх төрлийн гамшиг /хүчтэй салхин шуурга, хар салхи, газар хөдлөлт, хүчтэй давллага, үер, цас, зуд, ган гачиг, их хэмжээний бороо, аянга цахилгаан, гал түймэр гэх мэт/;
- Тэсрэлт, дэлбэрэлт, машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгаан ноцтой гэмтэл зэрэг юм.⁴⁶

Монгол Улсад хамгийн нийтлэг шүүхээр шийдвэрлэгддэг гэм хор тусгай төрөл бол тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хор юм. Улсын хэмжээнд 2019 онд нийт 25,302 зам тээврийн осол гарсан бол 2020 онд 21,768 осол гарсан байна.⁴⁷

Онолын хувьд авч үзвэл, тээврийн хэрэгсэл нь хүн, орчин тойрондоо эрсдэлтэй учир гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчим тус гэм хорын тусгай төрөлд үйлчилнэ. Хэдийгээр автомашин нь хүний амьдралын суурь хэрэглээ болсон ч жолооч болохын тулд хуульд заасны дагуу шалгуур хангаж, шалгалт өгч, үнэмлэхтэй байх тусгай шаардлага тавигддаг тул тээврийн хэрэгсэл ашиглалтыг онцгой үйл ажиллагаа гэж үзэх боломжтой байна.

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлд заасан гэм хорыг нөхөн төлөх этгээд болох “тээврийн хэрэгслийн эзэмшигч”-ийг хууль тогтоомжоор нэг мөр тодорхойлоогүй бөгөөд судлаачдын дунд үүнийг хэрхэн тодорхойлох асуудал маргаантай байна. “Тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэх ойлголтыг түүхэн үүднээс нь тайлбарлахад Иргэний хуулийн 501 дүгээр зүйл дэх “амьтан эзэмшигч” гэх ойлголтоос бий болсон гэх тайлбар байх бөгөөд түүнчлэн зарим тохиолдолд Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн зарим онолыг ч ашиглах боломжтой гэж зарим улс оронд тайлбарлаж байна.⁴⁸

Тээврийн хэрэгсэл “эзэмшигч”-ийг тусгайлан тодорхойлон хуульчилсан зүйл байхгүй тул энэ зохицуулалтыг Иргэний хуулийн “эзэмшил”-тэй холбоотой заалтын хүрээнд тайлбарлах шаардлага үүсэж байна. Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт заасны дагуу тээврийн хэрэгслийн “эзэмшигч”-ийг тодорхойлбол тухайн тээврийн хэрэгслийг бодитойгоор эзэмшилдээ байлгаж байгаа шууд эзэмшигч, эзэмших боломжоо бусдад олгосон шууд бус эзэмшигчийн аль алиныг хамрахаар байна. Үүнийг үгийн шууд утгаар тайлбарлавал машиныг жолоодож буй, жолооны ард байгаа этгээдэд бодит эзэмшил байна гэж ойлгохоор байгаа боловч Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3 дахь хэсэгт заасан эзэмшигч, “ашиглалт” гэсэн нэр томъёотой холбон тайлбарлавал энэ тохиолдолд жолоочийг “эзэмшигч” гэхээс илүү “ашиглагч” гэж үзнэ. Иймд автомашиныг түр хугацаагаар эзэмшилдээ авсан хүн бүрийг Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1 дэх хэсэгт заасан эзэмшигч гэж туйлшруулан ойлгох боломжгүй гэж үзэхээр байна.⁴⁹

46 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрх зүйн зохицуулалт болон Гэрээнд санал болгож буй жишиг заалт, Холбоос: https://gratanet.com/laravel-filemanager/files/3/force%20majure_MN.pdf

47 Үндэсний статистикийн хопоо, Холбоос: https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_039V1&SOUTM_select_all=0&SOUTMSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019&viewtype=table

48 Шиоми Ёшио, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүй I Шинзанша хэвлэлийн компани, 331 дэх тал. Дам ишлэв: Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалтын талаарх судалгаа, Шүүхийн шийдвэрт хийх хөндлөнгийн дүн шинжилгээ”, Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?id=960>

49 Ж.Оюунтунгаага, “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”, Хууль дээдлэх ёс сэтгүүл (№3, 2016).

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, Замын хөдөлгөөний дүрмийн 1.4-т тус тус тодорхойлсны дагуу “жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн, жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүнийг ойлгоно. Жолооч гэдэгт тээврийн хэрэгсэл эзэмшигч хамаарахгүй бөгөөд осол жолоочийн буруугаас болж үүсэх учраас тээврийн хэрэгсэл эзэмшигч гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх үр дагавар бий болохоор байна.

Харин Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.3, 499.4 дэх хэсэг нь тээврийн хэрэгслийг дамжуулан ашиглуулсан өмчлөгч, эзэмшигчийн гэм буруутай үйлдлийн улмаас хүлээх хариуцлагыг заасан. Тиймээс сүүлчийнх нь гэм буруутайгаар хариуцлага хүлээх бүлэг зохицуулалтад хамаарна. Иргэний хуулийн 499.1 дэх хэсгийг зорчигч болон ачаа тээврийн автомашин, галт тэрэг, агаарын тээврийн хэрэгсэл ашиглах нөхцөлд хэрэглэх ба замын хөдөлгөөний бусад оролцогсдын эрх ашгийг холбогдох этгээдийн гэм буруугаас үл хамааран хамгаалахад чиглэсэн байдаг.⁵⁰

Энэ талаар судлаач Л.Амгаланбаатар: “Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1 болон 499.3, 499.4-д заасан “тээврийн хэрэгслийн эзэмшигч”, “өмчлөгч буюу эзэмшигч” гэсэн нэр томъёонуудыг нэгдмэл болгож, “тээврийн хэрэгслийн эзэмшигч” эсхүл “эзэмшигч” гэж томъёолох; Иргэний хуулийн 499.3-т заасан хуулийн бичвэрт “зөвшөөрөлгүйгээр буюу түүний хүсэл зоригуос гадуур” гэх нэмэх⁵¹ саналыг дэвшүүлжээ. Гэвч Иргэний хуулийн 499.3 дахь хэсэгт эзэмшигчийн хүсэл зоригуос гадуур гэж нэмсэн ч тэрээр хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй тул энэ нь хууль зүйн үр дагавар бий болгохгүй юм. Харин тээврийн хэрэгсэл эзэмшигч гэснийг тодорхой болгож, хатуу хариуцлага хүлээлгэх этгээд тодорхой байх шаардлагатай байна.

Хүснэгт 3.8. Шүүхийн шийдвэр №4

1.	Шийдвэрлэсэн шүүх	Төв аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
2.	Огноо, дугаар	2021.01.27 223/МА2021/00001
3.	Талууд	Нэхэмжлэгч: Хариуцагч: А
4.	Маргааны агуулга	Хариуцагч А нь соната 2 маркийн тээврийн хэрэгслийг Г-ээс худалдан авсан ба өмчлөх эрх нь бүрэн шилжээгүй байхад буюу 2019.09.08-ны өдөр машиндаа засвар хийж байхад эвээс нь мултарч Чингэлтэй дүүргийн 12 хороо, булгийн 19 гудамж 1125 тоот хашаа байшинг мөргөж машины урд хэсэг байшинд тэр чигээрээ орж ирсэн. А ХХК-д 512000 төгрөгийн хөлс төлж, үнэлгээний тайлан гаргуулсан ба байшинд учирсан хохирлыг 12855000 төгрөг гэж тогтоосон. Осол гарсны дараа нэхэмжлэгч нь байшинд амьдран суух боломжгүй болсон тул 3 няхл хүүхдээ дагуулаад аав ээж, хамаатан саднаар амьдарч байгаад энэ зун бага зэрэг засвар хийгээд орсон. Иймд Ашид билгүүн ХХК-ийн үнэлсэн үнэлгээнээс падаангүй авсан зардал 1 553 000 төгрөг, зарлагын баримтаар авсан 1 140 000 төгрөг, нийт 2 693 000 төгрөгийг хасаад 10 674 000 төгрөгийг хариуцагчаас гаргуулж өгнө үү гэжээ.

50 Б.Буянхшиг, Үүргийн эрх зүй, нэмж завсарласан хоёр дахь хэвлэл, (УБ, 2011), 529 дэх тал.

51 Ж.Оюунтунгалаг, “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, №3 (2016).

5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.4, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар хариуцагчаас 10 674 000 төгрөг гаргуулж нэхэмжлэгчид олгож шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх: Осол гарах үед тухайн тээврийн хэрэгслийг хариуцагч А эзэмшиж, ашиглаж байсан ба Г-тай худалдах-худалдан авах хэлцэл хийж, эзэмшлийг шилжүүлэн авсан боловч тээврийн хэрэгслийн гэрчилгээ бичиг баримт нь өмнөх өмчлөгчөөс шилжээгүй байсан байна. Гэхдээ тээврийн хэрэгслийн улсын бүртгэл нь гэм хор хүлээх этгээдийг шууд тодорхойлох үндэслэл болохгүй юм. Иргэний хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-т зааснаар хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн зохих журмын дагуу тавьсан шаардлагаар түүний эзэмшилд тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болох тул тухайн тээврийн хэрэгсэл бусдад гэм хор учруулсан этгээдийн эзэмшилд шилжсэн болох нь тогтоогдсон байна. Хэрэгт авагдсан А ХХК-ийн тогтоосон хөрөнгийн үнэлгээ хэргийн бодит байдалтай нийцээгүй, байшинг бүхэлд нь зассанаар эд хөрөнгө өмнөх байсан байдалдаа нөхөн сэргээгдэнэ гэж үзсэн үндэслэл тодорхойгүй, үндэслэл муутай байх тул давж заалдах шатны шүүх И ХХК-ийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн гэм хорын хохирлын хэмжээг тогтоож, хариуцлагын хэмжээг тодорхойлох нь Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1, 229 дүгээр зүйлийн 229.1 дэх хэсгийн зохицуулалтад нийцнэ гэж үзэж хариуцагчаас гэм хорын хохиролд 7,980,800 төгрөг, нэхэмжлэгчийн хөрөнгийн үнэлгээ хийлгэхэд гарсан зардал 512,000 төгрөг, нийт 8,492,800 төгрөгийн шаардлагыг хангаж, үлдэх 2,181,200 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.
----	----------------------------	--

Хүснэгт 3.9. Шүүхийн шийдвэр №5

1	Шийдвэрлэсэн шүүх	Дархан-Уул аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал
2	Огноо, дугаар	2021.02.22 Дугаар 21
3	Талууд	Нэхэмжлэгч: Д Хариуцагч: Т
4	Маргааны агуулга	2020.06.13-ны өдрийн 21 цаг 30 минутын орчим Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн ТЭЦ-ийн уулзварт Biebee маркийн Т.Т-н өмчлөлийн автомашиныг С.А- жолоодож яваад замын хөдөлгөөний дүрмийн 8.9 дүгээр заалтыг зөрчиж С.Д-ын жолоодож явсан KIA RNI-NO маркийн машиныг мөргөж, 19.950.000 төгрөгийн хохирол учруулсан. Үүнээс 4.970.000 төгрөгийг С.А-гийн даатгуулсан даатгалын компаниас авсан. Үлдэгдэл 14.980.000 төгрөг дээр машин ачилтын 200.000 төгрөг, КТГ-т толгой харуулсан 100.000 төгрөг, Архангай аймгаас Дархан-Уул аймагт ирэхэд зарцуулсан бензиний мөнгө 145.000 төгрөг нийт 15.425.000 төгрөг хариуцагч Т.Т-аас нэхэмжилжээ. Хариуцагч хариу талбартаа С.А-той харилцан тохирч Автомашин түрээслэх, зарах, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан ба Түрээсийн гэрээгээр бусдад учруулсан хохирол, хариуцлагыг С.А хариуцахаар тохирсон. Иймд нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргажээ.

5	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.1, 499 дүгээр зүйлийн 499.4-т тус тус заасныг баримтлан хариуцагч Т.Т-аас 13.305,000 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч С.Д-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх хэсэг болох 2.120.000 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх: Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1-д “Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг төлөх үүрэгтэй”, 499.4-т “Тээврийн хэрэгсэл ашиглагчийг эзэмшигч буюу өмчлөгч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй” гэж тус тус зааснаар тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч Т.Т-д гэм хорын нөхөн төлбөрийн хариуцлага хүлээлгэсэн нь зөв. Өөрөөр хэлбэл механикжсан тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд заавал хамруулах бөгөөд Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш 1 сарын дотор бүртгүүлэх ба бүртгэлийн байгууллага тээврийн хэрэгслийг бүртгэж гэрчилгээ олгоно. Иймд тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийг тогтоох гол үндэслэл болдог. Тээврийн хэрэгслийн өмчлөгч буюу эзэмшигч Т.Т- гэм хор учирсан этгээдийн өмнө хариуцлага хүлээх боловч тэрээр өөрт учирсан хохирлоо уг авто машиныг жолоодож явсан этгээд болох С.А-гоос Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар шаардах эрхийг хязгаарлахгүй. Иймд шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.
---	----------------------------	---

Дээрх шүүхийн шийдвэрүүд нь тээврийн хэрэгслийн эзэмшигч буюу өмчлөгчийг ялгаатай тодорхойлж буй тохиолдлын жишээ юм. Тухайлбал, шүүхийн шийдвэр 4-т тээврийн хэрэгслийг хариуцагч өөрийн нэр дээр бүртгүүлээгүй нь түүнийг эзэмшигч биш гэж үзэх үндэслэл болохгүй тул жолооны ард суусан хүнд хариуцлага хүлээлгэсэн. Харин шүүхийн шийдвэр 5-т тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийг тогтоох гол үндэслэл болох тул авто машиныг жолоодож явсан этгээд бус тээврийн хэрэгсэл бүртгэлтэй этгээдээс хохирлыг барагдуулахаар шийдвэрлэжээ.

Ийнхүү тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг шийдвэрлэж буй шүүхийн практик ялгаатай байна. Нэгэнт уг гэм хорын төрөл нь хатуу хариуцлагын зарчимд суурилдаг тул хариуцлага хүлээх этгээд тодорхой байх шаардлагатай юм.

3.3.3. Барилга байгууламж барих, ашиглах явцад учирсан гэм хор

Иргэний хуулийн 500 дугаар зүйлд барилга байгууламж барих, ашиглах явцад учирсан гэм хорыг зохицуулсан. Ингэхдээ барилгын өмчлөгч буюу эзэмшигч нь бүх тохиолдолд биш гагцхүү зохих ёсоор арчилж хамгаалаагүй, гэмтэл согогтой байснаас бусад тохиолдолд хариуцлага хүлээхээр заажээ.

Хүснэгт 3.10. Монгол Улсын Иргэний хуулийн 500 дугаар зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1.	500 дугаар зүйлийн 500.1 дэх хэсэг	500.1.Зохих ёсоор арчилж хамгаалаагүй, гэмтэл согогтой байснаас бусад тохиолдолд байшин барилга бүтэн буюу хэсэгчлэн нурсны улмаас учирсан гэм хорыг тухайн барилгыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.
2.	500 дугаар зүйлийн 500.2 дахь хэсэг	500.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас, эсхүл хохирогчийн буруутай үйл ажиллагааны улмаас байшингаас ямар нэг зүйл унасан, хаягдсан буюу агсарсны улмаас гэм хор учирсан бол тухайн байшин барилгыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцлага хүлээхгүй.

Барилгын тухай хуульд барилгын норм, дүрмийн дагуу боловсруулж магадлал хийгдсэн зураг төслөөр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн барьсан орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, эрчим хүч, холбоо, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээг барилга байгууламж гэж тодорхойлсны зэрэгцээ барилга байгууламж, барилгын зураг төсөл, барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлага болон барилгын хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, материал үйлдвэрлэгчийн үүргийг нарийвчлан заажээ.⁵²

Иймд ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учрах, нурах тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хэн буруутай нь хариуцлага хүлээх тул “гэмтэл согогтой байсан” гэсэн ойлголт нь барилга бий болгох явцад бий болсон гэж үзэхээр байна. Харин байшин барилга бүтэн буюу хэсэгчлэн нурсан нь зохих ёсоор арчилж хамгаалаагүйгээс болсон бол үүнийг ашиглалтын явцад бий болсон гэж ойлгоно.⁵³

Хүснэгт 3.11. Шүүхийн шийдвэр №6

1.	Шийдвэрлэсэн шүүх	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал
2.	Огноо, дугаар	2022.09.02 210/МА2022/01637
3.	Талууд	Нэхэмжлэгч: Ү Хариуцагч: Б

52 Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Гэрээний бус үүрэг-IV, (УБ, 2016), 66-67 дахь тал.

53 Мөн тэнд.

4.	Маргааны агуулга	Миний бие эмнэлэгт үзүүлэх шаардлагын улмаас 2021.05.05-ны өдрөөс 06-ны өдөр шилжих шөнийн 02 цаг 38 минутын үед өөрийн өмчлөлийн автомашиныг жолоодон явж байхад автомашин дээр хариуцагч Э.Б-ын өмчлөлийн байрны дээвэр нурж унасан. Дээврийн арчилгаа хамгаалалтыг сахих, аюулгүй байдлыг хангах нь өмчлөгчийн үүрэг. Тухайн өдөр давагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшгийн үзэгдэл болсон гэдэг боловч бусад байшин, барилга байгууламжийн дээвэр нурсан зүйл болоогүй. Өмчлөгч үүргээ биелүүлээгүйгээс дээвэр хийсэж, автомашин дээр унасан. Дээвэр нурахтай холбоотой болон хохирол учрахад хохирогчийн шууд нөлөөлсөн идэвхтэй үйлдэл байхгүй. Мөн гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс нөлөөлсөн нь тогтоогдоогүй. Тус осолд хэрэг бүртгэлийн хэрэг нээн ажиллагаа явуулж байсан боловч 2021.07.07-ны өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдаж хэргийг хэрэгсэхгүй болгосон. Иймд Хас Үнэлгээ ХХК-ийн үнэлгээгээр автомашин учирсан хохирол 18,550,000 төгрөг, үнэлгээ хийлгэсэн зардал 856,000 төгрөг, нотариатын зардал 16,100 төгрөг, нийт 19,422,100 төгрөгийг хариуцагч Э.Б-с гаргуулж өгнө үү гэжээ.
5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 500 дугаар зүйлийн 500.1 дэх хэсэгт заасныг баримтлан Э.Б-с 19,406,000 төгрөг гаргуулж Ү-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдсэн 16,100 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Давж заалдах шатны шүүх: Иргэний хуулийн 500 дугаар зүйлийн 500.2 дахь хэсэгт зааснаар гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас, эсхүл хохирогчийн буруутай үйл ажиллагааны улмаас байшингаас ямар нэг зүйл унасан, хаягдсан буюу асгарсны улмаас гэм хор учирсан бол тухайн байшин барилгыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцлага хүлээхгүй юм. Цаг уур, орчны шинжилгээний газрын 2021.05.11-ний өдрийн 03/326 дугаар албан бичгээр 2021.05.05-06-нд шилжих шөнө Нийслэл хот орчмоор 0.0-3.0 мм нойтон цас орж, энэ үеэр хүчтэй салхи салхилж салхины хурд 8-13 метр, зарим үед секундэд 15-20 метр секунд хүрч цасан шуурга шуурч үзэгдэх орчин хязгаардагдаж байгаль цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдсан болохыг Ус, Цаг Уур, Орчны шинжилгээний Тахилт Хан-Уул Буянт Ухаа өртөөдийн бодит ажиглалтын мэдээнд үндэслэн тодорхойлов гэжээ. Уг баримтыг үндэслэн давагдашгүй хүчин зүйл болсон гэж үзэхгүй. Учир нь, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдалд гал түймэр, үер, газар хөдлөлт зэрэг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас байшин барилга бүрэн болон хэсэгчлэн нурсан зэргийг ойлгох бөгөөд хэрэгт авагдсан баримтаар дээрх нөхцөл байдал тогтоогдохгүй байна гэж үзэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 3.12. Шүүхийн шийдвэр №7

1.	Шийдвэрлэсэн шүүх	Улсын дээд шүүх
2.	Огноо, дугаар	2018.12.20 2018/ХТ2018/01917
3.	Талууд	Нэхэмжлэгч: О Хариуцагч: Б ХХК, Г ХХК

4.	Маргааны агуулга	Нэхэмжлэгч О нь "Б" ХХК-ийн барьж буй барилгад 2011 оны 7 дугаар сараас эхлэн туслах ажилчнаар ажилласан. 2011.10.24-ний өдөр "Б" ХХК-ийн 11 давхар барилга дээр ажиллаж байгаад 1 давхраас 2 давхарт ажиллах газраа очих гэж яваад харанхуй гэрэлтүүлэггүй лифтын хонгилд доошоо унаж хүнд гэмтэл авч нуруу нугасны хүнд хагалгаанд орсон. Унаж гэмтсэн лифтийн нүх ямар нэгэн хаалт хашлагагүй, анхааруулга, тэмдэг, тэмдэглээгүй, гэрэлтүүлэггүй байсан. Тухайн үед цагдаагийн байгууллага шалгаж байх явцад ажлын газраас надад эмчилгээний зардал 5.000.000 төгрөг өгч, цаашид дэмжиж туслана гэсэн учраас гомдолгүй гэснээр эрүүгийн хэрэг хаагдаж, үйлдвэрлэлийн ослын акт гараагүй өнгөрсөн. Одоо гэмтлийн дараах нугасны саажилт, доод мөчидын саажилт гэсэн оноштой, байнгын асаргаатай байх болсон. Түүнийг гэмтсэнээс хойш байгууллага нь 5.000.000 төгрөг өгснөөс өөрөөр дахин ямар нэгэн дэмжлэг тусалцаа үзүүлээгүй, миний биеийн байдлыг ч лавлаагүй. БНСУ-ын Сөүл хотын нуруу нугасны мэдрэлийн эмнэлэгт холбогдох материалуудаа явуулснаар мэдрэлийг дарж буй нугасны даралт шахалтыг чөлөөлж, нурууны өвдөлт болон хөл гуя дагаж өвдөх өвдөлтийг багасгах, бөгсөн биеийн мэдээ алдалтаас сэргийлнэ, төлбөрийн зардал 12.500.000 вон гэсэн хариуг ирүүлсэн болно. Уг гэмтлийн улмаас байнгын асаргаа шаардлагатай болж Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлгийн хяналтад орж 2018.08.02-ныг хүртэл асаргаанд байх шийдвэр гарсан. БНСУ-д эмчилгээнд явахад асран хамгаалагч хамт явах зайлшгүй шаардлагатай болох нь асаргаанд байдаг болохыг тодорхойлсон холбогдох баримтуудаар нотлогдоно. Иймд Монгол банкны зарласан ханшаар 2017.10.06-ны өдрийн хаалтын ханш БНСУ-ын вон 2.16 байх тул 12.500.000 вон нь монгол төгрөгт шилжүүлэхээр 27,000,000 төгрөг, БНСУ эмчилгээнд асран хамгаалагчийн хамт онгоцоор явах ирж очих тийзийн үнэ нийт 4.064.200 төгрөг, хоёр хүний буудалд байх зардал 1.321 ам.доллар буюу 3.253.583 төгрөг, нийт зардал 34.317.783 төгрөгийг "Б" ХХК-иас гаргуулж өгнө үү гэжээ.
5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Нэхэмжлэгч Д.О-н анхаарал болгоомжгүй байдал осол гарахад нөлөөлсөн гэж үзэн Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 228 дугаар зүйлийн 228.4 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэлийн шаардлагыг багасган хариуцагч тус бүрээс 11,439,261 төгрөг гаргуулж нэхэмжлэлийн зарим хэсгийг нь хангахаар шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх: Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангахгүй орхисон. Хяналтын шатны шүүх: Б ХХК, Н ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг хуульд заасан журмын дагуу хангаагүй, хяналт тавиагүй гэм буруутай байх тул О-ын эрүүл мэндэд учирсан гэм хорын хохирлыг хариуцах үүрэг хүлээнэ гэж анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны магадлалыг тус тус хэвээр үлдээсэн.

Дээрхээс харвал, барилга, байшинг зохих ёсоор арчилж хамгаалаагүй, гэмтэл согогтой байснаас бусад тохиолдолд Иргэний хуулийн 500 дугаар зүйлийн 500.1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэх бол зохих ёсоор арчилж хамгаалаагүй, гэмтэл согогтой байсан тохиолдлыг мөн хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт заасан ерөнхий гэм хорын хүрээнд шийдвэрлэх боломжтой байна. Ингэхдээ гэм хор учруулсан этгээд түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөх юм.

3.3.4 Амьтны учруулсан гэм хор

Иргэний хуулийн 501 дүгээр зүйлд амьтанд учруулсан бус амьтны учруулсан гэм хорыг тухайн амьтны өмчлөгч буюу эзэмшигч хариуцахаар заажээ. Амьтан гэдгийг зэрлэг, агнуурын амьтан, гэрийн тэжээвэр амьтан, тэжээвэр амьтан, мал

зэргээр ялгаагүй. Иймээс Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн” зэргийг ойлгохоор байна.

Амьтны учруулсан гэм хор нь гэм хорын эрх зүй дэх хатуу хариуцлагын зарчмын үндэс болсон тусгай төрөл юм. Энэ нь амьтныг хүн хараа хяналтдаа тодорхой хамгаалах хэрэгсэлтэй байлгаагүй тохиолдолд амьтан бусдад гэм хор учруулах нь байгалийн жам байдагтай холбоотой.

Хүснэгт 3.13. Монгол Улсын Иргэний хуулийн 501 дүгээр зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1	501 дугаар зүйлийн 501.1 дэх хэсэг	501.1.Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.
2	501 дугаар зүйлийн 501.2 дахь хэсэг	501.2.Гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтны үйлдлээс бусдад гэм хор учирсан нь тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол тэрээр гэм хорыг хариуцахгүй.

Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2 дахь хэсэгт зааснаар хариуцлага хүлээхийн тулд гэрийн тэжээвэр амьтан болон мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтны (албаны нохой зэрэг) эзэмшигч, өмчлөгчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэл байсан эсэхийг шалгах шаардлагатай байна. Үүнийг тодруулахад тухайн амьтныг тэжээхэд болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн ямар үүрэг хүлээх нь тодорхой байх шаардлагатай юм. Хэрвээ хууль тогтоомжид заасан үүргээ зөрчөөгүй байхад бусдад гэм хор учруулсан бол амьтныг өмчлөгч болон эзэмшигч гэм хорыг хариуцахгүй байх үр дагавар үүснэ.

Монгол Улсын хувьд нохой, муур асран хамгаалагч, түр харагчийн хариуцлагагүй байдлаас болж бусдын эрүүл мэндэд хохирол учрах тохиолдол түгээмэл байна. Тухайлбал, 2020 онд Монгол Улсын хэмжээнд нохойд хазуулсан шалтгаанаар осол, гэмтэлд өртөж, эмнэлгийн байгууллагад хандсан нийт 3,855 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс 75.1% /2,896/ тохиолдол нь ГССҮТ-д бүртгэгджээ. Хүн рүү дайрсан нохдын 90% нь эзэнтэй нохой байжээ. Нохойд хазуулсан шалтгаанаар гэмтсэн хүмүүсийг насны бүлгээр авч үзвэл 37% нь 0-15 насны хүүхдүүд, тэр дундаа 5-9 насны хүүхдүүд бусад насны бүлгийн хүмүүсээс 2-3 дахин өндөр хувьтайгаар буюу 659 тохиолдолд гэмтсэн байна.⁵⁴

Нохой нь гэрийн тэжээвэр амьтан бөгөөд тэдгээрийг асран хамгаалах, түр харах этгээдийн үүргийг тодорхой заасан хэм хэмжээ байхгүйгээс үүдэн “амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэл” гэдэгт юуг ойлгохыг тодорхойлоход бэрхшээлтэй байна. Тухайлбал, нохой, муурыг олон нийтийн газар, гудамж, талбайд зориулалтын хөтөлгөө, цээживчтэй авч явснаар бусдын эрүүл мэндэд хохирол учрахаас сэргийлэх боломжтой бөгөөд энэхүү үүргийг биелүүлээгүй этгээдэд үүрэг үүсэх учиртай. Харин нохой, муур асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрийн тэжээвэр амьтанд нь хүрэх, бие хамгаалах сэдэл бий болгохуйц үйлдэл хийсэн этгээдэд хохирол учирсан нь асран хамгаалагч,

54 Вай Инсайт ХХК, “Монгол Улсад гэрийн тэжээвэр амьтны эрхийг хамгаалах хууль хэрэгжүүлэх үндэслэл, хууль хэрэгжсэнээр гарах үр дүн” (судалгааны тайлан), (УБ, 2021), 50 дахь тал.

түр харагчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй учир гэм хорыг хариуцахгүй байх нь зохистой юм.

Хүснэгт 3.14. Шүүхийн шийдвэр №8

1.	Шийдвэрлэсэн шүүх	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
2.	Огноо, дугаар	2016.10.10 Дугаар 85
3.	Талууд	Нэхэмжлэгч: М Хариуцагч: Г
4.	Маргааны агуулга	Нэхэмжлэгч М нь нохойгоо 2021.08.08-ны өдөр 20 цаг 30 минутын орчимд байрныхаа гадаа салхилуулж байх үед нь тус байрны 01 дүгээр орцны 49 тоот айлын German Shephend нохой нь хүзүүвчгүй, уяагүй салхилж байх үедээ нохойг хазаж үхэлд хүргэх гэмтэл учруулсан бөгөөд гэмтэл авсан даруйд нь “Э” МЭСТ мал эмнэлэгт хандаж эмнэлгийн туслалцаа авсан байна. Эмнэлгийн үзлэгээр нохойн биеийн байдал маш муу, эмчлэгдэх ямар ч боломжгүй болсон гэсэн тул нэхэмжлэгчийн хүсэлтээр унтуулга хийжээ. Хариуцагч Г нь өөрийн German Shephend үүлдрийн том биетэй нохойг бусдад аюул занал учруулахгүй байх бүхий л нөхцөл байдлыг хангасан байдалтайгаар салхилуулж байх үүргээ биелүүлээгүйн улмаас нэхэмжлэгчийн нохойд үхэлд хүргэх гэм хорын хохирол учруулсан байх төдийгүй өнөөгийн ханшаар Т үүлдрийн нохой нь 2 000 000 төгрөгийн үнэтэйгээр худалдаалагддаг, мөн эм нохой байсан учир жилд 1-2 удаа гөлөглөх боломжтой ба нэг удаа гөлөглөхдөө 4-5 ширхэг гөлөг гаргадаг, 4 ширхэг гөлөгийг нь нэг бүрийг нь одоогийн ханшаар 2 000 000 төгрөгөөр худалдан борлуулж ашиг орлого олж болох байсан, өөрөөр хэлбэл дээрх Т үүлдрийн нохой нь арилжааны бүтээгдэхүүн болох учраас нэхэмжлэгчид учруулсан гэм хорын хохиролд 10 000 000 төгрөгийг хуульд заасны дагуу гаргуулж өгнө үү гэжээ.

5.	Шийдвэрлэсэн байдал	Шүүх: Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2-д зааснаар гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтны үйлдлээс бусдад гэм хор учирсан нь тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол тэрээр гэм хорыг хариуцахгүй гэж заажээ. Мөн хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх /адил нэр төрөл чанарыг эд хөрөнгө өгөх гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө гэжээ. Энэ зүйлд заасан “гэрийн тэжээвэр амьтан” гэдэгт хүний арчилгаа, маллагааны тусламжтайгаар амьдардаг таван хошуу малаас гадна ахуйн хэрэгцээнд зориулан гаршуулсан, өөртөө дасгасан амьтад болох нохой, муур, тахиа, гахай зэргийг ойлгоно. Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3-д “мал, амьтан өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ мал, амьтан, байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуйн шаардлага, бусдын аюулгүй байдлыг хангах талаар тогтоосон хууль дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй” байдаг. Хариуцагч олох байсан орлого болох 8 000 000 төгрөгийн хувьд Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журмын 5 дугаар зүйлийн 1-д “байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс нохойг үржлийн зориулалтаар ашиглах, нохойн аж ахуй байгуулах асуудлыг Нийслэлийн Мал эмнэлгийн болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын санал дүгнэлтийг үндэслэн тухайн дүүргийн Засаг даргын Тамгын газар шийдвэрлэнэ” гэж заажээ. Мөн тус нохой нь хээлгүй байсан болох нь баримтаар тогтоогдож байх тул олох байсан ашиг гэж 8 000 000 төгрөгийг хариуцагчаас шаардсан нь үндэслэлгүй байна гэж үзэв. Иймд Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар хариуцагчаас Т үүлдрийн нохойны үнэ болох 2 000 000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэлийн шаардлагаас олох байсан ашиг болох 8 000 000 төгрөгийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэжээ.
----	----------------------------	---

Хүснэгт 3.15. Шүүхийн шийдвэр №9

1.	Шийдвэрлэсэн шүүх	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх
2.	Огноо, дугаар	2018.03.26 Дугаар 120
3.	Талууд	Нэхэмжлэгч: Д Хариуцагч: А
4.	Маргааны агуулга	2017.11.15-ны өдөр Ө.А гийн нохой баруун хөлний шилбэнд 4 соёо оруулан хазсан гэмтэл учруулсан, гоо сайхнаа алдсан. Өмнөговь аймгийн Сэврэй сумын хүн эмнэлэгт 7 хоног эмчилгээ хийлгэж гарсан. Одоо хөл цаашаа идээлээд байгаа тул эмчилгээний мөнгө болон хохиролыг барагдуулж өгнө үү. Нэг соёо нэг сая төгрөг. Ө.А гэс хохиролын төлбөр болох 4 000 000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

5.	Шийдвэрлэсэн байдал	Амьтныг өөрийн эзэмшил, ашиглалтад байлгаж, захиран зарцуулах эрхтэй этгээдийг өмчлөгч гэж ойлгох ба хариуцагч Ө.А нь нэхэмжлэгч С.Д гийн хазуулсан нохойн өмчлөгч болох нь нэхэмжлэгчийн “Ө.А гийн гэрийн гадаа байсан нохойд хазуулсан. Тэдний малчин Саруул нохойгоо хорьж өгсөн боловч араас ирээд хазсан” гэх тайлбар, гэрч П.Х “А-д танай нохой манай охиныг урсан байна. Эмнэлэгт хэвтэж байгаа гэхэд А- эмнэлэгт гарсан төлбөрийг нь төлнө. Манайх нохойгоо алуулах гээд аваад ирсэн гэж байсан” гэх мэдүүлгээр тус тус нотлогдож байна. Гэрийн тэжээвэр амьтны эзэн тэдгээрийн өмчлөгч байдаг тул уг амьтны бусдад учруулсан гэм хорын хохирлыг хариуцан арилгах үүрэгтэй байна. Нэхэмжлэгч нь 7 хоног эмнэлэгт хэвтсэн, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсний нэг хоногийн төлбөр 15000 төгрөг, вакцины үнэ 45000 төгрөг, эм тариа, бензиний үнэ 60000 төгрөгийн зардал гарсан гэж тайлбарлаж байгааг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч үгүйсгэхгүй байх тул нэхэмжлэгчийн дээрхи тайлбарыг үндэслэн 210000 төгрөгийг хариуцагчаас гаргуулан нэхэмжлэгчид олгох үндэслэлтэй гэж үзлээ. Харин нэхэмжлэлийн шаардлагын үлдэх хэсгийг нотлох баримтыг шүүхэд ирүүлээгүй тул хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх нь зүйтэй гэж үзжээ.
----	----------------------------	--

Дээрхээс харвал, нохойгоо алдсан иргэнд учирсан гэм хорыг Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт заасны дагуу эд хөрөнгөд учирсан хохирол гэж үзэж байгаа бол нохойны хүнд учруулсан гэм хорыг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байна.

Үүнээс гадна Зөрчлийн тухай хуулийн 5.19 дүгээр зүйлд орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулахаар заасан. Иргэний хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг ялгах нэг үндэслэл нь гэмтлийн зэрэг байна.

Өөрөөр хэлбэл, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учирсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар, бусад тохиолдолд иргэний журмаар шийдвэрлэхээр харагдаж байна. Эдгээр хоёр зохицуулалт нь зорилгын хувьд ижил байх бөгөөд амьтны хүний амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлыг тухайн амьтныг ийнхүү хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй этгээд хариуцах агуулгатай юм.

2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр нэр бүхий гишүүдээс Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг⁵⁵ Улсын Их Хуралд өргөн барьсан бөгөөд төслийн 9 дүгээр зүйлд гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн үүргийг тодорхой заасан. Тухайлбал, олон нийтийн газар гэрийн тэжээвэр амьтантай зорчихдоо тухай амьтны төрөл, биеийн хэмжээнд тохирсон хүзүүвч, хошуувч, цүнх, хөтөлгөө зэрэг зориулалтын хэрэгсэлтэй авч явах; гэрийн тэжээвэр амьтан бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх; гэрийн тэжээвэр амьтан ашиглан бусад хүн, амьтныг айлган сүрдүүлэхгүй байх, гэрийн тэжээвэр амьтан орон сууц, хашаанаас хараа хяналтгүй гарахгүй байх, бусад амьтан орохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг үүргийг тусгажээ.

Ийнхүү тус хуулийн төсөл батлагдсан тохиолдолд Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2 дахь хэсэгт заасан “санаатай болон илт болгоомжгүй үйлдэл” гэдэгт юуг хамааруулахыг тухайн хүн хуульд заасан үүргээ биелүүлсэн эсэхийг тодруулах замаар тодорхойлох боломжтой байна.

55 Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл (2022), Холбоос: <https://d.parliament.mn/tusul/bb7314dd-9dbf-4797-b603-6b230d4257c8>.

3.3.5 Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлээс учирсан гэм хор

Иргэний хуулийн 502 дугаар зүйлийн 502.1 дэх хэсэгт барилга, байшин өмчлөгч, эзэмшигч гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчмыг аюултай үйл ажиллагаа, зүйлтэй холбон тогтоосон байна.

Хүснэгт 3.16. Монгол Улсын Иргэний хуулийн 502 дугаар зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1.	502 дугаар зүйлийн 502.1 дэх хэсэг	502.1.Барилга байгууламжийн хийц, зохион байгуулалтыг дур мэдэн өөрчилсөн, эсхүл түүнд байрлуулсан буюу дамжуулан оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодисын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд гэм хор учирсан бол уг гэм хорыг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, эсхүл аюултай зүйлийг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй.
2.	502 дугаар зүйлийн 502.2 дахь хэсэг	502.2.Онцгой аюул учруулж болох барилга байгууламж, эд хөрөнгийг өмчлөгч буюу эзэмшигч нь гэм буруутай байсан эсэхээс үл хамааран энэ хуулийн 502.1-д заасан гэм хорыг хариуцна.
3.	502 дугаар зүйлийн 502.3 дахь хэсэг	502.3.Өмчлөгчийн эзэмшилд байгаа барилга байгууламж дотор буюу түүний эдлэн газрын хил хязгаарын дотор бусдад гэм хор учирсан боловч түүнд өмчлөгч буруугүй бол тэрээр хариуцлага хүлээхгүй.

Уг зүйлийн гарчиг нь орчин тойрондоо аюултай үйл ажиллагаанаас учирсан гэм хор гэсэн агуулгатай боловч гэм хор учруулж буй эх сурвалжийг тодорхойлохдоо барилга байгууламжтай холбоотойгоор үйл ажиллагаа явуулж буй этгээд гэхээсээ илүүтэй, тухайн өмчлөгч, эзэмшигчид хариуцлага хүлээлгэх агуулга зонхилсон байна. Үүнд хариуцлага хүлээх гол үндэслэл нь “барилга байгууламжийн хийц зохион байгуулалтыг дур мэдэн өөрчилсөн”, “барилга байгууламжид оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодис”-ын улмаас үүссэн гэм хорын хоорондын шалтгаант холбоо тогтоогдсон байх талаар тодорхой байгаа боловч хариуцлага хүлээх этгээд нь “үйл ажиллагаа явуулж буй этгээдийн”, эсхүл “аюултай зүйл өмчлөгч, эзэмшигч” гэж хоёр өөр этгээд байж болохоор хуульчилсан байна.⁵⁶

Иргэний хуулийн тайлбарт орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа гэдэгт аюул учруулж болох зүйлийг ажиллуулах, хамгаалах, хадгалах зэрэг үүрэг бүхий этгээдийн үйл ажиллагааг ойлгож болно гэжээ. Харин тухайн объектыг орчин тойрондоо аюултай зүйл гэж үзэхэд чанарын шалгуураас гадна жин, хэмжээ, найрлага зэрэг тоон үзүүлэлт зайлшгүй шаардлагатай байна.⁵⁷

Гэвч орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа, зүйл гэдгийг шинжээр нь тайлбарласан тайлбар одоогоор байхгүй байна. Ийнхүү орчин тойрон гэдэгт дан ганц барилга, байшин биш гэдгийг тодорхойлох хэрэгцээ байна. Уг гэм хорын тусгай төрлийн мөн чанар нь үйлдвэрлэл явуулж буй этгээдэд илүү хамааралтай байдаг. Харин Монгол Улсын хувьд үүнийг ямар утгаар шүүхийн практикт хэрэглэж байгааг зарим шүүхийн шийдвэр дээр жишээ болгон авч үзье.

56 Ж.Оюунтунгалаг, “Гэм хорын тусгай төрөл: Эзэмшигчийн хариуцлага”, Иргэний эрх зүйн онол, практик /илтгэл, магадлал/, (УБ, 2017). Холбоос: <https://legaldata.mn/buteel/pdf?id=996>

57 Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Гэрээний бус үүрэг-IV, (УБ, 2016), 70 дахь тал.

Хүснэгт 3.17. Шүүхийн шийдвэр №10

1.	Шийдвэрлэсэн шүүх	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
2.	Огноо, дугаар	2019.07.17 Дугаар 1536
3.	Талууд	Нэхэмжлэгч: МД ХХК Хариуцагч: О
4.	Маргааны агуулга	МД ХХК-ийн даатгуулагч АНУ-ын иргэн Глен болон түүний эхнэр Рут нарын өмчлөлийн 400 м.кв талбай бүхий хувийн сууц гал түймрийн улмаас бүрэн шатаж, даатгалын гэрээгээр тохирсон даатгалын тохиолдол бий болсны улмаас даатгагч буюу нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэрийн дагуу даатгалын нөхөн төлбөрт 167,680,000 төгрөгийг төлсөн. Уг гал түймэр нь тухайн сууцны барилгын ажлыг гүйцэтгэсэн О цахилгаан хэрэгслийг буруу угсарч, суурилуулсан хэт хайхрамжгүй, болгоомжгүй, буруутай үйлдэл нөлөөлсөн үндэслэлээр даатгалын гэрээний дагуу төлсөн төлбөрийн хэмжээгээр гэм хорын хохирлыг нэхэмжилжээ.
5.	Шийдвэрлэсэн байдал	О нь УБЕГ-т хувийн сууцыг бариулж ашиглалтад өгсөн талаар баталгаа гаргаж байсан талаар талууд харилцан тайлбарлаж, үүнд маргаагүй, энэ талаар ИХШХШТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасан шаардлага хангаагүй баримт хэрэгт авагдсан байдаг боловч үүнээс өөр баримт үгүй тул тэрхүү баталгаа гаргасан явдлыг хувийн сууцыг АНУ-ын иргэн Глений захиалгаар хариуцагч барьж ашиглалтад оруулсан гэж үзэх хангалттай үндэслэл болохгүй гэж үзсэн. Иймд хариуцагч тухайн хувийн сууцны барилгын ажлыг, тэр тусмаа цахилгааны холболтын ажлыг гүйцэтгэсэн, эсхүл бусдаар гүйцэтгүүлсэн гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй тул О-г орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа явуулж байгаа этгээд гэж үзэх үндэслэлгүй гэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

Дээрхээс харвал, Иргэний хуулийн 502 дугаар зүйлд заасан зохицуулалт барилга, байгууламж өмчлөгч болон эзэмшигчийн хариуцлагатай холбоотой бөгөөд хатуу хариуцлагын зарчмыг үндэслэл болгосон гэм хорын тусгай төрөл юм. Харин тус шүүхийн шийдвэрээр өмчлөгч нь бусад этгээдийн эсрэг нэхэмжлэлийн шаардлага гаргасан нь зохицуулалтын хүрээнд хамаарахгүй болохыг харуулж байна.

Хүснэгт 3.18. Шүүхийн шийдвэр №11

1.	Шийдвэрлэсэн шүүх	Улсын Дээд шүүх
2.	Огноо, дугаар	2017.12.27 001/ХТ2018/00045
3	Талууд	Нэхэмжлэгч: С Хариуцагч: Т ХХК

4.	Маргааны агуулга	Иргэн Я.С нь 2015.12.24-ний өдөр Т ХХК-ийн Старт Эко авто сэлбэгийн захаас авто машины буфер худалдан авахаар очиход тус худалдааны төвийн ажилчин дагуулж, 2 давхарт гарч буфер үзүүлсэн. Нөгөө залуутай буферийг дамжлан, урд талд нь явж байгаад 2 давхрын онгорхой нүхээр унаж хүнд гэмтсэн. Я.С нь тус худалдааны төвийн 2 давхараас унаж бэртсэний улмаас цээжний хэнхэрцэгийн дарагдал, няцрал, баруун талын олон хавирга далд хугарал, баруун уушигны бүрэн бус авчилт, тархины няцрал, зөөлөн бүрхүүлийн доорх цус харвалт, хүнд гэмтэл гэсэн онош гарсан. Уг гэмтлийн улмаас хэдэн сар эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, хагалгаанд орсон, их хэмжээний эм тариа хэрэглэж зардал гаргасан. Т ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4930-200 стандартын 1.4-ийн 3 дахь хэсгийн хаалт хамгаалах хэрэгслийг хэрэглэсэн гэсэн заалтыг, мөн байгууллагын нийт ажилчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн 7.3 дахь үйлчлүүлэгчийг агуулахын сэлбэг хураасан тавиурын хэсгээр ойрхон явахыг хориглож, хэрэв явж байвал анхааруулга өгнө гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс Я.С- биед хүнд гэмтэл учруулсан буруутай. Иймд, Т ХХК болон тус компанийн захирал П.Т нараас эмчилгээний зардал болох 2.998.219 төгрөг, өмгөөллийн урьдчилгаа хөлс 500.000 төгрөг, нийт 3.498.619 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.
5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 512 дугаар зүйлийн 512.4, 227 дугаар зүйлийн 227.3-д зааснаар хариуцагч Т ХХК-иас 2.998.219 төгрөг гаргуулж нэхэмжлэгч Я.С-т олгож, нэхэмжлэлээс 500.000 төгрөг гаргуулах тухай шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.2, 505 дугаар зүйлийн 505.1-д зааснаар хариуцагч П.Т-т холбогдох 3.498.619 төгрөг гаргуулах тухай Я.С-ын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх: Иргэний хуулийн 502 дугаар зүйлийн 502.1, 505 дугаар зүйлийн 505.1 дэх хэсэгт заасныг баримтлан хариуцагч Т ХХК-иас 2.878.219 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Я.С-т олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 620.000 төгрөгт холбогдох хэсгийг болон хариуцагч П.Т-т холбогдох нэхэмжлэлийг тус тус хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэсэн байна. Хяналтын шатны шүүх: Анхан шатны шүүх нэхэмжлэлийн зарим хэсгийг хангахдаа Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 512 дугаар зүйлийн 512.4, 227 дугаар зүйлийн 227.3-т заасныг баримталсан нь тухайн маргаантай харилцаа, шаардах эрхэд хамааралгүйг давж заалдах шатны шүүх залруулж дүгнэсэн нь хуулийн үндэслэлтэй. Т ХХК-ийн хууль бус санаатай буюу болгоомжгүй үйлдлээс /эс үйлдэхүй/ болон тус компанийн ажил, үйлчилгээний дутагдлын улмаас нэхэмжлэгч Я.С-ын эрүүл мэндэд гэм хор учирсан гэх үндэслэл хэргийн баримтаар тогтоогдоогүй байна. Орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлээс учирсан гэм хорыг хариуцах нөхцөлийг Иргэний хуулийн 502 дугаар зүйлээр зохицуулсан байна. Тухайлбал, барилга байгууламж эзэмшигч, өмчлөгч нь барилга байгууламжийн хийц, зохион байгуулалтын өөрчлөлттэй үед бусдад учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй бөгөөд энэ тохиолдолд нэхэмжлэгчийн унаж бэртсэн үйлдэлд Т ХХК-ийн гэм буруутай нь тогтоогдох эсэхээс үл хамаарахыг давж заалдах шатны шүүх дүгнэсэн нь хуульд нийцжээ. Иймд, нэхэмжлэгч Я.С-ын эрүүл мэндэд учирсан хохирлын зарим хэсгийг хангахдаа давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 502 дугаар зүйлийн 502.1, 505 дугаар зүйлийн 505.1-д заасныг зөв тайлбарлан хэрэглэсэн, хоёр шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй байна. Иймд магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзжээ.

Хүснэгт 3.19. Шүүхийн шийдвэр №12

1.	Шийдвэрлэсэн шүүх	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
2.	Огноо, дугаар	2017.11.22 Дугаар 2401
3.	Талууд	Нэхэмжлэгч: С Хариуцагч: Б
4.	Маргааны агуулга	Нэхэмжлэгч нь 2016.09.11-ний өдөр иргэн Г.Б-ийн бохирын вакуумжуулсан нүхэнд хар лак шингэн бодисоор будгийн ажлыг хийж, ажлын хөлсөнд 20 000 төгрөг өгсөн. Г.Б-ийн аавын төрсөн дүү н.Н-тай хамт ажилласан ба нүхний 3 талыг будаад сүүлийн ханыг будаж байтал ард гал гарах шиг болоод дэлбэрсэн. н.Н тамхи татах гээд шүдэнз зурсан, түүнийг нүхнээс татаж гаргах гээд чадаагүй. Ингээд би гэмтлийн эмнэлэгт хүргүүлж түлэнхий тасгийн сэхээн амьдруулахад 27 хоног хэвтэж эмчлүүлсэн. Шүүх эмнэлгийн дүгнэлтээр гэмтлийн хүнд зэрэг тогтоож, хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Иймд эмчилгээний зардал 4 760 050 төгрөг, сэтгэл санааны хохирол 600 000 төгрөгийг Иргэний хуулийн 505 дугаар зүйлийн 505.2 дахь хэсэгт зааснаар гэм хор учруулсан тул хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээ буюу 240 000 төгрөгийн нөхөн төлбөр шаардаж байна гэжээ.
5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 502 дугаар зүйлийн 502.1, 505 дугаар зүйлийн 505.1, 505.2 дахь хэсэгт зааснаар хариуцагч Г.Б-аас 5 059 588 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Ш.С-т олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 600 000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх: Хариуцагч Г.Б нь нэхэмжлэгч Ш.С-аар ажил үүрэг гүйцэтгүүлэх үедээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх үүргээ биелүүлээгүй буюу Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын тухай хуулийн заалтыг зөрчсөн буруутай байна. Иймд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 505.2 дахь хэсэгт заасан зохицуулалтад нийцсэн гэж үзнэ. Сэтгэл санааны хохирол гаргуулах нэхэмжлэлийн шаардлагын тухайд: Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1 дэх хэсэгт зааснаар хохирогч эдийн бус хохирлыг шаардах эрхтэй боловч мөн хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт “гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлнө” гэж тусгайлан зохицуулжээ. Гэтэл эдийн бус хохирлыг арилгах Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт сэтгэл санааны хохирлыг арилгах талаар зохицуулагдаагүй тул нэхэмжлэлийн шаардлагын энэ хэсгийг хангах үндэслэлгүй юм. Түүнээс гадна шүүх орчин тойрондоо аюултай ажиллагаа болон орчин тойрондоо аюултай бусад зүйлээс учирсан гэм хорыг хариуцах тухай зохицуулалтыг баримталсан нь буруу байна. Учир нь Иргэний хуулийн 502 дугаар зүйл нь барилга байгууламжийн хийц зохион байгуулалтыг дур мэдэн өөрчилсөн болон тухайн барилга байгууламжид байрлуулсан, дамжуулан оруулсан эрчим хүч, галын болон тэсрэх аюултай, хортой бодисын улмаас учирсан гэм хорыг арилгах тухай зохицуулалт бөгөөд Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар “барилга байгууламж гэдэгт орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, зам барилга, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, түүний инженерийн шугам сүлжээ хамаарна”. Иймд иргэн Д.Б-ийн эзэмшлийн бохир усны нүхийг “барилга байгууламж” гэх ойлголтод хамааруулан үзэх боломжгүй тул давж заалдах гомлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний хувьд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Дээрхээс үзвэл, орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа болон орчин тойрондоо аюултай зүйл гэдгийг барилга байгууламжаар хязгаарлах хандлага практикт ажиглагдаж байна. Тус гэм хорын тусгай төрлийн мөн чанарыг авч үзвэл орчин тойрондоо аюултай үйл ажиллагаа гэдэгт барилга байгууламж болон тээврийн хэрэгслээс бусад үйл ажиллагааг шинжээр нь тодорхойлох хэрэгцээ шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн сэтгэл санааны хохирлыг шүүх хангаж шийдвэрлэх хууль зүйн үндэслэл байхгүй болох нь шүүхийн шийдвэр 12-оос харагдаж байна.

3.3.6. 7-14 хүртэлх насны, насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй иргэний учруулсан гэм хор

Иргэний хуулийн 503 дугаар зүйлд 7-14 хүртэлх насны болон эрх зүйн чадамжгүй иргэний учруулсан гэм хорыг хариуцах этгээдийг тодорхойлсон. Эх газрын эрх зүйн тогтолцоонд хариуцлага хүлээх чадамжгүй байдалд үндэслэн насанд хүрээгүй, сэтгэцийн өвчтэй этгээдийг гэм хорын хариуцлагаас хуулиар чөлөөлж байгаагаас үзэхэд хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд хүүхдийг хамгаалах зарчим үйлчилдэг гэж үзэхээр байна. Насны болон сэтгэцийн байдлыг харгалзан тодорхой этгээдийг хариуцлагаас чөлөөлсөнтэй холбоотойгоор тэдгээрийн учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргийг өөр этгээдэд шилжүүлснээр харж хандах, эсхүл хяналт тавих үүрэг бүхий этгээдийн хариуцлагыг хуульчлан тогтоосноор хараа хяналтын үүргээс үүсэх гэм хорын тусгай төрөл бий болж байна.⁵⁸

Хүснэгт 3.20. Монгол Улсын Иргэний хуулийн 503 дугаар зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1.	503 дугаар зүйлийн 503.1 дэх хэсэг	503.1.7-14 хүртэлх насны болон эрх зүйн чадамжгүй иргэний бусдад учруулсан гэм хорыг тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч хариуцан арилгана.
2.	503 дугаар зүйлийн 503.2 дахь хэсэг	503.2.7-14 хүртэлх насны иргэн сонгууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр хуулийн этгээд хариуцан арилгана.
3.	503 дугаар зүйлийн 503.3 дахь хэсэг	503.3.Сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон иргэний бусдад учруулсан гэм хорыг түүний асран хамгаалагч буюу түүнд байнгын хяналт тавих үүрэг бүхий этгээд хариуцан арилгана.
4.	503 дугаар зүйлийн 503.4 дэх хэсэг	503.4.Эцэг, эх, асран хамгаалагч нь хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэдгээ нотолж чадвал тэдгээрийг гэм хор арилгах үүргээс чөлөөлж болно.
5.	503 дугаар зүйлийн 503.5 дахь хэсэг	503.5.Насанд хүрээгүй хүмүүс бусдад учруулсан гэм хорыг өөрөө хариуцан арилгах бөгөөд түүний цалин хөлс, орлого, захиран зарцуулах эрхэд нь байгаа хөрөнгө гэм хорыг арилгахад хүрэлцэхгүй бол хүрэлцэхгүй байгаа тэр хэмжээгээр эцэг эх, харгалзан дэмжигч нь нөхөх хариуцлага хүлээнэ.
6.	503 дугаар зүйлийн 503.6 дахь хэсэг	503.6.Энэ хуулийн 503.5-д заасан гэм хорыг арилгахад энэ хуулийн 503.4-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.

Иргэний хуулийн 18, 19 дүгээр зүйлд тодорхойлсны дагуу иргэний эрх зүйн чадамжгүй иргэн гэдэгт 7 хүртэлх насны этгээд, сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсныг шүүхээс тооцож, асран хамгаалалт тогтоосон хүнийг ойлгоно. Мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ

58 Шварц Вандт, Хууль зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй, орч. Л.Эрдэнэ-Очир, (УБ, 2017), 139 дэх тал.

эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насан хүрсэн этгээдийг шүүхээс иргэний эрх зүйн чадамжийг нь хязгаарлаж, харгалзан дэмжигч томилно.

Хүснэгт 3.21. Шүүхийн шийдвэр №13

1.	Шийдвэрлэсэн шүүх	Говьсүмбэр аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
2.	Огноо, дугаар	2018.10.02 Дугаар 134/ШШ2018/00180
3.	Талууд	Нэхэмжлэгч: Б Хариуцагч: Э
4.	Маргааны агуулга	Миний бие эхнэр хүүхдийн хамт Дорноговь аймгийн Айраг сум явж автомашин оношлоод 2018.08.15-ны өглөө 03 цагийн орчим ирсэн. Машинаасаа буухдаа автомашин оношилгооны Launchxp431 gh төхөөрөмжөө бусад багаж хэрэгслийн хамт гэртээ авч орох гээд машин дээрээ түр тавиад бусад багаж хэрэгслээ машинаас авах гэтэл арын суудал дээр охин унтсан байсан. Ингээд машин дотроос багаж хэрэгслээ аваад эхнэр бид хоёр 2 хүүхдээ нэг нэгээр нь өргөөд машин дээрээ тавьсан Launchxp431 gh төхөөрөмжөө орхиж гэртээ орж амарсан байсан. 2018.05.15-ны өглөө 11 цагийн орчим эхнэр бид хоёр Launchxp431 gh төхөөрөмжөө автомашин дээр тавиад орхисноо санаад авах гээд гартал автомашин дээр байсан төхөөрөмж алга болсон байсан. Нэхэмжлэгч миний бие нь эхнэр Б.Ц-н хамт О ХХК-ийн камерыг шүүж үзэхэд 1 дүгээр байрны 1 дүгээр орцны 4 давхарын 8 тоотод суудаг Б.Э-н охин Х гэдэг хүүхэд манай автомашины оношилгооны төхөөрөмжийг аваад явсан бичлэг байсан. Бид тухайн үедээ Э.Х-г авсан гэж мэдээгүй, камер шүүж үзэж, зарлал нааж, хайсны эцэст олсон. Э.Х нь манай автомашины төхөөрөмжийг аваад аав Б.Э-д үзүүлсэн гэвч аав хэрэггүй юм байна гаргаж хая гэхээр нь хог дээр хаясан гэсэн. Бид хогийн цэг дээр ажил хариуцсан хүмүүсээр заалган үзсэн боловч хог дээрээс манай автомашины оношилгооны төхөөрөмж олдоогүй, мөн оношилгооны төхөөрөмж байж болох эд зүйл шатсан гэх зүйл ч мөн олдоогүй болно. Иймд эрх зүйн чадамжгүй Э.Х нь автомашины оношилгооны Launch xp431 gh төхөөрөмжийг авч 2,150,000 төгрөгийн хохирол учруулсан тул Э.Х-н аав Б.Э-с төхөөрөмжийн үнийг гэм хорын хохиролд нэхэмжилж байна гэжээ.

5.	Шийдвэрлэсэн байдал	Анхан шатны шүүх: Иргэний хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д 7-14 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн зарим чадамжтай байна гэсэн бөгөөд 2006.08.29-ний өдөр төрсөн Э.Х нь иргэний эрх зүйн зарим чадамжтай байна. Э.Х автомашины оношилгооны Launch xp431 gh төхөөрөмжийг авч явсан үйлдэл нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан хууль бус үйлдэлд тооцогдохгүй байх бөгөөд Иргэний хуулийн 116 дугаар зүйлийн 116.1-д заасан гээгдэл эд хөрөнгө олсон этгээд тухайн эд хөрөнгийн өмчлөгч буюу шаардах эрх бүхий этгээдэд нэн даруй мэдэгдэж, хүлээлгэн өгөх эрхтэй гэсний дагуу энэ үүргийг хүлээсэн этгээдэд иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд Э.Х болон хариуцагч Б.Э нар хамаарахгүй тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүх: Хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдлээс шалтгаалж гэм хорын хохирол бий болсон гэж дүгнэн нэхэмжлэлийн шаардлагыг 50 хувиар бууруулан Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 503 дугаар зүйлийн 503.1, 514 дүгээр зүйлийн 514.1-д зааснаар хариуцагч Б.Э-гаас 1,075,000 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Б.Б-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 1,075,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Хяналтын шатны шүүх: Эцэг эх, асран хамгаалагч нь хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлснээ нотолж чадвал тэдгээрийг гэм хор арилгах үүргээс чөлөөлөхөөр Иргэний хуулийн 503 дугаар зүйлийн 503.4-т заасан ба хариуцагч энэхүү үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн нь тодорхой бус, энэ талаарх баримт хэрэгт авагдаагүй, мөн Давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан баримтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1., 40.2.-т заасан журмын дагуу үнэлж, "...хүүхэд бусдын эд зүйлийг гэртээ авчирч байхад эзнийг нь олж тогтоох, зохих газарт нь мэдэгдэх, эсвэл авсан газарт нь буцаан тавиулах зэрэг арга хэмжээ аваагүй буруутай" гэж дүгнэснийг буруутгах боломжгүй, хэргийн нөхцөл болон гэм хор учрахад нэхэмжлэгчийн хэтэрхий болгоомжгүй, хайхрамжгүй байдал нөлөөлсөн гэж үзсэн нь үндэслэлтэй гэж үзсэн тул магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.
----	----------------------------	---

Хүснэгт 3.22. Шүүхийн шийдвэр №14

1.	Шийдвэрлэсэн шүүх	Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх
2.	Огноо, дугаар	2016.08.19 Дугаар 5483
3.	Талууд	Нэхэмжлэгч: Е Хариуцагч: М
4.	Маргааны агуулга	Э.Е нь 2016.04.13-ны өдөр бидний хүүхэд Б.Б-г зодож, хөнгөн гэмтэл учруулсан нь Баянзүрх дүүргийн Прокурорын газрын 4969 тоот дугаартай тогтоолд тодорхой дурьдсан. Энэ хэргийн улмаас хүүгийн маань хамрын ясны баруун хана цөмөрсөн, хамрын таславч мурийсан, одоо яаралтай хагалгаанд орох шаардлагатай боловч мөнгө төгрөгний бололцоогүйн улмаас мэс засалд оруулж чадахгүй байна. Мэс заслын зардал нь 1,150,000 төгрөг, ор хоногийн мөнгө 48,000 төгрөг, толгойн зураг авахуулахад гарсан зардал 120,000 төгрөг, шинжилгээний төлбөр 40,000 төгрөг, нотариатын зардал 2,500 төгрөг, одоо хүртэл эм, тариа хийлгэж байгаа болон автобус, таксины зардалд 679,500 төгрөгийн зардал гаргаад байна. Одоо хүүгийн маань хамар байнга битүүрэх, толгой өвдөх, цус гарах зэргээр зовиур илэрч байна. Бид, хүүгийн хамт "Э" эмнэлэгт үзүүлэхэд хагалгаанд орох шаардлагатай, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хийлгэсэн эмчилгээ нь хугарсан хамар, мурийсан таславч зэргийг эмчлээгүй, энэ мэс заслыг гоо сайхны гэж шууд ойлгож болохгүй. Нэгэнт хугарсан, мурийсан таславчийг мэс заслын аргаар эмчлэхгүй бол хүүхдийн хамар муруй, дотогш суусан, байнга битүүрдэг өвчтэй болно. Энэхүү үйл явдлаас болж миний хүүхэд сургуулиасаа гарсан, харьяа сургууль буцаан авахгүй гэж шийдсэн, цаашдын сургалт, хүмүүжилд сөргөөр нөлөөлсөн гэх үр дагаврууд бий боллоо. Иймд, Э.Е-н ээж М.М-аас 2,000,000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

5.	Шийдвэрлэсэн байдал	Шүүх: Иргэний хуулийн 503 дугаар зүйлийн 503.2-т зааснаар иргэний эрх зүйн зарим чадамжгүй буюу 7-14 хүртэлх насны иргэн сургууль, хүүхэд хүмүүжүүлэх болон эрүүл мэндийн байгууллагын шууд хяналтын дор байхдаа бусдад учруулсан гэм хорыг эдгээр хуулийн этгээд хариуцан арилгах юм. Э.Е нь хэрэг явдал болох өдөр 14 нас, 329 хоногтой байсан тул сургуулийн захиргааны байнгын хяналт дор байх, өдөр тутам хянаж, харгалзах насны хязгаарт хамаарагдахгүй байгаа тул түүний бусдад учруулсан гэм хорын хохирлыг харьяа сургууль хариуцах үүрэг хүлээхгүй. Харин Иргэний хуулийн 503.1-т зааснаар түүний хууль ёсны төлөөлөгч болох эх М.М хариуцан арилгах үүрэг хүлээнэ гэж үзэж хохирогч Б.Б-д эрүүл мэндэд учруулсан хохирлоо нөхөн сэргээхэд гарах мэдээ заслын төлбөр, мэдээ заслын дараах эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх ор, хоногийн төлбөр, компьютер томографийн оношлогоо хийлгэсэн болон шүүхэд нэхэмжлэл гаргах зорилгоор нотлох баримтыг хуульд зааснаар нотариатаар гэрчлүүлсэн зардалд нийт 1,320,500.00 төгрөгийг нэхэмжлэгч нарт олгуулж, шинжилгээ хийлгэсэн, эм, тариа хийлгэсэн болон автобус, таксины 679,500 төгрөгийн зардал гарсан нь баримтаар нотлогдохгүй байгаа тул нэхэмжлэлийн шаардлагаас 679,500 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.
----	----------------------------	--

Дээрхээс харвал, насанд хүрээгүй, иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийн учруулсан гэм хорыг Иргэний хуулийн 503 дугаар зүйлд заасны дагуу тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг,эх, асран хамгаалагч болон байнгын хяналт тавих үүрэгтэй этгээд хариуцан арилгах юм.

3.3.7. Үйлдлийнхээ учир холбогдлыг ойлгохгүй буюу өөрийгөө зөв удирдах чадваргүй байхдаа учруулсан гэм хор

Иргэний хуулийн 504 дүгээр зүйлд иргэний эрх зүйн бүрэн чадамжтай боловч өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй буюу зөв удирдах чадваргүй байхдаа бусдад гэм хор учруулсан этгээд хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөлийг тодорхойлжээ.

Хүснэгт 3.23. Монгол Улсын Иргэний хуулийн 504 дүгээр зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1.	504 дугаар зүйлийн 504.1 дэх хэсэг	504.1.Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй буюу зөв удирдах чадваргүй байхдаа бусдад учруулсан гэм хорыг хариуцахгүй.
2.	504 дугаар зүйлийн 504.2 дахь хэсэг	504.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундааны зүйл хэрэглэж өөрийгөө тийм байдалд хүргэсэн этгээдэд энэ хуулийн 504.1 хамаарахгүй.

Насанд хүрсэн эрх зүйн бүрэн чадамжтай этгээд өөрийгөө удирдан жолоодох чадваргүй буюу өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй буюу зөв удирдах чадваргүй гэдгийг тогтоох нөхцөлийг хуульд нэрлэн заагаагүй. Гэвч бусдад хүчээр дарлагдсан буюу хүндээр доромжлогдсон, эсхүл хохирогчийн хууль бус бусад үйлдлээс болж санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан, эсхүл ямар нэгэн өвчин, үйл явдлын улмаас сэтгэхүйн хүчтэй цочролд орж өөрийн үйлдэлд үнэлэлт өгч, үр дагаврыг ойлгохгүй буюу үйлдлээ удирдаж чадахгүй байдалд хүрсэн зэрэг нөхцөлийг ойлгож болох юм.

Харин мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундааны зүйл хэрэглэж өөрийгөө тийм байдалд хүргэсэн этгээдэд Иргэний хуулийн 504.1 дэх хэсэг хамаарахгүй буюу учруулсан гэм хороо өөрөө хариуцан арилгах үүрэгтэй буюу согтуурсан, мансуурсан үедээ бусдад гэм хор учруулсан этгээдийг хууль зүйн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл биш юм.

Хүснэгт 3.24. Шүүхийн шийдвэр №15

1.	Шийдвэрлэсэн шүүх	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
2.	Огноо, дугаар	2017.02.02 Дугаар 19
3.	Талууд	Нэхэмжлэгч: Г, Э Хариуцагч: Г
4.	Маргааны агуулга	Шүүгдэгч О.Г нь согтуугаар 2016.10.26-27-нд шилжих шөнө Архангай аймгийн Батцэнгэл сумын Дэл багийн нутаг дэвсгэр Ороохын өвөлжөө гэх газарт иргэн У.Г, Ж.Э нарыг “зүгээр байхад хэрүүл маргаан үүсгэлээ” гэх хувийн харьцааны улмаас маргалдан модон сандлыг зэвсгийн чанартай хэрэглэн зодож бие махбодид нь хөнгөн зэргийн гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэгт холбогджээ. Хохирол нь эрүүл мэндэд учирсан хохирол болон эмнэлэгт үзүүлсэн зардал болох 1.330.000 төгрөгийн хохирлыг барагдуулахыг шаардсан байна.
5.	Шийдвэрлэсэн байдал	Шүүх: Хариуцагч нь Шүүх, сэтгэц гэм судлалын 2016.12.23-ны өдрийн 23 тоот магадлагаанд хэрэг үйлдэхийн өмнө болон хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн хувьд архинд донтох өвчин III үе, хий үзэгдэл зонхилсон архины солио өвчтэй ба бусад эрхтэний хувьд тархины цус хомсдох дайрал ба түүнд хамаарах хам шинж өвчтэй, сэтгэцийн болон бусад эрхтэний өвчний улмаас сэтгэцийн хувьд хэрэг болох үед өөрийн үйлдэл, нийгмийн аюулын шинж чанар, өөрийн үйлдлийг зөв ойлгож, удирдан жолоодох чадваргүй байсан нь тогтоогдсон тул Иргэний хуулийн 504 дүгээр зүйлийн 504.1-д зааснаар шүүгдэгч О.Г нь дээрх гэм хорыг хариуцах үндэслэлгүй гэж үзэж энэ нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дээрх шүүхийн шийдвэрт сэтгэцийн хувьд архинд донтох өвчний III үе, хий үзэгдэл зонхилсон архины солио өвчтэй ба бусад эрхтний хувьд тархины цус хомсдох дайрал ба түүнд хамаарах хам шинж өвчтэй гэж тогтоогдсон үндэслэлээр өөрийн үйлдэл, нийгмийн аюулын шинж чанар, өөрийн үйлдлийг зөв ойлгож, удирдан жолоодох чадваргүй гэж үзэж Иргэний хуулийн 504 дүгээр зүйлийн 504.1 дэх хэсэгт заасны дагуу гэм хорын хариуцлагаас чөлөөлсөн байна. Ийнхүү сэтгэц болон биеийн эрүүл мэндтэй холбоотойгоор дээрх заалтыг тайлбарлах боломжтой ч ямар төвшний өвчин, эрүүл мэндийн байдлыг хамааруулах нь хэргийн нөхцөл байдлаас хамааран янз бүр байна. Иймд өөрийн үйлдлийг зөв ойлгож, удирдан жолоодох чадваргүй байсныг мэргэжлийн эмч, шинжээчийн тусламжтайгаар л тогтоох боломжтой байна.

3.3.8. Бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хор

Иргэний хуулийн 512 дугаар зүйлд бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хорыг зохицуулсан. Орчин үеийн бүтээгдэхүүний доголдлоос үүсэх хариуцлагын эрх зүйн онцлог нь доголдолтой бүтээгдэхүүн борлуулсан худалдагчийн эсрэг нэхэмжлэл гаргахад гэрээний харилцаатай байх ёстой гэсэн шаардлагыг халж гэм буруугүйгээр хариуцлага хүлээх үзэл баримтлал бий болсон явдал юм. Гэрээний харилцаатай байх ёстой гэсэн үзэл хандлага өөрчлөгдсөн шалтгаан нь доголдолтой бүтээгдэхүүнээс хохирсон гуравдагч этгээд хохирлоо барагдуулах боломжгүй байсантай холбоотой.⁵⁹

59 Б.Тамир, Бүтээгдэхүүний доголдлоос үүсэх хариуцлага, Харьцуулсан гэм хорын эрх зүйн цуврал, (УБ, 2021), 21 дэх тал.

Хүснэгт 3.25. Монгол Улсын Иргэний хуулийн 512 дугаар зүйл

№	Зүйл, заалт	Агуулга
1.	512 дугаар зүйлийн 512.1 дэх хэсэг	512.1.Чанар муутай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь хохирогчтой гэрээний харилцаатай байсан эсэхээс үл хамааран уг бараа, бүтээгдэхүүний улмаас учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.
2.	512 дугаар зүйлийн 512.2 дахь хэсэг	512.2.Бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дараах тохиолдолд энэ хуулийн 512.1-д заасан хариуцлагаас чөлөөлөгдөж болно: 512.2.1.уг бараа, бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор үйлдвэрлээгүй 512.2.2.борлуулахаар үйлдвэрлэн гаргах үед тухайн бараа, бүтээгдэхүүн бусдад хохирол учруулахуйц байгаагүй гэдгийг баримтаар нотолсон 512.2.3.бараа, бүтээгдэхүүн гэмтэл согогтой боловч үйлдвэрлэн гаргах үед тухайн үеийн норм, стандартад тохирч байсан 512.2.4.бараа, бүтээгдэхүүнийг борлуулахаар үйлдвэрлэн гаргах үеийн шинжлэх ухаан, техникийн түвшнээс шалтгаалан тэдгээрийн гэмтэл согогийг илрүүлэх боломжгүй байсан 512.2.5.тухайн бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, ашиглах журам зөрчсөний улмаас гэм хор учирсан болохыг түүнийг худалдсан буюу үйлдвэрлэсэн этгээд нотолсон.
3.	512 дугаар зүйлийн 512.3 дахь хэсэг	512.3.Энэ хуулийн 512.2.5-д заасан зөрчлийн улмаас бусдад гэм хор учирсан бол уг зөрчил гаргасан этгээд гэм хорыг хариуцна.
4.	512 дугаар зүйлийн 512.4 дэх хэсэг	512.4.Ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хорыг хариуцахад энэ зүйлд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

Орчин үеийн бүтээгдэхүүний доголдлоос үүсэх хариуцлагын эрх зүйн онцлог нь доголдолтой бүтээгдэхүүн борлуулсан худалдагчийн эсрэг нэхэмжлэл гаргахад гэрээний харилцаатай байх ёстой гэсэн шаардлагыг халж гэм буруугүйгээр хариуцлага хүлээх үзэл баримтлал бий болсон явдал юм. Гэрээний харилцаатай байх ёстой гэсэн үзэл хандлага өөрчлөгдсөн шалтгаан нь доголдолтой бүтээгдэхүүнээс хохирсон гуравдагч этгээд хохирлоо барагдуулах боломжгүй байсантай холбоотой.⁶⁰

Монгол Улсын Иргэний хуулийн 512 дугаар зүйлд бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний дутагдлын улмаас үүссэн гэм хорын зохицуулалт энэ жишгийн дагуу гэрээний харилцаанаас үл хамааран учирсан гэм хорыг арилгуулах агуулгатай байна. Гэвч уг зүйлийг эд хөрөнгийн эрх зөрчигдсөн тохиолдолд зөвхөн бараа, бүтээгдэхүүнээс өөр эд зүйлийн гэмтэл бий болсон нөхцөлд л хэрэглэнэ. Тухайн бүтээгдэхүүнд өөр дээр нь илэрсэн аливаа гэмтэл, доголдлыг худалдах, худалдан авах гэрээний зохицуулалтын дагуу шийдвэрлэнэ.

Ингэхдээ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Органик хүнсний тухай хуульд заасан шаардлагыг баримтална. Мөн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2018 оны А/253 тоот тушаалаар батлагдсан “Аюулгүйн тэмдгийн хэлбэр, хэмжээ, хэрэглэх журам”, Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрлэлийн сайдын 2018 оны А/09 тушаалаар батлагдсан “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/46/115 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Зайлшгүй сав, баглаа, боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошгожуулах журам”, Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтонд тавигдах ерөнхий шаардлага САС/MNS 1:2007,

60 Б.Тамир, Бүтээгдэхүүний доголдлоос үүсэх хариуцлага, Харьцуулсан гэм хорын эрх зүйн цуврал, (УБ, 2021), 21 дэх тал.

Хүсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавигдах шаардлага MNS 6648:2016 зэрэг стандартуудыг үндэслэл болгох юм.

Иргэний хуулийн 512 дугаар зүйлийн 512.2 дахь хэсэгт бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөлийг тусгасан. Эдгээрт:

- а) Судалгаа, шинжилгээ, туршилтын журмаар үйлдвэрлэсэн, тухайлбал, зах зээлд нийлүүлэх буюу худалдах, солилцох, эргэлтийн хэлбэрт оруулах үе шатанд хүрээгүй байсан бол бараа бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор үйлдвэрлээгүй гэж үзэж хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно.
- б) Борлуулахаар үйлдвэрлэн гаргах үед доголдолгүй байсан бол хариуцлагаас чөлөөлөгдөнө. Үйлдвэрлэгч бүтээгдэхүүний загвараас эхлээд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх үе хүртэл анхаарал болгоомжтой байх үүрэгтэй.
- в) Үйлдвэрлэгч барааг үйлдвэрлэхдээ норм стандартыг баримтлах ёстой. Энэ норм стандарт нь үйлдвэрлэлийн тодорхой хэлбэр, явцыг заасан бол бараа бүтээгдэхүүн нь доголдолтой гарсан ч хариуцлага хүлээхгүй.
- г) Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх үед тухайн үеийн техникийн болон шинжлэх ухааны судалгаа, туршилтаар доголдол илрээгүй гэдгийг нотолж чадвал хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэ нь үйлдвэрлэлийн доголдолтой холбоогүй, зөвхөн хөгжүүлэлт, зохион бүтээлтийн доголдолтой холбоотой байна.
- д) Үйлдвэрлэгч үйлдвэрлэн гаргаж байгаа эд хөрөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, журам, баталгаат болон эдэлгээний хугацаа ашиглахад дагаж мөрдөх аюулгүйн зааварчилгаа, анхааруулга, үйлдвэрлэсэн он, сар, өдөр зэрэг үйлдвэрлэлтэй холбогдсон үнэн зөв мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй. Үйлдвэрлэгч өөрөө энэ үүргээ биелүүлснийг болон хохирогч хадгалах, ашиглах заавар, горим зөрчсөнийг нотлох үүрэгтэй. Энэ тохиолдолд үйлдвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.⁶¹

Дүгнэвэл, Монгол Улсын Иргэний хуульд заасан гэм хорын тусгай төрлүүд нь залруулах шударга ёсны онолд үндэслэж шийдвэрлэгдэх бөгөөд гэм буруугүйгээр хариуцлага хүлээх зарчим ихэнх тусгай төрлийн зохицуулалтад тусгалаа олжээ. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд, шүүхээс Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг давхар зүйлчилж байгаа нийтлэг дутагдал ажиглагдлаа. Гэм хорын ерөнхий зохицуулалт нь тусгай зохицуулалтад хамаарахгүй нөхцөлийг шийдвэрлэхэд хэрэглэгдэх атал давхардуулан хэрэглэж байгаа нь тусгай зохицуулалтын ач холбогдлыг алдагдуулж байна.

Түүнчлэн Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтаас гадна Зөрчлийн тухай хуульд иргэний эрх зүйн зарим зөрчлүүд тусгагдсан нь гэм хорын эрх зүйн шийтгэлийн шударга ёсны бэхжүүлэх зорилго Зөрчлийн тухай хуулийн зорилго болсныг илэрхийлж байна. Иймд эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орны хувьд Зөрчлийн тухай хуулиар Иргэний хуультай давхардуулсан зорилго, агуулгатай иргэний эрх зүйн зөрчлийн төрлийг бий болгохоос аль болох татгалзах шаардлагатай гэж үзлээ.

61 Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Гэрээний бус үүрэг-IV, (УБ, 2016), 100-101 дэх тал.

IV. ГАДНЫ ОРНЫ ГЭМ ХОР УЧРУУЛСНААС ҮҮСЭХ ҮҮРГИЙН ТОГТОЛЦОО

Гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалт (non-contractual liability law)-ийг ХБНГУ-д “deliktrecht”, БНФУ-д “responsabilité civile délictuelle”, харин англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудад “tort” гэж нэрлэдэг. Гэм хорын эрх зүйн онцлогийг харьцуулан судлахад улс орнуудыг эрх зүйн бүлээр нь хуваан авч үзэх хангалтгүй байна. Англи болон Ирландын эрх зүйн тогтолцоог авч үзвэл, Европын орнуудын шийтгэлийн хуулиудтай төстэй буюу олон бие даасан гэм хорын төрөлтэй бөгөөд эдгээрт 70-75 иргэний эрх зүйн зөрчлийг нэрлэж болох юм.⁶²

Англи-америкийн эрх зүйн бүлийн орнуудын гэм хорын төрлүүд аль ч эх газрын эрх зүйн бүлийн улсаас их байдаг нь маргаангүй юм. Учир нь эх газрын эрх зүйн бүлийн улс орнууд, түүнчлэн Скандинавийн зарим орнуудад эдгээр олон төрлийн иргэний эрх зүйн зөрчлийг ерөнхий зохицуулалтад шингээн хуульчилсан байдаг.

Гэм хорын эрх зүйн тогтолцоо бүхэлдээ Германы (Ромын) болон Францын гэсэн хоёр төрөлд хуваагддаг байна. Германы тогтолцоонд хүн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон болон бие махбодод хохирол учруулсан гэм хорын төрөлд нөхөн төлбөр оногдуулах замаар хохирлыг нь барагдуулдаг бол бусад төрлийн гэм хор учруулсан тохиолдолд нөхөн төлөх боломжгүй гэж үздэг. Харин Францын гэм хорын эрх зүйн тогтолцоонд бүх төрлийн гэм хорын төрлүүдийг нөхөн төлөх боломжтой гэж үздэг байна. Иймд гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцоог судлахдаа ХБНГУ болон БНФУ-ыг сонгон авч судлалаа.

Хүн төрөлхтний түүхийн явцад гэм хор гэж хуулиар тодорхойлсон зөрчлүүдийн хэв шинж хувьсан өөрчлөгдсөөр иржээ. Тухайлбал, хатуу хариуцлагын зарчим аюултай амьтан өмчлөгчөөс үүдэлтэй байсан бол үйлдвэрлэл хурдацтай хөгжихийн хирээр аюултай үйл ажиллагаа явуулж буй этгээдэд хамааралтай болсон юм. Өөрөөр хэлбэл, гэм хорын төрөл нь тухайн нийгэм, соёл, эдийн засгийн хөгжлийг дагаад хувьсан өөрчлөгддөг байна. Иймээс гаднын орны зохицуулалтыг судлахдаа дорнын сэтгэлгээтэй улс орон болох Япон улсыг сонгон авч судлалаа.

4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Гэм хор гэдэг үг герман хэлэнд англи хэлний “tort” гэдэгтэй ижил буудаггүй байна. Үүний оронд “unlawful acts” буюу *unerlaubte Handlungen* гэж Иргэний хуульдаа тусгажээ. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтыг ХБНГУ-ын Иргэний хууль (BGB)-иар нийт 33 зүйлээр зохицуулсан байна. Гэм хорын эрх зүй нь англи-америкийн эрх зүйн бүлийн улс орнуудтай харьцуулахад ХБНГУ-ын хувьд бие даасан салбар эрх зүй гэж тооцогддоггүй онцлогтой. Харин үүргийн эрх зүйн нэг хэсэгт багтдаг тул Иргэний хуулийн 2-р дэвтрийн төгсгөлийн хэсэгт “Үүрэг” буюу *Schuldverhältnisse* хэсэгт 823-852 дугаар зүйлд зохицуулагджээ. Энэ утгаараа гэм хор учруулснаас үүсэх үүргийн бүрэлдэхүүн болох гэм бурууг шалгахад үүргийн ерөнхий зохицуулалтыг ашигладаг байна. Үүнийг 254 дүгээр зүйлд зохицуулсан бөгөөд гэрээний болон гэм хорын эрх зүйд нэгэн адил үйлчлэх үүргийн ерөнхий зохицуулалт юм.⁶³

62 Christian Von Bar, Ulrich Drobnig, The interaction of Contract law and tort and property law in Europe, A comparative study, p.26-27.

63 Hay, Peter, German Private and Commercial Law: An Introduction. By Norbert Horn, Hein Kötz, and Hans G. Leser, trans. Tony Weir, Oxford: Clarendon Press, 1982, p.153.

Монгол Улсын Иргэний хуульд мөн ялгаагүй Гэрээний бус үүрэг болох IV хэсгийн II дэд хэсэг буюу зөрчлийн улмаас үүсэх үүрэгт гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтыг хуульчилсан. Гэм хорыг арилгах зарим зохицуулалт Иргэний хуулийн Арван наймдугаар бүлэгт 228-230 дугаар зүйлд тусгагдсан нь манай улсад гэм хорын эрх зүй нь ХБНГУ-ын нэгэн адил үүргийн эрх зүйн нэг хэсэг болохыг илэрхийлж байна.

4.1.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго

Гэм хорын эрх зүйн зорилго ХБНГУ-д цаг хугацааны эрхэнд өөрчлөгдөж иржээ. Анх гэм хорын эрх зүйн үндсэн зорилго нь хохирогчид учруулсан гэм хорыг арилгах байсан. Харин сүүлийн үед илүү зохицуулалтын шинжтэй болсон байна. Ийнхүү зарим тохиолдолд гэм хорын эрх зүй нь тодорхой зан үйлийг удирдах, хязгаарлах, улмаар зөрчил гаргагчийг шийтгэх зорилго агуулах болжээ.⁶⁴

Гэм хорын эрх зүй нь хувийн эрх, эрх чөлөөг хууль бус үйлдлээс хамгаалах ерөнхий чиг үүрэгтэй хэдий ч үүнийг илүү нарийвчлан ойлгох шаардлагатай юм. Тухайлбал, ослын тохиолдолд гол зорилго нь хохирлыг барагдуулахад орших учиртай. Харин хүний хувийн мэдээлэл, эсхүл хувийн эрх чөлөөнд халдсан үйлдэлд гэм хорын эрх зүй нь хохирогчийг сэтгэл хангалуун болгох, зөвшилцөхөд анхаарах юм. Мөн эдийн засгийн болон худалдааны эрх ашиг хөндөгдвөл урьдчилан сэргийлэх зорилгыг агуулна.⁶⁵

Гэвч ХБНГУ-ын хувьд гэм хорын эрх зүйг шийтгэх зорилгыг агуулах ёсгүй гэсэн байр суурь одоо хүртэл давамгайлдаг тул англи-америкийн эрх зүйн бүл болон БНФУ-аас ялгаатай нь ялын журмаар гаргуулах хохирлыг хүлээн зөвшөөрөөгүй байна.

4.1.2. Гэм хорын ерөнхий зохицуулалт

ХБНГУ-ын 1900 оны Иргэний хуульд гэм хорын гурван ерөнхий зохицуулалтыг (Иргэний хуулийн 823 дугаар зүйлийн 823.1, 823.2 болон 826 дугаар зүйл) тусгажээ.

Хүснэгт 3.26. ХБНГУ-ын гэм хорын ерөнхий зохицуулалт⁶⁶

Хуулийн зүйл, хэсэг, заалт	Агуулга
823 дугаар зүйлийн 823.1 дэх хэсэг	Бусдын амь нас, бие махбодь, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө болон бусад эрхэд санаатай болон болгоомжгүйгээр хууль зөрчиж хохирол учруулсан этгээд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
823 дугаар зүйлийн 823.2 дахь хэсэг	Бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан хууль тогтоомжийг зөрчсөн этгээд гэм буруутай тохиолдолд 823.1-т заасан үүргийг хүлээнэ.
826 дугаар зүйл	Төрийн бодлогод харшлах замаар бусдад гэм хор учруулсан этгээд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

64 Zekoll, Joachim et al, Introduction to German law, 2019, p.270.

65 Id. p.271.

66 German Civil Code, Article 823.1, 823.2, 826, Холбоос:

https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html#p3489.

Иргэний хуулийн 826 дугаар зүйлтэй харьцуулахад 823 дугаар зүйлийн 823.1 дэх хэсэг нь зарим талаараа илүү өргөн боловч явцуу агуулгатай юм. Тус хуулийн 823 дугаар зүйл нь хохирол нөхөн төлөх ерөнхий үүрэг бөгөөд үүнд тодорхой эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдлийг хамаарах бол 826 дугаар зүйлээр тийм хязгаарлалт байхгүй юм. Практикт Иргэний хуулийн 823 дугаар зүйлийн 823.1 дэх хэсгээр эдийн засгийн цэвэр алдагдал (pure economic loss)-ийг хамгаалаагүй тул үүнийг 826 дугаар зүйлээр барагдуулдаг байна.⁶⁷

Нөгөө талаараа 823 дугаар зүйлийн 823.1 дэх хэсэгт болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсныг зохицуулсан бол 826 дугаар зүйлээр зөвхөн санаатай үйлдлийг хамруулж ойлгоно. Ийнхүү 823.1-т заасан ерөнхий үүргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар тодорхойлдог байна. Үүнд:

1. Бусдын эрх (*Rechte*) болон хууль ёсны ашиг сонирхолд (*Rechtsgüter*) буюу амь нас, бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, өмч болон бусад эрх (*sonstiges Recht*)-ийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй байх;
2. Үйлдэл, эс үйлдэхүй нь хууль бус байх (*Rechtswidrigkeit*)
3. Гэм буруутай байх (санаатай эсхүл болгоомжгүй)
4. Үйлдэл, эс үйлдэхүй болон хохирол хоёрын хооронд шалтгаан холбоотой байх зэрэг юм.⁶⁸

4.1.3. Гэм хорын тусгай зохицуулалт

ХБНГУ-ын Иргэний хуулийн II дэвтэрт 823-853 дугаар зүйлд гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтыг хуульчилсан. Дараах төрлийн тусгай гэм хорын төрлүүдийг тухайлан зохицуулжээ. Үүнд:

1. Зээлийн чадварыг дордуулах мэдээ, мэдээлэл түгээх (§824, Kreditgefährdung);
2. Гэрлэлтээс гадуурх бэлгийн харьцаанд орохыг албадах (§825, Bestimmung zur Bejwohnung);
3. Гэм хор хамтран учруулах (§830, Mittäter und Beteiligte);
4. Эрх зүйн чадамжгүй хүний учруулсан гэм хор (§832, Haftung des Aufsichtspflichtigen);
5. Амьтны учруулсан гэм хор (§833, Haftung des Tierhalters);
6. Барилга, байгууламж нурснаас үүссэн гэм хор (§836, Haftung bei Einsturz eines Bauwerkes);
7. Албан үүргээ зөрчсөнөөс үүссэн гэм хор (§839, Haftung bei Amtspflichtverletzung).

Хүснэгт 3.27. ХБНГУ-ын Иргэний хуулийн зарим зүйл, заалт

Хуулийн зүйл, хэсэг, заалт	Агуулга
824 дүгээр зүйл Зээлийн чадварыг дордуулах мэдээ, мэдээлэл түгээх	Бусдын зээлийн чадварыг дордуулах эсхүл амьжиргаа, хөгжил дэвшилд нь сөргөөр нөлөөлөхүйц худал мэдээлэл хэлсэн, эсхүл тараасан этгээд тухайн баримтыг худал гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран бусдад учирсан хохирлыг нөхөн төлнө.

67 Basil S.Markesinis, Hannes Unberath, The German law of torts and a comparative treatise, ed.4, Hart publishing, 2002, p.43.

68 Id.

825 дугаар зүйл Гэрлэлтээс гадуурх бэлгийн харьцаанд орохыг албадах	Бусдыг хууран мэхлэх, дарамтлах эсхүл харилцааны хараат байдлыг ашиглан бэлгийн харилцаанд орох, тийнхүү үйлдлийг зөвшөөрөхөд өдөөн хатгасан этгээд учруулсан хохирлыг хариуцан арилгана.
830 дугаар зүйл Гэм хор хамтран учруулах	Нэг болон түүнээс дээш этгээд хамтран гэм хор учруулснаас бий болсон хохирлыг хүн тус бүр хариуцан арилгана. Хэний үйлдлээр хэд хэдэн этгээд хохирол учруулсан болох нь тогтоогдоогүй тохиолдолд мөн хамаарна. Хамтран учруулсан гэм хорыг өдөөн хатгасан болон арга хэрэгсэл болсон этгээд гэм хор хамтран учруулсан этгээдтэй нэгэн адил хариуцлага хүлээнэ.
832 дугаар зүйл Эрх зүйн чадамжгүй хүний учруулсан гэм хор	Насанд хүрээгүй эсхүл сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан бусдын асран хамгаалалтад байгаа этгээдийн гуравдагч этгээдэд хууль бусаар учруулсан гэм хорыг түүнийг асран хамгаалах үүрэгтэй этгээд хариуцан арилгана.
833 дүгээр зүйл Амьтны учруулсан гэм хор	Амьтны бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулсан хохирлыг тухайн амьтныг хараа хяналтдаа байлгаж буй этгээд хариуцан арилгана. Мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог гэрийн тэжээвэр амьтны учруулсан эсхүл эзэмшигч нь анхаарал болгоомжтой байсан ч учирсан хохиролд хариуцлага хүлээхгүй.
836 дугаар зүйл Барилга, байгууламж нурснаас үүссэн гэм хор	Газарт бэхлэгдсэн барилга, байгууламж доголтой баригдсан эсхүл зохих ёсоор арчилж хамгаалаагүйгээс үүдэж барилга, байгууламж эсхүл түүний хэсэг нурснаас болж бусдын амь нас, бие махбод болон эрүүл мэндэд хохирол учирсан бол газар өмчлөгч хариуцлага хүлээнэ. Хэрэв барилга, байгууламжийг эзэмшигч аюулаас хамгаалах зорилгоор зохих ёсоор арчилсан бол хариуцлагаас чөлөөлөгдөнө. Бусдад газар эзэмших эрхээ шилжүүлсэн этгээд тухайн газар дээрх барилга, байгууламж нурснаас үүссэн хохирлыг нэг жилийн хугацаанд хариуцан арилгах үүрэгтэй. Хэрвээ өөрийн эзэмшилд байх хугацаанд зохих ёсоор арчилж байсан эсхүл дараагийн эзэмшигч зохих ёсоор арчлах замаар ослоос сэргийлэх боломжтой байсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.
839 дүгээр зүйл Албан үүргээ зөрчсөнөөс үүссэн гэм хор	Албан хаагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан үүргээ санаатай болон болгоомжгүйгээр зөрчсөнөөс түүнд учруулсан гэм хорыг хариуцан арилгана. Хэрвээ албан хаагчийн анхаарал болгоомжгүй байдлаас болж гэм хор учирсан бөгөөд хохирсон этгээд өөр арга замаар хохирлоо барагдуулах боломжгүй тохиолдолд мөн хариуцлага хүлээнэ.

Үүнээс харвал, 824, 833 дүгээр зүйлд заасан гэм хорын тусгай зохицуулалт нь хатуу хариуцлагын зарчмыг баримталсан байна. Монгол Улсын Иргэний хуульд заасан гэм хорын тусгай төрлүүдтэй харьцуулахад, зарим гэм хорын төрөл ижилхэн боловч ялгаатай байгааг анзаарах нь зүйтэй.

Тодруулбал, ХБНГУ-ын Иргэний хуулийн 836 дугаар зүйлд газарт бэхлэгдсэн барилга, байгууламж доголдолтой баригдсан эсхүл зохих ёсоор арчилж хамгаалаагүйгээс үүдэж барилга, байгууламж эсхүл түүний хэсэг нурснаас болж учирсан гэм хорын барилга, байгууламжийг өмчлөгч бус газар өмчлөгч хариуцан арилгана гэснийг онцлох шаардлагатай юм. Харин Монгол Улсын Иргэний хуулийн 500 дугаар зүйлд дээр заасан шалтгаанаас бусад тохиолдолд барилга, байгууламж өмчлөгч буюу эзэмшигч гэм хорыг хариуцахаар заасан.

Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 500 дугаар зүйлд заасан агуулга нь ялгаатай байх бөгөөд барилга, байгууламж доголдолтой баригдсан эсхүл зохих ёсоор арчилж хамгаалаагүйгээс үүдэж үүссэн гэм хорыг 500 дугаар зүйлээр бус гэм хорын ерөнхий зохицуулалтын хүрээнд хамааруулан шийдвэрлэх боломжтой. ХБНГУ-ын Иргэний хуулийн 836 дугаар зүйлд заасан гэм хорын тусгай төрөл нь барилга,

байгууламж нь газартай нэг бүхэл зүйл болж явах буюу хөрсөнд бэхлэгдсэн зүйл хөрсөндөө үлдэх зарчмаас үүдэлтэй байна.

Энэ зарчим ХБНГУ-тай ижил байдлаар манай улсад тусгалаа олсон байдаг. Монгол Улсын Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгт “газар түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох бүхий л эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарна.” гэж, 85.2 дахь хэсэгт “байнгын зориулалттай, газартай салшгүй бэхлэгдсэн байшин, барилга бусад зүйлс нь газрын үндсэн бүрдэл хэсэгт байна” гэж тус тус томъёолсон. Үүнээс харахад газар болон түүн дээр баригдсан барилга байгууламж нь нэг өмчлөгчтэй байна. Дээрх зарчмын үүднээс газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг нэг бүхэл болгож бүртгэх шаардлага үүсэж байгаа төдийгүй барилга, байгууламжтай холбоотой гэм хорын тусгай төрлийг энэ зарчимд нийцүүлэн ХБНГУ-ын нэгэн адил газрын өмчлөгч хариуцлага хүлээхээр зохицуулах нь оновчтой байна.

Түүнчлэн хэд хэдэн этгээдийн хамтран үйлдсэн гэм хорыг тусгай төрөл болгон зохицуулсан нь манай улсад байхгүй зохицуулалт байна. Үүнээс гадна 824, 825 дугаар зүйлд манай улсад байхгүй гэм хорын тусгай төрлийг хуульчилсан байна.

4.2. Бүгд Найрамдах Франц Улс

Франц улсад хохирлыг нөхөн төлөх тогтолцоо нь гэм хорын эрх зүйгээс гадна даатгалын эрх зүйтэй нягт хамааралтай байна. Учир нь бие махбод болон эд хөрөнгөд учирсан хохирлыг хэдэн сар, жил шүүхийн шийдвэр гарахыг хүлээсний дараа барагдуулдаг байх нь хүндрэлтэй юм. Энэ ч утгаараа гэм хор учруулснаас үүсэх үүргийг тогтолцоо нь хохирол барагдуулах үндсэн тогтолцоо гэхээсээ илүү дагалдах бүрэлдэхүүн болж явдаг байна.⁶⁹

4.2.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго

Эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсын хувьд Франц улсын гэм хорын эрх зүйн тогтолцооны зорилго нь нэн түрүүнд хохирол барагдуулах юм. Иргэний хуульд зааснаар эдийн засгийн цэвэр алдагдал (pure economic loss) болон эдийн бус гэм хорыг тусад нь ялгахгүй арилгах агуулгатай хэдий ч католик соёлтой улсын хувьд хэн нэгний нулимсыг мөнгөөр төлөх боломжгүй гэж үздэг байна. Иймдээ ч эдийн бус гэм хор одоо ч маргаантай сэдэв байсаар байна.

ХБНГУ-тай харьцуулахад Францын номлолд шийтгэлийн шударга ёсны үзэл санааг дэмждэг байна. Зарим тохиолдолд шүүх *pouvoir souverain d'appréciation* гэх бүрэн эрхэд тулгуурлан ноцтой тохиолдолд хохирлын хүрээг өргөн тогтоодог. Үүнийг шийтгэлийн шударга ёсыг бэхжүүлэх шалтгаан болгохыг нээлттэй хүлээн зөвшөөрдөггүй ч эдийн бус гэм хор учруулсан этгээдэд өндөр хэмжээний шийтгэл оногдуулсан тохиолдол байдаг. Жишээ нь, 1988 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр *Courrier du Sœur* сэтгүүл дээр олны танил хүний өөрийн хувийн сууцад, 18 настай байх үеийн нүцгэн зургийг түүний зөвшөөрөлгүй нийтэлсэн байна. Шүүхээс 250,000 франк гаргуулах шийдвэр гаргасан бөгөөд хохирлыг нөхөн төлөхөөс илүү хариуцагчийн олохыг оролдсон орлогын хэмжээгээр хохирлын хэмжээг тогтоосон нь нэг талаараа шийтгэл болсон байна.⁷⁰

69 Helmut Koziol (ed), Basic questions of tort law from a comparative perspective, 2015, p.6-7.

70 Christian von Bar, Ulrich Drobnig, The interaction of contract law and tort and property law in Europe, A comparative study, p.113-114.

4.2.2. Гэм хорын ерөнхий зохицуулалт

Гэм хорын ерөнхий зохицуулалт бүрэн тусгалаа олсон хууль бол БНФУ-ын Иргэний хууль юм. 1804 оны тус хуулийн 1382 дугаар зүйлд (одоо 1240 дүгээр зүйл) ерөнхий зохицуулалтыг “аливаа этгээд бусдын өөрт учруулсан хохирлыг нөхөн төлөхийг буруутай этгээдээс шаардах эрхтэй.” гэжээ. Энэхүү ерөнхий зохицуулалтад аль нэг эрх, ашиг сонирхлыг тодотгоогүй учраас хуулиар хамгаалсан бүх эрх, ашиг сонирхол үүнд хамаарах бөгөөд гэм буруу, хохирол болон тэдгээрийн шалтгаант холбоо урьдчилсан нөхцөл болно.

Франц хэлэнд тус ерөнхий зохицуулалтыг “*principes généraux*” гэж нэрлэдэг бөгөөд үүгээр тодорхой гэм хорын шинэ төрлийг халхавчлан үүсгэх, хариуцлага хүлээх нөхцөлийг шүүх төсөөтэй хэрэглэх боломжийг бүрдүүлэх зорилгогүй болохыг франц эрдэмтэд тайлбарладаг. Харин тухайн ерөнхий зохицуулалтад буй бүрэлдэхүүнийг хэрэглэх, тайлбарлах шаардлагатай үед шүүх хэрэглэдэг байна. Тусгай зохицуулалтад хамаарах гэм хорын тохиолдол практикт гарах нь илүү элбэг цаг үед ерөнхий зохицуулалтыг ховор хэрэглэдэг.⁷¹

4.2.3. Гэм хорын тусгай зохицуулалт

БНФУ-ын Иргэний хуулийн IV бүлгийн II дэд бүлэгт “Гэрээний бус үүрэг”-ийг зохицуулсан. Тус хуулийн 1240-1252 дугаар зүйлд гэм хороос үүсэх үүргийг хуульчилсан бөгөөд гэм хорын тусгай зохицуулалтаас илүүтэй ерөнхий зохицуулалтыг дотор нь хувааснаараа онцлогтой байна. Үүнийг 1240-1244 дүгээр зүйлд заажээ.⁷²

Хүснэгт 3.28. БНФУ-ын Иргэний хуулийн 1240-1244 дүгээр зүйл

Хуулийн зүйл, хэсэг, заалт	Агуулга
1240 дүгээр зүйл	Аливаа этгээд бусдын өөрт учруулсан хохирлыг нөхөн төлөхийг буруутай этгээдээс шаардах эрхтэй.
1241 дүгээр зүйл	Хүн бүр өөрийн бодитой үйлдлээр эсхүл хайхрамжгүй, илэрхий болгоомжгүйгээр бусдад учруулсан хохирлыг хариуцан арилгана.

71 Jean-Sébastien Borghetti, Simon Whittaker [ed.], French civil liability in comparative perspective, Hart Publishing, 2019, p.459.

72 Civil Law of France, Article 1240-1244, Холбоос: [Chapter I: Non-contractual liability in general \(Articles 1240 to 1244\) - Légifrance \(legifrance.gouv.fr\)](#)

1242 дугаар зүйл	Аливаа этгээд өөрийн бодитой үйлдлээс гадна бусад хүний өмнөөс хохирол барагдуулах үүрэг хүлээсэн, эсхүл удирдлага доор байдаг хүний үйлдлээс бий болсон хохирлыг хариуцан арилгана. Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн өмчилдөг этгээд өөрийн эсхүл хохирлыг нь барагдуулахаар үүрэг хүлээсэн этгээдийн буруугаас тухайн эд хөрөнгө гал түймэрт өртсөн тохиолдолд л гуравдагч этгээдийн хохирлыг хариуцан арилгана. Энэ зүйл Иргэний хуулийн 1733 болон 1734 дүгээр зүйлээр зохицуулагдаж байгаа өмчлөгч, түрээслэгчийн харилцаанд үйлчлэхгүй. Эцэг, эх нь хамт амьдарч буй насанд хүрээгүй этгээдийн учруулсан хохирлыг эцэг эхийн эрхийн (parental authority) хэмжээгээр хамтран эсхүл дангаараа хариуцан арилгана. Эзэн болон удирдах албан тушаалтан өөрийн ажилтны учруулсан, эсхүл ажилтнаар өөрийн ажлыг гүйцэтгүүлж байх явцад учруулсан хохирлыг хариуцан арилгана. Багш, урчууд өөрийн хараа хяналтад байлгах хугацаанд сурагч, шавийн учруулсан хохирлыг хариуцан арилгана. Эцэг, эх, урчууд нь хохирлоос урьдчилан сэргийлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнийг нотлоогүй тохиолдолд дээр дурдсан үүргийг хүлээнэ. Багшийн тухайд учирсан хохирол түүний гэм буруу, хайхрамжгүй, илэрхий болгоомжгүй байдлаас үүдэлтэй байсныг шүүхэд нотлох үүргийг нэхэмжлэгч хүлээнэ.
1243 дугаар зүйл	Амьтны өмчлөгч, эсхүл эзэмшигч тухайн амьтныг хараа хяналтад байлгах үед, эсхүл төөрч, зугтах үед учруулсан хохирлыг хариуцан арилгана.
1244 дүгээр зүйл	Байшин барилга өмчлөгч түүнийг зохих ёсоор арчилж хамгаалаагүйгээс, эсхүл барилгын явцад үүссэн доголдлоос болж байшин барилга нурснаас бий болсон хохирлыг хариуцан арилгана.

Францын эрх зүйн номлолд гэм хорыг дотор нь хувь этгээдийн учруулсан гэм хор (du fait personnel), эд зүйлээр учруулсан гэм хор (du fait des choses), гаднын хүчин зүйлээр учруулсан гэм хор (du fait d'autrui) гэж хуваадаг.⁷³

Хувь этгээдийн учруулсан гэм хорын урьдчилан нөхцөл:

- Гэм буруу (la faute)
- Хохирол (le dommage)
- Гэм буруутай үйлдэл, хохирол хоорондын шалтгаан холбоо (un lien de causalite) байна.

БНФУ-ын шүүхийн практикт гэм хорын эрх зүйд *theorie de la cause adequate*-ийг баримталдаг. *La theorie de l'equivalence des conditions*-ийг хэрэглэдэггүй.

Гэм хор учруулсан гэж үзэхгүй байх нөхцөлд давагдашгүй хүчин зүйл (la force majeure), гуравдагч этгээдийн буруутай зан байдал (le fait d'un tiers), хохирогчийн гэм буруу (la faute de la victime) хамаарна.

4.3. Япон Улс

Япон улсын Иргэний хуулийн 709-724 дүгээр зүйлд гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан. Түүхэн үүднээс авч үзвэл Японы гэм хорын эрх зүйн хөгжилд БНФУ болон ХБНГУ-ын гэм хорын эрх зүйн тогтолцоо хамгийн их нөлөөлсөн байна. Тухайлбал, нэхэмжлэлийн шаардлагыг хангахын тулд гэм хор учруулсан этгээдийн үйлдэл, хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байх ёстой юм. Энэ үзэл санааг Германы эрх зүйгээс нутагшуулан авсан байна.⁷⁴

73 В.П.Мозолин. Гражданское право. Часть 2. М, 2007, Холбоос: <https://jurisprudence.club/pravo-grajdansкое/deliktnyie-obyazatelstva-pravu.html>.

74 Eri Osaka, "Reevaluating the role of the tort liability system in Japan", *Arizona journal of international and comparative law*, Vol.26, №2 (2009), p.394-395.

4.3.1. Гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцооны зорилго

Япон улсын Иргэний хуульд гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан. Японы гэм хорын эрх зүйн ном, сурах бичгийг үзвэл гэм хорын эрх зүйн хамгийн нэн тэргүүний зорилго нь хохирогчийг хохиролгүй болгоход оршдог хэмээн бичдэг байна. Харин шийтгэх зорилгыг гэм хорын эрх зүйн дараагийн зорилго бөгөөд эрүүгийн эрх зүйн илүү зохицуулах асуудал гэж үздэг. Ийнхүү Японы эрх зүйн тогтолцоонд эрүүгийн эрх зүй болон иргэний эрх зүйг тодорхой заагладаг байна.⁷⁵

4.3.2 Гэм хорын ерөнхий зохицуулалт

Япон улс нь БНФУ-ын нэгэн адил гэм хорын ерөнхий зохицуулалттай байна. Иргэний хуулийн 709 дүгээр зүйлд “Бусдын эрх, хуулиар хамгаалагдсан эрх ашгийг санаатай эсхүл болгоомжгүйгээр зөрчсөн этгээд учруулсан хохирлыг барагдуулах үүрэгтэй”⁷⁶ гэж заасан. Францын гэм хорын эрх зүйд хохирол буюу “damage” байхыг шаарддаг бол Японы гэм хорын эрх зүйд бусдын эрх, эсхүл хуулиар хамгаалагдсан эрх ашгийг зөрчсөн байхыг шаардана. ХБНГУ-ын Иргэний хуулийн 823 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гагцхүү абсолют эрхийг хамгаалдаг бол Японы Иргэний хуулийн 709 дүгээр зүйлээр тийнхүү хязгаарлаагүй ажээ.⁷⁷

4.3.3. Гэм хор учруулсанд тооцохгүй нөхцөл

Гэм хорын ерөнхий зохицуулалтын бүрэлдэхүүнийг авч үзэхээс өмнө гэм хор учруулсан гэж үзэхгүй нөхцөлийг авч үзье. Японы Иргэний хуульд гэм хор учруулсан гэж үзэхгүй хоёр нөхцөлийг заасан байна. Үүнд:

а) Иргэний эрх зүйн зөрчил үйлдэх чадамжгүй байх

Иргэний хуулийн 712 дугаар зүйлд заасны дагуу насанд хүрээгүй этгээд өөрийн үйлдлээс бий болох хууль зүйн үр дагавар, хариуцлагыг ухамсарлах чадамжгүй нөхцөлд гэм хор учруулсны улмаас үүрэг үүсэхгүй. Түүнчлэн 713 дугаар зүйлд заасны дагуу сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийг хариуцах чадваргүй иргэний учруулсан гэм хорыг хариуцлагаас чөлөөлөх юм.

б) Аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал

Иргэний хуулийн 720 дугаар зүйлд “Өөрийн болон гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бусдын гэм хор учруулах үйлдлээс хамгаалах зорилгоор биет хохирол учруулсан этгээд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Хохирогч тухайн гэм хор учруулах үйлдэл гаргасан этгээдээс хохирлоо нэхэмжлэх эрхтэй.”⁷⁸ гэж заасны дагуу аргагүй хамгаалалтыг зохицуулжээ.

75 Jun Tsunematsu, “The meaning of tort liability in Japan: a sociological exploration”, International Journal of Japanese Sociology, №20 (2011), p.121.

76 A person who has intentionally or negligently infringed any right of others, or legally protected interest of others, shall be liable to compensate any damage resulting in consequence.

77 Keizo Yamagoto, Basic features of Japanese tort law. Jan Sramek Verlag, 2019, p.21.

78 A person who, in response to the tortious act of another, unavoidably commits a harmful act to protect himself/herself, the rights of a third party, or any legally protected interest, shall not be liable for damages; provided, however, that the victim shall not be precluded from claiming damages against the person who committed the tortious act.

4.3.4. Гэм хорын тусгай зохицуулалт

Японы Иргэний хуулийн 709 дүгээр зүйлд заасан ерөнхий зохицуулалт дээр нэмэгдэн зарим тусгай нөхцөл байдалд хэрэглэгдэх тусгай зохицуулалтыг хуульчилсан байна.

(1) Хэд хэдэн этгээдийн оролцоотой учруулсан гэм хор

Гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцаанд хэд хэдэн этгээдийн оролцоотой гэм хорыг ангилан авч үзэж болно. Үүнийг дотор нь мөн хоёр хэсэгт салгаж үзье.

а) Бусад этгээдийн үйлдлээс үүдэлтэй хүлээх хариуцлага

Иргэний хууль

Иргэний хуульд бусад этгээдийн үйлдлээс үүдэлтэй 3 төрлийн гэм хорыг зааж өгсөн. Нэгдүгээрт, Иргэний хуулийн 714 дүгээр зүйлд заасны дагуу иргэний эрх зүйн зөрчил үйлдэх чадамжгүй этгээдийн учруулсан гэм хорыг асран хамгаалж буй болон удирдлагадаа байлгаж буй этгээд хариуцах тухай юм. Хоёрдугаарт, Иргэний хуулийн 715 дугаар зүйлд заасны дагуу захирал буюу ажил олгогч өөрийн ажилтны учруулсан гэм хорыг хариуцах тухай байна. Гуравдугаарт, Иргэний хуулийн 716 дугаар зүйлд заасны дагуу ажил гүйцэтгэгч гэрээгээр гүйцэтгүүлж буй этгээдийн учруулсан гэм хорыг захиалагчийн өмнө хариуцах юм.

Тусгайлсан хууль

Иргэний хуулиас гадна тусгайлсан хуулийн хүрээнд хоёр гэм хорын төрлийг тусгасан байна. Нэгдүгээрт, 1947 оны 125 дугаартай Төрөөс нөхөн олговор олгох тухай хууль (State Redress Act)-ийн 1 дүгээр зүйлд төрийн албан хаагч өөрийн албан үүргээ хэрэгжүүлэх явцад, эсхүл төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад гэм буруутайгаар, санаатай эсхүл хайхрамжгүй байдлаар гэм хор учруулсан бол материаллаг хохирлыг төр эсхүл төрийн байгууллага хариуцна⁷⁹ гэж заасан.

Хоёрдугаарт, Тээврийн хэрэгслийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх тухай хуулийн 3 дугаар зүйлд тээврийн хэрэгслийг өөртөө ашиг, давуу тал бий болгох зорилгоор бусдад ашиглуулсны улмаас гуравдагч этгээдийн амь нас, бие махбодод учирсан хохирлыг нөхөн төлөх⁸⁰ тухай заажээ.

б) Хэд хэдэн этгээдийн үйлдлээс үүдэлтэй хүлээх хариуцлага

Хэд хэдэн этгээд гэм хор учруулах харилцааг зохицуулж өгсөн байна. Иргэний хуулийн 719 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нэгээс дээш этгээд бүлэглэн бусдад гэм хор учруулсан тохиолдолд хохирлыг хамтран эсхүл тус тусдаа барагдуулах үүрэг хүлээхээр хуульчилжээ.

79 The state or public body is liable for damage that a public official inflicts wrongfully and intentionally or negligently upon another in exercising the public power of the state or public body in carrying out his duties.

80 Whoever places a car at another's use for their own benefit is liable to compensate the damage that the other sustains to his life or body due to operating the car.

(2) Эд юмсаар учруулсан гэм хор

а) Иргэний хууль

Иргэний хуульд эд юмсаар учруулсан гэм хорын хариуцлага хүлээх хоёр тохиолдлыг тусгасан. Иргэний хуулийн 717 дугаар зүйлд газар дээрх барилга, байгууламжийг барих эсхүл ашиглах явцад гуравдагч этгээдэд учирсан хохирлыг тухайн барилга, байгууламжийг эзэмшигч эсхүл өмчлөгч хариуцан арилгана.⁸¹ Иргэний хуулийн 718 дугаар зүйлд амьтан эзэмшигч эсхүл харгалзагч тухайн амьтны бусдад учруулсан хохирлыг хариуцахаар заасан. Харин тухайн амьтны төрөл, онцлогт тохирсон зохистой анхаарал болгоомжтой байсан өмчлөгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.⁸²

б) Тусгайлсан хууль

Иргэний хуулиас гадна тусгайлсан хуульд заасан хоёр зохицуулалт чухал байна. Нэгдүгээрт, зам, гол мөрөн эсхүл бусад нийтийн эзэмшлийн байгууламжийг барих эсхүл ашиглах явцад бусдад учирсан хохирлыг төр эсхүл захиргааны байгууллага хариуцан арилгана⁸³ (Art 2 State Redress Act). Хоёрдугаарт, бүтээгдэхүүний доголдлоос үүдэн бусдын амь нас, эрүүл мэнд эсхүл эд хөрөнгө хохирол учирсан тохиолдолд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нөхөн төлнө (Art 3 Product Liability Act).⁸⁴

Дүгнэвэл

Дээрх гурван улсад нийтлэг байгаа гэм хорын эрх зүйн тусгай төрлүүд Монгол Улсын Иргэний хуульд тусгалаа олсон байна. Харин ерөнхий зохицуулалт нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 823 дугаар зүйлийн 823.1 дэх хэсэгт заасан ерөнхий зохицуулалттай ижил байдлаар субъектив эрхийг зөрчиж гэм буруутайгаар хохирол учруулсан байхыг шаардаж байна. Япон улсын хувьд гэм хорын зарим тусгай төрлүүд нь нарийвчилсан хуульд тусгалаа олсон нь сайн жишиг байх бөгөөд үүнийг манай улс нутагшуулах боломжтой юм.

81 The possessor or owner of a structure on land is liable when damage is sustained by another party due to any defect in the construction or maintenance of the structure.

82 A possessor of an animal is liable to compensate for damage that the animal inflicts on another person; provided, however, that this does not apply if the possessor managed the animal while exercising reasonable care according to the kind and nature of the animal.

83 The state or a public body is liable for damage that arises to another due to defectiveness in the construction or maintenance of roads, rivers, or other public constructions.

84 Keizo Yamagoto, Basic features of Japanese tort law, Jan Sramek Verlag, 2019, p.21-24.

У. ДҮГНЭЛТ

Монгол Улсын гэм хорын эрх зүй нь бие даасан салбар эрх зүй гэхээсээ илүү үүргийн эрх зүйн нэг хэсэг болон хөгжсөн байна. Харьцуулсан судалгаанд судалсан гаднын улсад гэм хорын эрх зүйн тогтолцооны зорилго нь залруулах шударга ёсыг бэхжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд гэм хорын тусгай зохицуулалтад заагаагүй тохиолдолд ерөнхий зохицуулалтыг хэрэглэдэг байна.

Харин англи-америкийн эрх зүйн бүлийн улс орнуудад гэм хорын ерөнхий болон тусгай төрөл байхгүй бөгөөд салангид бие даасан олон гэм хорын төрөл байдаг байна. Гэм хорын эрх зүйн шийтгэлийн шударга ёсны онол англи-америкийн эрх зүйн бүлийн улс орнуудад хүчтэй байр суурь эзэлдэг хэдий ч эх газрын эрх зүйн бүлийн зарим оронд хүлээн зөвшөөрч эхэлсэн нь Франц болон Япон улсын жишээнээс харагдаж байна.

Зорилгын хувьд Монгол Улсын гэм хор учруулснаас үүсэх үүргийн тогтолцоо эх газрын эрх зүйн бүлийн улстай ижил байдлаар залруулах шударга ёсыг бэхжүүлэхийг зорьсон хэдий ч уг зорилгод хүрэхэд зарим дутагдалтай талууд байсаар байна. Тухайлбал, эдийн бус гэм хорыг хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээр хязгаарласан байна. Мөн сэтгэл санааны хохирол гэх ухагдахуун агуулгын хувьд тусгагдаагүй тул үүнийг нэхэмжилж, хохирлоо барагдуулах боломж дутмаг байна.

Манай улсын хувьд Иргэний хуульдаа ялын журмаар гаргуулах хохирлыг хуульчлаагүй ч Зөрчлийн тухай хуульд шийтгэлийн шударга ёсны зарчмыг зорилгоо болгон зарим иргэний эрх зүйн зөрчлийг зохицуулжээ. Энэ нь давхардал бий болгож байгаагаас гадна олон гэм хорын төрлийг Зөрчлийн тухай хуулиар бий болгох эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуулиар гэм хорын эрх зүйн өөр нэг зорилго болон шийтгэлийн шударга ёсыг бэхжүүлэхээр заасан нь бусад оронд байхгүй холимог тогтолцоо бүрдэх нөхцөл бий болсныг онцлох нь зүйтэй.

Практикт манай улсын шүүх гэм хорын эрх зүйн хэрэг маргаан хянан шийдвэрлэхдээ ерөнхий зохицуулалтыг тусгай зохицуулалттай хамт зүйлчилж байгаа нь оновчгүй юм. Учир нь ерөнхий зохицуулалтад хамаарахгүй тусгай нөхцөлийг тусдаа хуульчилсан байхад ерөнхий зохицуулалтын гэм буруу зэрэг бүрэлдэхүүнийг давхар шаардах нь тусгай зохицуулалтын ач холбогдлыг бууруулж байна.

Ийнхүү Монгол Улсын хувьд гэм хорын учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулахын тулд гэм хорын эрх зүйн ерөнхий болон тусгай зохицуулалтын бүрэлдэхүүнийг нарийвчлан судлах, танин мэдүүлэх, иргэний эрх зүйн зөрчлийг бусад хуулиар зохицуулсныг анзаарч, Зөрчлийн тухай хуулиар гэм хорын тусгай төрөл нэмж хуульчлахгүй байх шаардлагатай гэж дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Иргэний хууль
3. Зөрчлийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төрийн албаны тухай хууль
6. Захиргааны ерөнхий хууль
7. Замын хөдөлгөөны аюулгүй байдлын тухай хууль
8. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
9. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл (2022)

Ном, сурах бичиг

1. С.Нарангэрэл, *Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг*, УБ, 2021.
2. С.Нарангэрэл, *Хууль зүй судлалын монгол-англи тайлбар толь*, УБ, 2005.
3. Б.Буянхишиг, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, гурав дахь хэвлэл, УБ, 2018.
4. Б.Буянхишиг, *Үүргийн эрх зүй*, нэмж завсарласан хоёр дахь хэвлэл, УБ, 2011.
5. Ж.Оюунтунгалаг, *Иргэний эрх зүйн онолын асуудал*, УБ, 2018.
6. Т.Мөнхжаргал, *Монгол Улсын иргэний эрх зүй, Үүргийн тусгай төрөл*, УБ, 2015.
7. Б.Улаанбаатар, *Иргэний эрх зүйн тайлбар толь*, УБ, 2005.
8. Б.Тамир, *Бүтээгдэхүүний доголдлоос үүсэх хариуцлага, Харьцуулсан гэм хорын эрх зүйн цуврал*, УБ, 2021.
9. Шварц Вандт, *Хууль зааснаар үүсэх үүргийн эрх зүй: зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй*, орч. Л.Эрдэнэ-Очир, УБ, 2017.
10. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Гэрээний бус үүрэг-IV, УБ, 2016.
11. Эрүүгийн эрх зүйн гарын авлага, УБ, 2017.
12. Т.Мөнхжаргал, *Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй*, УБ, 2005.
13. Ж.Оюунтунгалаг, *Харьцуулсан иргэний эрх зүй*, УБ, 2013.
14. Т.Золбоо, *Гэмт хэргийн бүтээц*, УБ, 2016.

Судалгааны өгүүлэл, эмхэтгэл

1. Монгол Улсын Иргэний хууль тогтоомж, Түүхэн эмхэтгэл 1206-2012 он, УБ, 2012.
2. Л.Амгаланбаатар, “Тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас учирсан гэм хорын эрх зүйн онолын асуудал, хууль хэрэглээ”, 2018.
3. Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалтын талаарх судалгаа”, Шүүхийн шийдвэрт хийх хөндлөнгийн дүн шинжилгээ.

4. Ж.Оюунтунгалаг, “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”, *Хууль дээдлэх ёс сэтгүүл*, №3 (2016).
5. Ж.Оюунтунгалаг, “Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал”, *Магистрын дипломын ажил*.
6. Ж.Оюунтунгалаг, “Гэм хорын тусгай төрөл: Эзэмшигчийн хариуцлага”.
7. Вай Инсайт ХХК, Монгол Улсад гэрийн тэжээвэр амьтны эрхийг хамгаалах хууль хэрэгжүүлэх үндэслэл, хууль хэрэгжсэнээр гарах үр дүн, 2021.

Шүүхийн шийдвэр

1. УДШ-ийн тогтоол, Дугаар 001/ХТ2017/00971, 2017.09.19, https://shuukh.mn/single_case/2917?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1
2. УДШ-ийн тогтоол, Дугаар 001/ХТ2019/00310, 2019.03.07, https://shuukh.mn/single_case/5687?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1
3. Төв аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Дугаар 223/МА2021/00001, 2021.01.27, https://shuukh.mn/single_case/17286?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1
4. Дархан-уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Дугаар 21, 2021.02.22, https://shuukh.mn/single_case/17820?date_range=2020/01/01%20-%202021/03/04%20&id=2&court_cat=1&bb=1
5. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Дугаар 210/МА2022/01637, 2022.09.02, https://shuukh.mn/single_case/25338?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1
6. Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 2018/ХТ2018/01917, 2018.12.20, https://shuukh.mn/single_case/4987?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1
7. Хан-уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, Дугаар 85, 2016.10.10, https://shuukh.mn/single_case/7526?start_date=&end_date=&id=1&court_cat=2&bb=1
8. Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 120, 2018.03.26, https://shuukh.mn/single_case/78666?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
9. Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 001/ХТ2018/00045, 2017.12.27, https://shuukh.mn/single_case/4338?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1
10. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Дугаар 2401, 2017.11.22, https://shuukh.mn/single_case/7212?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1
11. Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 134/ШШ2018/00180, 2018.10.02, https://shuukh.mn/single_case/80222?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
12. Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 5483, 2016.08.19, https://shuukh.mn/single_case/32614?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

13. Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, Дугаар 19, 2017.02.02, https://shuukh.mn/single_case/9221?start_date=&end_date=&id=1&court_cat=2&bb=1
14. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 1032, 2016.10.21, https://shuukh.mn/single_case/40256?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

Цахим мэдээлэл

1. www.legalinfo.mn
2. www.shuukh.mn
3. <https://d.parliament.mn/>
4. <https://www.1212.mn/>

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. German Civil Law BGB
2. Civil Law of France
3. Civil Law of Japan

Ном, сурах бичиг

1. Bryan A. Garner, editor in chief. *Black's Law Dictionary*, 9th ed., Thomson Reuters, 2009.
2. *Exploring tort law*, Edited by M.Stuart Madden, Cambridge University Press, 2005.
3. John C. P. Goldberg, Benjamin C. Zipursky, *The Oxford Introductions to U.S. Law, Torts*, NY, 2010.
4. Joseph W. Glannon, *The law of torts*, 4th ed.
5. Marco Cappelletti, *Comparative reflections on Punishment in Tort law*, in Jean-Sébastien Borghetti and Simon Whittaker (eds), *French Civil Liability in Comparative Perspective*, Hart Publishing, 2019.
6. Ward Farnsworth, *The legal analyst: a toolkit for thinking about the law*, The University of Chicago, 2007.
7. W.van Gerven, *Tort Law, Casebooks for the Common Law of Europe*, Hart publishing, 2000.
8. Guido Calabresi, *The complexity of torts- the case of punitive damages, Exploring tort law*, ed. by M.Stuart Madden, Cambridge University Press, 2005.
9. Christian Von Bar, Ulrich Drobnig, *The interaction of Contract law and tort and property law in Europe, A comparative study*.
10. Hay, Peter, *German Private and Commercial Law: An Introduction*. By Norbert Horn, Hein Kötz, and Hans G. Leser, Translated by Tony Weir, With a foreword by Clive M. Schmitthoff, Oxford: Clarendon Press, 1982.
11. Zekoll, Joachim, Gerhard Wagner, *Introduction to German law*, 2019
12. Basil S.Markesinis, Hannes Unberath, *The German law of torts and a comparative treatise*, ed.4, Hart publishing, 2002.

13. Helmut Koziol (ed), *Basic questions of tort law from a comparative perspective*, 2015.
14. В.П.Мозолин, *Гражданское право*, Часть 2, М, 2007.
15. Keizo Yamagoto, *Basic features of Japanese tort law*, Jan Sramek Verlag.

Судалгааны өгүүлэл, эмхэтгэл

1. Eri Osaka, "Reevaluating the role of the tort liability system in Japan", *Arizona journal of international and comparative law*, Vol.26, №2(2009).
2. Benjamin C.Zipursky, "Civil resource, not corrective justice", *The Georgetown law journal*, Vol.91:695(2003).
3. Catharine Pierce Wells, "Tort law as corrective justice: a pragmatic justification for jury adjudication", *Michigan Law Review*, Vol.88(1990).
4. Maud Laroche, "Reconnaître de très larges pouvoirs au juge : le juge peut-il considérer les comportements du responsable et de la victime", *Revue de Jurisprudence Commerciale*, Juillet/Août, Numéro 4(2013).
5. C Jauffret-Spinosi, "Les dommages-intérêts punitifs dans les systems de droit étrangers".
6. Jun Tsunematsu, "The meaning of tort liability in Japan: a sociological exploration", *International Journal of Japanese Sociology*, №20(2013).
7. Loth, Marc, "Corrective and distributive justice in tort law: On the restoration of autonomy and a minimal level of protection of the victim", *Maastricht Journal of European and Comparative law*, 22(6).

Цахим мэдээлэл

1. Arthur Ripstein: *Theories of the Common Law of Torts*, <https://plato.stanford.edu/entries/tort-theories/#CorJus>
2. Dr.Detlev Gabel, Markus Langen, Dr.Sylvia Lorenz, Dr.Dominik Stier, Nicolas Bechtold: *Compensating non-material damages based on Article 82 GDPR- is there a de minimis threshold?* <https://www.whitecase.com/insight-alert/compensating-non-material-damages-based-article-82-gdpr-there-de-minimis-threshold>
3. Грата Интернейшнл: Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн эрх зүйн зохицуулалт болон Гэрээнд санал болгож буй жишиг заалт, https://gratanet.com/laravel-filemanager/files/3/force%20majure_MN.pdf

ДӨРӨВ. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНААС ҮҮССЭН ЗАРИМ ТӨРЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааг удирдсан:

С.Сүхбаатар

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D)

Судалгааны багийн бусад гишүүд:

Б.Энх-Амгалан

Х.Санчир

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2022.12.30.

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	127
НЭГ. ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТӨРӨЛ, ТООН ҮЗҮҮЛЭЛТ	130
ХОЁР. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНААС ҮҮССЭН ЗАРИМ ТӨРЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ПРАКТИК.....	134
2.1. Гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	134
2.2. Эцэг тогтоосон шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	136
2.3. Эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	137
2.4. Хүүхдийн тэтгэлэг гаргуулсан шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	138
2.5. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	140
ДҮГНЭЛТ, САНАЛ	142
ЗӨВЛӨМЖ.....	144
НОМ ЗҮЙ.....	145

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” хэмээн заажээ. Ингэснээр гэрлэлт бүртгэх, цуцлах болон гэр бүлийн холбогдолтой бусад харилцаанд гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах төрийн үүргийг Үндсэн хуулиар баталгаажуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” хэмээн заасан. Төр энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон улсын эрх зүйн хүчийг ашиглах арга механизмыг Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”¹, “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”², “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй”³ хэмээн тусгасан. Тухайлбал, Монгол Улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын гишүүн орны хувиар тус конвенцод заасныг бүх талаар хэрэгжүүлж, гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг хадгалах, хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа халдлага, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зэргээр хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах үүрэгтэй.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”⁴-д дэвшүүлсэн зорилтуудын нэг нь гэр бүлийг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох явдал юм.

Гэр бүлийн тухай хууль 1999 онд батлагдан хэрэгжсэнээс хойших 23 жилийн хугацаанд тус хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь салбарын харилцааг зохицуулсан бусад хуулийн шинэчлэлийг дагалдан хийгджээ. Тухайлбал, 2002 онд Иргэний хууль, 2011 онд Нотариатын тухай хууль, 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, 2016 онд Хүүхэд хамгааллын тухай хууль, 2018 онд Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, 2021 онд Соёлын тухай хууль батлагдсантай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүдийг тус тус оруулсан байна.

Гэр бүлийн асуудал нь хувийн шинжтэй боловч нийгмийн үндсэн нэгж болдог учир гэр бүлийг төрөөс дэмжих, хамгаалах, гэр бүлийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, хариуцлагажуулах, гэр бүл дэх хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхэд үрчлэлт, асран хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох зэрэг асуудлыг хуулиар зохицуулах шаардлага зүй ёсоор

1 Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

2 Мөн зүйлийн 3 дахь хэсэг.

3 Монгол Улсын Үндсэн хууль, 16-р зүйлийн 14 дэх хэсэг

4 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим сан <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203094&showType=1> (Сүүлд үзсэн: 2022.12.12)

тулгардаг. Сүүлийн жилүүдэд нийгмийн амьдралд ихээхэн өөрчлөлт гарах болсон нь гэр бүлийн харилцаанд мөн нөлөөлж, тухайлбал гэр бүлийн асуудалд чөлөөтэй хандах байдал нэлээд ажиглагдаж байна. Үүний улмаас гэр бүл цуцлалт, гэр бүлийн гишүүд хоорондын маргаан, түүнээс үүдэлтэй хүүхдийн эрхийн зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг таагүй асуудал ихсэх боллоо.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.8-д “Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.” гэж заасан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/- ийн төслийг батлуулан гэр бүлийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг бий болгох, шинэ төрлийн үйлчилгээг бий болгож нэвтрүүлнэ.” хэмээн тодорхойлжээ.

Дээр дурдсан нөхцөл, байдлыг харгалзан, Хууль зүй, дотоод хэргийн яам 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө “Гэр бүлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/- ийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан. Үүний дагуу хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд, гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардах эрхийг хангах, шүүхээр хэрэг, маргааныг шийдвэрлэх харилцааг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв.

Судалгааны зорилго. Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн практикт дүн шинжилгээ хийх замаар тулгамдаж буй зарим асуудлыг тодруулан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино. Улмаар Гэр бүлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажилд дэмжлэг үзүүлнэ.

Судалгааны зорилт. Энэхүү судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно:

1. Дараах төрлийн хэрэг, маргааныг 2017-2021 онд иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн тоон үзүүлэлтийг судалж, дүн шинжилгээ хийх. Үүнд:

- Гэрлэлт цуцлах;
- Эцэг тогтоох;
- Эцэг, эх байх эрх хасах болон хязгаарлах;
- Хүүхдийн тэтгэлэг гаргуулах;
- Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох төрлийн хэрэг, маргаан багтана.

2. Шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр, практикт тулгамдаж буй асуудал (гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан; нэхэмжлэлийн шаардлагад тусгасан эсэхээс үл хамаарч гэрлэлт цуцлуулах маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэлгийн асуудлыг давхар шийдэж байгаа байдал; хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож буй шалтгаан гэх мэт)-ийг тодруулж, цаашид авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар санал, зөвлөмж дэвшүүлэх.

Судалгааны арга зүй. Гэр бүлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг судалгааны объект болгон, баримт бичгийн судалгааны арга, хууль зүйн техник, хууль тайлбарлах арга, харьцуулалтын арга болон задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх аргыг энэхүү судалгаанд ашиглав.

Судалгааны хамрах хүрээ. Тус судалгаанд, ШЕЗ-өөс гаргасан мэдээлэлд үндэслэсэн Үндэсний статистикийн хорооны мэдээлэл (Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлалаар тооцсон мэдээлэл), шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn сайт)-д байршуулсан мэдээлэлд тулгуурлан, Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн дагуу шүүхээр шийдвэрлэгдсэн зарим төрлийн хэргийн шүүхийн шийдвэрийг хамруулсан болно. Үүнд, сүүлийн 5 жил (2017-2021 он)-д хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдээс Гэрлэлт цуцлах; Эцэг тогтоох; Эцэг, эх байх эрх хасах болон хязгаарлах; Хүүхдийн тэтгэлэг гаргуулах; Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрүүдийг сонгож хамруулсан. Түүнчлэн судалгааны зорилт 2-д тухайлан заасан зарим асуудлыг тодруулах зорилтын хүрээнд дээр дурдсан 2017-2021 оны болон 2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэж ашигласан. Харин асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө, хуваарьт хөрөнгийн холбогдолтой зэрэг гэр бүлийн эрх зүйн бусад маргааныг хянан шийдвэрлэсэн ангилалд багтах шүүхийн шийдвэрүүдийг энэхүү судалгаанд хамруулаагүй болно.

Энэхүү судалгаа нь шүүхийн шийдвэрийн агуулга, хэрэг хянан шийдвэрлэсэн ажиллагаанд хийдэг дүн шинжилгээ (хууль хэрэглээний хувьд хууль зүйн үндэслэлтэй эсэх, процессын болон материаллаг эрх зүйн зарчим, хэм хэмжээнд нийцсэн агуулга, хэлбэртэй эсэхийг тодруулах гэх мэт) -ээс өөр дурдах нь зүйтэй.

Судалгааны ажлын хүрсэн үр дүн. Энэхүү судалгаагаар Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн сүүлийн 5 жил (2017-2021 он)-ийн шүүхийн практикийг судалж дүгнэн, тулгамдаж буй зарим асуудлыг тодруулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж дэвшүүлсэн тайлан боловсруулсан. Үүний дүнд, Гэр бүлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажилд дэмжлэг үзүүлнэ хэмээн найдаж байна.


НЭГ. ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТӨРӨЛ, ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ердийн иргэний эрх зүйн маргаанаас мөн чанар, маргааны зүйл, талуудын сэтгэл хөдлөл зэргээрээ онцлог ялгаатай байдлыг харгалзан үзэж бусад төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгамжтай хуульчилдаг, зарим улсын хувьд бие даасан Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байна. Манай улсын хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар бүлэгт Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж ялгамжтай байдлаар зохицуулахыг оролдсон ч хэт ерөнхий зохицуулалт, шүүгч, эвлэрүүлэн зуучлагчийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөндлөнгийн мэргэжилтнүүдийн оролцоо, шүүгчийн явуулах тусгай арга хэмжээг зохицуулаагүйгээс үүдэлтэйгээр ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас төдийлөн ялгагдахгүй байна.⁵

Гэр бүлийн холбогдолтой хэрэг, маргаан нь иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны нэг хэсэг бөгөөд энэ төрлийн хэрэг, маргааны тоо жилээс жилд өсөж байна.⁶ Сүүлийн 5 жил (2017-2021 он)-ийн хугацаанд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэсэн нийт 235 907 иргэний хэргийн 9.8% буюу 23 200 хэргийг Гэр бүлийн тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэжээ.

Гэр бүлийн эрх зүйн маргааны тоон үзүүлэлтийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл дараах дүнтэй байна.

График. 4.1. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо (2017-2021)



Эх сурвалж: ШЕЗ-ийн албан ёсны мэдээлэлд үндэслэсэн ҮСХ-ны мэдээлэл⁷


5 Улаанбаатар хотод гэр бүл, өсвөр насны хүний хэргийн дагнасан шүүх байгуулах тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан (ШЕЗ-ийн захиалгаар Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн, хэвлэгдээгүй тайлан), (УБ, 2019), 72 дахь тал.

6 Мөн тайлан, 10 дахь тал.

7 Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас, Холбоос: https://www.1212.mn/mn/statistic/statcate/573071/table-view/DT_NSO_2300_041V1, Сүүлд үзсэн огноо : 2022.12.15.

2017-2021 оны хугацаанд Гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэргийн дундаж үзүүлэлт нэг жилд 4640 байна. Үүнээс 2018 онд хамгийн олон буюу 4763 хэрэг шийдвэрлэсэн бол 2019 онд 4449 болж буурсан ч 2020 онд 4732 болж өсжээ. 2021 онд 2020 оноос 42 хэргээр цөөн буюу 0.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Гэвч 2021 оны байдлаар Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэргийн тоо 4690 буюу нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 10.3%-ийг эзэлж байгаа нь сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлт (жилд 4640 хэрэг буюу 9.8%)-тай харьцуулбал буураагүй гэж хэлж болно.


График 4.2. Шийдвэрлэсэн хэрэг



Эх сурвалж: Шүүхийн Ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан 2021 он⁸

Судалгаанд дэвшүүлсэн зорилтын хүрээнд, 2017-2021 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн Гэрлэлт цуцлах; Эцэг тогтоох; Эцэг, эх байх эрх хасах болон хязгаарлах; Хүүхдийн тэтгэлэг гаргуулах; Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох төрлийн хэргийн тоон үзүүлэлтийг авч үзье.

8 Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан 2021 он, Холбоос: https://www.judcouncil.mn/site/news_full/11991, Сүүлд үзсэн огноо: 2022.12.20.

График 4.3. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийг төрлөөр ангилсан нь (2016-2021)

Эх сурвалж: ШЕЗ, Монгол Улсын шүүхийн тайлан, 2017-2021 он⁹

Сүүлийн 5 жилийн хугацаа (2017-2021 он)-д Гэр бүлийн хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн хэргийн 60.4 хувь буюу 14021 хэрэг гэрлэлт цуцлах, 25.3 хувь буюу 5879 хэрэг хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 8.8 хувь буюу 2057 хэрэг эцэг тогтоох, 0.4 хувь буюу 97 хэрэг эцэг, эх байх эрх хасах, 5.1 хувь буюу 1183 хэрэг нь бусад төрөлд хамаарах гэр бүлийн маргаан эзэлж байна.

2017-2021 онд гэрлэлт цуцалсан хэргийн тоо бусад төрлийн хэргүүдтэй харьцуулахад хамгийн их байна. Гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээг Судалгааны тайлангийн II бүлгийн 2.1 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

2017-2021 онд эцэг тогтоосон хэргийн шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлт жил бүр хэлбэлзсэн байдал ажиглагдав. 2020 онд өмнөх оноосоо 63 хэргээр, 2021 онд өмнөх оноосоо 71 хэргээр буюу 17.6% хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Эцэг тогтоосон шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээг Судалгааны тайлангийн II бүлгийн 2.2 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

Эцэг, эх байх эрх хасах хэргийн хувьд 2017-2021 онд хэлбэлзсэн шинжтэй, 2018 онд өмнөх оноосоо дахин буурсан боловч 2019 онд дахин илүү өссөн байна. 2020, 2021 онуудад буурсан үзүүлэлттэй боловч энэ төрлийн хэргийн тоо бусад төрлөөс хамгийн цөөн хэвээр байна. Эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээг Судалгааны тайлангийн II бүлгийн 2.3 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

9 Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан, 2017-2021 он, Холбоос: <https://www.jud-council.mn/site/news/22>, Сүүлд үзсэн огноо: 2022.12.20.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн хувьд 2020 онд, өмнөх оноосоо 286 хэргээр буюу 27.3%-иар өссөн бөгөөд 2021 онд өмнөх оноосоо бага зэрэг буурсан үзүүлэлт ажиглагдсан. Хүүхдийн тэтгэлэг тогтоосон шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээг Судалгааны тайлангийн II бүлгийн 2.4 дэх хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

Хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцсон шүүхийн практикийг судлахдаа хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож буй шалтгааныг тодруулах зорилт тавьсан. Үүнтэй холбоотой хэсгийг Судалгааны тайлангийн II бүлгийн 2.5 дахь хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

2020-2021 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхээр Гэрлэлт цуцлах; Эцэг тогтоох; Эцэг, эх байх эрх хасах болон хязгаарлах; Хүүхдийн тэтгэлэг гаргуулах; Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох төрлийн хэргийг шийдвэрлэсэн тоон үзүүлэлтийг мөн авч үзье.

Хүснэгт 4.1. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн төрөл
(2020-2021 он)

№	Маргааны төрөл	2020 он	2021 он	Өөрчлөлт тоогоор	Өөрчлөлт хувиар
1.	Эцэг, эх байх эрх хасах	20	16	-4	20
2.	Эцэг тогтоох	402	331	-71	17.7
3.	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	1333	1297	-36	2.7
4.	Гэрлэлт цуцлах	2726	2823	+97	3.6

Хүснэгт 1-ээс үзэхэд, Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн иргэний хэргийн тухайд, 2021 онд гэрлэлт цуцлахтай холбоотой 2823 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноосоо 97 хэргээр буюу 3.6 хувиар өссөн; хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой 1297 хэрэг шийдвэрлэсэн нь 36 хэргээр буюу 2.7 хувиар, эцэг тогтоохтой холбоотой 331 хэрэг шийдвэрлэсэн нь 71 хэргээр буюу 17.7 хувиар, эцэг, эх байх эрх хасахтай холбоотой 16 хэрэг шийдвэрлэсэн нь 4 хэргээр буюу 20 хувиар, ... тус тус буурчээ.¹⁰


¹⁰ Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан 2021 он, Холбоос: https://www.judcouncil.mn/site/news_full/11991, Сүүлд үзсэн огноо: 2022.12.20.

ХОЁР. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНААС ҮҮССЭН ЗАРИМ ТӨРЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ПРАКТИК

2.1 Гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

2017 онд гэрлэлт цуцлуулах нийт 2791 хэрэг шийдвэрлэсэн бол 2018 онд үүнээс 154 хэргээр олон буюу буюу 5.5% хувиар өссөн байна. 2019 онд гэрлэлт цуцлуулах хэргийн тоо өмнөх оноосоо 209 хэрэг буюу 7%-иар буурсан ч 2021 онд 2020 онтой харьцуулахад 97 хэргээр олон буюу 3.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. (График 4.4-өөс үзнэ үү.)

График 4.4. Гэрлэлт цуцлах хэргийн тоо (2016-2021)



Эх сурвалж: ШЕЗ-ийн албан ёсны мэдээлэлд үндэслэсэн ҮСХ-ны мэдээлэл¹¹

Гэрлэлт цуцлах болсон шалтгаан нөхцөлд юуг хамаарах талаар Гэр бүлийн тухай хуульд тусгайлан заагаагүй боловч шүүх гэрлэлт цуцлуулахаар гаргасан нэхэмжлэлийн шаардлага дахь гэрлэгчдээс гэр бүлийн харилцаагаа цаашид хэвийн үргэлжлэх боломжгүйд хүргэсэн объектив болон субъектив нөхцөл байдлыг тогтоож, улмаар гэрлэгчид болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгод нийцүүлж шийдвэрлэнэ. Шүүх гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хүлээн авч хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтооно.¹²


Шүүхийн шийдвэрийн цахим сан Shuukh.mn сайтаас, 2017 онд шийдвэрлэсэн, гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс 50 шийдвэрийг түүвэрлэж, нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн тайлбар, мөн шүүхийн шийдвэрт тусгасан гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тодрууллаа. Үүнд, таарамжгүй харилцаа 32 буюу 64%, гэр бүлээс гадуурх харилцаа тогтоосон 10 буюу 20%, архидалт 5 буюу 10%, тусдаа

11 Үндэсний статистикийн хорооны цахим хуудас, Холбоос: https://www.1212.mn/mn/statistic/stat-cate/573071/table-view/DT_NSO_2300_041V1, Сүүлд үзсэн огноо: 2022.12.20.

12 Нээлттэй Нийгэм Форум, “Шүүхийн шийдвэрийн шинжилгээ, Эмхэтгэл I”, (УБ, 2018), 92 дахь тал


амьдарч байгаа 2 буюу 4%, гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2%-ийг тус тус эзэлж байна. (Үүнийг График 4.5-аас үзнэ үү.)

График 4.5. Гэрлэлт цуцлах болсон шалтгаан (2017)



Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn -аас түүвэрлэв.

График 4.6. Гэрлэлт цуцлах болсон шалтгаан (2022)



Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn -аас түүвэрлэв.

2022 онд шийдвэрлэсэн, гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс 50 шийдвэрийг түүвэрлэн авч үзэхэд, гэрлэлт цуцлах болсон шалтгаанд таарамжгүй харилцаа 38 буюу 76%, архидалт 6 буюу 12%, тусдаа амьдарч байгаа 4 буюу 8%, гэр бүлээс гадуурх харилцаа 1 буюу 2%, мөн гэр бүлийн хүчирхийлэл 1 буюу 2%-ийг тус тус эзэлсэн болно.

Ийнхүү 2017 он ба 2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэж судлахад, гэрлэлт цуцлалтын шалтгаанууд ойролцоо байв.

2.2. Эцэг тогтоосон шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 7 дугаар зүйлийн 1-д “Хүүхэд төрмөгцөө бүртгүүлэх, төрсөн цагаасаа нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрх эдэлнэ.” хэмээн заасныг Монгол Улс хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Гэр бүлийн тухай хуулийн 23.2-т “Энэ хуулийн 22-т зааснаас бусад тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, төрөл, садангийн хүн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага буюу 14 нас хүрсэн хүүхдийн хэн нэгний өргөдлийг үндэслэн эцэг, эхийг шүүх тогтооно”. Мөн хуулийн 23.2-т “Эцэг, эхийг тогтооход хариуцагч хүүхдийн эцэг, эхтэй эр, эмийн харилцаатай байсныг нотлох баримт, эмнэлгийн шинжилгээ, бусад баримтыг үндэслэнэ” гэж заасан. Хүүхдийн эцэг биш гэж хариуцагч маргаж байгаа тохиолдолд зохигчдын хүсэлтээр шүүгч захирамж гарган эцэг тогтоох шинжилгээ хийлгэхээр Шүүхийн шинжилгээний Үндэсний төвийн Шүүх эмнэлгийн хэлтсийг шинжээчээр томилно.¹³

График 4.7. Эцэг тогтоох хэргийн тоо (2016-2021)



Эх сурвалж: ШЕЗ-ийн албан ёсны мэдээлэлд үндэслэсэн ҮСХ-ны мэдээлэл¹⁴

График 7-д харуулсан, 2017-2021 онд шийдвэрлэсэн эцэг тогтоох хэргийн тоон үзүүлэлтийг авч үзвэл, 2017 онд 467 хэрэг байсан бол 2018 онд 392 хэрэг болж буурсан ч 2019 онд 465 хэрэг болж өссөн; 2020 онд 402 хэрэг шийдвэрлэсэн бол 2021 онд 331 болж буурчээ. 2021 оныг 2017 онтой харьцуулбал 136 хэргээр буюу 29.2% хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн хувьд, эцэг тогтоох хэргийг шийдвэрлэсэн үзүүлэлт нэг жилд дунджаар 411 хэрэг оногдож байна. Олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх зөрчигдсөн тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлэх эрхтэй ч энэ эрхээ эдлэхгүй үлддэг байдал бас бий.

¹³ Нээлттэй нийгэм форум, “Шүүхийн шийдвэрийн шинжилгээ, Эмхэтгэл I”, (УБ, 2018), 102 дахь тал.

¹⁴ Үндэсний статистик хорооны цахим хуудас, Холбоос: https://www.1212.mn/mn/statistic/stat-cate/573071/table-view/DT_NSO_2300_041V1, Сүүлд үзсэн огноо : 2022.12.20.

Үүнийг харгалзан, хүүхэд эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрхийн зөрчил манай улсад байсаар байгааг халах эрх зүйн зохицуулалт шаардлагатай юм.

2.3. Эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ


Гэр бүлийн тухай хуулийн 30 дугаар зүйлд “Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан/хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасаж болно” гэж заасан.

Мөн хуулийн 27.1-т “Хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга санаатай гачигдуулсан, хөдөлмөрийг нь зүй бусаар ашигласан, гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан хүний эцэг, эх байх эрхийг зургаан сар хүртэл хугацаагаар шүүх хязгаарлаж болно” гэж заажээ.

ҮСХ-ны мэдээлэл болон Шүүхийн шийдвэрийн цахим сан Shuukh.mn сайтад, эцэг, эх байх эрх хязгаарлах хэргийг эцэг, эх байх эрх хасах хэргийн төрөлд оруулан шүүхийн шийдвэрийн мэдээллийг хамтад нь байршуулдаг байна.

ҮСХ-ны мэдээллийг үндэслэн, эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэрийн 2017-2021 оны тоон үзүүлэлтийг эхний ээлжинд авч үзье.

График 4.8. Эцэг эх байх эрх хассан хэргийн тоо (2017-2021)



Эх сурвалж: ШЕЗ-ийн албан ёсны мэдээлэлд үндэслэсэн ҮСХ-ийн мэдээлэл¹⁵

Эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэрийн тоо 2017- 2021 онд гэр бүлийн холбогдолтой бусад төрлийн хэргээс цөөн боловч өсөлт, бууралт хэлбэлзсэн төлөв бас ажиглагдаж байна. 2018 онд 11 хэрэг байсан бол 2019 онд 26 хэрэг болсон нь сүүлийн 5 жилийн хамгийн дээд өссөн үзүүлэлт болжээ. 2020, 2021 онд


¹⁵ Үндэсний статистикийн хорооны цахим хуудас, Холбоос: https://www.1212.mn/mn/statistic/stat-cate/573071/table-view/DT_NSO_2300_041V1, Сүүлд үзсэн огноо: 2022.12.20.

шүүхээр шийдвэрлүүлсэн энэ төрлийн хэргийн тоо буурсан байна. (Энэ нь шүүхийн шийдвэрийн цахим сан Shuukh.mn сайтад байршуулсан шүүхийн шийдвэрийн тоон мэдээллээс зөрүүтэй.)

Шүүхийн шийдвэрийн цахим сан Shuukh.mn сайтад байршуулсан, эцэг, эх байх эрх хассан 2018-2021 оны шүүхийн шийдвэрүүдээс эцэг, эх байх эрх хассан ба хязгаарласан шүүхийн шийдвэрүүдийг ангилж байршуулсан байгааг авч үзье. 2018 онд нийт 3 шүүхийн шийдвэр, үүнээс эцэг, эх байх эрх хассан 2, эцэг, эх байх эрх хассан хэргийг хэрэгсэхгүй болгосон 1 шүүхийн шийдвэр; Эцэг, эх байх эрх хассан шүүхийн шийдвэр 2019 онд 6 байх бөгөөд хэргийг хэрэгсэхгүй болгосон болон эцэг, эх байх эрх хязгаарласан шүүхийн шийдвэр байхгүй; 2020 онд энэ төрлийн маргааныг шийдвэрлэсэн нийт 4 шүүхийн шийдвэрээс 3 шийдвэр нь эцэг, эх байх эрх хассан, 1 шийдвэр нь эцэг, эх байх эрх хязгаарласан шийдвэр; 2021 онд нийт 6 шүүхийн шийдвэрийн 5 нь эцэг, эх байх эрх хассан шийдвэр байгаа бол хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр 1 гэсэн үзүүлэлт гарсан.

Дээр дурдсан үзүүлэлт нь ҮСХ-ны мэдээллийн цахим санд байршуулсан холбогдох шүүхийн шийдвэрийн тоон мэдээллээс зөрүүтэй. Хувь хүний нууцтай холбоотой зэрэг шалтгааны улмаас шүүхийн шийдвэрийн цахим сан Shuukh.mn сайтад нийт шүүхийн шийдвэрийг байршуулдаггүй.

График 4.9. Эцэг эх байх эрх хассан хэргийн тоо (2018-2021)



Эх сурвалж: Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn -аас түүвэрлэв.

2.4. Хүүхдийн тэтгэлэг гаргуулсан шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ


НҮБ-ийн 1989 оны Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлд “Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангаж ажиллах ёстой” гэж заасан. Үүнээс үзвэл хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалах нь шүүхийн үйл ажиллагаанд нэгэн адил хамаарах бөгөөд үүний илрэл нь гэр бүлийн эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүн харгалзан үзэх ёстой.¹⁶

¹⁶ Улаанбаатар хотод гэр бүл, өсвөр насны хүний хэргийн дагнасан шүүх байгуулах тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан (ШЕЗ-ийн захиалгаар Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн судалгааны хэвлэгдээгүй тайлан), (УБ, 2019), 58 дахь тал.

ИХШХШТХ-ийн 132.5-д “Гэрлэгчид шүүхээс эвлэрүүлэх арга хэмжээ авсан хугацаанд эвлэрээгүй бол шүүгч гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана. Шүүгч гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа хүүхдийг цаашид хүмүүжүүлэх талаар гэрлэгчдийн хооронд хэлэлцэн тохирсон зүйл байхгүй бол хүүхдийг эцэг буюу эхийн хэний нь асрамжид үлдээх, хамтран өмчлөх дундын өмчийг хуваах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах болон орон сууцны маргааны асуудлыг нэхэмжлэлийг үндэслэн хянан шийдвэрлэнэ. Хуульд заасан бол гэрлэлт цуцлахыг бүртгэхэд хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг шүүх тодорхойлж, түүнийг гэрлэгчдийн хэн нь ямар хэмжээгээр төлбөл зохихыг тогтооно” гэж заасан. Мөн Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2-т зааснаар эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3 дахь хэсгүүдэд эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй байх, эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулан тэтгэлэг тогтоож болох, харилцан тохиролцож гэрээ байгуулаагүй бол тэтгэлийг шүүх тогтооно.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн хувьд, 2018 онд өмнөх оноосоо 90 хэргээр олон буюу 9.4% хувиар өссөн; 2020 онд өмнөх оноосоо 286 хэргээр буюу 27% хувиар тус тус өссөн байна. Эдгээр мэдээллээс үзэхэд хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо жилээс жилд нэмэгдсэн үзүүлэлт гарчээ. Харин 2021 онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах нийт хэргийн тоо 1297 байгаа нь өмнөх оноосоо 36 хэргээр бага буюу 2.7%-иар буурсан байна. (График 10-аас үзнэ үү.) Гэсэн ч үүнийг гэрлэлт цуцлах хэргийн тоо 2021 онд өмнөх оноосоо өссөн байдалтай харьцуулан авч үзвэл хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо буурсан нь анхаарал татах асуудал юм. Энэ нь гэрлэлт цуцлуулсан талууд хүүхэдгүй, эсвэл хүүхэд нь 18 насанд хүрсэн, эсвэл тэтгэлэг гаргуулахаар нэхэмжлэл гаргаагүй зэрэг шалтгаантай байж болно.

График 4.10. Хүүхийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо (2017-2021)



Эх сурвалж: ШЕЗ-ийн албан ёсны мэдээлэлд үндэслэсэн ҮСХ-ийн мэдээлэл¹⁷

Энэхүү судалгаанд дэвшүүлсэн зорилт 2-ын хүрээнд, хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагад тусгасан эсэхээс үл хамаарч гэрлэлт цуцлах маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэмжийн асуудлыг давхар шийдэж байгаа эсэхийг тодруулъя.

¹⁷ Үндэсний статистикийн хорооны цахим хуудас, Холбоос: https://www.1212.mn/mn/statistic/stat-cate/573071/table-view/DT_NSO_2300_041V1, Сүүлд үзсэн огноо: 2022.12.20.

2017 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, 10 шийдвэр буюу 20% нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80% нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй гаргасан байна. 2022 оны шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 50 шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10%, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90% нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй гаргасан байна.

Дээр дурдсан үзүүлэлт нь 2017, 2022 оны холбогдох шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэсэн тус тус 50 шүүхийн шийдвэрийн 40-45 шийдвэр нь шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа нэхэмжлэлийн шаардлагад дурдаагүй бол хүүхдийн тэтгэлгийг хамтад нь шийдвэрлэдэггүй байдлыг илэрхийлэв. Иймд ИХШХШТХ-ийн 132.5-д зааснаар шүүгч хүүхдийн тэтгэлэг гаргуулах асуудлыг нэхэмжлэлийг үндэслэн хянан шийдвэрлэнэ гэж заасныг баримталж, хэрэв нэхэмжлэлийн шаардлагад дурдаагүй л бол хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй үлдээдэг тал ажиглагдаж байна. Ингэснээр хүүхдээ тэжээн тэтгэхтэй холбогдох үүргийг эцэг, эхийн аль нэг нь үүрэх нөхцөл болж, шүүхийн үйл ажиллагааны улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол хохирох байдал үүсдэг.

2.5. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд хүүхэд үрчлэлтийг ямар үндэслэлээр хүчингүйд тооцохыг заажээ. Гэр бүлийн тухай хуулийн 61.1-т “Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан, энэ хуулийн 57.2-т заасан этгээд болох нь илэрсэн тохиолдолд төрүүлсэн эцэг, эх, сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн өөрийн нэхэмжлэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно” гэж заасан. Мөн хуулийн 61.2-т зааснаар шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно.

Гэр бүлийн тухай хуулийн 57.2-т “Ганц бие, бусдын асрамжид байгаа 60-аас дээш настай төрөл, садан бус Монгол Улсын иргэн, 60-аас дээш настай гадаадын иргэн, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн болон хорих ял эдэлж байгаа хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно” гэж заасан.

Шүүхийн шийдвэрийн цахим сан Shuukh.mn сайтад байршуулсан, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон 2017- 2021 оны шүүхийн шийдвэрүүдийг авч үзэхэд, 2017 онд 97 шүүхийн шийдвэр, 2018 онд 12 шүүхийн шийдвэр, 2019 онд 11 шүүхийн шийдвэр, 2020 онд 12 шүүхийн шийдвэр, 2021 онд 9 шүүхийн шийдвэр байв. Эдгээр шүүхийн шийдвэрээс 2018-2021 оны шүүхийн шийдвэрүүдийг хамруулж, хүүхэд үрчилснийг ямар үндэслэлээр шүүх хүчингүйд тооцсоныг тухайлан авч үзье. Үүнд:

- 2018 онд нийт 12 шүүхийн шийдвэрээс 11 буюу 91.6% хувь нь Гэр бүлийн тухай хуулийн 61.2-т заасан “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож, 1 шүүхийн шийдвэр нь хэргийг хэрэгсэхгүй болгосон;
- 2019 оны нийт 11 шүүхийн шийдвэрээс 9 буюу 81% хувь нь мөн “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож, 1 шүүхийн шийдвэр нь хэргийг хэрэгсэхгүй болгож, үлдсэн 1 шүүхийн шийдвэрээр хэргийг түдгэлзүүлсэн;
- 2020 онд нийт 12 шүүхийн шийдвэрээс 3 шүүхийн шийдвэр нь Гэр бүлийн тухай хуулийн 61.1-т заасан үндэслэлээр, үлдсэн 9 шүүхийн шийдвэр буюу 75% хувь нь “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож шийдвэрлэсэн;
- 2021 онд 9 шүүхийн шийдвэрээс 1 нь Гэр бүлийн тухай хуулийн 57.2-т заасан үндэслэлээр шийдвэрлэж, 1 шүүхийн шийдвэр нь хэргийг хэрэгсэхгүй болгож, үлдсэн 7 шүүхийн шийдвэр буюу 77% хувь нь “бусад үндэслэл”-ээр хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцож тус тус шийдвэрлэсэн үзүүлэлт гарсан.

Дээр дурдсан байдлаас үзэхэд, хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон 2018-2021 оны шүүхийн шийдвэрүүдийн дийлэнх нь Гэр бүлийн тухай хуулийн 61.2-т заасан “бусад үндэслэл”-ээр үрчлэлтийг хүчингүйд тооцсон байна. Нийт түүвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдээс авч үзэхэд “бусад үндэслэл”-ээр гэдэгт дараах үндэслэлийг нэхэмжлэлийн шаардлагад дурдсан байв. Үүнд: гадаад улсад ажиллаж сурч ирээд хүүхдээ өөр дээрээ буцааж авах болсон, эцэг, эх нь хүүхдээ өөрийн асрамжид авах болсон, үрчлэгч өндөр насанд хүрсэн, эсвэл нас барсан зэрэг шалтгаан багтана.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд гэрлэлт болон түүнд холбогдох бусад харилцаанд гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төрийн үүргийг баталгаажуулсны дүнд төрөөс тогтвортой бодлого хэрэгжүүлж иржээ. Мөн гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг хадгалах, хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа халдлага, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх чиглэлээр олон улсын гэрээний үүргээ биелүүлэх үүрэгтэй.

Нийгмийн амьдралд гарсан хурдацтай өөрчлөлтийн дагуу гэр бүлийн харилцааг зохицуулж буй дотоодын эрх зүйн орчныг онцгой анхаарах зайлшгүй шаардлага тулгарсан. Энэ хүрээнд Гэр бүлийн тухай хууль(Шинэчилсэн найруулга)-ийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн практикийг судлав.

Гэр бүлийн эрх зүйн маргааны төрлүүд нь өөр хоорондоо харилцан холбоотой бөгөөд нэг төрлийн маргааныг шийдвэрлэхэд бусад асуудал хөндөгдөж, гэр бүлийн бусад гишүүний, ялангуяа хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж, хохирдог байдал ажиглагдаж байна.

Гэр бүлийн харилцаанаас үүссэн хэрэг, маргаан нь иргэний эрх зүйн бусад маргаанаас онцлог ялгаатай болохыг тодорхойлж, гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хангалттай үндэслэл болох эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна. Ингэснээр гэр бүл хамгаалал, гэр бүлийн тогтвортой байдлыг хадгалах төрийн бодлогын хэрэгжилтэд тодорхой нөлөө үзүүлнэ.

Энэхүү судалгаагаар, гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн сүүлийн 5 жил (2017-2021 он)-ийн шүүхийн практикийг судалсны дүнд хийсэн дүгнэлтийг тоймлож, тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Гэрлэлт цуцлах хэргийн тухайд: Гэр бүлийн тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн хэргийн төрлүүдээс гэрлэлт цуцлах хэргийн тоо хамгийн их байхын зэрэгцээ буурахгүй, харин ч өсөх хандлагатай байна. Судалгааны зорилт 2-ын хүрээнд, шүүхийн шийдвэрүүдээс түүвэрлэн судлахад, гэрлэлт цуцлуулах болсон хамгийн том шалтгаан нь таарамжгүй харилцаа бөгөөд архидалт, хамтын бус амьдрал, гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг бусад шалтгаан гэрлэлт цуцлахад хүргэж байгааг тодруулав. (Шүүх гэрлэлт цуцлахдаа хүүхдийн тэтгэлгийг хамтад нь шийдвэрлэдэггүй зэрэг бусад асуудлыг холбогдох хэсгийн дүгнэлтээс үзнэ үү.)

Гэр бүл цуцлах хэргийг шүүхээр шийдвэрлэхээс өмнө хийгддэг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх замаар гэр бүлийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн ажиллагааг төрөөс анхаарах шаардлагатай. Гэрлэлт цуцлахад гэр бүлийн эрх зүйн маргааны бусад асуудал хөндөгддөг байдлыг харгалзан гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөх эрсдэлээс сэргийлэх, хамгаалах зохицуулалтыг хуульчлах нь зүйтэй.

Эцэг тогтоох хэргийн тухайд: Сүүлийн 5 жилийн хувьд, эцэг тогтоосон шүүхийн шийдвэрийн үзүүлэлт жилд дунджаар 411 хэрэг байна. Энэ нь нэг талаас хүүхдийн эцэг мөн эсэхийг хүлээн зөвшөөрөхгүй байх, нөгөө талаас хүүхдийн эцэг, эх байхтай холбоотой үүрэг, хариуцлага хүлээхгүй байх харилцаа, хандлага практикт байсаар байгаагийн илэрхийлэл юм. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан, Монгол Улсын хүлээсэн үүрэг хэрэгжихгүй байх зөрчилд мөн хүргэж байна. Иймд хүүхэд эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрхийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Эцэг, эх байх эрх хасах хэргийн тухайд: 2017-2021 оны шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлтээр, эцэг, эх байх эрх хасах хэрэг гэр бүлийн холбогдолтой бусад төрлийн хэргээс цөөн боловч өсөлт, бууралт хэлбэлзсэн төлөвтэй байна.

ҮСХ-ны мэдээллийн сайтад эцэг, эх байх эрхийг хязгаарлах хэргийг эцэг, эх байх эрхийг хасах хэргийн төрөлд оруулан тоон мэдээллийг хамтад нь байршуулдаг байдлыг өөрчилж, тус бүрээр нь ангилж, шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлтийг ялгамжтай мэдээлэх нь зүйтэй юм.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн тухайд: Шүүхийн практикаас үзвэл, 2017- 2020 онд хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо жилээс жилд нэмэгдсэн байна. 2021 онд гэрлэлт цуцлах хэргийн тоо өссөн байхад хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо буурсан байдлын шалтгаант холбоог тодруулах нь олон талын ач холбогдолтой. Тус судалгаагаар дэвшүүлсэн зорилт 2-ын дүнд, шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа нэхэмжлэлийн шаардлагад дурдаагүй бол хүүхдийн тэтгэлгийг хамтад нь шийдвэрлэдэггүй байдлыг тодрууллаа. Цаашид шүүхээр гэр бүл цуцлалтыг хянан шийдвэрлэхдээ хүүхдийн тэтгэлгийг хамтад нь шийдвэрлэдэг зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсын олон улсын гэрээнд заасныг хэрэгжүүлж, хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тал дээр хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах үүргээ шүүхийн байгууллага орхигдуулж байгааг анхаарч эрх зүйн хүрээнд дорвитой арга хэмжээ авах ёстой.

Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох хэргийн тухайд: Гэр бүлийн тухай хуульд хүүхэд үрчлэлтийг ямар үндэслэлээр хүчингүйд тооцохыг тодорхой заахаас гадна “бусад үндэслэл” гэж томъёолсон тодорхой бус үндэслэлийг мөн заасан. Гэвч хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон 2018-2021 оны шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд дийлэнх шийдвэр нь Гэр бүлийн тухай хуульд заасан “бусад үндэслэл”-д хамаарах үндэслэлүүдээр үрчлэлтийг хүчингүйд тооцсон байна. Иймд шүүхийн энэ практикийг харгалзан, Гэр бүлийн тухай хуульд заасан хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох “бусад үндэслэл” гэсэн зохицуулалтад анхаарал хандуулж, үрчлэлтийг тооцох үндэслэлүүдийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлага байгааг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ Гэр бүлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажилд энэхүү судалгаа дэмжлэг үзүүлнэ хэмээн найдаж байна.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүнд үндэслэн, бодлогын болон практик ач холбогдолтой хэмээн найдаж, дараах асуудлыг зөвлөмж болгож байна. Үүнд:

- Гэр бүлийн тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлахдаа сүүлийн 5 жилийн шүүхийн практикт дүн шинжилгээ хийж, зарим асуудлыг тодруулсан энэхүү судалгааны үр дүнг ашиглах;
- 2019 онд ШЕЗ-ийн захиалгаар Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Улаанбаатар хотод гэр бүл, өсвөр насны хүний хэргийн дагнасан шүүх байгуулах тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан” (хэвлэгдээгүй тайлан)-д тусгагдсан шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээ болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн санал, зөвлөмжийг мөн Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэрэгцээнд харгалзан үзэх;
- Гэр бүлийн тухай хуулийн дагуу шүүхээр хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд заасан хүний эрх, тухайлбал Хүүхдийн эрхийн конвенцод баталгаажуулсан хүүхдийн эрхийг хангах үүрэг заавал биелэгдэх нөхцөлийг бүрдүүлж эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх;
- Гэр бүлийн холбогдолтой хэрэг, маргааны шүүхийн шийдвэрийн цахим санг хөгжүүлэх, ашиглалтыг сайжруулах, тухайлбал гэр бүлийн эрх зүйн маргааны хүрээг тодорхой болгох замаар шүүхийн шийдвэрүүдийн ангиллыг нарийвчлан байршуулах ажлыг хэрэгжүүлэх зэрэг зөвлөмж багтана.

НОМ ЗҮЙ

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, 1999 он
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
4. Хүүхдийн эрхийн конвенц, 1988 он

Хоёр. Судалгааны тайлан

1. Нээлттэй Нийгэм Форум, Шүүхийн шийдвэрийн шинжилгээ, Эмхэтгэл I, УБ., 2018 он
2. Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэн, Улаанбаатар хотод гэр бүл, өсвөр насны хүний хэргийн дагнасан шүүх байгуулах тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан (ШЕЗ-ийн захиалгат судалгаа, хэвлэгдээгүй тайлан), 2019 он

Гурав. Цахим эх сурвалж

1. Эрх зүйн нэгдсэн мэдээллийн цахим сан www.legalinfo.mn
2. Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn
3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас <https://www.judcouncil.mn/>
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn

